

Жилийн тайлан
2021

01	ЕРӨНХИЙ АГУУЛГА	
	Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	4
	Удирдлагын баг, бүтэц зохион байгуулалт	5
	Тогтвортой хөгжилд хамтдаа	8
	Компанийн засаглал	10
	Дотоод аудит, хяналт	11
	Монгол Улсын эдийн засаг	12
	Банкны сектор	14
	2021 оны онцлох үйл явдал	15
	Санхүүгийн хураангуй тайлан	18
	Тогтвортой байдал	20
	Хүний нөөцийн удирдлага	28
02	БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	
	Байгууллагын зах зээл	30
	Жижиг дунд бизнесийн зах зээл	37
	Иргэдийн зах зээл	40
	Гадаад харилцаа, Олон улсын банк	47
	Ностро данс	50
	Харилцагчийн үйлчилгээ	53
	Хөрөнгө зохицуулалтын удирдлага	54
	Эрсдэлийн удирдлага	56
	Мэдээллийн технологи	59
03	ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН	63

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Худалдаа, хөгжлийн банк Монгол Улсад 2 шатлалт банкны системийн үндэс суурийг тавих, үүсэн бэхжихэд томоохон үүргийг гүйцэтгэж ирсэн. Бид зах зээлд төлбөрийн карт, АТМ, интернэт банк, мобайл банк, олон улсын мөнгөн гуйвуулгын SWIFT үйлчилгээ зэргийг анхлан нэвтрүүлж байсан. Мөн олон улсын зах зээл дээр таван удаагийн бондыг гарган арилжаалж, амжилттай төлсөн Монгол Улсын цорын ганц арилжааны банк билээ. Бид ирэх 30-н жилийн стратегиа шинэчлэн, тогтсон хуучин ойлголтууд, үнэлэмжүүд, уламжлалт банкны үйл ажиллагааг шинэчлэн, харилцагчдадаа үнэ цэн бүтээх, шинэ бизнес загварт шилжин ажиллаж байна.

2021 он дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас улс үндэстэн бүрд эдийн засгийн таагүй нөхцөл байдал үргэлжилсэн жил байлаа. Гэсэн хэдий ч ХХБ дэлхийд нэр хүндтэй Уур амьсгалын ногоон сан (Green Climate Fund)-ын Монгол Улс дахь итгэмжлэгдсэн байгууллагын хувьд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгальцагуурын гамшигт үзэгдлийн эрсдэлийг бууруулах үндэсний төсөл, хөтөлбөрүүдэд урт хугацаат, нэн хөнгөлөлттэй нөхцөл бүхий санхүүжилтүүд олголоо. Цар тахлын сөрөг үр дагавар банкны секторын үйл ажиллагаанд нөлөөлсөн ч бид харилцагчдынхаа бизнесийн нөхцөл байдалд тохируулан, уян хатан арга хэмжээнүүдийг авч хамтдаа хичээн ажиллаа. Түүнчлэн төр засгаас болон төв банкнаас хэрэгжүүлж буй төлбөр тооцоо, зээл, хадгаламжийн бүтээгдэхүүнтэй холбоотой шийдвэрүүдэд манлайлан оролцож иргэд, харилцагчид, ажилтнууд та бүхнийгээ боломжит бүх хэлбэрээр дэмжин ажилласан гэдгийг дурдмаар байна.




Хүндэтгэсэн,
ХХБ-ны Гүйцэтгэх захирал
О.Орхон

УДИРДЛАГЫН БАГ

О.ОРХОН /Гүйцэтгэх захирал/	Р.ВҮҮД /Ерөнхийлөгч/	О.БАНЗРАГЧ /Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч/	А.ЭНХМЭНД /Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч/
Ч.СОЛОНГО /Гүйцэтгэх захирлын орлогч/	Д.НЯМРЭНЦЭН /Гүйцэтгэх захирлын орлогч/	С.БААТАР /Гүйцэтгэх захирлын орлогч/	Ц.ГАНБАЯР /Гүйцэтгэх захирлын орлогч/
	Л.ГАНТӨМӨР /Гүйцэтгэх захирлын орлогч/	П.МӨНХНАСТ /Гүйцэтгэх захирлын орлогч/	


БАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХАМТДАА



Банкны лого нь мөнгөний нэгж болох зоосны хэлбэрт суурилсан бөгөөд зоосны голд дүрслэгдсэн мөнгөний авдарт тасралтгүй эргэлдэх эргэлтээр дөрвөн зүг найман зовхисоос мөнгө, эд баялаг хуримтлагдан арвижиж, элбэг дэлбэг байхын бэлгэдэлтэй.



УРИА

ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА

Банкны ажилтнууд, харилцагчид, хөрөнгө оруулагчид зэрэг хүн бүхнийг хөгжил дэвшлийн зүгт хамт алхахыг уриалан дуудах, нэгтгэх, зоригжуулах утгатай.

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХАМТДАА

Тогтвортой хөгжлийн тодорхойлолт болох ирээдүй хойч үеийн хэрэгцээг бууруулахгүйгээр дэлхийн өнөөгийн хүн амын хэрэгцээг хангах цогц үйл явцыг банк, харилцагч, түнш болон улс орон хамтдаа дэмжиж, нэг зорилгын дор нэгдэж ажиллахыг уриалсан утгатай.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид харилцагчдадаа хүсэл, тэмүүлэлдээ хүрэхэд нь зориулж, хүлээлтээс нь давсан санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологиор хүргэнэ.

АЛСЫН ХАРАА

Хөгжиж буй Монголын дэвшил бүхнийг манлайлагч банк байна.

ҮНЭТ ЗҮЙЛС

Бидний харилцагч

Үнэлэмжтэй

Төгс төгөлдөр

Эгнэгт нээлттэй

Эвсэг баг

Гүйцэтгэл төгс

Чин хүндлэл

Б Ү Т Э Э Г Ч

С R E A T O R

Customer centric

Recognition

Excellence

Accessible

Teamwork

Outperforming

Respect

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХХБ нь олон улсын туршлагаар шалгарсан компанийн засаглалын бүхий л хэм хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг. Дээд түвшний, сайн байгууллагын засаглал нь бидний үйл ажиллагааны гол чиглүүлэгч болдог билээ. Бид компанийн засаглалын бүтцэдээ Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн болон удирдлагын багийн гишүүд, хувь нийлүүлэгчдийн хамтын ажиллагаа, нягт харилцааг нарийн тодорхойлдог. Байгууллагынхаа эрхэм зорилго, зорилтдоо хүрэхийн тулд ажилтан бүр ёс зүйн ямар хэм хэмжээг үйл ажиллагаандаа баримтлахыг ч нарийвчлан заасан.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ХХБ-ны ТУЗ нь байгууллагын бүхий л шатанд ил тод, үнэнч шударга байдлыг чухалчлан, нээлттэй засаглалыг бий болгохын зэрэгцээ ямар ч нөхцөлд тохирсон алсын хараа, стратеги бүхий бодлогоор банкны үйл ажиллагааг чиглүүлж, дэмжин ажилладаг.

УДИРДЛАГЫН БАГ

ХХБ-ны удирдлагын баг нь банк, санхүүгийн чадварлаг менежерүүдээс бүрддэг ба компанийн засаглалын зохистой бүтэц, олон жилийн туршлага нь удирдлагын багийн амжилттай ажиллах суурь нь болдог. Мөн банкны урт удаан хугацааны ашигт ажиллагааг хангах, улмаар хувь нийлүүлэгчдийн үнэ цэнийг өсгөх боломжийг олгодог.

АЖИЛТНУУД

ХХБ-ны амжилтын үндэс нь эрч хүчтэй, чадварлаг ажилтнууд бөгөөд тэднийг шударгаар урамшуулах, дэмжих, албан тушаал дэвшүүлэх хөгжлийн тогтолцоог сайжруулснаар харилцагчдадаа банкны шилдэг үйлчилгээг үзүүлж чаддаг.

БИД

ХХБ нь хууль, ёс зүйн хариуцлагын хүрээнд нийцсэн ажиллах орчныг бүрдүүлэхийг үргэлж эрмэлзсээр ирсэн. Харилцагч, бизнесийн түншүүд болон нийгэмдээ банкны шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэн, хувь нийлүүлэгчид болон харилцагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ шударга байх зарчимтай.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЗОРИЛГО

Компанийн засаглалыг сайжруулан олон улсын шилдэг зарчим, туршлагуудын хэмжээнд хүргэх. Олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц, нэр хүндтэй үнэ цэнтэй, хөрөнгө оруулалтыг татах.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ИЙН ДАРГА
Рандолф КОППА

ГИШҮҮД
Должин ЭРДЭНЭБИЛЭГ
Дамбийжав ХҮРЭЛБААТАР
Дагмид ЯНЖМАА

ХАРААТ БУС ГИШҮҮД
Жалбаа БОЛОРМАА
Жамсрандорж ДЭЛГ ЭРСАЙХАН

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Навааншарав Нямсүрэн

ДОТООД АУДИТ, ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Дотоод аудит нь засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын үр дүнтэй байдлыг хараат бусаар үнэлж дүгнэх замаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулдаг. ХХБ-ны дотоод аудитын үйл ажиллагааг ТУЗ-ийн харьяа Аудитын хороо, Дотоод аудитын газар хариуцан ажиллаж байна.

ДОТООД АУДИТ ГАЗАР

Дотоод аудитын газар нь банкны үйл ажиллагааг сайжруулах, бие даасан, бодитой байдлаар баталгаажуулалт хийх, үнэ цэн нэмэгдүүлэхэд чиглэсэн оновчтой зөвлөмж, зөвлөгөө өгөхөд чиглэж, Гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар үйл ажиллагаагаа явуулдаг. Дотоод аудиторуудын олон улсын институт (IIA)-ийн гаргасан Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ (International Professional Practice Framework), олон улсын сайн туршлагыг үйл ажиллагаандаа жишиг болгон ажилладаг.

Дотоод аудитын газар нь тайлант онд:

- 2021 онд аудитын баталгаажуулах болон зөвлөх үйлчилгээг зохистой түвшинд гүйцэтгэн, ТУЗ, Аудитын хорооны баталсан төлөвлөгөөг 98 хувьтай хэрэгжүүлсэн.
- Аудитын бодлого, журмуудаа шинэчлэн боловсруулж, ТУЗ, Аудитын хороогоороо батлуулж, үйл ажиллагаандаа шинэ арга барил, сайн туршлагуудыг нэвтрүүлэн ажиллаа.

Ирэх 2022 онд Дотоод аудитын газар үндсэн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн гүйцэтгэхээс гадна шинэ, дэвшилтэт цогц аудитуудыг гүйцэтгэх, аудитын программ хангамжийн шинэ хувилбарыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, Чанарын удирдлагын албаны үйл ажиллагааг бэхжүүлж зорилт тавин ажиллаж байна.



ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО


Дотоод хяналтын үйл ажиллагаа нь банкны өдөр тутмын үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг ба бизнес, үйл ажиллагааны бүх түвшинд эрсдэлийг бууруулах тогтолцоо юм. Үүнд банкны дээд удирдлага, Гүйцэтгэх удирдлага, ажилтнууд, холбоотой талууд оролцож, дотоод хяналтын үр дүнтэй, үр ашигтай байдалд Аудитын хороо, Дотоод аудитын газар үнэлэлт дүгнэлт өгөх зарчмаар ажилладаг. ХХБ нь дотоод хяналтын тогтолцоогоо оновчтой болгох талаар арга хэмжээ авч, тасралтгүй сайжруулдаг билээ. Тухайлбал, банкны бүх нэгжүүд Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан "Дотоод хяналтын матриц"-ыг мөрдөж ажиллагаас гадна заавар журамдаа дотоод хяналттай холбоотой заалтыг тусгах, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод хяналтын үүргийг тусгах, хяналтын чиг үүрэг бүхий ажлын байр, тайлагналтын тогтолцоотой.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ

“ГАДААД ХУДАЛДААНЫ ТАСАЛДЛААС ҮҮДЭН УУЛ УУРХАЙ, ТЭЭВЭР, БАРИЛГЫН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ БУУРАВ”

2021 онд эдийн засаг хүлээлтээс бага өсөлттэй гарсан бөгөөд цар тахлын өмнөх үе буюу 2019 оны түвшинд хүрсэнгүй. БНХАУ Ковид-19 цар тахлын дэглэмээ чангаруулан хилийн хязгаарлалт тогтоосны улмаас боомтууд дээр уул уурхай болон бусад бүтээгдэхүүний тээвэрлэлт удааширч, эдийн засгийн өсөлт саарахад голлох нөлөөг үзүүлэв.

Түүхий эд, бараа материалын нийлүүлэлт доголдож улмаар барилга болон боловсруулах салбарын үйлдвэрлэл буурлаа. Хөдөө аж ахуйн салбарын хувьд малыг тогтворжуулах бодлого, малын хөлийн албан татвар болон бусад хүчин зүйлийн улмаас буурав. Харин дотоодод хөл хорио суларч, вакцинжуулалт эхлэхтэй зэрэгцэн эдийн засгийн идэвхжил нэмэгдэн, худалдаа, үйлчилгээ, зочид буудал, нийтийн хоолны салбаруудын орлого мөн бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ өсжээ.



“ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ИРГЭД, АЖ АХУЙ НЭГЖҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭВ”

“Эрүүл мэндээ хамгаалах, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд зээл олголт нэмэгдлээ. Тухайлбал ЖДҮ эрхлэгчдийг дэмжих ажлын байрыг дэмжих зээл, Монголбанкны репо санхүүжилттэй зээл, хөдөө аж ахуйг дэмжих зээл болон орон сууцны ипотекийн хөтөлбөрийн зээлүүдийг олгосон бөгөөд үүний үр дүнд банкны системийн нийт зээлийн үлдэгдэл 2020 оны эцсээс 21.3 хувиар өсжээ.


Мөн банкнууд Монголбанкны шийдвэр, “Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-н дагуу ипотекийн хөтөлбөрийн зээлүүдийн хугацааг сунгаж, эргэн төлөлтийг хүү хуримтлуулахгүйгээр хойшлуулж ажиллав.



“ЭДИЙН ЗАСАГТ БОЛСОН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ”

Вакцинжуулалт эхлэв: 2021 оны байдлаар Монгол улсын нийт хүн амын 66.5 хувь нь дархлаажуулалтын 2 тун, 28.2 хувь нь 3 тун хийлгэжээ.

- Инфляц эрчимжив:** 2021 оны 12 дугаар сард Монгол улсын жилийн инфляцын түвшин 13.4 хувьд хүрсэн нь 2014 оны 8 сараас хойших дээд үзүүлэлт болов.
- Түүхий эдийн үнэ өсөв:** Дэлхийн зах зээлд түүхий эд, газрын тосны үнэ өсөв. 2021 онд Монгол улсын хувьд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тоо хэмжээгээр буурсан хэдий ч үнийн дүнгээр өмнөх оноос өсжээ.
- Хүү буурав:** 2020 онд бодлогын хүү түүхэн доод түвшинд хүрсэн бөгөөд банкны салбарын зээл, хадгаламжийн хүү мөн буурлаа. 2021 оны 12 дугаар сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.47 пунктээр буурчээ.



БАНКНЫ СЕКТОР


Манай улсын хувьд банкны салбар давамгайлсан зах зээлийн бүтэцтэй эдийн засагтай тул банкны салбарын эрүүл мэнд, тогтвортой байдал нь санхүүгийн системийн ерөнхий дүр зургийг харуулах чухал үзүүлэлт билээ.

Тайлант онд банкны секторын нийт актив жилийн **11.8** хувийн өсөлт үзүүлж **41.0** их наяд төгрөгт хүрлээ. Активын өсөлтийн **79.3** хувийг цэвэр зээл, үлдсэн **20.7** хувийг бусад активуудын өсөлт бүрдүүлжээ.

ЗЭЭЛ

Засгийн газраас хэрэгжүүлж буй "10 их наяд төгрөгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр"-ийн хөнгөлөлттэй зээлүүд, орон сууцны ипотекийн хөтөлбөр нь нийт зээлийн багцын тасралтгүй өсөлтийг дэмжсэнээр нийт зээлийн багц жилийн 21.3 хувиар өсөж 20.7 их наяд төгрөг боллоо. Нийт зээлийн багцын 50.3 хувь буюу 10.4 их наяд төгрөгийг иргэдийн зээл, 47.5 хувь буюу 9.8 их наяд төгрөгийг байгууллагын зээл эзэлж байна.

2020 оны эцэст банкны секторын чанаргүй зээлийн түвшин 11.8 хувь байсан бол 2021 оны IV улиралд 1.8 пунктээр буурч 10.0 хувь боллоо. Нийт чанаргүй зээлийн 49.2 хувийг байгууллагад олгосон зээл, 14.3 хувийг иргэдэд олгосон зээл, үлдсэн 36.4 хувийг бусад харилцагчийн сегментэд олгосон зээл бүрдүүлж байна. Чанаргүй зээлийн түвшний бууралтын шалтгаан нь нийт зээлийн багцын эрчимтэй өсөлт, ипотекийн хөтөлбөрийн зээлийн эргэн төлөлтийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлуулах болон төлбөрийн зөрчилтэй зээлд бүтцийн өөрчлөлт хийж хугацааг сунгах зохицуулалтын арга хэмжээг Монголбанкны зүгээс хэрэгжүүлсэнтэй холбоотой юм.



ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

Нийт хадгаламжийн хэмжээ 19.0 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хувь буюу 0.97 их наядар нэмэгдсэн үзүүлэлт юм. Нийт хадгаламжийн 79 хувь буюу 15.04 их наядыг төгрөгийн хадгаламж, үлдсэн 21 хувь буюу 3.97 их наядыг валютын хадгаламж эзэлж байна. Нийт төгрөгийн хадгаламжийн 89 хувийг иргэд, 11 хувийг байгууллага бүрдүүлж байгаа бол нийт валютын хадгаламжийн 82 хувийг иргэд, 18 хувийг байгууллага бүрдүүлж байна.

Нийт харилцахын дүн жилийн 38 хувиар өсөж 7.5 их наяд боллоо. Иргэдийн төгрөгийн харилцах 38 хувь буюу 1.29 их наяд төгрөг, байгууллагын төгрөгийн харилцах үлдсэн хувийг буюу 2.15 их наяд төгрөгийг бүрдүүлж байна. Иргэд болон байгууллагын валютын харилцахын хувьд өмнөх онтой харьцуулахад 41 хувь болон 15 хувиар тус тус өсөж 0.37 их наяд, 1.97 их наяд төгрөг болжээ.

АШИГТ АЖИЛЛАГАА

2021 онд банкны салбар 542.0 тэрбум төгрөгийн ашигтай буюу өнгөрсөн оноос 104 хувиар илүү ашигтай ажиллаа. Цар тахлын нөлөө буурч, эдийн засаг сэргэхтэй зэрэгцэн банкны ашигт ажиллагаа сайжирч байна. Банкууд ашигтай ажиллаж, банкнуудын өөрийн хөрөнгө нэмэгдэж байгаа нь банкны системийн эрсдэл даах чадварыг сайжруулж байна.



2021 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Худалдаа, хөгжлийн банк нь 2007 оноос хойш олон улсын зах зээлд нийт 1.14 тэрбум ам.доллартой тэнцэхүйц 5-н удаагийн бондыг амжилттай арилжаалж, харилцагчдадаа хөнгөлөлттэй зээл хэлбэрээр олгож, улсын гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийг тогтворжуулах болон худалдааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулжээ. Мөн олон улсын зах зээлд бонд арилжаалсан Монголын хамгийн анхны аж ахуйн нэгж төдийгүй, цорын ганц арилжааны банк.

Тайлант оны байдлаар Монгол улсад үйл ажиллагаа эрхэлдэг 42,400 гаруй байгууллага ХХБ-ны банкны бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглан бизнесээ өргөжүүлж

байна. Түүнчлэн банк санхүүгийн систем, байгууллагын зах зээлийн 46.4 хувийг ХХБ бүрдүүлж байна.

Мөн Монгол Улсын гадаад төлбөр тооцоо, худалдааны санхүүжилтийн үйлчилгээний 40 гаруй хувийг дангаар гүйцэтгэж байна. Энэ хүрээнд бид олон улсын нэр хүнд бүхий 300 гаруй банк, санхүүгийн байгууллагуудтай корреспондент банкны харилцаа тогтоон хамтран ажиллаж, тэдгээр банкуудад нээсэн 77 ностро дансаар дамжуулан 16 төрлийн валютаар дэлхийн аль ч улс руу гадаад гуйвуулга хийх үйлчилгээ үзүүлж байна. Түүнчлэн олон улсад төлөөлөгчийн газартайгаар салбартаа тэргүүлэн ажилладаг билээ.

42,400
байгууллага

Зах зээлийн
46.4

МУ-ын гадаад төлбөр тооцоо, худалдааны санхүүжилт

Зах зээлийн
40 гаруй хувь

Олон улсын
300 гаруй банк

Санхүүгийн байгууллага корреспондент харилцаа

77 ностро данс

160 төрлийн валют

2021 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

В3

Олон улсын үнэлгээний Moody's агентлаг ХХБ-ны үнэлгээг В3 түвшинд хэвээр үлдээж, хэтийн төлөвийг "Тогтвортой" болгон өсгөлөө.

Олон улсын хөрөнгө оруулалтын банкт хамтран **15 сая** ам.долларын урт хугацаат санхүүжилтийн гэрээг байгууллаа.

ОХУ-н тэргүүний банк болох Газпромбанкт "Хамтын ажиллагааны гэрээ" байгууллаа. Ийнхүү ОХУ болон МУ-н хамтран хэрэгжүүлэх мега төслүүдэд оролцогч талуудын төлбөр тооцоо, үүргийн хэрэгжилтийг хангах гэрээ, хэлэлцээрт банкны дэмжлэг үзүүлэх үйлчилгээг нэвтрүүллээ. Мөн хөрөнгө зохицуулалт, худалдааны санхүүжилт зэрэг өргөн хүрээтэй, урт хугацааны түншлэл эхлүүлээ.



ToC
2021 оны "Онцлох ToC Банк"-аар шалгарлаа.

Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн №20 дугаар тогтоолоор "Алт-2" үндэсний хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөрийн нийт санхүүжилтийн **84** хувийг олголоо.

ЗГ-аас хэрэгжүүлж буй "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө" хөтөлбөрт оролцож, нийт 17 харилцагчийн 76 тэрбум төгрөгийн "Хөдөө аж ахуйг дэмжих зээл"-ийг ноос ноолуур, газар тариалан, мах, гурил, арьс ширний салбарт үйл ажиллагаа эрхэлдэг харилцагчдад олголоо. Энэ нь хөтөлбөрийн нийт багцын **26.5%**-г эзэлж байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны №311 дугаар тогтоолоор Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдэд шатахууны нөөц бүрдүүлэх санхүүжилтийн зээл"-ийн хөтөлбөр баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд **100** тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аккредитив, Баталгааны хүсэлт болон Овердрафтын үйлчилгээг онлайнар хүлээн авах ажлыг 2022 онд нэвтрүүлж, ашиглалтад оруулахад бэлэн болсон.

Харилцагчийн цагийг хэмнэх, өөрөө өөртөө үйлчлэх дижитал боломжийг таниулах зорилгоор онлайн шугамын зээл, тодорхойлолтуудыг цахимаар авах талаар харилцагчдад шат дараалалтай мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллаа. Үр дүнд тайлант оны эцсээр **29.1 тэрбум** төгрөгийн зээлийг харилцагч өөрөө **Ти Ди Би** онлайн банк ашиглан авсан байна.

Банкны үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамж, систем, мэдээллийн сан, сүлжээ, холбоо, сервер, тоног төхөөрөмжүүд болон тэдгээрийн үйлдлийн систем, мэдээллийн аюулгүй байдал, ажилтны үйл ажиллагааны төлбөрийн картын системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах стандарт **PCI-DSS (Payment Card Industry Data Security)**-г 5 дахь жилдээ баталгаажууллаа.

Ти Ди Би онлайн системд **TDB Wallet**-г шинээр нэвтрүүлсэн. Уг боломжийн хүрээнд банкны харилцагч өөрийн дурын банкны картыг өөрийн **Wallet**-д бүртгэх, түүгээр дамжуулан шимтгэлгүй гүйлгээ хийх боломжтой боллоо.

Ногоон зээлийн хөтөлбөртөө ОУ-н эдийн засгийн хамтын ажиллагааны банк (IBEC)-с **10 сая** ам.долларын санхүүжилт татлаа.

VISA International байгууллагатай хамтын ажиллагаа эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан дэлхийд алдартай зураач Ромеро **BRITTO**-той хамтран, түүний бүтээлийг албан ёсны эрхтэйгээр картан загварт тусгайлан буулгасан, **BRITTO** ВИЗА цоо шинэ картыг зах зээлд нэвтрүүллээ.

Шамбала Инженеринг Кампус ХХК-тай хамтран **SHAMBALA 2056** инженерийн сууринг дэмжиж ажиллахаар боллоо.

Олон улсын банк болох стратегийн зорилгын хүрээнд даян дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх, ногоон банк болох зорилтуудыг тодорхойлж, тэдгээрийн биелэлтийг хангахад чиглэсэн **"Climate 30+ Ногоон Сэргэлтийн Хөтөлбөр"**-ийг санаачлан эхлүүлээ.

Монгол Банкны **"Репо санхүүжилтийн зээл"**, АХБ-ны **"Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил"**-ийн төслийн нэмэлт санхүүжилт, **"Ажлын байр нэмэгдүүлэх төсөл"**, **"ХБНГУлсын КФВ банкны санхүүжилттэй төсөл"**, **"ЖАЙКА төсөл"** зэрэг гадаад болон дотоод банк санхүүгийн байгууллагуудын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна. Банк нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол хангаж, олон улсын шаардлагыг биелүүлэн ажиллаж байгаа нь дээрх төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэх нөхцөл болж байна.

Стратеги зорилтын хүрээнд банкны томоохон байгууллагын харилцагч жижиг, дунд бизнес эрхлэгч нарыг дэмжих зорилгоор **"Нийлүүлэлтийн сүлжээний зээлийн эрх"**-ийн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүллээ.

Банкны зээл олголтын үйл ажиллагааг автоматжуулж иргэдийн зээл олголтын үйл ажиллагаанд **хиймэл оюун ухаан (AI), машин сургалт (Machine learning)**-д тулгуурласан харилцагчийн кредит скоринг тооцох моделийг сургаж үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Олон улсын гадаад гуйвуулгын **SWIFT** сүлжээний **SWIFT GPI** үйлчилгээг банкны үйл ажиллагаанд нэвтрүүллээ. Ингэснээр гадаад шилжүүлгийг бодит цагийн горимоор хянах, буцаан дуудах хүсэлт илгээх, хүлэн авах, шилжүүлгийн гүйлгээ эцсийн хүлээн авагчид очих, гүйцэтгэгдэх хугацааг багасгах, харилцагчид тухай бүр нь гүйлгээтэй холбоотой мэдээллийг мэдэгдэх давуу тал үүслээ.

Монголбанкнаас хэрэгжүүлж буй **₮** картыг чип технологитой болгох ажлын хүрээнд ХХБанк манлайлан оролцож **₮** чип картан баталгаажуулалтыг гуравдагч байгууллагаар амжилттай хийлгэлээ. 2021.10.01-ний өдрөөс эхлэн дотоодын **₮** чип картыг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Харилцагчийн санал хүсэлтийг хүлээн авах нэгдсэн портал болох **EAPP** онлайн хүсэлтийн системийг шинээр үйл ажиллагаанд нэвтрүүлэв.

САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН

ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТУСДАА САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тэрбум төгрөгөөр		
	2019	2020	2021
Хөрөнгө			
Бэлэн мөнгө ба Монголбанкн дахь мөнгөн хөрөнгө	1,096.1	857.0	976.4
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь мөнгөн хөрөнгө	301.4	570.0	504.4
Санхүүгийн хөрөнгө оруулалт	1,832.6	1,712.0	2,602.6
Охин болон хараат компани дахь хөрөнгө оруулалт		40.8	0.5
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	494.9	89.4	101.6
Зээл ба урьдчилгаа	3,503.2	4,108.7	4,588.5
Бусад хөрөнгө	103.8	112.7	200.1
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	80.9	149.0	79.9
Борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгө		4.1	3.6
Үндсэн хөрөнгө, цэвэр	392.3	458.6	480.8
Ашиглах эрхтэй хөрөнгө	12.7	10.1	7.9
Биет бус хөрөнгө, цэвэр	5.8	4.4	2.3
НИЙТ ХӨРӨНГӨ	7,823.7	8,116.8	9,548.7
Өр төлбөр			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	189.4	102.9	13.9
Буцаан худалдаж авах гэрээгээр борлуулсан үнэт цаас	65.0	224.3	289.8
Харилцагчдын харилцах, хадгаламж	3,821.4	5,311.5	6,266.3
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	76.2	99.7	78.0
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	759.3	558.7	1,408.7
Хоёрдогч өглөг	150.0		-
Гаргасан өрийн үнэт цаас	1,536.5	160.1	160.1
Бусад өр төлбөр	508.6	628.4	289.1
Түрээсийн өр төлбөр	13.6	11.4	9.0
Орлогын татварын өглөг		0.1	12.5
Хойшлогдсон татварын өглөг		2.2	1.0
НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,120.0	7,099.3	8,528.6
Өөрийн хөрөнгө			
Хувьцаат капитал	50.0	72.7	323.8
Нэмж төлөгдсөн капитал	19.3	251.1	-
Дахин үнэлгээний нөөц	129.2	169.0	151.2
Борлуулах боломжит санхүүгийн хөрөнгийн хуримтлагдсан хэрэгжээгүй олз (гарз)	22.2	24.1	4.4
Тусгай зориулалттай нөөц			54.6
Хуримтлагдсан ашиг	483.0	500.6	486.2
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	703.7	1,017.5	1,020.1
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	7,823.7	8,116.8	9,548.7

ТУСДАА ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	2019	2020	2021
Хүүгийн орлого	701.6	707.9	597.1
Хүүгийн зардал	(521.7)	(506.2)	(405.6)
Хүүгийн цэвэр орлого	179.9	201.7	191.5
Шимтгэл, хураамжийн цэвэр орлого	40.4	39.4	44.4
Үйл ажиллагааны бусад орлого (алдагдал), цэвэр	32.1	(5.7)	(13.4)
Хүүгийн бус цэвэр орлого	72.5	33.7	31.0
Үйл ажиллагааны орлого	252.4	235.4	222.5
Үйл ажиллагааны зардал	(129.9)	(131.6)	(130.9)
Үнэ цэнийн бууралтын нөөцийн алдагдал	(58.1)	(64.7)	57.7
Хараат компанийн алдагдлаас ногдох хувь		(14.5)	(28.7)
Татварын өмнөх ашиг	64.4	24.6	120.5
Орлогын татварын зардал	-	(3.6)	(15.7)
Тайлант жилийн цэвэр ашиг	64.4	21.0	104.8

ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2019	2020	2021
Ашигт ажиллагаа			
Зардлын орлогод эзлэх хувь	51.5%	55.9%	58.8%
Цэвэр хүүгийн зөрүү	3.1%	3.5%	2.9%
Өөрийн хөрөнгийн өгөөж	9.1%	2.1%	10.3%
Активын өгөөж	0.8%	0.3%	1.1%
Өсөлтийн харьцаанууд			
Активын өсөлт	7.4%	3.7%	17.6%
Зээлийн өсөлт	14.7%	17.3%	11.7%
Харилцах, хадгаламжийн өсөлт	8.5%	39.0%	18.0%
Өөрийн хөрөнгийн өсөлт	-24.2%	44.6%	0.3%
Активын чанар			
Зээл / Харилцах, хадгаламж	91.7%	77.4%	73.2%
Зээлийн активт эзлэх хувь	44.8%	50.6%	48.1%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	32.1%	39.3%	40.6%
Өөрийн хөрөнгийн харьцаа			
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ	11.4%	14.8%	13.0%
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	17.0%	16.4%	13.0%

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Бид бизнесийн үйл ажиллагаандаа тогтвортой, хариуцлагатай байдлыг чухалчлан байгаль орчинд ээлтэй бизнесийг дэмжин санхүүжүүлэх замаар урт хугацааны тогтвортой хөгжлийг бий болгох, зөв жишгийг нийгэмдээ бүтээхээр ажилладаг.

2012 онд Нидерландын Хөгжлийн Банк (FMO)-тай хамтран “Байгаль орчин, нийгмийн хариуцлагын эрсдэлийн менежментийн систем” (БОНХМС)-ийг Монгол Улсад цогцоор нь хэрэгжүүлсэн анхны банк юм. 2013 оны 11-р сард арилжааны банкнууд “Монгол улсын Тогтвортой Санхүүжилт (ТоС) - ийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хамтарсан тунхаг бичигт нэгдсэн. Энэхүү үйл явдал манай улсын ирээдүйн хөгжлийн томоохон дэвшил болсныг онцлон тэмдэглэж байна. Арилжааны банкнууд нэгдэн ажилласнаар амьдрах орчин болох ус, хөрс, агаарын бохирдол, цаг уурын өөрчлөлт, хүний эрхийг зөрчсөн асуудлуудын эсрэг бат зогсож, байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах замаар тогтвортой хөгжлийг бий болгох хэтийн зорилго өөд тэмүүлж байна.

2020 онд Банк шинэ бүтэц зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа эрхэлж Ногоон санхүүжилтийн албыг (НСА) Олон улсын банкны газрын Гадаад эх үүсвэрийн удирдлага, хяналтын хэлтсийн харьяанд шинээр байгуулсан. НСА нь олон улсын сайн туршлагыг банканд нэвтрүүлэх, төсөл хөтөлбөрт хамтын санхүүжилт татах чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.



БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО

ХХБанкны байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлогын хүрээнд бид МУ-ын зохих хууль тогтоомж болон дүрэм зааврыг баримталж ажилладаг. Мөн дараах зарчмуудыг хэрэгжүүлж, дагаж мөрдөхийг зорьж байна.

- НҮБ-ын Даян дэлхийн гэрээний арван зарчим
- НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүгийн санаачилга: Байгаль орчны болон тогтвортой хөгжлийн талаарх санхүүгийн байгууллагуудын тунхаглал
- Үндэстэн дамнасан корпорац болон нийгмийн бодлогын талаарх Олон улсын хөдөлмөрийн байгууллагын зарчмын гурван талт тунхаглал
- Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)-ийн Гүйцэтгэлийн найман стандарт
- МУ-ын Тогтвортой санхүүгийн холбоо (ТоС холбоо)-ны Тогтвортой санхүүжилтийн найман зарчим
- Бүс ба Зам санаачилгын Ногоон хөрөнгө оруулалтын долоон зарчим



ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН БОДЛОГО

2019 онд бүрэн шинэчлэгдсэн “Жендерийн эрх тэгш байдлын бодлого”-ыг олон улсын стандартын дагуу бэлдэн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Уг бодлогоор эрх тэгш байдлыг хангахын төлөө шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх, жендерийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг чадавхжуулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх, мэдлэгийг бий болгох, жендерийн харьцааг тэнцвэржүүлэх, ялган гадуурхалтаас сэргийлэхэд оршино.

Энэхүү бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг МУ-ын Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр болон бусад олон улсын байгууллагуудын тэргүүн туршлагыг харгалзсан ба НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын Жендерийн эрх тэгш байдлыг хангах зорилго, зорилтуудыг дэмжин ажиллахаар зохицуулагдсан болно. Түүнчлэн МУ-ын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021 он), Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагийн жендерийн бодлого (2016-2024)-д нийцсэн болно.



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХАМТДАА

ХХБ нь Монгол Улсад тогтвортой санхүүжилтийг дэлгэрүүлэх зорилгоор Бизнесийн ногоон зээлийн бүтээгдэхүүн болон Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэв. 2020 оноос хойш ХХБ нь Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг хэрэгжүүлж байгаа ба эдгээрээс дөрөвт нь (Чанартай боловсролыг дэмжих, Жендерийн эрх тэгш байдлыг хангах, Зохистой хөдөлмөр эрхлэлт ба эдийн засгийн өсөлтийг дэмжих, Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах)

онцлон хувь нэмрээ оруулахаар тодорхойлсон билээ. 2021 оны байдлаар ХХБ тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд 1.29 их наяд төгрөгийн зээлийг олгожээ. ХХБ нь Монголбанк, Олон улсын санхүүгийн корпорац, Монголын тогтвортой санхүүжилтийн холбооноос хамтран гүйцэтгэдэг ТоС-ын хэрэгжилтийн үнэлгээнд “А” үнэлгээ авч 2021 оны Онцлох ТоС банк, 2022 оны Тогтвортой санхүүжилтийн Манлайлагч байгууллагаар шалгарав.



Тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд 1.29 их наяд төгрөгийн зээл олгов



Монгол улсад тогтвортой болон ногоон санхүүжилтийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх Бэлэн байдлын хөтөлбөрийг Уур амьсгалын ногоон сангийн Удирдах зөвлөлөөр батлуулав



2021 оны Онцлох ТоС банк, 2022 оны Тогтвортой санхүүжилтийн Манлайлагч байгууллага




Олон талт хөгжлийн банкнууд болон санхүүгийн байгууллагын түнш боллоо

Тогтвортой хөгжлийн зорилтуудаас дараах дөрвөн зорилгыг үйл ажиллагаандаа тусгайлан тусгаж хэрэгжүүлж байна

4 ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ



5 ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ



8 ЗУВИН ЗАСГИЙН ӨСӨРТ БАЛГАХАТ ИХЭМЖ БАЙРАГ ЭНГ БОГТОХ



13 ҮҮР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БАГААСГАХ



20

21



ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ 4

ЗОРИЛГО

- 4.1 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд үнэ төлбөргүй, тэгш, чанартай бага болон дунд шатны боловсролыг эзэмшиж, холбогдох, үр дүнтэй эрдэм мэдлэгтэй болсон байх
- 4.3 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүнд хямд үнэтэй, чанартай техникийн, мэргэжлийн болон дээд боловсрол, түүний дотор их дээд сургуулийн боловсролыг тэгш авах боломжийг бүрдүүлэх
- 4.5 2030 он гэхэд боловсролын байгууллагад суралцагсдын жендерийн зохистой харьцааг хангаж, эмзэг бүлэг, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, нутгийн уугуул хүмүүс, эмзэг бүлгийн хүүхдүүдэд бүх шатны боловсрол, мэргэжлийн сургалтыг тэгш авах боломжийг бүрдүүлэх
- 4.7 2030 он гэхэд тогтвортой хөгжлийн мэдлэг, тогтвортой амьдралын хэв маяг, хүний эрх, жендерийн тэгш байдал, энх тайван болон хүч үл хэрэглэх соёлыг төлөвшүүлэх, дэлхийн иргэн байх, соёлын олон янз байдал болон тогтвортой хөгжилд соёлын оруулж буй хувь нэмрийг ойлгуулах мэдүүлэх замаар тогтвортой хөгжлийг дэмжихэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг бүх суралцагчдад олгох

2021 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД

Хязгааргүй мөрөөдөл төслийн хүрээнд гурван сургуулийн номын санг тохижуулж, **6100** гаруй хүүхдүүдийн боловсролд хувь нэмэр орууллаа.

Тайлант хугацаанд тогтвортой хөгжлийн дотоод сургалтад давхардсан тоогоор нийт мянга гаруй ажилтан хамрагдсан байна. Үүнд:

- a. Тогтвортой санхүүжилт, уур амьсгалын өөрчлөлтийн сургалт
- b. Ногоон болон нийгмийн зээлийн сургалт
- c. Жендер ба манлайлал сургалт
- d. Шинэ харилцааны менежерүүдэд Байгаль орчин, нийгмийн хариуцлагын үнэлгээ, Жендерийн эрх тэгш байдлын бодлогын талаарх сургалт
- e. Газар, хэлтсүүдийн удирдлагуудад Жендерийн эрх тэгш байдал, Жендерийн мэдрэмжтэй менежментийн сургалт

Нийт ажилтнуудад зориулан Тогтвортой хөгжил, тогтвортой санхүүжилтийн талаар мэдлэг олгох цуврал мэдээлэл, олон нийтэд зориулан Тогтвортой санхүүжилтийн товхимол бэлтгэн хүргүүлээ.



ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ 5

ЗОРИЛГО

- 5.1 Бүх эмэгтэйчүүд, охидыг ялгаварлан гадуурхах явдлыг таслан зогсоох
- 5.5 Улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хүрээнд шийдвэр гаргах бүх үе шатанд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор эмэгтэйчүүдийг хангах
- 5.c Бүх түвшинд жендерийн тэгш байдлыг хөхүүлэн дэмжих, бүх охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх хүчирхэгжүүлэх зохистой бодлого, хэрэгжиж болох хууль тогтоомжийг батлан сайжруулах

2021 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД

- Жендерийн хороогоо шинэчлэн байгуулж, байгууллагын бүхий л түвшинд Жендерийн эрх тэгш байдлын бодлогын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ХХБ нь үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах замаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үр дүнтэй оролцоог жендерийн мэдрэмжтэйгээр дэмжихэд хувь нэмэр оруулсаар байгаа билээ. Мөн Монгол дахь эмэгтэй удирдлагатай жижиг, дунд бизнесүүдийг тусгай хөтөлбөр хэрэгжүүлэн дэмжиж байна.
- 2021 оны эцсийн байдлаар Банкны нийт ажилтнуудын **61** хувь нь эмэгтэй, **39** хувь нь эрэгтэй байна. Түүнчлэн Банкны дунд түвшний ажилтнуудын **54** хувь нь эмэгтэй, **46** хувь нь эрэгтэй байна.
- 2021 оны эцсийн байдлаар ХХБ-ны томоохон харилцагч байгууллагуудын гүйцэтгэх захирлуудын 33 хувь нь эмэгтэй, 67 хувь нь эрэгтэй байхад жижиг, дунд бизнесийн сегментийн харилцагчдын гүйцэтгэх захирлуудын 35 хувь нь эмэгтэй, 65 хувь нь эрэгтэй байна. Түүнчлэн, ХХБ-аас бизнесийн зээлийн бүтээгдэхүүн олгосон иргэдийн 73 хувь нь эмэгтэй, 27 хувь нь эрэгтэй байгаа бол банкнаас иргэдийн зээлийн бүтээгдэхүүн олгосон иргэдийн 52 хувь нь эмэгтэй, 48 хувь нь эрэгтэй байна.
- ХХБ-ны Жендерийн хорооны харьяа "Жендер Нетворкинг Клуб"-ыг үүсгэн байгуулж жендерийн талаарх мэдлэг, мэдээллийг түгээх, ажилтнуудын оролцоог хангах зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийт ажилтан
61% эмэгтэй
39% эрэгтэй



Бизнесийн зээл олгосон иргэд
73% эмэгтэй
27% эрэгтэй





ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ 8


ЗОРИЛГО

- 8.3 Бүтээмжтэй үйл ажиллагаа, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдал, инновацыг дэмждэг хөгжлийн чиг баримжаатай бодлогыг хөхүүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох замаар бичил, жижиг, дунд бизнесийг албан ёсны болгож, тэдгээрийн өсөлтийг дэмжих
- 8.10 Хүн бүрд банк, даатгал, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг хүргэж өргөжүүлэх, түүнийг дэмжих дотоодын санхүүгийн институтын чадавхыг бэхжүүлэх

2021 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД

"COVID-19" цар тахал МУ-ын эдийн засгийн байдалд сөрөг үр дагаврыг гаргаж байгаа ч ХХБ нь цар тахалтай холбоотой гэнэтийн эрсдэлийг нэлээд сайн зохицуулж ажиллаж байна. Тухайлбал:

- 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ХХБ нь бусад арилжааны банкнуудтай харьцуулахад өөрийн хөрөнгийн хэмжээ, нийт зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээ, нийт хадгаламжийн хэмжээ зэргээр хоёр дугаарт эрэмбэлэгдэж байна. Мөн, ХХБ нь МУ-ын бараг бүх салбар дахь 400 орчим томоохон аж ахуй нэгжид үйлчилгээ үзүүлдэг ба тайлант хугацаанд нийт 93 салбар, тооцооны төв, 282 бэлэн мөнгөний АТМ болон 9,896 ПОС терминалаар дамжуулан үйл ажиллагаа явуулж байна.
- 2021 оны эцсээр 1,281.4 тэрбум төгрөгийн бизнесийн зээлийг нийт давхардсан тоогоор 334 томоохон харилцагч байгууллагад олгосон. Ойролцоогоор 297.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нийт 1,941 жижиг болон дунд бизнест олгосон. Харин 1.065 их наяд төгрөгийн санхүүжилтийг нийт 55,502 иргэнд олгосон байна.
- 2020 оноос хойш ХХБанк нь иргэдэд зориулсан хэрэглээний ногоон зээлийн бүтээгдэхүүнийг өөрсдийн эх үүсвэрээр гаргаж эхэлсэн. 2021 оны 4-р улирлын байдлаар ХХБ нь ойролцоогоор 3.8 тэрбум төгрөгийн ногоон зээлийг 543 иргэдэд олгосон байна.
- Банкны бизнесийн ногоон зээлийн багцын хувьд, 2021 оны 4-р улирлын байдлаар банкнаас нийт 37.56 тэрбум орчим төгрөгийн бизнесийн ногоон зээл олгогдсон. Энэ нь 2021 оны 3-р улиралтай харьцуулахад 19.8%-ийн өсөлттэй үзүүлэлт юм. Банкны бизнесийн ногоон зээлийн багц нь цаашид 2022 ондоо үргэлжлүүлэн өсөх хандлагатай байна.
- Мөн 2021 оны 4-р улирлын байдлаар ХХБ-ны нийгмийн шинж чанартай зээлийн хэмжээ 1.26 их наяд төгрөг буюу 441.02 сая ам.доллартай тэнцэж байна. Тус үзүүлэлтийг 2021 оны 1-р улиралд олгосон нийгмийн шинж чанартай зээлийн хэмжээтэй харьцуулахад ХХБ-ны нийт нийгмийн зээлийн багц нь 58.4%-аар өссөн байна.



УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БАГАСГАХ 13

ЗОРИЛГО

- 13.3 Цаг уурын өөрчлөлтийг багасгах, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох, цаг уурын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, урьдчилан сэрэмжлүүлэх талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж, хүмүүсийн болон институтын чадавхыг сайжруулах
- 13.a Эрсдэлийг бууруулах үндсэн арга хэмжээ болон түүний хэрэгжилтийн талаарх ил тод байдлын хүрээнд хөгжиж буй орнуудын хэрэгцээ шаардлагыг хангах, Ногоон цаг уурын сангийн үйл ажиллагааг тус санд хуримтлагдсан хөрөнгийг ашиглан аль болох хурдан бүрэн эхлүүлэх зорилгоор бүх төрлийн эх үүсвэрээс 2020 он гэхэд жил бүр 100 тэрбум ам.долларыг хамтран бүрдүүлэх зорилтын үүднээс НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцыг хэрэгжүүлэхээр хүлээсэн хөгжингүй улс орнуудын үүрэг амлалтыг биелүүлэх

2021 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД

- Green Hour - өдөр бүр 1 цаг гэрлээ унтрааж эрчим хүчээ хэмнэх аяныг санаачлан ажилласан.
- Банкандаа хаягдал зай хураагуур болон хуванцар савны зориулалтын хогийн сав байршуулан хог хаягдлыг ялгах үйл ажиллагааг байнгын хадгалж байна. Хураагдсан аюултай хог хаягдлыг "Монголын Хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо" болон "Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв"-д хүргүүлдэг.
- Тогтвортой, ногоон санхүүжилтийг хөгжүүлэх ажлын хүрээнд Монголдоо анхлан "Тогтвортой санхүүжилтийн хүрээ" баримт бичгийг боловсруулан гаргав. Энэхүү баримт бичигт ногоон болон нийгмийн зээлийн шалгуурыг тодорхойлон заасан төдийгүй ногоон эх үүсвэрийн ашиглалт, төслийн үнэлгээ ба сонгон шалгаруулалт, үнэлгээ ба тайлагналын үйл ажиллагааг бүрэн зохицуулах боломжтой болох юм. Банк нь өөрийн Тогтвортой санхүүжилтийн хүрээг Ногоон бондын зарчим, Нийгмийн бондын зарчим болон Тогтвортой хөгжлийн бондын удирдамжтай нийцэж байгаа эсэх дээр хөндлөнгийн үнэлгээ «SPO» (Second-party opinion) гаргуулсан анхны байгууллага юм (Хөндлөнгийн үнэлгээг Moody's-ийн хараат компани V.E /Vigeo Eiris/-ээр гаргуулсан).
- 2021 онд анхны "Ногоон санхүүжилтийн форум"-ыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Монголбанк болон бусад харилцагч, хамтран ажиллагч байгууллагуудын оролцоотойгоор амжилттай зохион байгуулав. Мөн Монголын төр, хувийн хэвшлийн байгууллага дундаас анх удаа тогтвортой хөгжлийг цогцлооход хувийн хэвшлийн хувь нэмэр, үүрэг оролцоог нэмэгдүүлэх үндсэн зорилготой "Climate 30+" Ногоон сэргэлтийн хөтөлбөрийг санаачлан, хөгжүүлэлт дээр ажиллаж байна.
- БОАЖЯ-аас зохион байгуулсан "Хүлэмжийн хийн тооцоолуур"-ыг хөгжүүлэх ажилд ToC холбоотой хамтран хөгжүүлэлтэд туслалцаа үзүүлж ажиллаа. Монгол улсад тогтвортой болон ногоон санхүүжилтийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх Бэлэн байдлын хөтөлбөрийг Уур амьсгалын ногоон сангийн Удирдах зөвлөлөөр батлуулав.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



НЭГ ХААЛГА НЭГ ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газраас тайлант оны 2-р сард “Нэг хаалга-Нэг шинжилгээ” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан. Энэхүү ажилд эрүүл мэндийн салбарынхан манлайлж, **1900** гаруй эмч, эмнэлгийн албан хаагч **24** цагаар 12 хоногийн **500** гаруй мянган шинжилгээ хийж, хариуг нь гарган ажилласан. Монгол улсад ковид-19 вирусийн эсрэг вакцинжуулалтыг эхлүүлэх үндсэн суурь болсон энэхүү ажлыг ХХБ дэмжин ажилласан юм.



ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ТЭРГҮҮН ЭГНЭЭНД ТЭМЦЭГЧИД

Тайлант оны 5-р сард ХХБ Эрүүл мэндийн яамтай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан. Санамж бичгийн хүрээнд **эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилтнуудад банкны бүх төрлийн бүтээгдэхүүн болон ипотекийн зээлийн хүсэлтийг очер дараалалгүй хүлээн авч үйлчлэхээр** болсон билээ. Мөн олон улсын сувилалчдын өдрийг тохиолдуулан Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг болон Сүхбаатар Эрүүл Мэндийн Төвийн хамт олонд талархал илэрхийлж, урам өгөх гарын бэлэг гардуулсан юм.



БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС ХАМТ ОЛНОО ХАМГААЛЪЯ!

Ковид-19 цар тахлын үед нийт давхардсан тоогоор **16000** гаруй удаа түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч ажилтнуудаа болзошгүй эрсдэлээс хамгаалж ажиллаа.



ИТГЭЛ НАЙДВАР, БОЛОМЖ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, тэдэнд урам зориг, эрч хүч, өөртөө итгэх итгэлийг нь нэмэгдүүлэх **«Итгэл найдвар, Боломж»** марафон гүйлтийн тэмцээнийг ХХБ уламжлал ёсоор ивээн тэтгэж, дэмжин ажиллаа. Тус тэмцээнийг жил бүр Achilles International Mongolia олон улсын байгууллага зохион байгуулдаг.



НЭГ ТЭРБУМ МОД

Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх зорилготой “Нэг тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд **ХХБ-ны хамт олон нэгдэж, “СХД, Бумбатын булаг” орчимд мод тарьсан** юм. Байгаль дэлхийд үнэлж баршгүй хөрөнгө оруулалт болсон мод тарих үйлсэд бүх нийтээрээ нэгдэж, зөв ургуулан арчлахыг уриаллаа.



ХЯЗГААРГҮЙ МӨРӨӨДӨЛ

Хүүхэд багачуудын тав тухтай орчинд сурч, хөгжих нөхцөлийг бүрдүүлэх зорилготой “Хязгааргүй мөрөөдөл” төслөө амжилттай үргэлжлүүлсээр байна. Тайлант онд нийслэлийн ЕБ-ын 1-р сургууль, 93-р сургууль болон АШУҮИС-н харьяа ЕБ-ын ахлах сургуулиудын номын санг тохижуулан номын фондыг баяжуулж өглөө. Ийнхүү төслийн хүрээнд нийт **47** сургуулийн **140,441** сурагч хүүхдүүд, **5038** орчим багш сурган хүмүүжүүлэгчийн мэдлэг боловсролд бодит хувь нэмрээ оруулаад байна.

ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Худалдаа, хөгжлийн банк нь салбарынхаа түүчээ болж нийгмийн хариуцлага, гадаад харилцаа, тогтвортой хөгжлийн бодлого, хүний нөөцийн бодлогоороо манлайлдаг нь бидний бахархал. Бид банкныхаа шинэчилсэн стратегитай холбоотойгоор хүний нөөцийн урт хугацааны стратегийн зорилгоо тодорхойлон **талент менежмент**ийг хэрэгжүүлж ажиллав.


Дөрвөн мянга гаруй ажил горилогчид Худалдаа, хөгжлийн банканд орох хүсэлтээ ирүүлж, бид олон улсын жишигт нийцсэн сонгон шалгаруулалтын зарчмаар 350 гаруй шилдэг ажил горилогчдыг банкандаа авч, сургаж хөгжүүлэн, найдвартай ажлын байраар хангалаа. Ажилтнуудынхаа карьер хөгжлийг тасралтгүй, үр өгөөжтэй байлгах зорилгын дагуу 370 гаруй ажилтнаа босоо болон хөндлөн чиглэлд албан тушаал дэвшүүлэн томилохдоо ХХБанкны жендерийн эрх тэгш байдлын бодлогыг хэрэгжүүлэн, хүйсийн харьцааг тэнцвэртэй хангаж ажиллав.


Банкны ололт амжилтын тулгуур болсон үнэ цэнтэй 2300 ажилтныхаа сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, цалин хөлс, урамшууллын оновчтой системийг нэвтрүүллээ. Цалин, хөлс, урамшууллын системээ шинэчилснээр ажилтанд цалин хөлсний өөрчлөлтүүд ил тод, ойлгомжтой болов. Мөн ажилтан бүрд цалин, хөлсөө нэмэгдүүлэх боломж нээлттэй, шударга болсноор илүү сэтгэл ханамжтай ажиллах нөхцөл бүрдсэн. Ажилтнууд ажлын байран дээрээ илүү мэргэшин, мэдлэг, ур чадвараа хөгжүүлэн ажилласнаар шаардлагатай нэмэгдлүүдийг авах боломжтой боллоо. Мөн нийт ажилтнууд цалингаа өсгөх боломжоор хангагдлаа.


Ажилтнуудаа тасралтгүй хөгжүүлэх, мэргэшүүлэх Банкны алсын хараа, эрхэм зорилго, урт хугацааны зорилтуудтай уялдуулан ажлын байрны зорилго, зорилтод хүрэхэд шаардлагатай чадамжуудыг тодорхойлох **“ХХБ-ны Чадамжийн толь бичиг”**-ийг боловсруулан, үйл ажиллагаандаа нэвтрүүлэв. Ингэснээр ажилтнуудын чадамжийг хөгжүүлэх замаар бизнесийн тогтвортой өсөлтийг ханган ажиллах боломжийг бүрдүүллээ. Чадамжийн толь бичиг дээр үндэслэн ажилтнуудын чадамжийн өнөөгийн түвшнийг үнэлэн, цаашид хөгжүүлэх ур чадвар, арга барилуудыг тодорхойлж байна. Мөн цаашид хүрэх зорилтод түвшин буюу банкны шаардлагыг танилцуулж, ажилтнаа сургаж хөгжүүлж, карьерын зураглалыг боловсруулан ажиллаж байна.

Банкны үнэлгээний тогтолцоог дахин загварчлан, боловсруулж **Чадамжийн үнэлгээг** хийж, гүйцэтгэв. Ажилтанд тавигдах мэдлэг, ур чадварын шаардлагыг тодорхойлсноор өндөр чадамжтай хүний нөөцийг бүрдүүлж банкны бизнесийн үр ашигт эерэг үр дүнг бий болгож ажиллав.

Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор **“Эрүүл мэндийн багц”** шинжилгээнд хамруулж ажилласан. Мөн Ковид-19 цар тахлын үед нийт давхардсан тоогоор **16000** гаруй удаа түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч болзошгүй эрсдэлээс ажилтнуудаа урьдчилан сэргийллээ.

 **350+**
хүнийг ажлын
байраар хангалаа

 **370+**
гаруй ажилтнаа албан
тушаал дэвшүүллээ

 **2300**
ажилтан цалин, хөлсөө нэмэгдүүлэх
боломж нээлттэй боллоо

СУРГАЛТ, ХӨГЖИЛ

Банкны стратеги, ажилтнуудын сургалт хөгжлийн хэрэгцээнд үндэслэн гадаад, дотоодын сургалтуудад давхардсан тоогоор 15292 ажилтныг 28 төрлийн 300 гаруй удаагийн сургалтад хамруулж мэдлэг, ур чадварыг хөгжүүллээ. Мөн стратегитай уялдсан сургалтын хөтөлбөрүүдийг шинээр бий болгон нийт ажилтнуудын **60%**-ийг тус сургалтуудад хамруулан ажиллав.

Банк нь Олон улсын банк болох урт хугацааны стратеги зорилтын хүрээнд гадаад хэлний F мэргэшсэн төвүүдтэй хамтран ажиллаж нийт ажилтны **10%**-ийг модуль сургалтад хамрууллаа.

Сургалт, хөгжлийн цогц моделийг боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн сургалт, хөгжлийн оновчтой хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, байнгын тасралтгүй сургалт, хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэв.

Ажилтнуудынхаа сургалт, хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг оновчтой тодорхойлох, сургалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор сургалтын үр өгөөжийг тооцож, хэмжиж эхлэв. Сургалтын үр өгөөжийг тооцоолон цаашдын сайжруулах шаардлагатай процесс болон асуудлуудыг тодорхойлон үүний үр дүнд банкны гүйцэтгэл, бүтээмжид эергээр нөлөөлж эхлэв.



Давхардсан тоогоор

15292 ажилтан **28** төрөл **300+** удаа сургалт




ХОЁРДУГААР БҮЛЭГ

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

БАЙГУУЛЛАГЫН ЗАХ ЗЭЭЛ

Худалдаа хөгжлийн банк нь байгууллагын хэрэглэгчдийн зах зээл, тэр дундаа томоохон бизнесүүд дээр төвлөрөн ажиллаж ирсэн бөгөөд 2021 онд ХХБ-ны Байгууллагын банкны газар нь зах зээлд тэргүүлэгч байр сууриа хадгалж, улам тэлсэн жил болж өнгөрлөө.



ХХБ-ны шинэ стратегийн хүрээнд шинэ бүтэц зохион байгуулалтад шилжин, бүтэн нэг жилийг үдлээ. Энэ хугацаанд байгууллагын сегментийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, цар тахлын үед харилцагч байгууллагуудаа халамжлах, хүндрэл бэрхшээлийг даван туулахад нь дэмжлэг үзүүлэх, түргэн шуурхай, найдвартай үйлчилгээг үзүүлэхэд анхаарч ажиллаа.

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол улс төдийгүй дэлхий дахинд Цар тахлын нөлөөгөөр амаргүй жил өнгөрсөн хэдий ч Байгууллагын банкны газар нь төсөв, төлөвлөгөөндөө хүрч, багцын өсөлт үзүүлсэн жил болов. Нийт зээлийн багцаар зах зээлд эзлэх хувь 46.4% болсон байна.








2021 онд нийт **1800** гаруй байгууллагын харилцагчид **40** гаруй төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож, харилцан ашигтай хамтран ажилласан байна. Мөн түүнчлэн Харилцагч төвтэй банк болох зорилтын хүрээнд ББГ-ын харьяа Байгууллагын хамтын ажиллагааны хэлтсийн байгууллагын сегмент хариуцсан Харилцааны менежерүүдээрээ дамжуулан сегментийн харилцагчдын хэрэгцээнд нийцсэн, тэдний онцлогт тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож, харилцагчид улам ойртон ажиллаа.

ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ



НОГООН СЭРГЭЛТИЙН ХӨТӨЛБӨР

ХХБ нь Олон улсын банк болох стратегийн зорилгын хүрээнд даян дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх, Ногоон банк болох гэсэн зорилтуудыг тодорхойлж, эдгээрийн биелэлтийг хангахад чиглэсэн "Climate 30+ Ногоон сэргэлтийн хөтөлбөр"-ийг санаачлан эхлүүлээд байгаа билээ. Байгууллагын сегментийн харилцагчдад Тогтвортой ус хаягдлын хэрэглээ, Эрчим хүчний хэмнэлт, Бохирдлоос сэргийлэх бууруулах чиглэлийн хүрээнд нийт 29.3 тэрбум төгрөгийн ногоон зээлийг олгосон байна.



ХӨДӨӨ АЖ, АХУЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Эдийн засаг, зах зээлд үзүүлж буй цар тахлын нөлөөллийг бууруулах, бизнес эрхлэгчдийг дэмжих, эдийн засгийг сэргээх, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцож, харилцагчдаа дэмжиж ажиллаж байна.

Үүний хүрээнд ЗГ-аас хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө” хөтөлбөрт оролцож, нийт 17 харилцагчийн 76.0 тэрбум төгрөгийн “Хөдөө аж ахуйг дэмжих зээл”-ийг ноос ноолуур, газар тариалан, мах, гурил, арьс ширний салбарт үйл ажиллагаа эрхэлдэг харилцагчдад олгоод байна. Энэ нь хөтөлбөрийн нийт багцын **26.5%**-г эзэлж байна.




АЛТ ХӨТӨЛБӨР

ББГ нь хямд өртөг бүхий, урт хугацаатай санхүүжилтийг олгож, харилцагч байгууллагуудын санхүүгийн зардлыг бууруулж, төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх, цаашлаад харилцагчдынхаа санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор дараах хөтөлбөрүүдэд оролцож байна.

Үүнд:

1. Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн №20 дугаар тогтоолоор “Алт-2” үндэсний хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөрийн нийт санхүүжилтийн 84 хувийг олгоод байна.
2. Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны №311 дугаар тогтоолоор “Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдэд шатахууны нөөц бүрдүүлэх санхүүжилтийн зээл”-ийн хөтөлбөр баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд 100 тэрбум төгрөгийн санхүүжилт олгожээ.



БУСАД ХӨТӨЛБӨР

Өмнөх жилүүдэд эхэлсэн Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Хөгжлийн банк болон бусад байгууллагуудын хэрэгжүүлж буй:

- Монгол банкны “Репо санхүүжилтийн зээл”-ийн төсөл
- АХБ-ны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил”-ийн төслийн нэмэлт санхүүжилт
- “Ажлын байр нэмэгдүүлэх” төсөл
- “ХБНГУлсын КФВ банкны санхүүжилттэй” төсөл
- “Жайка” төсөл зэрэг гадаад, дотоодын банк санхүүгийн байгууллагуудын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.


Энэ нь банк зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээ тогтмол хангаж, олон улсын байгууллагын шаардлагыг биелүүлэн хариуцлагатай ажиллаж буйг илтгэх юм.



ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

Бид бүх төрлийн валютаар гадаад дотоод гүйлгээ болон шилжүүлэг хурдан шуурхай хийх харилцахын бүтээгдэхүүн, хүү болон валютын сонголттой, өрсөлдөхүйц хадгаламжийн бүтээгдэхүүн харилцагч нартаа санал болгодог. Мөн мөнгөн хөрөнгөө үр ашигтай удирдахад нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Тайлант оны эцэст байгууллагын сегментийн харилцагчдаас татсан харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүний үлдэгдэл **1,949.6** тэрбум төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад даруй **56%** - ийн өсөлт үзүүлсэн байна.




Үүнээс хугацаатай хадгаламжийн үлдэгдэл 705.3 тэрбум төгрөг буюу банкны системийн байгууллагын хугацаатай хадгаламжийн үлдэгдлийн 35%-ийг бүрдүүлж байна



ГАДААД ХУДАЛДАА

Монгол улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ 2021 оны 11 сарын эцсийн байдлаар өмнөх оны жилийн эцэсээс 14%-р буюу экспорт, импорт аль аль нь мөн хувийн өсөлт үзүүлжээ.

ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХЭМЖЭЭ:



Цар тахлын нөлөөгөөр дэлхий нийтээрээ дижитал бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглах шаардлага, хэрэгцээ үүсээд байна. Бид ч мөн адил бүтээгдэхүүн үйлчилгээгээ цахимжуулах, харилцагчдаа боломжит цахим үйлчилгээнд хамруулж ажиллахыг зорилгоо. Үүний хүрээнд харилцагчийн цагийг хэмнэх, өөрөө өөртөө үйлчлэх дижитал боломжийг нэмэгдүүлэх зорилгоор онлайн шугамын зээл, тодорхойлолтуудыг ажилтны оролцоогүйгээр цахимаар авах тухай харилцагчдад таниулж, мэдээлэл зөвлөгөөгөөр ханган, амжилттай ажилласан. Үр дүнд нь 2021 онд нийт 29.1 тэрбум төгрөгийн зээлийг харилцагч өөрөө TDB Online банк ашиглан авсан байна.

Мөн Аккредитив, Баталгааны хүсэлт болон Овердрафтын үйлчилгээг онлайнаар хүлээн авах ажлыг 2022 онд нэвтрүүлж, ашиглалтад оруулахад бэлэн болсон. Дотоод үйл ажиллагаагаа цахимжуулах, шийдвэр гаргах процессыг хялбарчлах, цаашлаад Ногоон банк болох зорилт руу чиглэн цаасны хэрэглээ, үргүй зардлыг бууруулах зэрэг олон ажлыг санаачлан хэрэгжүүлж байна.



ЖИЖИГ ДУНД БИЗНЕСИЙН ЗАХ ЗЭЭЛ

Худалдаа, хөгжлийн банк нь Монгол Улсын эдийн засгийн гол тулгуур болсон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг тууштай дэмжиж, тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг түргэн шуурхай, эрсдэлгүй хүргэж ирсэн.

Банк 2021 онд өөрийн 64 мянга гаруй жижиг, дунд бизнес эрхлэгч харилцагчдад бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүргэж, бизнесийг нь дэмжин харилцан ашигтай хамтран ажилласан.

2021 онд бид харилцагч төвтэй банк стратегийн хүрээнд харилцагчийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан олон улсын чиг хандлагыг дагаж, 5 зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд шинээр нэвтрүүллээ. Тайлант онд банкнаас жижиг, дунд бизнес эрхлэгчдэд олгосон зээлийн нийт үлдэгдэл 521 тэрбум төгрөг, өөрийн банкны зээлийн багцын 9.42%-ийг бүрдүүлж байна.

Тайлант оны эцэст харилцагчаас татсан эх үүсвэрийн үлдэгдэл **912.7** тэрбум төгрөг болж, өөрийн банкны татан төвлөрүүлсэн хөрөнгийн **15.49%** -ийг эзэлж байна.



Харилцагчийн тоо
64,361



Зээлийн багцын үлдэгдэл
521 тэрбум төгрөг



Нийт харилцах, хадгаламжийн үлдэгдэл **912.7** тэрбум төгрөг

ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ЗЭЭЛ

"Climate 30+" Тогтвортой Санхүүжилтийн Үндэсний Санаачилга хөтөлбөрийн хүрээнд Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүллээ. Энэхүү зээл нь эмэгтэй гүйцэтгэх удирдлагатай болон эмэгтэй ажилтнууд давамгайлсан бизнес, аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй санхүүжилт санал болгох юм. Уг санхүүжилтийн хүрээнд 2021 онд 6.5 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.



БИЗНЕСИЙН НОГООН ЗЭЭЛ

ХХБ нь Ногоон банк болох зорилтын хүрээнд "Climate 30+" Тогтвортой Санхүүжилтийн Үндэсний Санаачилга (2021-2030) хөтөлбөрийг эхлүүлсэн. Уг санаачилга дор харилцагч нарынхаа урт удаан хугацааны тогтвортой үйл ажиллагааг дэмжих зорилгоор "Бизнесийн ногоон зээл"-ийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж, 2021 онд 11.4 тэрбум төгрөгийн зээл олгоод байна. Энэхүү ногоон зээл нь эхний 24 сар хүртэлх хугацаанд зээлийн үндсэн төлөлтөөс чөлөөлөх бөгөөд харилцагчийн бизнест бодит дэмжлэг болж чадна.



ЗЭЭЛИЙН ХҮҮ БУУРАВ

Цар тахлын нөлөөллөөс бизнесийн орлого нь тасалдсан жижиг, дунд бизнес эрхлэгчдээ дэмжих зорилгоор бизнесийн бичил зээл, эргэлтийн хөрөнгийн зээл, хөрөнгө оруулалтын жижиг зээлийн хүүгээ буурууллаа.

shoppy.mn

Шоппи ХХК-тай хамтран Shoppy.mn платформоор дамжуулан бараа бүтээгдэхүүнээ худалдан борлуулдаг байгууллага, хувь хүмүүст зориулсан таатай нөхцөл бүхий эргэлтийн хөрөнгийн зээлийг зах зээлд нэвтрүүлсэн. Уг бүтээгдэхүүн нь зээл хүсэгчээс барьцаа шаардахгүй, зээлийн шийдвэр нь ажлын 1-3 хоногт гарах боломжтой, зөвхөн Shoppy.mn дэх цахим дэлгүүрийн орлогод нь үндэслэх ба аль ч банкны харилцагч байх боломжтой.

РЕПО САНХҮҮЖИЛТИЙН ЗЭЭЛ

Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-нд тусгагдсан "Репо санхүүжилтийн зээл"-ийн 278.5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг МБ-аас авч, салбар тооцооны төвүүдээр дамжуулан олгосон байна.

Репо санхүүжилтийн зээл
278.5 тэрбум төгрөг

ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР ЦУГЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

Жижиг дунд бизнес эрхлэгч буюу түрээслэгч нартаа зориулж түрээсийн төлбөрийг сар бүрийн эцэст өндөр дүнгээр төлдөг. Энэхүү санхүүгийн дарамтыг бууруулахаар түрээсийн төлбөр цуглуулах үйлчилгээг нэвтрүүллээ. Энэ үйлчилгээ мөн түрээслүүлэгч талд гэрээний дагуу тогтсон хугацаанд түрээсийн орлогоо тогтмол эрсдэлгүй авах нөхцөлийг бүрдүүлсэн бүтээгдэхүүн юм. Уг бүтээгдэхүүн нь түрээсийн гэрээн дээр үндэслэдэг ба хоёр талын харилцааг тогтмол шилжүүлэг үйлчилгээний тусламжтайгаар бататгаж, түрээслэгчийн өдөр бүрийн орлогоос тодорхой дүнгээр хуримтал үүсгэн, сар болгоны төлбөрийн өдөр түрээслүүлэгчийн данс руу автоматаар төлбөрийг шилжүүлэх юм.

АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ЗЭЭЛ

Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-нд тусгагдсан "Ажлын байрыг дэмжих зээл"-ийг 2021.12.31-ний өдрийг дуустал 218.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг ХХБ-ны бүх салбар, тооцооны төвүүдээр олгож амжилттай хэрэгжүүлсэн.

Ажлын байр дэмжих зээл
218 тэрбум төгрөг

НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭНИЙ ЗЭЭЛИЙН ЭРХ

Худалдаа хөгжлийн банкны стратеги зорилтын хүрээнд «Нийлүүлэлтийн сүлжээний зээлийн эрх"-ийн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүллээ. Уг бүтээгдэхүүн нь монголын санхүүгийн зах зээлд Нийлүүлэлтийн сүлжээнд оролцож буй талуудын төлбөр тооцоог шийдвэрлэсэн **АНХДАГЧ** бүтээгдэхүүн юм.

Ханган нийлүүлэгч талд:

Зээлээр борлуулж буй бараа бүтээгдэхүүний авлагыг урьдчилан авах боломж

Худалдан авагч талд:

Ханган нийлүүлэгчээс бараа, бүтээгдэхүүн зээлээр авах шаардлагагүй болж, төлбөрийг ханган нийлүүлэгчид тухай бүрд төлөх боломж

ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ (Бүтээгдэхүүнээр)

Бизнесийн зээл
353 тэрбум төгрөг

Үл хөдлөх хөрөнгийн зээл
101.6 тэрбум төгрөг

Төслийн зээл
52.7 тэрбум төгрөг

Бусад
13.7 тэрбум төгрөг

ИРГЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

2021 он дэлхий даяар тархсан Ковид-19 халдварт өвчинтэй тэмцсэн онцгой жил байлаа. Иргэдийн банкны газар болон түүний харьяа хэлтсүүд нь 2021 онд иргэдийн сегментийн харилцагчдад зориулсан банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг банкны салбар дээр ирж авахаас илүүтэйгээр цахим үйлчилгээг түлхүү санал болгож дижитал банк болох зорилт руу тэмүүлэн ажиллаа.

БАРИМТАЛСАН БОДЛОГО:

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн хувьд:

Монгол улсын нийт иргэдийг хуримтлалтай болгох, түүний үр ашгийг харилцагчдад танин мэдүүлэх, харилцагч нарт гэр бүлийн болон хувийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх төлөвлөгөөтэй үйл ажиллагааг зохион байгуулан, бүтээгдэхүүний нөхцөлийг илүү уян хатан, харилцагчид таатай, бусад арилжааны банкнуудаас ялгарахуйц давуу талтай байхад чиглэсэн бодлого баримтлан ажиллаа.



Зээлийн хувьд:

Харилцагчид зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг илүү түргэн шуурхай хүргэх үүднээс хиймэл оюун ухаан ашиглан зээл шийдвэрлэх хурдыг нэмэгдүүлэх, бүрдүүлэх баримт бичгийг багасгах, харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, шинэ зээлийн хүсэлтийг зайнаас хүргэж, зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөлийг илүү уян хатан байлгах бодлого баримтлан ажиллаа.

ОНЦЛОХ АЖЛУУД

Зээлийн хувьд:

Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж буй “Эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд иргэдийн хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэн ажиллаа. Үүний хүрээнд 2021 онд 3,579 иргэнд 304 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг олголоо.

Даатгал зуучлалын хувьд:


Бид даатгал зуучлалын үйлчилгээндээ харилцагчийн эрх ашиг бүрэн хамгаалагдаж, гэрээний дагуу даатгалын хамгаалалтаа авч байх зарчмыг нэн түрүүнд баримталж ажилладаг. Энэ хүрээндээ өнгөрөгч онд нийт 2.08 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг харилцагч, даатгуулагч нартаа олгууллаа. Түүнчлэн зуучлалын үйлчилгээний гол зорилго нь талуудын эрх ашгийг харилцан эрх тэгш байлгахад оршдог. Бид хамтран ажиллагч даатгалын компаниуддаа нийт 4.64 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлж, банкны даатгал зуучлалын салбарт тэргүүлэгчдийн байр сууриа хадгалаа. 2022 онд бид санхүүгийн салбарын олон улсын чиг хандлага болох финтекийг үйл ажиллагаандаа ашиглаж, банкны даатгал зуучлалын үйлчилгээнд технологийн дэвшлийг бүрэн нэвтрүүлэх зорилготой ажиллаж байна.

Даатгалын компаниуд
4.64 тэрбум төгрөгийн
хураамжийн орлого

Харилцагчид
2.08 тэрбум төгрөгийн
нөхөн төлбөр


ЦАЛИНГИЙН БАГЦ

ХХБ-аар дамжуулан цалин олгодог байгууллагын ажилтан, харилцагч нарын санхүүгийн цогц хэрэгцээнд нийцүүлэн Харилцах данс, Цалингийн карт, Дижитал банк, Хадгаламж, Даатгал зэрэг банкны бүтээгдэхүүн үйлчилгээг багтаасан “Цалингийн багц” үйлчилгээг шинээр нэвтрүүллээ. Цалингийн багц бүтээгдэхүүнийг авснаар харилцагч банкны зарим бүтээгдэхүүн, үйлчилгээг шимтгэл, хураамжгүйгээр ашиглах боломж бүрдлээ.




ХҮҮХДИЙН БАГЦ

ХХБ нь банкны 18 хүртэлх насны харилцагч нарын насны онцлогт тохируулан хүүхдэд багаас нь санхүүгийн боловсрол олгох зорилгоор “Маамуу, Kids, Junior” багцыг шинээр нэвтрүүллээ. Тус бүтээгдэхүүнд хүүхдэд хамгийн эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн болох хүүхдийн хадгаламж, хөнгөлөлт буцаан олголттой олон улсын эрхтэй карт, дижитал банкны үйлчилгээг нэгтгэн банкны шимтгэл, хураамжаас чөлөөлөн багцалснаараа онцлог юм.



ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙН СКОРИНГ МОДЕЛЬ

Хиймэл оюун ухаан (AI)-д суурилсан харилцагчийг үнэлэх скоринг модель боловсруулж Цалингийн зээл, Автомашины зээл, Кредит карт, Орон сууцны зээлийн үйл ажиллагаанд нэвтрүүллээ. Ингэснээр харилцагчийн зээлийн хүсэлтийг шийдвэрлэх хурд нэмэгдэх, харилцагчид боломжит хамгийн бага хүүг санал болгох, зээлийн чанаргүй болох магадлалыг урьдчилан тодорхойлж эрсдэлийн түвшнийг бууруулахад нэг алхам урагшиллаа.



НОГООН ЗЭЭЛ

ХХБанк нь нийгмийн хариуцлагын хүрээнд Байгаль орчин, нийгэмд ээлтэй “Ногоон зээл”-ийн бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн “Ногоон хувийн сууц барих болон цахилгаан автомашины зээл”-ийг шинээр нэмэгдүүллээ. Ингэснээр Монгол улсын агаар болон хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор байгаль орчинд ээлтэй, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг зээлээр санхүүжүүлэх юм.



УРТ ХУГАЦААТ ХАДГАЛАМЖ

Гадаад валютын хуримтлалыг дэмжих зорилгоор урт хугацаатай, хүүнээс хүү бодох, хугацааны дундуур зарлага гаргах зэрэг уян хатан нөхцөлтэй хадгаламжийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүллээ.

\$ ХАДГАЛАМЖ

Урт хугацаатай

Хүүгээс хүү бодно

Хугацааны дундуур зарлага гаргах боломжтой

ЗЭЭЛИЙН ХҮСЭЛТИЙГ ОНЛАЙНААР

Харилцагчийн цаг завьг хэмнэх, банкны бүтээгдэхүүн үйлчилгээг хялбар болгох зорилгоор цалингийн зээлийн хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх болсон. Цаашид ч бүх төрлийн хэрэглээний зээлийн хүсэлтийг цахимаар хүлээн авч, салбар орохгүйгээр банкны үйлчилгээг зайнаас өгөх зорилготой ажиллаж байна.

ЗЭЭЛИЙН ТӨЛБӨР

Дэлхий дахинд тархсан коронавирусын халдварт өвчинтэй холбоотой харилцагчдаа санхүүгийн дарамтад орохоос урьдчилан сэргийлэх, онцгой үеийг даван туулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор давхардсан тоогоор нийт 18,713 зээлдэгчийн зээлийн хүү болон үндсэн төлбөрийг хойшлууллаа. Харилцагчдын цаг завьг хэмнэх, эрсдэлээс сэргийлэх үүднээс зээл хойшлуулах хүсэлт болон зээл хойшлуулсантай холбоотой нэмэлт гэрээг банкны цахим хуудсаар дамжуулан зайнаас байгууллаа.

Давхардсан тоогоор **18,173** зээлдэгч > Зээлийн хүү болон үндсэн төлбөрийг хойшлууллаа

ХЭРЭГЛЭЭНИЙ ОНЛАЙН ЗЭЭЛ

ХХБ нь Коди ХХК-тай хамтран хэрэглээний цахим зээлийг зах зээлд нэвтрүүлэн багагүй хугацааг өнгөрүүлсэн. 2021 онд цахим зээлийн хамтран ажиллагч байгууллагын тоог 21 болгон өргөжүүллээ. Ингэснээр иргэд ХХБ-ны харилцагч эсэхээс үл хамааран хамтрагч байгууллагуудын веб сайтаас бараагаа сонгон, зайнаас зээлийн хүсэлт илгээж, гэртээ хүргүүлэн авах юм. Түүнчлэн банкны салбар байршиж буй орон нутгийн иргэд цаг хугацаа, орон зайг үл хамааран хэрэглээний онлайн зээлд хамрагддаг боллоо.

ДЭЛХИЙН ХУРИМТЛАЛЫН ӨДӨР

Монголбанк, Монголын Банкны Холбоо, ХБНГУ-ын Хадгаламжийн банкны олон улсын хамтын ажиллагааны сан, арилжааны банкнууд хамтран 10 дахь жилдээ “Дэлхийн хуримтлалын өдөр”- тэмдэглэн өнгөрүүллээ. Банкны зүгээс Монгол HD телевизийн “Өглөө хөтөлбөр”-т оролцож олон нийтэд санхүүгийн боловсрол, хуримтлалын ач холбогдлын мэдээлэл хүргэн ажиллаа.

ХАЙРЛАГДСАН ДЭЛХИЙ

Хувь хүний өдөр тутмын энгийн үйлдэл байгаль, эх дэлхийд хэрхэн нөлөөлж болохыг ойлгуулах зорилготой “Хайрлагдсан дэлхий” сэдэвт видео бичлэгийн уралдаан 18 хүртэлх насны хүүхдүүд дунд зарласан юм. 6 хүртэлх насны 3 хүүхдэд 2,200,000₮-ийн Маамуу хадгаламжийн эрхийн бичиг, 7-12 хүртэлх насны 3 хүүхдэд 1 Pad 4th gen, Playstation 4, Hoverboard, 13-18 насны 3 хүүхдэд 4,500,000 ₮-ийн хадгаламжийн эрхийн бичиг болон For you junior картаар шагналаа.

ДАНС ЗАЙНААС НЭЭХ

МУ-ын Засгийн газрын шийдвэрээр Монгол улсын иргэн бүрд 300,000₮-ийн нэг удаагийн тусламж олгох болсон. Энэ хүрээнд зайнаас данс нээх боломжийг бүрдүүлэх программ хөгжүүлэлтийг хийлгэж, гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэглэлд шилжсэн хатуу хөл хорионы хугацаанд нийт 13,288 харилцагчийн хүсэлтийг хүлээн авч, бүрэн шийдвэрлэж ажиллаа.

13,288 > **Хатуу хөл хорионы үед зайнаас данс нээлгэлээ харилцагч**



Иргэдийг хуримтлалтай болгох, хуримтлалын үр ашгийг таниулан ойлгуулахад чиглэсэн “Хуримтлалтай Монгол” хадгаламжийн урамшуулалт аяныг 13 долоо хоногийн турш амжилттай зохион байгууллаа. Тус аяны хүрээнд 1 харилцагч “Нэг өрөө байр”, 13 харилцагч “Турк улс руу аялах эрх”, 13 харилцагч 1,000,000₮, 130 харилцагч 500,000₮-ийн хадгаламжийн эрхийн эздээр тодорсон юм.

1 харилцагч	Нэг өрөө байр
13 харилцагч	Турк улс руу аялах эрх
13 харилцагч	1,000,000₮-н хадгаламжийн эрх
130 харилцагч	500,000₮-н хадгаламжийн эрх

САЛБАР НЭГЖИЙН ХҮРТЭЭМЖ

Бид харилцагчдадаа илүү ойртох, салбар нэгжийн хүртээмжийг сайжруулах зорилгоор дараах салбар нэгжүүдийг нээж, үйл ажиллагааг нь эхлүүллээ.

- Шинээр байгуулагдсан Олон улсын нисэх буудалд байрлах Шинэ нисэх салбар
- Макс моол худалдааны төвд байрлах Макс моол салбар
- Мишээл тавилгын их дэлгүүрийн Misheel Walking Street-д байрлах Мишээл салбар
- Парк-Од худалдааны төвд байрлах Парк-Од салбар
- Шангри-Ла салбарын Дипломат хэсэг

Мөн харилцагчдадаа олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг тав тухтай, таатай орчинд хүргэх зорилгоор банкныхаа Жуулчин, Хан-Уул, Торгон хил, Бага тойруу, Дархан, Гурван гал, Тэнгэр плаза, Гандирс, Оргил стар, Бизнес төв, Үйлдвэр, М плаза, Дорноговь, Эрдэнэт, Хөтөл, Зүүн хараа, 220 мянгат салбарууд болон Их дэлгүүр, 11-р хороолол, Био комбинат, Хархорин, 4-р хороолол тооцооны төвүүдийн дизайн, тохижилт бүхий засварын ажлыг хийж, гадаад, дотоод орчныг сайжруулан, өнгө төрхийг шинэчиллээ.



TDB ONLINE ЦАХИМ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Бид Монгол Улсын банк, санхүүгийн салбарт цахимжуулалт (дигиталчлал), дижитал шилжилтийг тэргүүлэх байр суурьтайгаар гүйцэтгэж байна. Тайлант онд харилцагчдадаа илүү нийцтэй, хүртээмжтэй, харилцагч бүрийн хүсэл сонирхолд тохирсон байдлаар банкны үйлчилгээг илүү хялбар, илүү аюулгүй хүргэхэд чиглэсэн технологийн, платформын шинэчлэлийг хийж ажиллаа. Энэ нь ХХБ ирээдүйд илүү үр бүтээмжтэй ажиллах технологи, инновацын бааз суурь болох юм.

Тайлант хугацаанд цахим бүтээгдэхүүн үйлчилгээнд давхардсан тоогоор 833,451 харилцагч бүртгэлтэй байгаа нь банкны нийт идэвхтэй харилцагчийн 95-аас дээш хувийг хамарч байна. Энэ нь цахим банкны хэрэглэгчдийн тоо өмнөх онтой харьцуулахад 9 хувиар өссөн үзүүлэлт юм. Мөн тайлант онд банкны хэмжээнд хийгдсэн нийт гүйлгээний 97% цахимжсан хэлбэрээр буюу банкны ажилтны оролцоогүй хийгджээ. Цахим үйлчилгээний гүйлгээний тоо өмнөх оноос 195%, гүйлгээний дүн 89%-аар тус тус өссөн байна. Энэ нь иргэд, байгууллагууд цахим үйлчилгээг идэвхтэй ашигладаг болсныг илтгэж байна.



Банкны нийт идэвхтэй харилцагчийн
95% цахим банканд бүртгэлтэй.



Банкны нийт гүйлгээний
97% цахимаар хийгдсэн

Банк өөрийн гол цахим суваг болох TDB Online үйлчилгээнд хүүхдэд зориулсан Online Kids, Online Junior эрхийн бүлэг мөн Япон иргэний эрхийн бүлгийг шинээр нэвтрүүлсэн. Мөн цахим үйлчилгээний боломжийг шинэчилж илүү хурдан, илүү хялбар болгож, банкны олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний шийдлийг хөгжүүлэн харилцагч нартаа хүргэсээр байна.

TDB ONLINE-Д НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ БОЛОМЖУУД

- TDB Pay Wallet
- Гадаадын 11 улсын утасны дугаарт мессеж илгээх
- Corporate Gateway үйлчилгээгээр татвар, гааль, билл төлбөрийг төлөх
- WeChat Pay
- Иргэн харилцагчид зээлийн шугам нээлттэй
- IBAN дугаараар гүйлгээ хийх
- ATM-с QR кодоор бэлэн мөнгө авах
- Харилцагч мэдээллээ нууцлах
- Дансны хуулгаасаа шууд гүйлгээ хийх

TDB ONLINE ҮЙЛЧИЛГЭЭНД ШИНЭЧЛЭЛТ ХИЙГДСЭНЭЭР:

- Харилцагч банкны бүтээгдэхүүн үйлчилгээг илүү хялбараар авч, хэрэглээ нэмэгдсэн
- Харилцагчид загвар дизайн болон ашиглалт илүү хялбар, хурдан, ойлгомжтой болсон
- Харилцагчид зориулсан гарын авлага, зөвлөмжүүд хүргэсэн
- UX/UI-ын дизайн шинэчлэгдсэн

CORPORATE GATEWAY

Энэ нь систем хоорондын интеграци хийх замаар үйл ажиллагааны процессыг хялбарчлах, автоматжуулах зорилго бүхий сувгийн холболт хийх үйлчилгээ юм. Банкны бүхий л үйлчилгээг API хэлбэрээр дамжуулан системийн холболт хийнэ. Ингэснээр харилцагч байгууллагын гараар хийгдэж буй механик үйл ажиллагааг автоматжуулж, үйл ажиллагааны шат дарааллыг багасгаж, цаг хугацаа, зардал хэмнэх юм. Өөрөөр хэлбэл бизнесийн хурдасгуур болсон цахим банкны дараагийн шат болохуйц үйлчилгээ юм. Бид 2021 онд үйлчилгээ үзүүлэгч 68 байгууллагын дотоод орчинд банкны үйлчилгээг холбон, нийт 188 байгууллага болон тэдгээрийн хэрэглэгчдэд банк болоод төлбөр тооцооны үйлчилгээг илүү ойртуулан ажиллаа.

БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМААР АВАХ ХАНДЛАГА ӨМНӨХ ОНООС ИЙНХҮҮ ӨСЖЭЭ

Хадгаламж
барьцаалсан зээл
58%↑

Хадгаламжийн
данс нээх
66%↑

Харилцах
данс нээх
99%↑

Карт
захиалах
145%↑

Тодорхойлолт
авах
261%↑

2021 онд бид эрхэм харилцагчдынхаа болоод зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан, олон улсын чиг хандлагыг дагасан олон төрлийн дагалдах урамшууллын хөтөлбөртэй картын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж, картын загвар өнгө төрхийг дэлхийн хэмжээнд нийцүүлж, банкны үнэ цэнтэй харилцагчдынхаа сэтгэл ханамжийг өндөрт байлгахыг онцгойлон анхаарч олон төрлийн урамшуулалт бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүллээ.



ATM

2021 онд хөл хорионы үед салбарын ачааллыг бууруулах зорилгоор ATM дээр шинээр Transfer limit-тэй болсон. Ингэснээр харилцагчид өндөр дүнтэй гүйлгээг заавал салбарт ирж хийх шаардлагагүй болсон. Мөн картын Use limit нь ATM дээр орлогын гүйлгээ хийхэд тоологддоггүй байхаар шинэчиллээ.

Худалдаа, хөгжлийн банк стратеги бодлогынхоо хүрээнд банкны системийн суурь бүтэц, программ хангамжийн хүчин чадлаа нэмэгдүүлж, дэвшилтэт технологийг шат дараатайгаар нэвтрүүлж байгаа юм. Харилцан уялдаа бүхий программ хангамж, системүүдийг нэгтгэсэн цогц платформыг бий болгож, үйлчилгээгээ мэдээллийн аюулгүй байдал, нууцлал хамгааллын өндөр түвшинд, илүү шуурхай өндөр хүчин чадалтайгаар хүргэхийг зорьж байна. Харилцагчид банкны салбарын цагийн хуваарь болон орон зайнаас үл хамаарч хүссэн үедээ цахимаар банкны бүтээгдэхүүн үйлчилгээг авах боломж нэмэгдсээр байгаа билээ.



КАРТ, ТӨЛБӨР ТООЦОНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

BRITTO карт

Тайлант онд ХХБ ОУ-ын VISA Inc-д үндсэн гишүүнээр элсэж хамтын ажиллагааг эхлүүлсний 20 жилийн ой тохиолоо. 20 жилийн ойн хүрээнд дэлхийд алдартай зураач Ромеро Бритто-той хамтран түүний бүтээлийг картын загварт тусгайлан буулгасан Бритто Виза картыг 2021 оны 11-р сарын 8-нд зах зээлд нэвтрүүлэн, нээлтийн арга хэмжээг Шангри-Ла зочид буудалд зохион байгуулав. Дэлхийн хэмжээний зураачийн оюуны бүтээлийг албан ёсны эрхтэйгээр төлбөрийн картад буулгаснаараа салбартаа анхдагч байр сууриа дахин баталлаа. Түүнчлэн Монгол улсын топ 200 гаруй аж ахуйн нэгжтэй хамтран Бритто карт болон бусад карт эзэмшигчдэдээ зориулан худалдан авалтын 3-10%-ийн буцаан олголтын урамшуулалт хөтөлбөр явуулж байна.



Худалдан авалт бүрд буцаан олголттой



Санхүүгийн боловсрол олгох төлбөр тооцооны бэлэн бус гүйлгээг таниулах ажлын хүрээнд хүүхдэд зориулсан - Kids Loyalty



СЭЗДС-тай хамтран Оюутны карт



Токио - 2020 олимпын наадам эхэлсэнтэй холбоотойгоор ОУ-ын VISA энгийн болон алтан карт

тус тус зах зээлд шинээр нэвтрүүлэв.



УРАМШУУЛАЛТ АЯН

Visa International, UnionPay байгууллагуудтай хамтарсан урамшуулалт хөтөлбөрүүдийг харилцагчдынхаа дунд зохион байгууллаа.



WeChat Pay

Дэлхийн өнцөг булан бүрээс харилцагчид нэгдсэн Хятад Улсын хамгийн алдартай WeChat мессенжер программд суурилсан "WeChatPay" олон улсын төлбөр хүлээн авах үйлчилгээнд Монгол улсаас анх удаа Худалдаа, хөгжлийн банк нэгдэж зах зээлд нэвтрүүлээ.

Энэхүү үйлчилгээ нь Пос терминал, Васко төхөөрөмж зэрэг ямар нэгэн нэмэлт төхөөрөмж шаардахгүй бөгөөд гар утас, таблет зэрэг ухаалаг төхөөрөмж дээр суулгасан "TDB POS" аппликейшнээр дамжуулан БНХАУ-ын хэрэглэгчдээс олон улсын төлбөр тооцоог хүлээн авах боломжтой шинэ төрлийн ухаалаг төлбөрийн шийдэл юм.



ПОС

Харилцагчдад банкны үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн дараах шинэчлэлтүүдийг хийлээ.

- Худалдан авалтын гүйлгээ хийсэн үед ПОС-с НӨАТ-ын баримт хэвлэж эхэлсэн.
- Android үйлдлийн загвартай ПОС терминалыг үйл ажиллагаанд нэвтрүүлж эхэлсэн.
- Монгол улсын томоохон ШТС-уудад зориулсан программын шийдлийг Genesys ХХК-тай хамтран хөгжүүлж эхэлсэн.

ГАДААД ХАРИЛЦАА, ОЛОН УЛСЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ОНЦЛОХ АЖИЛ, ОЛОЛТ АМЖИЛТ

- ОХУ-ын Засгийн газраас хэрэгжүүлж буй өндөр технологийн бүтээгдэхүүний экспортыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд **РОСЭКСИМБАНК**-тай хамтран Оросын экспортыг дэмжих агентлагийн баталгаатайгаар ачаа тээврийн галт тэрэг нийлүүлэх худалдан авалтын санхүүжилтийг харилцагчид амжилттай олгов.
- Олон улсад нэр хүнд бүхий Германы хамгийн том банк болох **Deutsche Bank**-нд худалдааны санхүүжилтийн шугамыг амжилттай нээлгэв. Тус санхүүжилтийн шугамын хүрээнд банкны харилцагчид нь таатай нөхцөлөөр худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүнийг ашиглах боломжтой боллоо.
- Англи улсын **Crown Agents Bank**-д худалдааны санхүүжилтийн шугамыг амжилттай нээлгэв. Тус санхүүжилтийн шугамын хүрээнд банкны харилцагчид таатай нөхцөлөөр худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүнийг ашиглах боломжтой боллоо.
- Их Британи, Энэтхэг улстай худалдаа эрхэлж буй үйлчлүүлэгчдэд илүү өрсөлдөхүйц нөхцөлтэй (хүү, хугацаа) худалдааны санхүүжилтийг олгох үүднээс **UKEF** болон Энэтхэгийн хөгжлийн **ЭКСИМ** банктэй бизнесийн харилцааг амжилттай байгууллаа.
- Худалдааны санхүүжилтийн стратегийн дагуу **Deutsche Zentral-Genossenschaftsbank** (DZ Bank)-д зээлийн шугам батлуулж, харилцагчийн аккредитив болон баталгааг илүү сайн нөхцөлөөр нээж эхэллээ.
- ОХУ-ын Russian Export Center-с 2021 оны 12-р сарын 10-ны өдөр зохион байгуулсан «Made in Russia» олон улсын форумд Монгол улсын банкны салбарыг төлөөлөн оролцож, «10 years of export financing: lessons and prospects» сэдвийн хүрээнд олон улсын банк, санхүүгийн байгууллагын төлөөлөгчдөд Монгол улсын эдийн засаг, ОХУ-тай харилцаа, ирээдүйн боломжуудын талаар танилцуулав.
- Монгол болон Вьетнам улсын хоорондын худалдааг дэмжих зорилгоор Вьетнам улсын **BIDV** банканд Вьетнам контент бүхий аккредитивыг баталгаажуулах шугам шинээр батлуулав.
- Унгар улсын ЭКСИМ** банктэй хамтын ажиллагааны гэрээг шинэчлэн, хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллахаар болов.
- БНБУ-ын Хөгжлийн банктэй** тус улсад үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний импортыг санхүүжүүлэх зорилгоор ам.доллар, евро, рубль болон Беларусь рублийн санхүүжилтийн гэрээ байгууллаа. Тус зээлийн гэрээ нь манай банкны харилцагчдын БНБУ-д үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн үйлчилгээг импортлох болон албан ёсны төлөөлөгчөөс худалдан авалт хийхэд өртөг багатайгаар санхүүжүүлэх боломжийг олгох юм.
- ХХБанк хоёр дахь баримтын худалдааны санхүүжилтийг (буцаан үл дуудагдах төлбөрийн үүрэг бүхий) **Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Олон Улсын Банк** (IBEC)-тай хамтран амжилттай хийж гүйцэтгэлээ. Гэрээний хүрээнд Европын тэргүүлэгч банканд төлбөр төлөх үүргийг IBEC хүлээсэн болно. Энэхүү төлбөрийн хэрэгсэл нь худалдагч болон худалдан авагч талуудад төлбөр тооцооны таатай боломжийн нөхцөлийг санал болгодог онцлогтой юм.
- БНХАУ-ын Хөгжлийн банктэй** (CDB) байгуулсан санхүүжилтийн гэрээний хүрээнд БНХАУ-аас импортлох тоног төхөөрөмж, худалдан авалтад өрсөлдөхүйц өртөг бүхий санхүүжилтийг харилцагчдаа олголоо.
- ОХУ-ын улаан буудайн импортыг санхүүжүүлэх зорилгоор Олон улсын хөрөнгө оруулалтын банктэй хамтран **Москвагийн Кредит Банкнаас** ам.долларын эх үүсвэр татлаа.

- БНХАУ-н Анхуй мужийн **Хуйшанг банкнаас** БНХАУ-ын экспортыг дэмжих, хямд өртөгтэй санхүүжилт олгох зорилгоор зээлийн шугам баталлаа.
- БНХАУ-ын **“ICBC”** банкнаас харилцагчдад өрсөлдөхүйц нөхцөлтэй худалдааны санхүүжилт олгох зорилгоор баталсан зээлийн шугамын хугацааг дахин нэг жилээр амжилттай сунгалаа.
- Тайвань, Монголын хоорондын хоёр талын худалдааг дэмжих зорилгоор **БНХАУ-ын Экспорт-Импортын банкттай** худалдааны санхүүжилтийн шугамыг шинэчлэн баталлаа. Улмаар Тайваниас бараа, бүтээгдэхүүний таталт хийдэг манай банкны харилцагч нарт хямд санхүүжилт авах боломж нээгдэж байна.
- ОХУ болон Монгол улсын хооронд төлбөр тооцоог саадгүй явуулах үүднээс **Eximbank of Russia**-д төгрөгийн лоро дансыг амжилттай нээлээ.
- Харилцагчдадаа үр ашигтай, найдвартай, саадгүй гадаад мөнгөн гуйвуулга явуулахад дэмжлэг үзүүлэх үүднээс **Deutsche Zentral-Genossenschaftsbank** (DZ Bank)-д Хонг Конг долларын данс болон **Natixis** банканд 11 валютаас бүрдсэн олон валютын дансыг амжилттай нээлээ.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖИЛ, ОЛОЛТ АМЖИЛТ

- Тогтвортой хөгжлийн зорилгуудын хүрээнд нийт **1.3** их наяд төгрөгийн зээлийг олгов.
- Монголбанк, Олон улсын санхүүгийн корпорац, Монголын тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн холбооноос хамтран гүйцэтгэдэг ТоС-ийн хэрэгжилтийн үнэлгээнд **“А”** үнэлгээ авч 2021 оны Онцлох ТоС банк, 2022 оны Тогтвортой санхүүжилтийн Манлайлагч байгууллагаар шалгарав.
- Олон улсын сэргээгдэх эрчим хүчний агентлаг (IRENA), НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP), Тогтвортой эрчим хүч, бүх нийтийн хамтарсан санаачилга (SEforALL)-аар Уур амьсгалын ногоон сан (УАНС)-тай хамтран хэрэгжүүлж буй **Уур амьсгалын хөрөнгө оруулалтын платформ** (Climate Investment Platform)-ын түнш байгууллага боллоо.
- Тогтвортой, ногоон санхүүжилтийг хөгжүүлэх ажлын хүрээнд Монгол улсдаа анхдагч болох **“Тогтвортой санхүүжилтийн хүрээ”** баримт бичгийг боловсруулан гаргасан. ХХБ нь өөрийн Тогтвортой санхүүжилтийн хүрээг Ногоон бондын зарчим, Нийгмийн бондын зарчим болон Тогтвортой хөгжлийн бондын удирдамжтай нийцэж байгаа эсэх дээр хөндлөнгийн үнэлгээ, дүгнэлт болох «SPO» (Second-party opinion)-г гаргуулсан анхны байгууллага юм. (Хөндлөнгийн үнэлгээг V.E /Vigeo Eiris/ гүйцэтгэсэн)
- Монгол Улсад анхны **“Ногоон санхүүжилтийн форум”**-ыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Монголбанк болон бусад харилцагч, хамтрагч байгууллагуудынхаа оролцоотойгоор зохион байгуулав.
- ХХБ-ны оролцоотойгоор South Pole компанийн (Швейцарт төвтэй, нүүрстөрөгчийн санхүүжилтийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг) боловсруулсан хүлэмжийн хийн ялгарлын тооцоолуурыг банкны үйл ажиллагаанд ашиглан, **ногоон зээлийн дүгнэлтийг бие даан** гүйцэтгэж эхэлсэн.
- Олон улсын хөрөнгө оруулалтын банк (IIB) болон Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны банк (IBEC)-аас тогтвортой хөгжлийг дэмжих зорилгын хүрээнд нийт **71.2** тэрбум төгрөгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн.
- Ногоон зээлийн хөтөлбөр болон Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн хөтөлбөрүүдийн хүрээнд **Бизнесийн ногоон зээл** болон **Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийг** зах зээлд амжилттай нэвтрүүлсэн.
- Бизнесийн ногоон зээл бүтээгдэхүүнийг нэвтрүүлснээс хойш санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд нь нэг жилд **38.3** сая кг CO2 (нүүрсхүчлийн хий) хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахаар байгаа нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад багагүй түлхэц үзүүлнэ гэж үзэж байна.
- Тогтвортой санхүүгийн холбоотой хамтран Монгол Улсад тогтвортой болон ногоон санхүүжилтийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх **Бэлэн байдлын хөтөлбөрийг** Уур амьсгалын ногоон сангийн Удирдах зөвлөлөөр батлуулан ажиллаа.

- **Уур амьсгалын ногоон сангийн итгэмжлэгдсэн байгууллагын** хувьд ХХБ Монголын ногоон таксономийн дагуу эрчим хүчний хэмнэлт, бага бохирдуулагч эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч, тогтвортой хөдөө аж ахуй болон тогтвортой ус, хаягдлын хэрэглээ, цэвэр тээвэр зэрэг ангиллыг хамрахуйц цогц төсөл, хөтөлбөрийн саналыг боловсруулж, хөгжүүлэлт хийгдэж байна.
- Шотланд улсын Эдинбургийн Их Сургуулийн Бизнесийн сургуультай хамтран банкны дотоод болон зээлийн үйл ажиллагаанаас ялгаруулах **нүүрстөрөгчийн цэвэр ялгарлыг тэг болгох**, тогтвортой байдлын тайлагналын хүрээнд зөвлөх төслийг боловсруулан ажиллаа.

ТОКИОГИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ОЛОЛТ, АМЖИЛТ

Япон улсын хөрөнгө оруулалттай компаниуд

2021 онд Япон улсын **8** компани Токиогийн төлөөлөгчийн газраар дамжуулан мэдээлэл авч Монгол улсад өөрсдийн салбар компанийг байгуулан хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байна. Эдгээр компаниуд нь голлон худалдаа, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт үйл ажиллагаа компаниуд байна.

Санхүүжилтийн шинэ схем

Япон улсын томоохон үнэт цаасны компани Daiwa Securities Group болон Credit Saison компаниудын хувь нийлүүлэн байгуулсан Fintertech Co.,Ltd байгууллагаас “Тогтвортой хөгжлийн 17 зорилт”-д хамаарах төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зориулалт бүхий **1** сая ам.долларын санхүүжилт татав.

Япон улсаас Монгол улс руу хийгдэх мөнгөн гуйвуулгын үйлчилгээний шинэ платформ

Токио дахь төлөөлөгчийн газар Япон улсын Queen Bee Capital байгууллагатай хамтран Япон улсаас Монгол улс руу хийгдэх гадаад гуйвуулгын үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Queen Bee Capital нь Япон улсын санхүүгийн зохицуулах хорооноос олгосон мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компани юм. Тус байгууллага нь хамгийн дэвшилтэт МУТСТ/ХТМ бодлого журмыг хэрэгжүүлдэг. Түүнчлэн өөрсдийн аппликейшн болон цахим хуудсыг Монгол хэл дээр орчуулан хүргэж байна.



2 шатлал бүхий санхүүжилтийг хэрэгжүүлэв

Япон улсын LIGER HOLDING INTERNATIONAL байгууллагаас түүний хувь нийлүүлсэн охин компани болох Их агдир ББСБ ХХК-д олгох **4** сая ам.долларын санхүүжилтийг дамжуулан олгов.

НОСТРО ДАНС

№	Валют	Банкны нэр	Байршил	SWIFT код
1	USD	COMMERZBANK AG	FRANKFURT, GERMANY	COBADEFF
2		AO UNICREDIT BANK	MOSCOW, RUSSIA	IMBKRUUM
3		BANK OF CHINA (HONG KONG) LIMITED	HONG KONG	BKCHHKHH
4		INDUSTRIAL AND COMMERCIAL BANK OF CHINA	ERLIAN, CHINA	ICBKCNBJNMA
5		KOOKMIN BANK	SEOUL, KOREA	CZNBKRSE
6		KOREA EXCHANGE BANK	SEOUL, KOREA	KOEXKRSE
7		OVERSEA CHINESE BANKING CORPORATION LIMITED	SINGAPORE	OCBCSGSG
8		SBERBANK OF RUSSIA	MOSCOW, RUSSIA	SABRRUMM
9		RUSSIAN AGRICULTURAL BANK	MOSCOW, RUSSIA	RUAGRUMM
10		EXIMBANK OF RUSSIA	MOSCOW, RUSSIA	EXIRRUMM
11		TRANSKAPITALBANK	MOSCOW, RUSSIA	TJSCRUMM
12		BANK OF INNER MONGOLIA	HUHEHAOTE, CHINA	HSSYCNBH001
13		MENGSHANG BANK	BAOTOU, CHINA	BTCBCNBJ
14		VTB BANK (PJSC)	MOSCOW, RUSSIA	VTBRRUMM
15		KASIKORNBANK PUBLIC COMPANY LIMITED	BANGKOK, THAILAND	KASITHBK
16		NOVIKOMBANK	MOSCOW, RUSSIA	CNOVRUMM
17		CROWN AGENTS BANK	SURREY, UK	CRASGB2L
18		NATIXIS BEYOND BANKING	PARIS, FRANCE	NATXFRPP
19		INTERNATIONAL BANK FOR ECONOMIC CO-OPERATION	MOSCOW, RUSSIA	IBECRUMM
20	EUR	COMMERZBANK AG	FRANKFURT, GERMANY	COBADEFF
21		BAYERISCHE LANDESBANK	MUENCHEN, GERMANY	BYLADEMM
22		ERSTE GROUP BANK AG	VIENNA, AUSTRIA	GIBAATWG
23		TRANSKAPITALBANK	MOSCOW, RUSSIA	TJSCRUMM
24		EXIMBANK OF RUSSIA	MOSCOW, RUSSIA	EXIRRUMM
25		CROWN AGENTS BANK	SURREY, UK	CRASGB2L
26		NATIXIS BEYOND BANKING	PARIS, FRANCE	NATXFRPP

27	JPY	COMMERZBANK AG	FRANKFURT, GERMANY	COBADEFF
28		MIZUHO CORPORATE BANK LTD.	TOKYO, JAPAN	MHCBJPJT
29		SUMITOMO MITSUI BANKING CORPORATION	TOKYO, JAPAN	SMBCJPJT
30		MUFG BANK	TOKYO, JAPAN	BOTKJPJT
31		NATIXIS BEYOND BANKING	PARIS, FRANCE	NATXFRPP
32	GBP	COMMERZBANK AG	FRANKFURT, GERMANY	COBADEFF
33		TRANSKAPITALBANK	MOSCOW, RUSSIA	TJSCRUMM
34		KOOKMIN BANK	SEOUL, KOREA	CZNBKRSE
35		CROWN AGENTS BANK	SURREY, UK	CRASGB2L
36	NATIXIS BEYOND BANKING	PARIS, FRANCE	NATXFRPP	
37	CHF	COMMERZBANK AG	FRANKFURT, GERMANY	COBADEFF
38		NATIXIS BEYOND BANKING	PARIS, FRANCE	NATXFRPP
39	AUD	ANZ BANKING GROUP	MELBOURNE, AUSTRALIA	ANZBAU3M
40		COMMERZBANK AG	FRANKFURT, GERMANY	COBADEFF
41		NATIXIS BEYOND BANKING	PARIS, FRANCE	NATXFRPP
42	KRW	KOOKMIN BANK	SEOUL, KOREA	CZNBKRSE
43		KOREA EXCHANGE BANK	SEOUL, KOREA	KOEXKRSE
44	CNY	AGRICULTURAL BANK OF CHINA	HUHEHAOTE, CHINA	ABOCCNB050
45		BANK OF CHINA (HONG KONG) LIMITED	HONG KONG	BKCHHKHH
46		BANK OF CHINA	HUHEHAOTE, CHINA	BKCHCNBJ880
47		CHINA CONSTRUCTION BANK CORPORATION	ERLIAN, CHINA	PCBCCBNJNME
48		INDUSTRIAL AND COMMERCIAL BANK OF CHINA	ERLIAN, CHINA	ICBKCNBJNMA
49		SHANGHAI PUDONG DEVELOPMENT BANK	SHANGHAI, CHINA	SPDBCNSH
50		BANK OF INNER MONGOLIA	HUHEHAOTE, CHINA	HSSYCNBH001
51		MENGSHANG BANK	BAOTOU, CHINA	BTCBCNBJ
52		COMMERZBANK AG	FRANKFURT, GERMANY	COBADEFF
53		NATIXIS BEYOND BANKING	PARIS, FRANCE	NATXFRPP
54		CAD	COMMERZBANK AG	FRANKFURT, GERMANY
55	NATIONAL BANK OF CANADA		MONTREAL, CANADA	BNDCCAMMINT
56	NATIXIS BEYOND BANKING		PARIS, FRANCE	NATXFRPP

57	RUB	AO UNICREDIT BANK	MOSCOW, RUSSIA	IMBKRUUM
58		SBERBANK	MOSCOW, RUSSIA	SABRRU66
59		RUSSIAN AGRICULTURAL BANK	MOSCOW, RUSSIA	RUAGRUMM
60		TRANSKAPITALBANK	MOSCOW, RUSSIA	TJSCRUMM
61		VTB BANK (PJSC)	MOSCOW, RUSSIA	VTBRRUMM
62		EXIMBANK OF RUSSIA	MOSCOW, RUSSIA	EXIRRUMM
63		PROMSVYAZBANK	MOSCOW, RUSSIA	PRMSRUMM
64		NOVIKOMBANK	MOSCOW, RUSSIA	CNOVRUMM
65		NATIXIS BEYOND BANKING	PARIS, FRANCE	NATXFRPP
66		INTERNATIONAL BANK FOR ECONOMIC CO-OPERATION	MOSCOW, RUSSIA	IBECRUMM
67	NZD	AUSTRALIA AND NEW ZEALAND BANKING GROUP LIMITED	WELLINGTON, NEW ZEALAND	ANZBNZ22
68		COMMERZBANK AG	FRANKFURT, GERMANY	COBADEFF
69	HKD	COMMERZBANK AG	FRANKFURT, GERMANY	COBADEFF
70		DZ BANK AG	HONG KONG	GENOHKHH
71	SGD	COMMERZBANK AG	FRANKFURT, GERMANY	COBADEFF
72		OVERSEA CHINESE BANKING CORPORATION LIMITED	SINGAPORE	OCBCSGSG
73		NATIXIS BEYOND BANKING	PARIS, FRANCE	NATXFRPP
74	SEK	COMMERZBANK AG	FRANKFURT, GERMANY	COBADEFF
75		NORDEA BANK AB	STOCKHOLM, SWEDEN	NDEASESS
76	TRY	TURKIYE IS BANKASI	ISTANBUL, TURKEY	ISBKTRIS
77	THB	KASIKORNBANK PUBLIC COMPANY LIMITED	BANGKOK, THAILAND	KASITHBK

ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Харилцагч төвтэй банк болох стратегийн зорилгын хүрээнд 2021 онд Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан харилцагчдад зайнаас хялбар бөгөөд түргэн шуурхай бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлж, сэтгэл ханамжийг өндөр байлгахыг зорьж ажилласан. Мөн хүлээлтээс давсан үйлчилгээг үзүүлэх, үр ашигтай хамтын ажиллагааг нэмэгдүүлэхийн зэрэгцээ харилцагчаа зөв тодорхойлон, хамтран ажиллах журмыг шинэчлэн боловсрууллаа.

Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийн дагуу 2021 оны эхний хагас жилийн хөл хорионы үед банкны нэгжүүд ажиллаагүй тул харилцагчийн мэдээллийг зайнаас баталгаажуулж, шинэчлэх арга хэмжээг авсан бөгөөд ингэснээр харилцагч цахим сувгуудыг ашиглан банкны үйлчилгээ 24/7 цагийн турш авах боломжоор хангаж ажилласан юм.

2021 онд цахим банк ашиглан QR кодоор баталгаажсан 11 төрлийн нийт 27,000 ширхэг дансны тодорхойлолтыг банканд ирэлгүйгээр харилцагч зайнаас авсан. Энэ нь 2020 оны тоон үзүүлэлттэй харьцуулахад 177%-аар, харилцагчийн мэдээлэл шинэчлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 930%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Мөн хөл хорионы дараа ажиллаж буй банкны нэгжүүдэд тогтмол ариутгал, халдваргүйжүүлэлт хийж харилцагч болон ажилтнуудынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, түргэн шуурхай банкны үйлчилгээг хүргэхийг зорьж ажиллаа.

Харилцагч бүрийнхээ эрх ашгийг хамгаалж, аливаа санхүүгийн эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн боловсрол олгох зорилготой Монголбанк болон арилжааны банкууд хамтран зохион байгуулж хэрэгжүүлдэг "Ятгах тусам нягтал-2021" аянд амжилттай оролцож харилцагчдаа тогтмол зөвлөмж мэдээлэл хүргэж ажилласан. Тайлант хугацаанд нийт 12 мянган харилцагчийн 2.2 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц хэмжээний санхүүгийн эрсдэлээс хамгаалж, 8 мянган харилцагчийнхаа санал хүсэлтийг хүлээн авч, шуурхай шийдвэрлэн ажиллаа.

Automatic Clearing House-ийн төлбөр тооцоонд оролцогч банкны хувьд, Монголбанкнаас хэрэгжүүлж буй Дансны нэгдсэн сан /Central Addressing module/, IBAN /International bank account number/ төслийг нэвтрүүлэх ажлын хүрээнд банканд бүртгэлтэй нийт харилцагчдын дансыг Дансны нэгдсэн санд нийлүүлэн банк хоорондын гүйлгээнд хүлээн авагчийн нэрийг лавлах боломжоор хангасан. Мөн **IBAN** дугаарлалтыг шинээр үүсгэснээр харилцагчийн зүгээс дотоод болон олон улсын төлбөр тооцоог стандартын дагуу гүйлгээ хийх боломжийг бүрдүүлсэн бөгөөд цаашид улам сайжруулахаар хамтран ажиллаж байна.

2021 ондоо банкны нэгжийн үйлчилгээний ажилтны дүр төрхийг шинэчлэн, үндэсний үйлдвэрлэгч **Michel&Amazonka** брэндтэй хамтран дүрэмт хувцсыг үндэсний хэв маягийг агуулсан загвараар урлуулж, 31 жилийн ойн өдрөө харилцагчдаа шинэ дүр төрхөөр үйлчилж эхэлсэн.

Цаашид харилцагчийн үйлчилгээг улам боловсронгуй болгох үүднээс харилцагчийн үйлчилгээг сайжруулахад чиглэсэн урт хугацааны зорилт бүхий төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон улсын стандарт, мэдээллийн технологид суурилсан хөрөнгө оруулалтыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

24/7
8000
харилцагчийн санал
хүсэлтийг шийдвэрлэв.

11 төрлийн 8000 ширхэг
дансны тодорхойлолт
зайнаас авчээ.

12 мянган харилцагч – 2.2
тэрбум төгрөгтэй тэнцэхүйц
хэмжээний санхүүгийн
эрсдэлээс хамгааллаа



ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТЫН УДИРДЛАГА

Валютын зах зээл

Валют арилжааны зах зээлд тэргүүлэгч байр суурьтай тус банк нь Монгол улсын эдийн засаг, гадаад худалдаа, экспорт, импортод голлох үүрэг гүйцэтгэж буй харилцагч байгууллага, иргэдийнхээ гадаад валютын хэрэгцээг Ковид-19 цар тахалтай хугацаанд тогтвортой хангах хариуцлагатай үүргийг амжилттай биелүүлж ажиллаа. Банк нь цахим банкаар хийгдэх валют арилжааг дэмжиж, зайнаас уян хатан ханшаар арилжаа хийх боломжийг харилцагчдадаа олгосон. Үүний үр дүнд тайланд онд цахим банкаар хийгдсэн валют арилжааны дүн 126 хувиар өссөн.

Мөн, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийг дэмжих зорилгоор олон улсын банк, санхүүгийн байгууллагаас татсан валютын эх үүсвэрийг урт хугацаатай своп хэлцлээр төгрөгт хөрвүүлж харилцагчдадаа ханшийн эрсдэлгүй, төгрөгийн ногоон зээлийг авах боломжийг бүрдүүлж ажиллаа.



Цахим банкаар хийгдсэн валют арилжааны тоо
126 хувиар өсжээ

Алт, үнэт металлын зах зээл

Цар тахлаас үүдэлтэй хөл хорио, хязгаарлалт, инфляц зэрэг дэлхийн нийгэм, эдийн засагт тулгарч буй хүндрэл, саад бэрхшээлүүдээс болж тайлант хугацаанд таваарын захын ханш хэлбэлзэл өндөртэй өнгөрлөө. Гэсэн хэдий ч тайлант хугацаанд Монголбанкны хүлээн авсан алтны хэмжээ **20.8** тоннд хүрсэн бөгөөд манай банкны биет алтны зах зээлд эзлэх хувь тогтмол нэмэгдсэн.

Монголбанкны Алт-2 хөтөлбөрийн хүрээнд урьдчилгаа төлбөр буюу эргэлтийн хөрөнгийн болон урт хугацаат буюу хөрөнгө оруулалтын санхүүжилтийг үргэлжлүүлэн амжилттай хэрэгжүүлж, алт олборлогч харилцагч нартаа хамгийн их дүнтэй санхүүжилтийг олгосон бөгөөд төлбөрийн санхүүжилтийн хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь амжилттай гүйцэтгэж байна. Түүнчлэн тайлант онд **Монгол Улсад анх удаа ирээдүйд олборлох алтыг урьдчилан тохиролцсон нөхцөлөөр худалдан авах гэрээ бүхий санхүүжилт** (stream finance)-ийг харилцагч байгууллагад олгож, өндөр хөгжилтэй орны санхүүжилтийн схемийг дотоодод нэвтрүүлээ.

SELL

BUY

BUY

Мөнгөний зах зээл

Цар тахлын хүнд нөхцөл байдалтай тайлант хугацаанд тус банк нь зохицуулах байгууллага болон Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийг сэргээх хөтөлбөр, арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцон харилцагч байгууллага, иргэдэд олгох зээл олголтыг нэмэгдүүлж ажилласан. Монголбанкнаас тогтоосон заавал байлгах нөөцийн шаардлага, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг тогтмол хангаж ажиллаа. Банк нь дотоодын мөнгөний зах зээл дээрх тэргүүлэх байр сууриа бататгаж, 2021 оны эцсийн байдлаар дотоодын зах зээл дээрх хөрвөх чадвартай нийт үнэт цаасны 23.6 хувийг дангаараа эзэмшиж байна.



Дотоодын зах зээл дээр хөрвөх чадвартай үнэт цаас
23.6 хувийг дангаар эзэлж байна.

Актив, пассивын удирдлага

Эдийн засгийн хүндрэлтэй, тодорхойгүй байдалтай тус хугацаанд актив, пассивын удирдлагаар дамжуулан цэвэр хүүгийн орлогыг зохистой түвшинд хадгалах, дунд хугацааны хүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлд анхаарч ажиллаа. Хөрвөх чадвар, хүүгийн мэдрэмж болон төсөөллийг оруулсан шинжилгээний загварыг дотоод үйл ажиллагаандаа ашиглан банкны актив, пассивын удирдлага, хяналтыг хэрэгжүүлснээс гадна балансын оновчтой хуваарилалтын зарчмыг ашиглан банкны эрсдэл даах чадварыг нэмэгдүүлсэн.

Түүнчлэн, цар тахлын нөхцөл байдалд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс Базел III-т заасан төлбөрийн чадварын харьцаанууд болох эх үүсвэрийн тогтвортой байдлын харьцаа (**NSFR**) болон богино хугацааны төлбөрийн чадварын харьцаанууд болох **LCR, Time to Wall** харьцаануудыг тогтмол тооцож, хангаж ажилласан.

Кастодиан үйлчилгээ

Тайлант онд банк нь харилцагчдадаа цахимаар кастодиан бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэн ажиллаж, харилцагчдынхаа эрэлт хэрэгцээг тасралтгүй хангасны үр дүнд кастодиан харилцагчийн тоо, хадгалуулж буй хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн.

Түүнчлэн, зохицуулах байгууллагаас хөрөнгө оруулалтын менежментийн тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллагуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн цогц үйлчилгээг санал болгон ажилласан ба кастодиан үйлчилгээтэй холбоотой хууль, журмын өөрчлөлт, шинэчлэлтэд олон улсын практик, судалгаанд суурилсан санал хүргүүлж хувь нэмрээ оруулан ажиллаа.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Худалдаа, хөгжлийн банк нь Байгууллагын Эрсдэлийн удирдлага (Enterprise Risk Management, цаашид ERM)-ын зохистой засаглалыг бизнесийн бүх үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг. ERM нь эрсдэлийн орчныг тасралтгүй хянах, сайжруулах боломжийг бий болгож, эрсдэлийн талаарх ойлголт, мэдлэг, найдвартай ажиллагаа, стратеги шийдвэр гаргах зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг. Банкны хувь нийлүүлэгчдийн хурлаас банкны стратегийн шийдвэрүүдийг гаргах бөгөөд уг стратегид тулгуурлан банкны эрсдэлийн засаглалыг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэх үүрэг бүхий хамгийн дээд нэгж нь “Төлөөлөн удирдах зөвлөл” (ТУЗ) болон түүний дэргэдэх “Эрсдэлийн удирдлагын хороо” (ЭУХ) юм.

Банкны ТУЗ нь эрсдэлийн зохистой засаглал, эрсдэлийн аппетит (банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн дээд хэмжээ) зэрэг эрсдэлийн бодлогын баримт бичгийг баталдаг бөгөөд Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч нь банкны өдөр тутмын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж, ТУЗ болон түүний дэргэдэх ЭУХ-нд тайлагнадаг. Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч нь эрсдэлийн хамгаалалтын 2-р шугам болох эрсдэлийн удирдлагыг хариуцдаг ба үйл ажиллагааны хүрээнд дараах газар, нэгжүүд хамаардаг.

- Эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалтын газар, түүний харьяа
Зах зээл, хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хэлтэс
- Зээлийн эрсдэлийн газар
- Зээлийн хэрэг бүртгэлийн хэлтэс
- Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын газар, түүний харьяа
Цахим эрсдэлийн удирдлагын хэлтэс
- Комплайнсын хэлтэс

Эрсдэлийн хамгаалалтын **2-р шугам** болох эдгээр газар нэгжүүд нь банкны эрсдэлийн удирдлагын арга хэмжээнүүд болох өдөр тутмын эрсдэлтэй үйл ажиллагаанд хяналт тавих (risk monitoring), эрсдэлийг олж ирлүүлэх (risk identification), эрсдэлийг үнэлж хэмжих (risk assessment), эрсдэлийн лимитүүдийн биелэлтийг мэдээлэх (risk reporting), тухай бүр эрсдэлийг бууруулах арга хэмжээг авах (risk mitigation), эрсдэлийн удирдлагыг сайжруулах (risk management improvement) арга хэмжээг эрсдэлийн аппетит болон дотоод үйл ажиллагааны заавар, журмуудаар дамжуулан тасралтгүй хийдэг.

Эрсдэлийн хамгаалалтын **1-р шугам** болох бизнесийн нэгжүүд нь тус бүрийн чиг үүрэг, бизнесийн зорилт болон ТУЗ-с батлагдсан эрсдэлийн аппетитын хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг бол **3-р шугам** болох дотоод аудит нь эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилтийг хараат бус байдлаар хянан баталгаажуулах үйл ажиллагааг хамаардаг.

Эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалт

Эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалтын газар нь банкны эрсдэлийн тогтолцоо, засаглалыг тогтмол сайжруулж, олон улсын Базелийн хороо болон зохицуулагч байгууллагын гаргасан эрсдэлийн удирдлагын стандарт, зөвлөмжид нийцүүлэх үндсэн зорилгын хүрээнд эрсдэлийн бодлого, журам, арга аргачлалыг сайжруулах, шинэ стандартыг банкны үйл ажиллагаанд нэвтрүүлэх замаар банкны үйл ажиллагааг бодлогын хувьд дэмжих чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Тайлант онд банкны зохистой үйл ажиллагааны олон улсын стандарт болох Базель стандартын багана II (Pillar 2)-ын үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох эрсдэлийн аппетитын тогтолцоог банкны үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, эрсдэлийн аппетитын хэрэгжилтийг тогтмол хянаж ажиллаа.

Банкны бизнес төлөвлөгөө болон түүнтэй уялдсан эрсдэлийн аппетитын хүрээнд банк өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадвар болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үнэлгээг тогтмол хянадаг ба цаашлаад гэнэтийн хүндрэлийн үеийг даван туулах, стресс нөхцөлд банк үйл ажиллагаагаа тасралтгүй хэвийн явуулахад шаардлагатай өөрийн хөрөнгийн нөөцийг тодорхойлох шинжилгээнүүдийг тогтмол хийдэг.

Банкны түүхэн өгөгдөлд үндэслэн зээлдэгчийн зээлжих зэрэглэлийг (Credit rating/Credit scoring) тогтоох machine learning аргачлалд суурилсан скоринг моделийг хэрэглээний зээлийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн ба тус моделийг эргэн хянах арга, аргачлалыг боловсрууллаа. Энэхүү модель нь зээлийн судалгаа, шийдвэрлэх үйл явцыг хурдасгах зээлийн скорингод тохирсон оновчтой зээлийн нөхцөлийг санал болгох зэрэг банкны дотоод үйл ажиллагаа болон харилцагчийн үйлчилгээнд өндөр ач холбогдолтой юм.

Эрсдэлийн засаглалыг сайжруулах, зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд одоо үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дотоод заавар, журмуудыг шинэчилж, зээлийн судалгаа, олголтод баримтлах андеррайтинг стандартууд болон олгосон зээлийн эргэн хяналтад баримтлах стандартуудыг шинээр боловсруулсан. Энэ нь банкны нийт салбар, тооцооны төвүүдэд өдөр тутамд хийгддэг зээлийн судалгаа, олголт, эргэн төлөлт болон олгосны дараах хяналттай холбоотой бүхий л үйл ажиллагааг илүү оновчтой, тодорхой, хялбар болгохоос гадна банкны зээлийг эрсдэлийг бууруулахад чиглэсэн томоохон ажил боллоо.

Зах зээл, хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

Зах зээл, хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хэлтэс нь хүүгийн эрсдэл, ханшийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг нэгж бөгөөд эдгээр эрсдэлүүдийг үнэлэх арга аргачлал, загварыг судлан олон улсын сайн туршлагад нийцүүлэн сайжруулж, эрсдэлийн хяналтын чиг үүргийн хүрээнд холбогдох тайлан, мэдээг банкны удирдлагад тогтмол мэдээлж ажиллаа. Мөн дотоод болон гадаад зах зээлийн судалгааг голлох сектор тус бүрийн хувьд тогтмол хийж банкны бизнесийн нэгжүүд болон удирдлагуудад мэдээллийг тухай бүрд хүргүүлж ажилладаг.

ТУЗ-с баталсан эрсдэлийн аппетит болон зохицуулагч байгууллагын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хүрээнд зах зээл, хөрвөх чадварын эрсдэлүүдийг тогтмол хянаж, дүгнэлт зөвлөмжүүдийг өгч ажиллаж байна. Үүнд:

- Банкны хөрвөх чадварын эрсдэлийг мөнгөн урсгалын **"Behavioural GAP"** тайлан, Базель стандартын жишиг үзүүлэлтүүд болох Time to wall, LCR, NSFR -г тогтмол хэмжин, тайлагнаж, тухай бүр дүгнэлт зөвлөмж өгдөг.
- Банкны зах зээлийн эрсдэлийг хамгийн их эрсдэлийн аргаар (**Value at Risk**) тогтмол хэмжиж, удирдлагыг хэрэгжүүлдэг. Мөн зах зээлийн эрсдэлийг үнэлэх аргачлалыг **Базель III** стандартын дагуу мэдрэмжид суурилсан стандарт аргачлалаар (Standardised approach: Sensitivity-based method) шинэчлэн сайжруулав.
- Хүүгийн эрсдэлийг (IRRBB) **Duration GAP** болон **EVE** үзүүлэлтүүдээр тогтмол хэмжиж, банкны удирдлагад тайлагнадаг. Базель III стандартад нийцүүлэн сценарио таамаглалуудыг сайжруулж, өөрийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийн мэдрэмтгий байдал буюу **ΔEVE** үзүүлэлтийг тооцох аргачлалыг шинэчиллээ.
- Харилцагч тал, улс орны эрсдэлийг харилцагч тал бүрээр зээлжих зэрэглэл болон дотоод загварт үндэслэн лимит тодорхойлон, хяналт тавин ажиллаж байна.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

ХХБанкны мэдээллийн технологийн үйл ажиллагаа нь олон улсын стандарт шаардлагад нийцсэн мэдээллийн технологийн дэвшилтэд техник, арга хэрэгсэлд тулгуурлан банкны үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдлыг хангах, ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхэд онцгойлон анхаарч, мэдээллийн технологийн сүүлийн үеийн техник, программ хангамжийн технологиудыг өргөн ашиглаж байна.

Тайлант онд олон улс, корреспондент банк, зохицуулагч байгууллагын шаардлагыг хангах, дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлж, дотоод үйл ажиллагааг сайжруулах, харилцагчид банкны үйлчилгээг улам ойртуулах, цахим банкны үйлчилгээгээр дамжуулан өөрт шаардлагатай бүхий л бүтээгдэхүүн үйлчилгээг шуурхай бөгөөд найдвартай авах, төлбөр тооцоог хялбар гүйцэтгэх программ хангамж, технологийн боломжийг хангах, мэдээллийн технологийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажилласан байна. Эдгээрээс дурдвал:

COBIT5 ОЛОН УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЗАСАГЛАЛ УДИРДЛАГЫН COBIT5 ТОГТОЛЦОО

Олон улсын мэдээллийн технологийн засаглал удирдлагын COBIT5 тогтолцоонд суурилсан мэдээллийн технологийн хөндлөнгийн аудитыг хийлгэж, зохицуулагч байгууллагын шаардлагыг хангав. Аудитын үр дүнд COBIT5 процессын үнэлгээ өмнөх удаагийн аудитын үнэлгээнээс эрс нэмэгдэж Банкны мэдээллийн технологийн бүтэц, хариуцлага, удирдлагын процесс нь сайжирсан гэсэн дүгнэлт гарсан.



PAYMENT CARD INDUSTRY DATA SECURITY STANDARD

Банкны үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамж, систем, мэдээллийн сан, сүлжээ, холбоо, сервер, тоног төхөөрөмжүүд болон тэдгээрийн үйлдлийн систем, мэдээллийн аюулгүй байдал, ажилтны үйл ажиллагааны төлбөрийн картын системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах стандарт PCI-DSS (Payment Card Industry Data Security Standard)-ыг 5 дахь жилдээ баталгаажууллаа.

ДАНСНЫ НЭГДСЭН САН

Монголбанктай хамтран Дансны нэгдсэн сан (СAМ) модулийг нэвтрүүлэв. Уг модулийг нэвтрүүлснээр банк хоорондын гүйлгээнд оролцогчид хүлээн авагчийн дансны дугаараар дансны нэрийг лавлах боломж бий болсон. Ингэснээр харилцагч хүлээн авагчийн нэрийг бичих үйлдлийг автоматжуулж, банк хоорондын гүйлгээг илүү хялбар, найдвартай хийх боломж бүрдлээ.

DELL IDPA ТЕХНОЛОГИ

Банкны нөөц дата төвд Dell IDPA технологийн шийдлийг нэвтрүүлэв. Ингэснээр банкны үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн сан, аппликэйшн систем тэдгээрийн найдвартай нөөцийг банкны үндсэн болон нөөц дата төвд дэвшилтэд шийдэл ашиглан хадгалах, шаардлагатай тохиолдолд дата төвүүдийн алинд ч сэргээх үйл ажиллагааг богино хугацаанд гүйцэтгэх боломжтой болсон.



Олон улсын гадаад гуйвуулгын SWIFT сүлжээний SWIFT GPI үйлчилгээг банкны үйл ажиллагаанд нэвтрүүллээ. Ингэснээр гадаад шилжүүлгийг бодит цагийн горимоор хянах, буцаан дуудах хүсэлт илгээх, хүлэн авах, шилжүүлгийн гүйлгээ эцсийн хүлээн авагчид очих, гүйцэтгэгдэх хугацааг багасгах, харилцагчид тухай бүр нь гүйлгээтэй холбоотой мэдээллийг мэдэгдэх давуу талууд бий болсон.

- Банкны суурь бүртгэлийн системийн мэдээллийн сангийн гүйцэтгэлийг нэмэгдүүлж, ачаалал даах чадвар, найдвартай ажиллагааг сайжруулсан. Уг шинэчлэлтийн үр дүнд мэдээллийн сангийн гүйцэтгэл 30 хувиар нэмэгдэж, тогтвортой найдвартай ажиллагаа сайжирсан.



Монголбанкнаас хэрэгжүүлж буй ₮ картыг чип технологитой болгох ажлын хүрээнд ХХБанк манлайлан оролцож ₮ чип картыг гуравдагч байгууллагаар баталгаажуулалтыг амжилттай хийлгэж 2021.10.01-с эхлэн дотоодын ₮ чип картыг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Уг ажлын хүрээнд ХХБанкны нийт АТМ, ПОС терминалын хувьд шаардлагатай тохиргоо хийгдэж ₮ чип картыг бүрэн дэмжиж ажиллах боломжтой болсон.



2020 онд хөндлөнгийн аудитаар Pin Security Audit хийлгэж, уг аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу 2021 онд картын онлайн системийн нууцлалын түлхүүрийг "Keyblock" төрөлд шилжүүлэн шинэчилсэн. Ингэснээр төлбөрийн карт, АТМ, ПОС төхөөрөмжийн нууцлал аюулгүй байдал сайжирч, олон улсын стандартын шаардлагад нийцэн ажиллаж байна.



Харилцагч TDB Online системийн OTP идэвхжүүлэх кодыг зөвхөн салбарт өөрийн биеэр ирж авдаг байсныг TDB Online системийг ашиглан онлайнар хүлээн авах боломжтой болгосон. Ингэснээр цар тахал, хөл хорионы үед харилцагч нарт үүсэж байсан хүндрэлтэй асуудлыг автоматжуулж, салбар тооцооны төвийн ажилтнуудын ачааллыг бууруулсан.



TDB Online системийн карт захиалгын хэсэгт карт дахин захиалах боломжийг шинээр нэмсэн. Уг боломж нэмэгдсэнээр харилцагч картаа хаях эсвэл гэмтээсэн тохиолдолд заавал салбарт очиж хүсэлт өгөхгүй TDB Online системээс карт дахин захиалах боломжтой боллоо.



TDB Online системд TDB Wallet –г шинээр нэвтрүүлсэн. Уг боломжийн хүрээнд банкны харилцагч өөрийн дурын банкны картыг өөрийн Wallet-д бүртгэх, түүгээр дамжуулан гүйлгээг шимтгэлгүй хийх боломжтой болсон.



Банкны зээл олголтын үйл ажиллагааг автоматжуулж иргэдийн зээл олголтын үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан (AI), машин сургалт (Machine learning)-д тулгуурласан харилцагчийн кредит скоринг тооцох моделийг сургаж үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Ингэснээр банк харилцагчийн санхүүгийн үзүүлэлтэд тохирсон зээлийн нөхцөлийг санал болгох, зээл олгох хугацааг богиносгох, ажилтнаас хамаарах хамаарлыг багасгах, чанаргүй зээл бий болох эрсдэлийг бууруулах давуу талтай.



Жижиг дунд болон томоохон байгууллагуудын ашигладаг шугамын зээлийн үйлчилгээг ЖДБЭрхлэгчдэд нээлттэй болгож TDB Online системээр дамжуулан онлайнар шийдвэрлэх боломжтой болсон.



Харилцагчийн санал хүсэлтийг хүлээн авах нэгдсэн портал болох EAPP онлайн хүсэлтийн системийг шинээр үйл ажиллагаанд нэвтрүүлэв. Энэхүү порталаар дамжуулан иргэд хүсэлт илгээснээр тухайн иргэн нь банкны харилцагч биш тохиолдолд ДАН системээр баталгаажуулан банкны харилцагчаар бүртгүүлэх, Цалингийн зээлийн хүсэлт, Зээлийн хугацаа сунгах хүсэлт, Пос терминал захиалах хүсэлтүүдийг тус тус илгээх боломжтой болсон.

[\(https://www.cardcentre.mn/eapp/\)](https://www.cardcentre.mn/eapp/)



2021 оны ипотекийн орон сууцны зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор зээлийн хугацаа сунгах, зээл төлөлтийг хойшлуулах үйл ажиллагааг автоматжуулсан. Ингэснээр 18,713 зээлийн дансны эргэн төлөлтийг хойшлуулсан.



900 орчим ПОС төхөөрөмжийг шинээр үйл ажиллагаанд нэвтрүүлж, харилцагчдад хүлээлгэн өгсөн байна.

- 2021 онд ХХБанк нь банкны нөөц дата төвийн бэлэн байдлын туршилтыг 2 удаа гүйцэтгэж, туршилтаар бизнес үйл ажиллагаа, мэдээллийн сан, гадаад шилжүүлгийн Swift систем гэх мэт банкны бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй найдвартай байдлыг хангахад шаардлагатай үйл ажиллагааг шалган амжилттай баталгаажуулав.

shoppy.mn Шоппи ХХК-тай хамтарсан онлайн зээлийн үйлчилгээнд тус платформыг ашигладаг байгууллагуудыг нэмэх боломжийг үүсгэлээ. Ингэснээр харилцагчдын хэрэгцээ шаардлагад илүү ойртсон, олон нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг зээлийн таатай нөхцөлөөр авах боломжтой юм. Түүнчлэн "Ногоон зээл", байгальд ээлтэй бараа бүтээгдэхүүнд зориулсан зээлийн тусгай нөхцөл хэрэглэгчдэд санал болгох программын боломжийг үйл ажиллагаанд нэвтрүүлэв. Ингэснээр 17 худалдааны сайтуудаар онлайн зээлийн үйлчилгээг үзүүлэх боломж бүрдсэн. Мөн харилцагч байгальд ээлтэй бараа бүтээгдэхүүнийг илүү хялбар авах боломжтой болсон. 2021 онд Шоппи ХХК тай хамтарсан онлайн зээлийн шийдвэрлэгдсэн хүсэлт 117 хувиар нэмэгдсэн байна.


Тайлант онд мэдээллийн системийн сайжруулалт, автоматжуулалт, тасралтгүй найдвартай ажиллагаанд өндөр ач холбогдол өгч ажилласны үр дүнд нийт гүйлгээний 96.7 хувь нь цахим суваг ашиглан хийгдсэн байгаа нь өмнөх оноос 1.7 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



Нийт гүйлгээний
96.7% цахим сувагаар хийгдсэн

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК
(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

Аудитлагдсан санхүүгийн тайлан
2021 оны 12 дугаар сарын 31



Building a better
working world

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК**Аудитлагдсан санхүүгийн тайлан**

Агуулга	Хуудас
Банкны талаарх мэдээлэл	1
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга ба гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл	2
Хараат бус аудиторын дүгнэлт	3 – 4
Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	5
Санхүүгийн байдлын тайлан	6
Өмчийн өөрчлөлтийн тайлан	7
Мөнгөн гүйлгээний тайлан	8 – 10
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	11 – 101

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК**Банкны талаарх мэдээлэл**

ТУЗ-ийн гишүүд:	Д. Эрдэнэбилэг (ТУЗ-ийн дарга) Р. Коппа Д. Янжмаа Д. Хүрэлбаатар Ж. Болормаа Ж. Дэлгэрсайхан
Нарийн бичгийн дарга:	Н. Нямсүрэн
Албан хаяг:	Энхтайвны өргөн чөлөө 19, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Улаанбаатар хот 14210, Монгол улс
Аудиторууд:	Эрнст энд Янг Монголия Аудит ХХК Мэргэшсэн нягтлан бодогчид

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга ба гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл

Худалдаа Хөгжлийн Банк ХХК-ийн (цаашид “Банк” гэх) Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”)-ийн дарга Должингийн Эрдэнэбилэг, Гүйцэтгэх захирал Ононгийн Орхон болон Санхүү хариуцсан захирал Дуламжавын Энхтуяа, бид Банкны санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.


Должингийн Эрдэнэбилэг
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга


Ононгийн Орхон
Гүйцэтгэх захирал


Дуламжавын Энхтуяа
Санхүү хариуцсан захирал

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2022 оны 3-р сарын 31



Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel : +976 11 314032 / +976 11 312005
Fax : +976 11 312042
ey.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Худалдаа Хөгжлийн Банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид Худалдаа Хөгжлийн Банк ХХК (“Банк”)-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Банкны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)-өөс баталж гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”-ийн дагуу Банкнаас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Банкны үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

“АОУС”-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Банкны дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлттэй эсэхийг үнэлэх.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Худалдаа Хөгжлийн Банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Банкны үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Банкны тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Банкны хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Банкны хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.




Гарын үсэг зурсан



Доржбат Мандахбаяр
Захирал
Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2022 оны 3-р сарын 31

Баталсан



Адриан Чу
Партнер

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

	Тодруулга	2021 мян.төг	2020 мян.төг
Үр ашигт хүүгээр тооцсон хүүний орлого	5	570,786,451	693,931,310
Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого	5	26,321,014	18,648,135
Хүү болон түүнтэй адилтгах зардал	6	(405,636,562)	(506,145,302)
Хүүний цэвэр орлого		191,470,903	206,434,143
Шимтгэл, хураамжийн орлого	7	65,236,995	54,072,967
Шимтгэл, хураамжийн зардал	7	(20,800,855)	(14,708,811)
Шимтгэл, хураамжийн цэвэр орлого		44,436,140	39,364,156
Арилжааны болон үйл ажиллагааны бусад зардал	8	(13,405,598)	(21,075,742)
Нийт үйл ажиллагааны орлого		222,501,445	224,722,557
Хүлээгдэж буй үнэ цэнийн бууралтын алдагдлын буцаалт/(зардал)	9	57,705,549	(136,115,283)
Үйл ажиллагааны цэвэр орлого		280,206,994	88,607,274
Үйл ажиллагааны зардал	10	(130,938,563)	(131,602,195)
Хараат компанийн алдагдлын хувь	16	(28,728,932)	(14,501,873)
Татварын өмнөх ашиг/(алдагдал)		120,539,499	(57,496,794)
Орлогын албан татварын зардал	11.1	(15,729,066)	(3,296,265)
Тайлант жилийн ашиг/(алдагдал)		104,810,433	(60,793,059)
Нэгж хувьцааны ашиг (Төгрөг):			
Нэгж хувьцаанд ноогдох суурь болон хорогдуулсан ашиг/(алдагдал)	12	21,803	(16,546)
Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал) (татварын дараах)			
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдах бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):</i>			
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өрийн хэрэглүүрийн дахин үнэлгээний өөрчлөлт	32	(1,266,566)	259,785
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):</i>			
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өмчийн хэрэглүүрийн дахин үнэлгээний өөрчлөлт	32	(18,633,681)	2,074,620
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	32	14,843,570	-
Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал)		(5,056,677)	2,334,405
Тайлант жилийн татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого/(алдагдал)		99,753,756	(58,458,654)

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

Санхүүгийн байдлын тайлан

	Тодруулга	2021 оны 12 сарын 31 мян.төг	2020 оны 12 сарын 31 мян.төг	2020 оны 1 сарын 1 мян.төг
ХӨРӨНГӨ				
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	13	976,352,237	856,797,775	1,095,813,724
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	14	504,417,550	570,001,654	300,933,709
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдлын тайланд бүртгэх санхүүгийн хөрөнгө	15	199,870,221	127,666,125	97,023,096
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдлын тайланд бүртгэх өмчийн хэрэглүүр	15	–	–	31,035,000
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өрийн хэрэглүүр	15	1,754,434,647	714,034,384	628,163,257
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өмчийн хэрэглүүр	15	57,662,947	34,422,196	26,254,377
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүр	15	590,679,288	835,033,030	1,048,988,620
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	16	506,297	40,813,475	–
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	17	101,647,498	89,371,192	494,861,756
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	18	4,588,465,405	4,025,127,248	3,468,609,901
Бусад хөрөнгө	19	200,051,593	125,974,796	131,193,070
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	20	79,902,629	148,990,218	80,897,528
Борлуулах зориулалттай хөрөнгө	21	3,605,964	4,138,693	–
Үндсэн хөрөнгө	22	480,838,433	458,644,011	392,311,221
Ашиглах эрхтэй хөрөнгө	23	7,902,693	10,132,850	12,717,699
Биет бус хөрөнгө	24	2,334,413	4,374,414	5,870,617
НИЙТ ХӨРӨНГӨ		9,548,671,815	8,045,522,061	7,814,673,575
ӨР ТӨЛБӨР				
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	25	13,938,713	102,946,144	189,383,778
Рэпо хэлцэл	26	289,792,528	224,287,616	65,013,356
Харилцагчдын харилцах, хадгаламж	27	6,266,310,519	5,311,418,183	3,821,434,134
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	17	78,035,961	99,723,102	76,226,529
Зээлээр авсан санхүүжилт	28	1,408,740,129	558,736,354	759,290,707
Хоёрдогч өглөг		–	–	150,046,057
Гаргасан өрийн бичиг	29	160,140,274	160,140,274	1,536,488,710
Бусад өр төлбөр	30	289,069,965	644,264,706	512,311,798
Түрээсийн өр төлбөр	23	8,999,663	11,384,522	13,591,398
Орлогын татварын өглөг	11.2	12,499,999	111,957	–
Хойшлогдсон татварын өр төлбөр	11.3	1,035,344	2,155,509	–
НИЙТ ӨР ТӨЛБӨР		8,528,563,095	7,115,168,367	7,123,786,467
ЭЗДИЙН ӨМЧ				
Энгийн хувьцаа	31	323,809,925	72,723,171	50,000,707
Нэмж төлөгдсөн капитал	31	–	251,086,754	19,298,006
Бусад нөөц	31	210,143,332	220,381,635	178,559,796
Хуримтлагдсан ашиг		486,155,463	386,162,134	443,028,599
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		1,020,108,720	930,353,694	690,887,108
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		9,548,671,815	8,045,522,061	7,814,673,575

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Өмчийн өөрчлөлтийн тайлан

	Энгийн хувьцаа мян.төг (Тод. 31)	Нэмж төлөгдсөн капитал мян.төг (Тод. 31)	Бусад нөөц мян.төг (Тод. 31)	Хуримтлагдсан ашиг мян.төг	Нийт эздийн өмч мян.төг
2019 оны 1 сарын 1-ээр	50,000,707	19,298,006	151,476,785	482,926,897	703,702,395
СТОУС 9-н нөлөө	–	–	(321,974)	(12,493,313)	(12,815,287)
Тусгай зориулалттай нөөцөд шилжүүлсэн *	–	–	27,404,985	(27,404,985)	–
2020 оны 1 сарын 1-ний байдлаар	50,000,707	19,298,006	178,559,796	443,028,599	690,887,108
Тайлант жилийн ашиг	–	–	–	(60,793,059)	(60,793,059)
Бусад дэлгэрэнгүй орлого	–	–	2,334,405	–	2,334,405
Нийт дэлгэрэнгүй орлого	–	–	2,334,405	(60,793,059)	(58,458,654)
Хэрэгжсэн дахин үнэлгээний нөөц	–	–	(17,689)	17,689	–
УБХБ-аас шилжиж ирсэн нөөц (Тод. 3)	–	–	43,414,028	–	43,414,028
Тусгай зориулалттай нөөцөд шилжүүлсэн*	–	–	(3,908,905)	3,908,905	–
Нэгдэлтэй холбоотойгоор нэмж гаргасан хувьцаа (Тод. 3)	9,973,842	94,537,126	–	–	104,510,968
Шинээр гаргасан хувьцаа (Тод. 31)	12,748,622	137,251,622	–	–	150,000,244
2020 оны 12 сарын 31-ний болон 2021 оны 1 сарын 1-ний байдлаар	72,723,171	251,086,754	220,381,635	386,162,134	930,353,694
Тайлант жилийн ашиг	–	–	–	104,810,433	104,810,433
Бусад дэлгэрэнгүй орлого	–	–	(5,056,677)	–	(5,056,677)
Нийт дэлгэрэнгүй орлого	–	–	(5,056,677)	104,810,433	99,753,756
Хэрэгжсэн дахин үнэлгээний нөөц	–	–	(32,613,320)	32,613,320	–
Ногдол ашиг (Тод. 31)	–	–	–	(9,998,730)	(9,998,730)
Тусгай зориулалттай нөөцөд шилжүүлсэн*	–	–	27,431,694	(27,431,694)	–
Энгийн хувьцааны нэмэгдэл	251,086,754	(251,086,754)	–	–	–
2021 оны 12 сарын 31-ний байдлаар	323,809,925	–	210,143,332	486,155,463	1,020,108,720

*Бусад нөөцөд тусгай зориулалтын нөөц багтсан ба уг нөөцийг Монголбанкны шаардлагад нийцүүлэн байгуулсан бөгөөд Монголбанкны зөвшөөрлөөр Банкны хувьцаа эзэмшигчид хуваарилах боломжтой.

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Мөнгөн гүйлгээний тайлан

Тодруулга	2021 мян.төг	2020 мян.төг
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Татварын өмнөх ашиг	120,539,499	(57,496,794)
<i>Тохируулгууд:</i>		
Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	(21,067,389)	7,287,137
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	8 (10,997,768)	(169,780)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө борлуулсны (олз)/гарз	8 (3,391,791)	(3,022,069)
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн (“ХОЗҮХХ”) үнэ цэнийн өөрчлөлтийн олз	8 (433,617)	(20,122,404)
Өмчлөх бусад хөрөнгө борлуулсны цэвэр (олз)/гарз	8 (204,152)	365,423
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө борлуулсны олз	8 (6,063,066)	–
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт хэсэгчлэн борлуулсны олз	8 (5,434,794)	–
Орон сууцны зээлийн бүтцийн өөрчлөлтөөс үүссэн цэвэр гарз	8 6,754,302	5,592,847
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх (БҮЦӨБДО) өрийн хэрэглүүр борлуулсны (олз)/гарз	8 509,109	(3,585,857)
Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралт	8 27,650,688	–
Бусад зээл болон урьдчилгааны бүтцийн өөрчлөлтийн гарз	8 17,805,897	–
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд (БҮЦӨБДО) бүртгэгдэх өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын анхны хүлээн зөвшөөрөлтийн гарз	8 14,508,803	–
Өмчлөх бусад хөрөнгө данснаас хассаны гарз	8 2,123,116	11,246,598
Хөрөнгийн дахин үнэлгээний гарз	8 1,745,195	–
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтаас хүлээн зөвшөөрсөн олз	8 –	(768,590)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх (БҮЦӨАА) өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн гарз	8 –	4,158,690
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх (БҮЦӨАА) хөрөнгө оруулалт борлуулсны гарз	8 –	41,282
Хараат компанийн алдагдлын Банканд ногдох хувь	16 28,728,932	14,501,873
Эрсдэлийн сангийн зардал/(буцаалт)	9 (57,705,549)	136,115,283
Үндсэн хөрөнгийн элэгдэл	10 13,653,950	12,977,972
Биет бус хөрөнгийн хорогдуулга	10 2,373,456	2,421,188
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	10 5,128,494	4,865,339
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	10 154,371	34,119
Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз	10 –	346,076
Зээлээр авсан санхүүжилтийн хүүгийн зардал	6 116,374,067	119,439,476
Хоёрдогч өглөгийн хүүгийн зардал	6 –	20,666,526
Гаргасан өрийн бичгийн хүүгийн зардал	6 12,800,000	70,089,966
Түрээсийн өглөгийн хүүгийн зардал	6 1,219,631	1,821,379
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн бус гүйлгээ	(2,278,405)	31,862,218
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	264,492,979	358,667,898
Үйл ажиллагааны хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлтүүд:		
Монголбанк дахь заавал байлгах нөөц	(124,050,688)	(128,337,531)
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	(15,513,234)	65,395,769
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	(501,093,613)	150,256,004
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	3,873,960	5,953,514
Бусад хөрөнгө	(61,028,385)	21,112,053
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	(89,007,431)	(104,335,246)
Репоз хэлцэл	65,504,912	150,847,622
Харилцагчдын харилцах, хадгаламж	954,892,336	681,415,078
Бусад өр төлбөр	(348,300,156)	(29,327,557)
Үндсэн үйл ажиллагаанаас хүлээн авсан мөнгөн гүйлгээ	149,770,680	1,171,647,604
Төлсөн орлогын албан татвар	–	(5,470,061)
Түрээсийн өглөгийн хүүгийн хэсэгт хамаарах төлөлт	(1,219,631)	(1,821,379)
Зээлээр авсан санхүүжилтийн хүүгийн төлөлт	(105,600,240)	(123,622,668)
Хоёрдогч өглөгийн хүүгийн төлөлт	–	(20,712,359)
Гаргасан өрийн бичгийн хүүгийн төлөлт	(12,800,000)	(78,299,373)
Үндсэн үйл ажиллагаанаас хүлээн авсан цэвэр мөнгөн гүйлгээ	30,150,809	941,721,764

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

Тодруулга	2021 мян.төг	2020 мян.төг
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Нэгдлийн үр дүнд хүлээн авсан бэлэн мөнгө	3 –	7,705,567
Санхүүгийн хөрөнгө оруулалтын худалдан авалт	(1,422,590,074)	(149,727,966)
Санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны орлого	930,207,988	368,144,729
Алтны урьдчилгаа гэрээний төлөлт	(14,244,000)	–
Үндсэн хөрөнгө борлуулснаас хүлээн авсан мөнгө	15,976,615	3,770,943
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	22 (25,018,146)	(4,919,708)
Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулсны олз	10,305,493	–
Биет бус хөрөнгийн худалдан авалт	24 (333,455)	(381,917)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас хүлээн авсан цэвэр мөнгөн гүйлгээ	(505,695,579)	224,591,648
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Зээлээр авсан санхүүжилтийн татан авалт	1,096,949,851	359,758,646
Зээлээр авсан санхүүжилтийн эргэн төлөлт	(255,441,498)	(596,544,559)
Ногдол ашиг	31 (9,998,730)	–
Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн хэрэгжилтээс олсон орлого	–	421,700,000
Өрийн бичгийн эргэн төлөлт	–	(1,397,320,000)
Хоёрдогч өглөгийн (эргэн төлөлт)/татсан эх үүсвэр	31 –	(150,000,224)
Шинээр гаргасан хувьцаа /(Эргэлтээс гаргасан хувьцаа)	31 –	150,000,244
Түрээсийн өглөгийн үндсэн төлбөрийн эргэн төлөлт	(5,230,452)	(4,317,826)
Санхүүгийн үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ	826,279,171	(1,216,723,719)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)	350,734,401	(50,410,307)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13 1,376,373,291	1,426,783,598
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13 1,727,107,692	1,376,373,291
Хүүтэй холбоотой үйл ажиллагааны мөнгөн урсгал		
Төлсөн хүү	412,379,234	(483,879,585)
Хүлээн авсан хүү	646,982,797	542,726,441
Мөнгөн бус үйл ажиллагаанууд		
Ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өглөгийн нэмэгдэл	23 2,636,768	1,682,331
Түрээсийн гэрээний өөрчлөлт	23 575,218	–
Зээлийн үүргийн гүйцэтгэлийг барьцаа хөрөнгөөр хангуулсан	20,404,728	52,892,702
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	34,069,935	–
Үндсэн хөрөнгийн борлуулалтын үнэ	33,789,205	–
Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн борлуулалтын үнэ	16,655,777	–
Санхүүгийн хөрөнгө оруулалтаас хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт руу хийсэн дахин ангилал	16 –	26,876,310
Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн өөрчлөлт		
Түрээсийн өглөг	мян.төг	мян.төг
1 сарын 1-нээр	11,384,522	13,591,398
Мөнгөн бус нэмэгдэл	2,636,768	1,682,331
УБХБ-аас шилжиж ирсэн	–	970,544
Түрээсийн өөрчлөлт	575,218	–
Түрээсийн гэрээ цуцлагдсан түрээсүүд	(366,393)	(541,925)
Тайлант үеийн хүүгийн зардал	1,219,631	1,821,379
Түрээсийн өглөгийн хүүгийн төлөлт	(1,219,631)	(1,821,379)
Түрээсийн өглөгийн үндсэн төлбөрийн төлөлт	(5,230,452)	(4,317,826)
12 сарын 31-нээр	8,999,663	11,384,522

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн өөрчлөлт (үргэлжлэл)

	Зээлээр авсан санхүүжилт мян.төг	Хоёрдогч өглөг мян.төг	Гаргасан өрийн бичиг мян.төг
2020 оны 1 сарын 1-нээр	759,290,707	150,046,057	1,536,488,710
Шинээр татсан эх үүсвэр	359,758,646	–	–
УБХБ-аас шилжиж ирсэн (Тод. 3)	37,733,505	–	–
Эргэн төлөлт	(596,544,559)	(150,000,224)	(1,397,320,000)
Хүүгийн төлөлт	(123,622,668)	(20,712,359)	(78,299,373)
Цэвэр (эргэн төлөлт)/татсан эх үүсвэр	(322,675,076)	(170,712,583)	(1,475,619,373)
Хойшлогдсон төлбөр	(7,538,698)	–	–
Гадаад валютын ханшийн зөрүү	10,219,945	–	29,180,971
Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн бус гүйлгээ	2,681,247	–	29,180,971
Хуримтлагдсан хүү болон хойшлогдсон төлбөрийн хорогдуулалт	119,439,476	20,666,526	70,089,966
2020 оны 12 сарын 31 болон 2021 оны 1 сарын 1- ний байдлаар	558,736,354	–	160,140,274
Шинээр татсан эх үүсвэр	1,096,949,851	–	–
Эргэн төлөлт	(255,441,498)	–	–
Хүүгийн төлөлт	(105,600,240)	–	(12,800,000)
Цэвэр эргэн төлөлт	735,908,113	–	(12,800,000)
Хойшлогдсон төлбөр	(2,127,043)	–	–
Гадаад валютын ханшийн зөрүү	(151,362)	–	–
Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн бус гүйлгээ	(2,278,405)	–	–
Хуримтлагдсан хүү болон хойшлогдсон төлбөрийн хорогдуулалт	116,374,067	–	12,800,000
2021 оны 12 сарын 31-ний байдлаар	1,408,740,129	–	160,140,274

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 сарын 31

1. Банкны талаарх мэдээлэл

Худалдаа, хөгжлийн банк ХХК (“Банк”) нь 1990 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан ба 1993 онд хийгдсэн анхны банкны салбарын хяналт, шалгалтын актын дор Монголбанкнаас олгосон 8 тоот зөвшөөрлийн дагуу банк, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг.

Банк нь Монгол улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Банкны төв байрны албан ёсны хаяг нь Худалдаа, хөгжлийн банкны байр, Энх тайвны өргөн чөлөө 19, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Улаанбаатар хот 14210, Монгол улс.

Банк нь Банкны тухай хууль болон Монголбанкны 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн Н/100 тоот тогтоолд тус тус үндэслэн 2020 оны 6 дугаар сарын 26-нд Улаанбаатар хотын банк ХХК (“УБХБ”)–тай албан ёсоор нэгдсэн. Нэгдэл нь Банк болон УБХБ-ны хооронд байгуулсан Нэгтгэн нийлүүлэх гэрээгээр зохицуулагдсан ба 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн УБХБ-ны бүх хөрөнгө, өр төлбөр, нөөц болон салбарууд нь Банканд нэгтгэгдсэн (“Нэгдэл”) болно (Тодруулга 3-г харна уу).

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар банкны 64.00%-ийг Сингапурт бүртгэлтэй Глобулл Инвестмент энд Девелопмент Пте Лтд (“Глобулл”) эзэмшиж байв. Глобулл-н 92.20%-ийг АНУ-д бүртгэлтэй Ю Эс Глобал Инвестмент ХХК, 7.80%-ийг Должингийн Эрдэнэбилэг тус тус эзэмшдэг. (Банкны хувьцаа эзэмшигчид болон тэдгээрийн эзэмшлийн хувийг Тодруулга 31-ээс харна уу). Ю Эс Глобал Инвестмент ХХК-г Должингийн Эрдэнэбилэг бүхэлд нь эзэмшдэг.

2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилийн санхүүгийн тайлангуудыг гаргахыг зөвшөөрөв.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд

2.1 Тайлан бэлтгэх үндэслэл ба нийцлийн мэдэгдэл

Банкны санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)–өөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)–ын дагуу бэлтгэгдсэн болно.

Банк нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилийн санхүүгийн тайлангуудыг СТОУС 9 “Санхүүгийн хэрэглүүр”-ийн хэрэгжилтээс бусдаар НББОУСЗ-өөс баталж гаргасан СТОУС-ын дагуу боловсруулсан банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу бэлтгэж толилуулсан ба санхүүгийн хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтын бүртгэлдээ Монголбанкаас баталсан заавар, журмыг мөрдөж байсан.

Банк нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилд СТОУС 9-г анх удаа хэрэгжүүлж эхэлсэн. Иймээс Банкны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилийн санхүүгийн тайлангууд нь СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн анхны тайлан болно. Дэлгэрэнгүйг Тодруулга 2.5-аас харна уу.

Санхүүгийн тайлангууд нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн болон өмчийн хэрэглүүр, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө, бодит үнэ цэнийн аргаар бүртгэгдэх санхүүгийн үүсмэл хэрэглүүр, борлуулах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө, анх хүлээн зөвшөөрснөөс хойш дараа тайлант үед бодит үнэ цэнээр хэмжигдэх барилга болон газар, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, үнэт металлыг эс тооцвол түүхэн өртөгийн зарчмаар бэлтгэгдсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд мянгачилан, Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр тайлагнасан.

2.2 Санхүүгийн тайлангийн толилуулга

Банк нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварынх нь дарааллаар толилуулсан. Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараах 12 сарын дотор (богино хугацаанд) ба 12 сараас хойших хугацаанд (урт хугацаанд) хүлээн авах эсвэл төлөх төлбөрийн талаарх шинжилгээг тодруулга 37-д толилуулсан.

Ирээдүйн үйл явдлаас хамааралгүйгээр хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй ба хөрөнгө, өр төлбөрийг зэрэг хүлээн зөвшөөрөх эсвэл цэвэр дүнгээр нь барагдуулах хандлагатай байгаа үед санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлж, цэвэр дүнг санхүүгийн байдлын тайланд толилуулна. Нягтлан бодох бүртгэлийн стандарт эсвэл тайлбарт шаардаагүй эвсэл зөвшөөрөөгүй мөн банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгайлан толилуулаагүй тохиолдолд орлого ба зардлын дүнгүүдийг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд цэвэршүүлэхгүй.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)**2.3 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд**

Банкны санхүүгийн тайлангуудыг батлан гаргах өдрийн байдлаар батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартуудын жагсаалтыг дор үзүүлэв. Банк энэхүү стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх үеэс дагаж мөрдөнө.

<ul style="list-style-type: none"> СТОУС 17 СТОУС 17-ын нэмэлт өөрчлөлт НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт СТОУС 3-ын нэмэлт өөрчлөлт НББОУС 16-ын нэмэлт өөрчлөлт 	<p><i>Даатгалын гэрээ¹</i> <i>Даатгалын гэрээ¹</i> <i>Богино хугацаат болон урт хугацаат өр төлбөрийн ангилал¹</i> <i>Үзэл баримтлалын хүрээний зөвлөмж²</i> <i>Үндсэн хөрөнгө: Зориулалтаар ашиглаж эхлэхээс өмнөх хөрөнгийн орлого²</i> <i>Давагдашгүй гэрээ – Гэрээ биелүүлэх зардал²</i> <i>Охин компани нь анхлан хэрэгжүүлэгч²</i></p>
<ul style="list-style-type: none"> НББОУС 37-ын нэмэлт өөрчлөлт СТОУС 1 Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартыг анх удаа хэрэгжүүлэх СТОУС 9 	<p><i>Санхүүгийн хэрэглүүр – Санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх '10 хувь' шалгуур - хураамж²</i> <i>Бодит үнэ цэнийн хэмжилт дэх татвар²</i> <i>Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт¹</i> <i>Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг толилуулах нь¹</i></p>
<ul style="list-style-type: none"> НББОУС 41 Хөдөө аж ахуй НББОУС 8-ын нэмэлт өөрчлөлт НББОУС 1 ба СТОУС Практикийн бичиг баримт 2-ын нэмэлт өөрчлөлт 	

¹2023 оны 1 сараас эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ

²2022 оны 1 сараас эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ

СТОУС 17 Даатгалын гэрээ

2017 оны 5-р сард НББОУС3 нь даатгалын гэрээний хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, тайлагнал болон толилуулгын зарчмуудыг тусгасан нягтлан бодох бүртгэлийн иж бүрэн шинэ стандарт болох СТОУС 17 Даатгалын гэрээ стандартыг баталсан. СТОУС 17 нь хүчин төгөлдөр болох хугацаанаасаа эхлэн 2005 онд батлагдсан СТОУС 4 Даатгалын гэрээ стандартыг орлоно. СТОУС 17 нь даатгалыг гаргаж буй аж ахуйн нэгжийн төрлөөс үл хамааран бүх төрлийн даатгалын гэрээнд (жишээлбэл, амь насны даатгал, шууд даатгал, давхар даатгал гэх мэт) мөн түүнчлэн тодорхой онцлог бүхий санхүүгийн хэрэглүүр болон баталгаанд үйлчилнэ. Стандартын хамрах хүрээ нь цөөн хэдэн хязгаарлалттай. СТОУС 17 нь СТОУС 9 эсхүл СТОУС 17-ийн хүрээнд ямар хэрэглүүр эсхүл бүрэлдэхүүн хэсгүүд орохыг тодорхойлоход нөлөөлж болох даатгалын шинж чанар бүхий банкны бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн шинэ шаардлагыг танилцуулсан.

Даатгалд хамрагддаг зээлийн карт ба түүнтэй адилтгах бүтээгдэхүүнүүд: эдгээр бүтээгдэхүүнийг олгогчдын ихэнх нь СТОУС 9-ийн дагуу санхүүгийн хэрэглүүр гэж үзэн одоогийн ашиглаж буй бүртгэлийн зарчмыг үргэлжлүүлэх боломжтой болно. СТОУС 17 нь даатгалын гэрээний тодорхойлолтыг хангасан зээлийн картын гэрээг (мөн түүнтэй адилтгах зээлийн эсхүл төлбөрийн нөхцөлтэй бусад гэрээг) гагцхүү аливаа нэг үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээний үнийг тогтоохдоо тухайн үйлчлүүлэгчийн даатгалтай холбоотой эрсдлийг тусгаагүй тохиолдолд СТОУС 17-ийн хамрах хүрээнд оруулахгүй.

Хэрэв даатгалын нөхцөл нь зээлийн картын гэрээний нөхцлийн нэг хэсэг болж олгогддог тохиолдолд, олгогч нь дараах шаардлагын дагуу бүртгэнэ:

- Даатгалын бүрэлдэхүүн хэсгийг салгаж СТОУС 17-ийн дагуу бүртгэх
- Бусад бүрэлдэхүүн хэсгүүдийг холбогдох бусад стандартууд (жишээлбэл, СТОУС 9, СТОУС 15 Хэрэглэгчидтэй байгуулсан гэрээний орлого эсхүл НББОУС 37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө гэх мэт)-ын дагуу бүртгэнэ.

Даатгалын шинж чанарыг хангасан боловч даатгалын тохиолдол үүсэхэд гэрээний дагуу даатгуулагчийн үүргийг биелүүлэхэд шаардагдах хэмжээгээр нөхөн төлбөрийг хязгаарласан зээлийн гэрээ: Энэ төрлийн зээлийг олгогчид – жишээ нь: нас баралтаас болон чөлөөлөгдсөн зээл - СТОУС 9 эсхүл СТОУС 17-г сонгох боломжтой. Уг сонголт нь эргэлт буцалтгүй бөгөөд багцын түвшинд хийгдэнэ.

СТОУС 17 нь 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэх эсхүл түүнээс хойших тайлагналын хугацаанд хүчин төгөлдөр болох бөгөөд шаардлагатай тоон үзүүлэлтүүдийг харьцуулна. Хэрэв Банк нь СТОУС 17 анх хэрэгжүүлж эхлэхээс өмнө эсхүл тухайн өдрөөс эхлэн СТОУС 9 болон СТОУС 15 стандартуудыг хэрэгжүүлж эхэлсэн тохиолдолд СТОУС 17-г хугацаанаас нь өмнө мөрдөж эхлэхийг зөвшөөрсөн. Уг стандарт нь Банкны санхүүгийн тайланд нөлөөлөхгүй гэж үзэж байна.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)**2.3 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд (үргэлжлэл)****СТОУС 17 Даатгалын гэрээтэй холбоотой нэмэлт өөрчлөлт**

СТОУС 17-д оруулсан нэмэлт нь стандартын тодорхой шаардлагуудыг хялбарчилж, санхүүгийн гүйцэтгэлийг тайлбарлахад хялбар болгосон болно. Мөн нэмэлт өөрчлөлтүүд нь, СТОУС 17-д шилжихэд шаардагдах хүчин чармайлтыг багасгах нэмэлт хөнгөлөлтүүдийг тусгасан. Түүнчлэн нэмэлт өөрчлөлтүүд нь СТОУС 17-ын хүчин төгөлдөр болох хугацаа буюу 2023 оны 1-р сарын 1-нээс эхлэх буюу түүнээс хойш жилийн тайлангийн үе болон өмнө нь хэрэглэхийг зөвшөөрсөнийг хойшлуулсан. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь Банкинд нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

НББОУС 1 Богино хугацаат болон урт хугацаат өр төлбөрийн ангилал ба түүнтэй холбоотой нэмэлт өөрчлөлт

2020 оны 1-р сард НББОУС3 нь НББОУС 1-ийн 69-өөс 76-р хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулах замаар өр төлбөрийг урт ба богино хугацаат гэж ангилах шаардлагыг тодорхойлсон. Нэмэлт өөрчлөлтүүд нь:

- Төлбөр тооцоог хойшлуулах эрх гэж юу болох
- Тайлант хугацааны эцэст хойшлуулах эрхтэй байх ёстой
- Аж ахуйн нэгжийн хойшлуулах эрхээ хэрэгжүүлэх магадлал энэ ангилалд нөлөөлөхгүй
- Зөвхөн хөрвөх өр төлбөрт оруулсан дериватив нь өөрөө өмчийн хэрэглүүр болох тохиолдолд л өр төлбөрийн хугацаа нь түүний ангилалд нөлөөлөхгүй

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2023 оны 1-р сарын 1-нээс хойших тайлант жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилдэг болох бөгөөд эдгээрийг ухрааж бүртгэх аргаар хэрэгжүүлнэ. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь банкны санхүүгийн тайланд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

Үзэл баримтлалын тайлбар - СТОУС 3-ын нэмэлт өөрчлөлтүүд

2020 оны 5-р сард НББОУС3-өөс СТОУС 3 Бизнесийн нэгдэл - үзэл баримтлалын хүрээний талаархи нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Нэмэлт өөрчлөлтүүд нь 1989 онд гаргасан Санхүүгийн тайланг бэлтгэх, танилцуулах хүрээ, түүний шаардлагыг мэдэгдэхүйц өөрчлөхгүйгээр 2018 оны 3-р сард баталсан Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын хүрээний зөвлөмжөөр солих зорилготой байсан.

Түүнчлэн удирдах зөвлөлөөс НББОУС 37 эсвэл СТОУТХ 21 Татварт хамаарах өр төлбөр ба болзошгүй өр төлбөрийн улмаас үүсэх "2 дахь өдөр" болзошгүй ашиг, алдагдлаас зайлсхийх үүднээс СТОУС 3-г хүлээн зөвшөөрөх зарчимд үл хамаарах зүйлийг нэмэлтээр оруулсан. Мөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайлан бэлтгэх, танилцуулах тогтолцооны зөвлөмжийг орлуулснаар нөлөөлөлд өртөж болзошгүй хөрөнгийн талаар СТОУС 3-т байгаа удирдамжийг тодруулж өгсөн.

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойших тайлангийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ. Нэмэлт өөрчлөлтүүд нь Банкинд нөлөөлөхгүй гэж үзэж байна.

Үндсэн хөрөнгө: Зориулалтаар ашиглаж эхлэхээс өмнөх орлого - НББОУС 16-ийн нэмэлт өөрчлөлт

2020 оны 5-р сард НББОУС-аас "Үндсэн хөрөнгө - Зориулалтаар ашиглаж эхлэхээс өмнөх орлого"-г батласан бөгөөд үүнд аж ахуйн нэгж байгууллагууд үндсэн хөрөнгийг өөрийн өртгөөс тухайн хөрөнгийг байршил, нөхцөл байдалд нь авчрах явцад үүссэн/бий болсон эд хөрөнгийг зарж борлуулахаас олсон орлогыг хасахыг хориглосон. Үүний оронд аж ахуйн нэгж эдгээр зүйлсийн борлуулалтаас олсон орлого, эдгээр бүтээгдэхүүнтэй холбоотой зардлыг ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ.

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2022 оны 1-р сарын 1-нээс хойши жилийн тайлангийн үеүүдэд хүчинтэй бөгөөд тухайн нэмэлт, өөрчлөлтийг анх хэрэглэх үед танилцуулсан хамгийн эрт хугацаа буюу түүнээс хойш ашиглах боломжтой болсон үндсэн хөрөнгөд буцаан хамаарах ёстой. Энэхүү өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланд томоохон нөлөө үзүүлэхгүй гэсэн хүлээлттэй байна.

Давагдашгүй гэрээ - Гэрээ биелүүлэх өртөг - НББОУС 37-ийн нэмэлт өөрчлөлтүүд

2020 оны 5-р сард НББОУС3-өөс НББОУС 37-д нэмэлт өөрчлөлт оруулж, гэрээ нь давагдашгүй эсвэл алдагдалтай эсэхийг үнэлэхдээ аж ахуйн нэгж ямар зардлыг тооцох шаардлагатайг тодорхойлсон. Нэмэлт өөрчлөлтүүд нь "шууд хамааралтай зардлын хандлагыг" хэрэгжүүлдэг. Бараа, үйлчилгээ үзүүлэх гэрээнд шууд хамааралтай зардлууд нь нэмэгдсэн өртөг болон гэрээний үйл ажиллагаатай шууд холбоотой зардлын хуваарилалтыг хоёуланг багтаана. Ерөнхий болон захиргааны зардал нь гэрээнд шууд хамааралгүй бөгөөд гэрээнд заасны дагуу нөгөө талдаа тодорхой төлбөр тооцоогүй тохиолдолд хасагдана.

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойших тайлангийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ. Банк эдгээр нэмэлт өөрчлөлтийг анх хэрэгжүүлэх тайлант жилийн эхэнд үүргээ биелүүлээгүй байгаа гэрээнүүдэд хэрэгжүүлнэ.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.3 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд (үргэлжлэл)

СТОУС 1 Олон улсын санхүүгийн тайлагналын стандартыг анхлан хэрэгжүүлэх - Охин компани нь анх удаа хэрэгжүүлэгчийн хувьд

СТОУС-ыг 2018-2020 оны туршид жил бүр боловсронгуй болгох ажлын хүрээнд НББОУСЗ-с СТОУС 1-д нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэ нэмэлт өөрчлөлтийг СТОУС 1-ийн Д16 (а)-г охин компани нь хэрэгжүүлэхээр сонгосон тохиолдолд хамааралтай бөгөөд толгой компанийн СТОУС-д шилжсэн огноог үндэслэн толгой компанийн тайлагнасан дүнг ашиглан хөрвүүлэлтээс үүссэн хуримтлагдсан зөрүүг хэмжихийг охин компанид зөвшөөрсөн. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойшхи тайлагналын хугацаанд хүчин төгөлдөр бөгөөд түүнээс өмнө хэрэгжүүлэхийг зөвшөөрнө. Нэмэлт өөрчлөлтүүд Банкинд нөлөөлөхгүй гэж үзэж байна.

СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр - Санхүүгийн өр төлбөрийг хэрэгсэхгүй болгох "10 хувь" тай тэнцэх төлбөрийн хураамжийн тест

2018-2020 оны туршид НББОУС-ын үйл явцыг жил бүр сайжруулж, НББОУСЗ-өөс СТОУС 9-д нэмэлт өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлтөөр аж ахуйн нэгж шинэ эсвэл өөрчлөгдсөн санхүүгийн өр төлбөрийн нөхцөл нь анхны санхүүгийн өр төлбөрийн нөхцөлөөс ялгаатай эсэхийг үнэлэхдээ төлбөрийн хэмжээг нэмж оруулсан болно. Эдгээр төлбөрт зөвхөн зээлдэгч ба зээлдүүлэгчийн хооронд төлсөн эсвэл хүлээн авсан төлбөр орох бөгөөд үүнд бусдын өмнөөс зээлдэгч эсвэл зээлдүүлэгчийн төлсөн буюу авсан төлбөр багтсан болно. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг тухайн аж ахуйн нэгжид анх хэрэгжүүлсэн тайлант жилд эсвэл дараа нь өөрчилсөн эсвэл солигдсон санхүүгийн өр төлбөрт энэхүү нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлнэ.

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойших тайлангийн хугацаанд хүчин төгөлдөр болно. Банк энэхүү өөрчлөлтийг хэрэгжүүлж эхэлсэнээс хойш эсвэл дараа нь өөрчилсөн санхүүгийн өр төлбөрүүдэд хэрэгжүүлэх ба энэ нь санхүүгийн тайланд нь материаллаг нөлөө үзүүлэхгүй гэсэн хүлээлттэй байна.

НББОУС 41 Хөдөө аж ахуй - Бодит үнэ цэнийн хэмжилт дэх татвар

НББОУСЗ нь 2018-2020 оны жилүүдэд СТОУС-ын стандартыг сайжруулах ажлын хүрээнд НББОУС 41 Хөдөө аж ахуй, стандартад нэмэлт өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлтөөр НББОУС 41-ийн 22 дахь хэсэгт зааснаар аж ахуйн нэгжүүд НББОУС 41-ийн хүрээнд хөрөнгийн бодит үнэ цэнийг хэмжихдээ татвар ногдуулах мөнгөн гүйлгээг хасах шаардлагыг хассан болно. Энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойших тайлант хугацааны бодит үнэ цэнийн хэмжилтэд хэрэгжүүлж эхлэнэ. Нэмэлт өөрчлөлт нь Банканд нөлөөлөхгүй гэж үзэж байна

НББОУС 8 нэмэлт өөрчлөлт: Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт

2021 оны 2-р сард НББОУСЗ нь НББОУС 8-ийн НББ-ийн тооцооллын тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулсан.

Энэхүү өөрчлөлтүүд нь НББ-ын тооцооллын өөрчлөлт, НББ-ийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга зэргийн хоорондын ялгааг тодорхойлсон. Мөн аж ахуй нэгжүүд НББ-ийн тооцооллыг боловсруулахад хэмжилтийн техник болон өгөгдөл хэрхэн хэрэглэгддэгийг тодруулж өгсөн.

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2023 оны 1-р сарын 1 –ний өдрөөс эсвэл түүнээс хойших тайлант жилүүдэд хүчин төгөлдөр болох бөгөөд НББ-ийн тооцооллын өөрчлөлт, НББ-ийн бодлогын өөрчлөлтүүдэд үйлчилнэ. Холбогдох баримтуудын толилуулсан тохиолдолд эрт хэрэгжүүлэхийг зөвшөөрнө.

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй.

НББОУС 1 болон СТОУС Практик тайлагналын 2 нэмэлт өөрчлөлтүүд: НББ-ийн бодлогын толилуулга

2021 оны 2-р сард НББОУСЗ-өөс НББОУС 1 болон СТОУС Практик тайлагналын 2-т материаллаг байдлын дүгнэлт хийх нэмэлт өөрчлөлтүүд оруулсан. Энэ нь НББ-ийн толилуулгад материаллаг байдлын дүгнэлтийг ашиглах заавар жишээг багтаасан. Нэмэлт өөрчлөлтүүд нь аж ахуйн нэгжүүдэд "гол" нягтлан бодох бүртгэлийн толилуулах шаардлагыг "материаллаг" нягтлан бодох бүртгэлийн бодлогоо ил тод болгох шаардлагаар сольж, аж ахуйн нэгжүүд материаллаг байдлын үзэл баримтлалыг хэрхэн ашиглах талаар зааварчилгааг нэмж оруулснаар илүү хүртээмжтэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгын гаргахад туслах зорилготой юм.

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс эсвэл түүнээс хойших тайлант жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилэх бөгөөд өмнө хэрэгжүүлэхийг зөвшөөрнө. Практик тайлагналын 2 нь НББ-ийн мэдээлэлд материаллаг байдлын тодорхойлох заавал шаардагдахгүй зааварчилгааг гаргасан тул энэ өөрчлөлтөд хүчин төгөлдөр болох огноо шаардлагагүй болно. Банк одоогоор энэхүү нэмэлт, өөрчлөлт нь НББ-ийн бодлогын тодруулгад хэрхэн нөлөөлөхийг үнэлж байна.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй

Гадаад валютын ханшийн тэгшитгэл

Банкны үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн тэмдэгт нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох “Монгол төгрөг” юм. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрийг тайлагналын өдрийн спот ханшаар дахин хөрвүүлдэг. Мөнгөн зүйлсийн ханшийн тэгшитгэл эсвэл төлбөр тооцооноос үүссэн аливаа зөрүүг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Түүхэн өртгөөр бүртгэдэг мөнгөн бус зүйлсийг анх гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлнэ. Харин өмчийн хөрөнгө оруулалт зэрэг бодит үнэ цэнэ нь гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг бодит өртгийг тодорхойлсон өдрийн ханшаар хөрвүүлж бүртгэнэ. Бодит үнэ цэнийн аргаар бүртгэдэг мөнгөн бус зүйлсийн ханшийн тэгшитгэлээс үүссэн олз эсвэл гарзыг бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз ба гарз хэсэгт толилуулна.

Хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрөх

Үр ашигт хүүгийн аргачлал

СТОУС 9-ийн дагуу хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн санхүүгийн хэрэглүүр, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хэрэглүүрийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан тодорхойлно. СТОУС 9-ийн дагуу бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан тодорхойлно. Үр ашигт хүү гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалуудыг хугацааных нь туршид эсвэл тохиромжтой гэж үзсэн богино хугацаанд дансны үнэ эсвэл санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөг хүртэл нь дискаунтчилсан хүү юм.

Үр ашигт хүүг (цаашлаад, санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртгийг) үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын хөнгөлөлт, урамшуулал, шимтгэл болон зардлыг оролцуулан тооцдог. Банк нь зээлийн нийт хугацааны турш тогтмол өгөөж хүртэнэ гэсэн хамгийн сайн тооцооллыг илэрхийлэх өгөөжийн хувиар хүүгийн орлогыг бүртгэдэг. Тиймээс өөр шатлалуудад тооцогдсон хүүгийн түвшнүүдийн нөлөөлөл болон бүтээгдэхүүний нийт хугацааны бусад шинж чанаруудыг (урьдчилж төлсөн төлбөр, нэмэгдүүлсэн хүү болон шимтгэлүүд) оролцуулан тооцдог.

Хэрэв тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн хүлээгдэж буй мөнгөн урсгал нь зээлийн эрсдэлээс бусад шалтгаанаар өөрчлөгдсөн бол ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалуудын өөрчлөлтийг анхны үр ашигт хүүгээр дискаунтчилан цаашлаад дансны үнийг тохируулна. Уг өөрчлөлт нь эерэг эсвэл сөрөг залруулгаар санхүүгийн байдлын тайланд тухайн санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны үнэд нөлөөлж үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон хүүгийн орлого/зардлыг нэмэгдүүлж эсвэл бууруулж болно.

Хүү болон түүнтэй адилтгах орлого/зардал

Цэвэр хүүгийн орлого болон зардлыг үр ашигт хүүгийн арга болон бусад аргыг ашиглан тооцдог. Эдгээрийг хүүгийн орлого болон зардлын аль алины хувьд харьцуулагдахуйц мэдээллийг харуулахын тулд орлогын тайланд тусад нь толилуулсан болно.

Банк нь зөвхөн дээр дурьдсан санхүүгийн хэрэглүүрийн хувьд үр ашигт хүүгийн аргаар хүүгийн орлого болон зардлыг тооцоолдог.

Бусад хүүгийн орлого болон зардалд үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хейдж хэлцлийн хүү болон бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэхээр хэмжигддэг бүх санхүүгийн хөрөнгө/өр төлбөрүүдийн хүү (гэрээний хүүгийн хувь хэмжээгээр тооцдог худалдах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөөс бусад) орно.

Арилжааны зориулалттай санхүүгийн хөрөнгө/өр төлбөрийн хүүгийн орлого/зардал нь “Арилжааны цэвэр орлого”-д бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр хүлээн зөвшөөрөгдсөн болно.

Банк нь үнэ цэнэ буурсан гэж үзсэнээс бусад санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргаар уг санхүүгийн хөрөнгийн дансны үнээс тооцдог.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурч, "3-р шатлал" –д орсон тохиолдолд Банк үр ашигт хүүгийн аргыг ашиглан санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан цэвэр өртгөөс хүүгийн орлогыг тооцно. Санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орохоо больсон тохиолдолд хүүгийн орлогыг дансны үнээс тооцно.

Худалдаж авсан болон үүссэн үнэ цэнийн бууралт (ХАҮҮЦБ) санхүүгийн хөрөнгүүдийн хувьд, Банк нь хүүгийн орлогыг зээлээр залруулагдсан үр ашигт хүүгээр хөрөнгийн хорогдуулсан өртгөөс тооцно. Зээлээр залруулагдсан үр ашигт хүү нь анх хүлээн зөвшөөрөх үед ирээдүйн мөнгөн гүйлгээг ХАҮҮЦБ хөрөнгийг хорогдуулсан өртөг руу хорогдуулах хүү юм.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрөх (үргэлжлэл)

Хураамж ба шимтгэлийн орлого

Банк нь өөрийн харилцагч нарт үзүүлдэг төрөл бүрийн үйлчилгээнээс хураамж, шимтгэлийн орлого олдог. Хураамж, шимтгэлийн орлогыг тухайн үйлчилгээг үзүүлсний хариуд Банкны олох төлбөрийн хэмжээг тусгасан хэмжээгээр хүлээн зөвшөөрнө. Гүйцэтгэлийн үүрэг, түүнчлэн тэдгээрийг хангах хугацааг гэрээ байгуулах үед тодорхойлдог. Банкны орлогын гэрээнд доор тайлбарласны дагуу олон гүйцэтгэлийн үүрэг ихэвчлэн байдаггүй.

Банк нь харилцагчдадаа үйлчилгээ үзүүлэх үед төлбөрийг нэхэмжлэх бөгөөд ихэнхдээ үйлчилгээ үзүүлсэн даруй эсвэл тодорхой хугацаанд үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг гэрээний хугацаа дууссаны дараа авдаг (доорхиос өөрөөр заагаагүй бол). Банк нь үйлчилгээгээ харилцагчид шилжүүлэхээс өмнө ихэвчлэн хяналт тавьдаг тул орлогын зохицуулалтын үндсэн үүрэг гэж дүгнэсэн.

Гэрээт хугацаацаагаар үзүүлж буй үйлчилгээний хураамжийн орлого

Гэрээт хугацааны туршид үйлчилгээг үзүүлж олох орлогыг тэр хугацааны туршид нь хуримтлуулна. Үүнд шимтгэлийн орлого, хөрөнгийн зохицуулалт, кастодиан, бусад зохицуулалт болон зөвлөх үйлчилгээний хураамжууд багтана.

Гүйлгээний үйл ажиллагаанаас олсон шимтгэлийн орлого

Гуравдагч талтай гүйлгээний талаар хэлэлцээр хийх эсвэл гүйлгээнд оролцохтой холбоотойгоор үүссэн хураамжууд (хувьцаа эсвэл бусад үнэт цаасыг худалдан авах, бизнес худалдан авах, худалдах зохицуулалт гэх мэт)-ыг холбогдох гүйлгээ дууссан үед хүлээн зөвшөөрнө. Тодорхой нэг гүйцэтгэлтэй уягдсан хураамж эсвэл хураамжийн бүрэлдэхүүн хэсгийг холбогдох шалгуурууд хангагдсаны дараа хүлээн зөвшөөрнө.

Холбогдох санхүүгийн хэрэглүүрийн салиугүй хэсэг болох хураамжийн орлого

Банкны холбогдох санхүүгийн хэрэглүүрийн салшгүй хэсэг болох хураамжийн орлого нь: зээл олголтын шимтгэл, татан авагдах магадлалтай зээлүүд дээр зээлийн үйлчилгээний шимтгэл болон зээлтэй холбоотой бусад шимтгэлүүд орно. Эдгээр шимтгэл нь (өсөн нэмэгдэх аливаа зардлын хамт) зээлийн үр ашигт хүүгийн залруулга гэж хүүгийн орлогоор хүлээн зөвшөөрөгдөнө. Харин татан авахгүй нь бараг тодорхой болсон зээлүүдийн зээлийн үйлчилгээний шимтгэл нь хугацааны эцэст орлогоор хүлээн зөвшөөрөгдөнө.

Шимтгэл ба хураамжийн зардал

Хураамжийн зардал нь арилжааны банкинд тогтмол төлдөг үйлчилгээний шимтгэл хураамжийг илэрхийлдэг. Хураамжийн зардлыг бодитоор үйлчилгээ авсан тухай бүрд хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Тодорхой гүйцэтгэлийн хэмжээтэй холбогдох төлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг гүйцэтгэл биелэгдсэн үед нь хүлээн зөвшөөрдөг.

Арилжааны цэвэр орлого

Арилжааны цэвэр орлогод "Арилжаалах зорилгоор эзэмшиж буй" санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хүүгийн орлого, зардал, бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн бүх олз, гарз болон ногдол ашиг хамаарна.

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдлын тайланд бүртгэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн цэвэр ашиг, алдагдал

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдлын тайланд бүртгэх санхүүгийн хэрэглүүрийн цэвэр олз гарзад БҮЦӨАА-д бүртгэх санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр болон арилжааны бус БҮЦӨАА-д бүртгэх хөрөнгүүдийг хамааруулна. Энэ ангилалд бодит үнэ цэнийн өөрчлөлт, хүү, ногдол ашиг болон гадаад валютын ханшийн зөрүү багтсан болно.

Хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүсэх цэвэр ашиг, алдагдал

Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдийг үл хүлээн зөвшөөрөхөд үүсэх цэвэр ашиг, алдагдал нь хорогдуулсан өртгөөр хэмжигдэх эсвэл бодит үнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэх санхүүгийн хөрөнгүүдийг борлуулах эсвэл үл хүлээн зөвшөөлөх үеийн хүлээн авсан орлого болон дансны үнэ (үнэ цэнэ бууралт тооцсон) хоорондын зөрүүгээр тооцсон алдагдал (эсвэл ашиг)-аар хэмжигдэнэ.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Санхүүгийн хэрэглүүр - анхны хүлээн зөвшөөрөлт

Хүлээн зөвшөөрөх өдөр

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа, харилцагчдын харилцах болон хадгаламжаас бусад бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө арилжаа хийсэн өдрөөр (Банк нь тухайн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон өдөр) хүлээн зөвшөөрнө. Үүнд хэвийн нөхцөлтэй арилжаа буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг арилжаа орно. Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа нь хөрөнгийг харилцагчдын дансанд шилжүүлсэн үед хүлээн зөвшөөрнө. Банк нь харилцагчдын харилцах, хадгаламжийг Банкинд шилжсэн үед хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хэрэглүүрийн анхны хэмжилт

Санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн ангилал нь гэрээний нөхцөл болон бизнес загвар дээр үндэслэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрөөс бусад бүх санхүүгийн хэрэглүүрийн анхны хэмжилт нь тэдгээрийн бодит үнэ цэнэ дээр гүйлгээний зардлыг нэмсэн дүн байна. Худалдааны авлагын анхны хэмжилт нь гүйлгээний дүнгээр байна. Санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнэ нь гүйлгээний үнээс өөр байх тохиолдолд Банк нь “эхний өдөр”-ийн ашиг алдагдалыг доор тайлбарласны дагуу бүртгэнэ.

“Эхний өдөр”-ийн ашиг ба алдагдал

Ажил гүйлгээний үнэ нь бодит үнэ цэнээсээ ялгаатай бөгөөд бодит үнэ цэнэ нь зах зээлийн ажил гүйлгээнээс ажиглагдахуйц өгөгдөлд суурилсан үнэлгээний аргачлал ашигласан байвал Банк нь бодит үнэ цэнэ болон ажил гүйлгээний үнийн зөрүүг цэвэр арилжааны орлогоор хүлээн зөвшөөрнө. Зарим өгөгдөл нь ажиглагдахуйц мэдээлэлд суурилаагүй үнэлгээний загвараар тооцсон тохиолдолд ажил гүйлгээний үнэ болон бодит үнэ цэнийн зөрүүг зөвхөн орлого орж ирэх нь тодорхой болсон эсвэл санхүүгийн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрөх тохиолдолд л ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хэмжих ангилал

Банк өөрийн бүх хөрөнгийг бизнесийн загвар болон гэрээний нөхцөл дээр үндэслэн дараах аль нэгээр нь ангилна:

- Хорогдуулсан өртгөөр бүртгэх;
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх;
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх

Банк нь үүсмэл санхүүгийн хэрэглүүр болон арилжааны үнэт цаасны багцыг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөөр ангилж хэмжинэ. Хэмжилт болон хүлээн зөвшөөрөлтийн зөрчлийг арилгаж эсвэл бууруулж байгаа нөхцөлд Банк нь санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх гэж тодорхойлж болно.

Зээлийн үүрэг болон санхүүгийн баталгаанаас бусад санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр эсвэл, арилжааны зорилгоор эзэмшиж буй эсвэл санхүүгийн үүсмэл хэрэглүүр тохиолдолд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдлын тайланд бүртгэж хэмжинэ.

Бодит үнэ цэнийн тодорхойлолт

Бодит үнэ цэнэ гэдэг нь хэмжилт хийсэн өдрийн зах зээлд оролцогчдын хооронд хийсэн дэс дараалалтай гүйлгээний үр дүнд борлуулснаас орж ирэх мөнгөн дүн болон өр төлбөрт шилжүүлсэн мөнгөн дүн юм. Бодит үнэ цэнийн хэмжилт нь дараах зах зээл дээр хөрөнгийг борлуулсан эсвэл өр төлбөрийг шилжүүлсэн гүйлгээний дүнгээр тодорхойлно. Үүнд:

- Хөрөнгө ба өр төлбөрийн үндсэн зах зээлд, эсвэл
- Үндсэн зах зээл байхгүй тохиолдолд, хөрөнгө ба өр төлбөрийн хувьд хамгийн ашигтай зах зээлд

Үндсэн болон хамгийн ашигтай зах зээл нь Банкны хувьд оролцож болохуйц зах зээлүүд байх ёстой.

Хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан үнэ нь зах зээлд оролцогчид нь хөрөнгө ба өр төлбөрийн эдийн засгийн хамгийн өндөр үр өгөөжийг хүртэнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэдэг.

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтийг, тухайн зах зээлд оролцогч тал нь хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг хүртэж чадаж байх эсвэл уг хөрөнгийг борлуулснаар худалдан авсан талд уг хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг өгч байх, нөхцөлд тооцно.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)**Бодит үнэ цэнийн тодорхойлолт (үргэлжлэл)**

Банк нь бодит үнэ цэнэ тооцоход шаардлагатай мэдээллүүд нь хангалттай олдцотой үед үнэлгээний техникүүдийг хэрэглэх нь тохиромжтой байдаг ба ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг нэмэгдүүлж, үл ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг хамгийн бага түвшинд байлгадаг.

Бодит үнэ цэнээрээ хэмжигдэж, санхүүгийн тайланд тайлагнаж байгаа бүх хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах түвшнийг хэрэглэдэг. Үүнд:

- Түвшин 1- санхүүгийн хэрэглүүр - Үнэлгээнд ашиглагдсан өгөгдлүүд нь хэмжилтийн өдрөөрх бирж дээр бүртгэлтэй ижил төсөөтэй хөрөнгө болон өр төлбөрийн (залруулаггүй) идэвхитэй зах зээл дээрх үнэ юм. Банк нь хэмжээ болон хөрвөх чадварын хувьд адил төсөөтэй хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн тайлангийн өдрөөр боломжтой, заавал болон хэрэгжих үнийн хангалттай арилжааны үйл ажиллагаатай байхыг идэвхтэй зах зээл гэж үзнэ.
- Түвшин 2- санхүүгийн хэрэглүүр - Үнэлгээнд ашигласан өгөгдлүүдийг санхүүгийн хэрэглүүрийн дуусах хугацааны туршид боломжтой байх зах зээлийн бүх өгөгдлүүдээс шууд болон шууд бусаар үнэлгээнд ашигласан өгөгдлүүд юм. Эдгээр өгөгдлүүдийн дотор идэвхтэй зах зээл дээрх ижил төстэй хөрөнгө болон өр төлбөрийн үнэ, идэвхгүй зах зээл дээрх ижил төстэй хэрэглүүрийн үнэ болон үүнээс өөр хүүгийн түвшин, өгөөжийн муруй, харгалзах хэлбэлзэл, зээлийн эрсдэлийн үнэ гэх зэрэг ажиглагдахуйц өгөгдлүүд орно. Мөн түүнчлэн, тухайн хөрөнгийн шинж байдал болон байршил, харьцуулах зүйлсийн аль нь үнэлгээ тогтоосон хэрэглүүртэй холбогдох зэргээс хамааран залруулга хийж болно. Гэвч ажиглагдахуйц бус өгөгдөл дээр үндэслэн нийт хэмжилтэнд чухал ач холбогдолтой дээрх залруулгыг хийсэн бол Банк нь хэрэглүүрийг Түвшин 3-р ангилна.
- Түвшин 3 - санхүүгийн хэрэглүүр - Эдгээрт, хэмжилтийн хувьд бүхэлдээ чухал ач холбогдол бүхий нэг болон түүнээс дээш ажиглагдахуйц бус өгөгдлүүд багтана.

Банк нь үнэлгээний техник болон хэрэгжүүлж буй аргачлалууд болон загварын тохируулгуудыг тогтмол шалгаж үздэг. Гэвч суурь загвар нь Банкны санхүүгийн хэрэглүүрийг үнэлэхтэй холбоотой бүх хүчин зүйлүүд болох зээлийн эрсдэл, өөрийн зээлийн болон/эсвэл санхүүжилтийн зардал зэргийг бүрэн дүүрэн хамруулж чадахгүй байх магадлалтай юм. Иймд Банк нь бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хэрэглүүртэй холбоотой зээлийн эрсдэлийг тооцоолоход төрөл бүрийн техник хэрэглэдэг ба үүнд хөрөнгө тус бүрийн хувьд ашиглалтын хугацааны туршид холбогдох талд хүлээгдэж буй зээлийн эрсдэлийг багцад суурилан тооцох аргачлал багтдаг бөгөөд энэ нь холбогдох талд хүлээгдэж буй барьцаагүй санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэлийг тусгахын тулд хийгддэг. Банк өөрийн зээлийн үнэ цэнийг зах зээлийн бодит өгөгдлүүдээс, тухайлбал, арилжаалагдсан өрийн хоёрдогч үнэ зэргээс тооцдог.

Тайлант хугацааны эцэс бүрт Банк нь санхүүгийн тайландаа тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийн хувьд түвшин хооронд хөдөлгөөн гарсан эсэхийг дахин нягталж үздэг.

Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн шинжилгээ болон бусад шаардлагатай мэдээллийг Тодруулга 35-д тусгасан.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр

Бусад Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах хадгаламж, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа болон хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хэрэглүүр

Банк нь доорх нөхцлүүд хангагдсан тохиолдолд бусад Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах хадгаламж, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа болон бусад санхүүгийн хэрэглүүрийг хорогдуулсан өртгөөр бүртгэхэд ангилна:

- Бизнесийн загварын зорилго нь гэрээнд заасан мөнгөн төлбөрийг цуглуулах зорилгоор санхүүгийн хөрөнгийг эзэмшдэг
- Санхүүгийн хөрөнгүүдийн гэрээний нөхцөл нь тодорхой үеүүдэд үлдэгдлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийн мөнгөн гүйлгээг ихэсгэдэг.

Эдгээр нөхцөлүүдийн дэлгэрэнгүй тайлбарыг дор үзүүлэв.

Бизнесийн загварын үнэлгээ. Банкны бизнес загвар нь хэрэглүүрийн түвшинд биш нийлмэл багцын түвшинд хянагддаг ба дараах ажиглагдахуйц хүчин зүйлсээс хамаарна:

- Бизнес загварын (тухайн бизнес загварт хамаарагдах санхүүгийн хөрөнгө) үр дүнд нөлөөлж буй эрсдэл ба эдгээр эрсдэлийг хэрхэн хянах аргачлал
- Эдгээр хөрөнгүүдээс мөнгөн гүйлгээг өмнө нь хэрхэн хүлээн авч байсан туршлага
- Багцын гүйцэтгэлийг хэмжих болон тайлагнахад ашигласан хэмжигдэхүүнүүд
- Байгууллагын удирдлагуудад хэрхэн урамшуулал олгодог (санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ эсвэл гэрээний цуглуулсан мөнгөн урсгал дээр үндэслэдэг)

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)**Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр (үргэлжлэл)**

Борлуулалтын хүлээгдэж буй давтамж, үнэ цэнэ ба хугацаа нь үнэлгээ хийхэд чухал хүчин зүйл болно.

Бизнес загварын тест нь хамгийн боломжит хувилбар дээр үндэслэдэг ба ‘хамгийн муу’ эсвэл ‘стресс’ нөхцөлүүдийг харгалзан үздэггүй. Хэрэв анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах мөнгөн урсгал нь анхны таамагласан хүлээлтээс өөр байвал Банк тухайн бизнес загварт хамааралтай санхүүгийн хөрөнгийн ангиллыг солихгүй бөгөөд харин уг мэдээллийг санхүүгийн хөрөнгө шинээр худалдаж авах үед үнэлгээндээ оруулдаг.

Үндсэн төлбөр ба хүүгийн төлбөрийн шалгуур (ҮТХТ шалгуур). Санхүүгийн хэрэглүүрийн ангиллын хоёр дахь шат бол Банк үндсэн болон хүүгийн төлбөрийн шалгуурын шаардлагыг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нөхцлийг дүгнэдэг.

Энэхүү шалгуурын хүрээнд ‘Үндсэн’ гэдэг нь анхны хүлээн зөвшөөрөх үеийн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ бөгөөд санхүүгийн хөрөнгийн ашиглах хугацааны туршид өөрчлөгдөж болно (жишээ нь үндсэн төлбөрийн эргэн төлөлт эсвэл урамшуулал/хөнгөлөлтийн хорогдуулалт).

Зээлийн гэрээн дэх хүүгийн хамгийн гол элемент нь мөнгөний өнөөгийн үнэ цэнэ болон зээлийн эрсдэл байдаг. Үндсэн төлбөр ба хүүгийн төлбөрийн шалгуурын үнэлгээг хийхийн тулд Банк нь хүүгийн түвшнийг тогтоосон хугацаа гэх мэт холбогдох хүчин зүйлс, үнэлэмжийг авч үздэг.

Нөгөө талаас, эрсдэл үүрэх магадлал багатай гэрээний заалт эсхүл үндсэн зээлийн зохицуулалттай холбоогүй гэрээний мөнгөн урсгалын тогтворгүй байдал зэрэг нь зөвхөн үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл дүнгийн гэрээний мөнгөн урсгалд нөлөөлөхгүй. Ийм тохиолдолд санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ.

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх үүсмэл санхүүгийн хэрэглүүр

Үүсмэл санхүүгийн хэрэглүүр нь санхүүгийн хэрэглүүр эсвэл бусад гэрээ байхын тулд доорх гурван шинж чанарыг бүхэлд нь агуулах шаардлагатай:

- Үнэ цэнэ нь тодорхой хүүгийн түвшин, санхүүгийн хэрэглүүрийн үнэ, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ, валютын ханшийн өөрчлөлт, зээлжих зэрэглэл болон гэрээний холбогдох талын үүрэг хариуцлагад хамаарахгүй бусад хувьсагчийн өөрчлөлтөөс хамаардаг бол
- Анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаггүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил байдлаар хандахаар хүлээгдэж буй адил төсөөтэй гэрээнд шаардлагатайгаас бага анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаг бол
- Ирээдүйд төлөгдөхөөр бол

Банк нь төрөл бүрийн харилцагчидтай үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хэлцлүүд хийдэг бөгөөд эдгээрт кросс своп, гадаад валютын болон хүүгийн форвард гэрээ хэлцлүүд зэрэг орно. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ.

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хейджийн нягтлан бодох бүртгэл хэрэглэж байгаагаас бусад үед “Бусад орлого”-д бүртгэдэг.

Банк нь төрөл бүрийн харилцагчидтай санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн хэлцлүүд хийдэг бөгөөд эдгээрт кросс своп хэлцэл, гадаад валютын болон хүүгийн форвард гэрээ хэлцлүүд зэрэг орно. Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ.

Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хейджийн нягтлан бодох бүртгэл хэрэглэж байгаагаас бусад үед “Арилжааны цэвэр орлого”-д бүртгэдэг.

Санхүүгийн хэрэглүүрт агуулагдсан санхүүгийн үүсмэл хэрэглүүр нь дээр дурдсан тодорхойлолтод нийцэж байгаа ба эдийн засгийн үзүүлэлт болон эрсдэлийн хувьд агуулагч гэрээтэй нягт холбоотой биш, мөн агуулагч гэрээг арилжааны зорилгоор эзэмшээгүй тохиолдолд тус санхүүгийн үүсмэл хэрэглүүрийг салгаж бодит үнэ цэнээр бүртгэнэ. Агуулагч гэрээнээс салгасан санхүүгийн үүсмэл хэрэглүүрийг бодит үнээр арилжааны багцад хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)*Арилжаалах зориулалттай санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр*

Банк нь санхүүгийн хөрөнгийг арилжааны үйл ажиллагаагаар дамжуулан богино хугацаанд ашиг олох зорилгоор худалдаж авсан эсвэл багцаар нь удирдаж буй санхүүгийн хэрэглүүрийн багцын нэг хэсэг болгон арилжаалах зориулалттай гэж ангилдаг. Арилжаалах зориулалттай хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь хэмжин бүртгэдэг. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг цэвэр арилжааны орлогод хүлээн зөвшөөрнө. Хүү, ногдол ашгийн орлого болон зардлыг гэрээний нөхцлийн дагуу, эсвэл төлбөр хийх эрх нь тогтоогдсон үед арилжааны цэвэр орлогод бүртгэнэ.

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэх өрийн хэрэглүүр

Банк нь өрийн хэрэглүүрийг доорх нөхцөлүүдийг хангасан тохиолдолд Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өрийн хэрэглүүрд ангилна:

- Бизнесийн загварын дагуу гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах болон санхүүгийн хэрэглүүрийг борлуулах зорилгоор эзэмших
- Санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөл нь зөвхөн үндсэн төлбөр ба хүүний шалгуурыг хангах

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр нь бодит үнэ цэнээр хэмжигдэх бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз, гарз нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэнэ. Хүүгийн орлого болон гадаад валютын ханшийн олз, гарзыг хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгүүдийн адил ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцооллыг доорх тодруулгуудад тайлбарласан. Банк нь нэг төрлийн үнэт цааснаас нэгээс олыг эзэмшдэг бол эхэлж авсанаа эхэлж зарлагдахаар бүртгэнэ. Үл хүлээн зөвшөөрөх үед бусад орлогод хуримтлагдсан олз, гарз нь бусад дэлгэрэнгүй орлогын тайлангаас ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдана.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэглүүр

Анх хүлээн зөвшөөрсөний дараа, Банк НББОУС-32 санхүүгийн хэрэглүүр толилуулга болон арилжаалах зорилгоор эзэмшдэггүй өмчийн тодорхойлолтонд нийцсэн зарим өмчийн хэрэглүүрийг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өмчийн хэрэглүүр рүү буцаах боломжгүйгээр ангилна. Энэ ангилал нь хэрэглүүрийн түвшинд суурилан тодорхойлогддог.

Энэ өмчийн хэрэглүүрийн олз гарзыг хэзээ ч ашиг алдагдлын тайланд бүртгэхгүй. Банк хүлээн авах орлогын санхүүгийн хэрэглүүртэй холбоотой зардлыг нөхөн төлбөрт ашигласан тохиолдолд ашиг нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх бол бусад үед төлбөрийн эрх нь баталгаажсан тохиолдолд ногдол ашгийг бусад үйл ажиллагааны орлого гэж ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх өмчийн хэрэглүүр нь үнэ цэнийн бууралтын үнэлгээнд хамаарахгүй.

Гаргасан өрийн хэрэглүүр ба зээлээр авсан санхүүжилт

Анх хүлээн зөвшөөрсний дараа, зээллэгүүдийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцоходоо зээл авах үеийн хөнгөлөлт, урамшуулал ба үр ашигт хүүгийн нэг салшгүй хэсэг болж буй зардлуудыг авч үзнэ. Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн аль алиных нь элементүүдийг агуулсан нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг, хүлээн зөвшөөрөгдөх өдөр салгана.

Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн аль алиных нь элементүүдийг агуулсан нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг, хүлээн зөвшөөрөгдөх тусад нь бүртгэнэ. Банк нь эдгээр үүсмэл бус санхүүгийн хэрэглүүрийг бүртгэлд тусгахдаа, эхлээд тухайн хэрэглүүр нь нийлмэл эсэх талаар болон тухайн хэрэглүүр болон бүрэлдэхүүн хэсгүүдийг НББОУС 32-н дагуу санхүүгийн өр төлбөр болон хөрөнгө эсвэл өөрийн хөрөнгө гэж ангилна. Банк нь санхүүгийн хэрэглүүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө: (а) Банкинд санхүүгийн өр төлбөр болж байвал, (б) Тухайн хэрэглүүрийг эзэмшигчид, Банкны өөрийн хөрөнгөнд хөрвөх боломж олгож байвал. Хөрвөх хэрэгслийн өр төлбөр болон өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнүүдийн ангилал нь, тухайн хөрвөх нөхцөл нь зарим нэг эзэмшигчдийн хувьд эдийн засгийн давуу талтай байсан ч хөрвөх нөхцөл нь хэрэгжих эсэх болон түүний өөрчлөгдөх магадлалаас шалтгаалан өөрчлөгддөггүй. Хөрвөх санхүүгийн хэрэглүүрийн өөрийн хөрөнгө болон өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн бүртгэлийн дүнг хуваарилахдаа, өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүний дүн нь тухайн хэрэглүүрийн нийт бодит үнэ цэнээс өр төлбөрийн бүрэлдэхүүн гэж тусад нь тодорхойлсон дүнг хассанаас үлдсэн дүн байна. Нийлмэл санхүүгийн хэрэглүүрд агуулагдсан өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнээс (өөрийн хөрөнгийн хөрвөх нөхцөл гэх мэт) бусад аливаа үүсмэл хэрэглүүрийн үнэ цэнэ нь (худалдан авах опцион гэх мэт) өр төлбөрийн бүрэлдэхүүнд багтана. Банк нь тухайн хэрэглүүрийн өөрийн хөрөнгө болон өр төлбөрийн бүрэлдэхүүнүүдийг тусад нь бүртгэх гэж буй бол тухайн өр төлбөрт салгах шаардлагатай агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүр байгаа эсэхийг үнэлнэ.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)*Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр*

Энэ ангилал дахь санхүүгийн хөрөнгө нь арилжаалах зорилгоор эзэмшээгүй бөгөөд анх хүлээн зөвшөөрөхдөө удирдлагаас тодорхойлогдсон эсвэл СТОУС-9-н дагуу бодит үнэ цэнээр хэмжих зайлшгүй шаардлагатай гэж тодорхойлсон байна.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө нь санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр бүртгэгдэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөд тодорхойлсон хэрэглүүрээс олсон хүүгийн орлого эсвэл зардал нь үр ашигт хүүг ашиглан мөн хөнгөлөлт/урамшууллыг нь харгалзах дүнгээр тооцдог. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөөс олсон хүүгийн хэмжээг гэрээний хүүг ашиглан бүртгэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэглүүрийн ногдол ашгийн орлогыг төлбөр хийх эрх тогтоогдсон үед үйл ажиллагааны бусад орлогод бүртгэнэ.

Санхүүгийн баталгаа, аккредитив болон ашиглагдаагүй зээлийн үүрэг

Банк нь санхүүгийн баталгаа, аккредитив болон зээлийн амлалт гаргадаг. Санхүүгийн баталгаа гаргаж өгсний улмаас хүлээн авсан урамшууллыг санхүүгийн тайлангуудад анхлан бүртгэхдээ бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Ийнхүү анхлан хүлээн зөвшөөрсний дараагийн тайлант үед баталгаа бүрт Банкны хүлээх хариуцлагыг хэмжихдээ анхлан хүлээн зөвшөөрсөн дүнгээс ашиг, алдагдлын тайланд бүртгэсэн хуримтлагдсан хорогдлыг хассан дүн хоёрын аль өндрөөр нь хэмжинэ.

Хүлээн авсан урамшууллыг баталгааны хугацааны туршид ашиг, алдагдлын тайланд “Хураамж ба шимтгэлийн орлого”-оор хүлээн зөвшөөрнө.

Ашиглагдаагүй зээлийн үүрэг болон аккредитив нь амлалт бөгөөд энэхүү амлалтын хугацаанд Банк нь урьдчилан тодорхойлсон нөхцөлтэй зээлийг харилцагчид олгох шаардлагатай. Санхүүгийн баталгааны гэрээнүүдийн адилаар тэдгээр гэрээнүүдэд “Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал”-ын шаардлагуудын дагуу сан байгуулна. Санхүүгийн баталгаа, аккредитив болон ашиглагдаагүй зээлийн гэрээний үнэ цэнэ нь зах зээлд олгогдох зээлийн гэрээний нөхцөлтэй ижил байхаас гадна санхүүгийн байдлын тайланд тусгагдахгүй. Энэхүү санхүүгийн хэрэглүүрийн нэрлэсэн үнэ болон үнэ цэнийн бууралтын хүлээгдэж буй алдагдал нь Тодруулга 33-д тусгагдсан.

Харилцагчдын харилцах, хадгаламж

Үүнд харилцагчдаас татсан харилцах, хугацаагүй, хугацаатай хадгаламж болон банкны баталгааны эх үүсвэр хамаарна. Анхны хэмжилтийн дараа үед харилцагчдад өгөх өр төлбөрүүдийг ҮАХ-ийн аргаар хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

Бусад санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж

Бусад банк, санхүүгийн байгууллагуудаас татсан төгрөгийн болон валютын хадгаламжууд болон дотоод гадаадын арилжааны банкууд, Монголбанкны хугацаатай хадгаламжууд мөн хамаарна. Банк нь, харилцагчдийн харилцах хадгаламжийг мөнгөн хөрөнгө нь банканд шилжсэн үед хүлээн зөвшөөрдөг. Анхны хэмжилтийн дараа бусад Банкуудад өгөх өр төлбөрийг ҮАХ-ийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийн дахин ангилал

Банк санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш бизнесийн шугам худалдан авах, дуусгах болон цуцлах онцгой нөхцөл байдлаас бусад нөхцөлд дахин ангилахгүй. Санхүүгийн өр төлбөр дахин ангилагддаггүй.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлт*Санхүүгийн хөрөнгө өөрчлөх*

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын болог зээлийн эрсдлийн бус шалтгаанаар арилжааны бүтцийн өөрчлөлтийн үйл ажиллагааны үр дүнд гэрээний мөнгөн гүйлгээг дахин тохиролцсон эсвэл өөр хэлбэрээр бүтцийн өөрчлөлт оруулсан тохиолдолд, Банк уг өөрчлөлт нь тухайн санхүүгийн хөрөнгийг данснаас хасахад хүргэсэн эсэхийг тодорхойлох үнэлгээг хийдэг. Санхүүгийн хөрөнгийн хувьд энэхүү үнэлгээ нь чанарын хүчин зүйл дээр суурилдаг.

Банк харилцагчид олгосон зээлийг үл хүлээн зөвшөөрөх эсэхийг үнэлэхдээ доорх нөхцөлүүдийг авч үздэг:

- зээлийн валют өөрчлөгдсөн
- өмчийн шинж чанар тодорхойлогдсон
- бизнесийн түнш өөрчлөгдсөн
- өөрчлөлтийн улмаас ҮТХТ-ийн шалгуур хангахгүй байх

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)**Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлт (үргэлжлэл)***Санхүүгийн хөрөнгө өөрчлөх (үргэлжлэл)*

Хэрвээ өөрчлөлт нь мөнгөн урсгалд мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй бол энэ өөрчлөлтийг үл хүлээн зөвшөөрөх гэж авч үзэхгүй. Мөнгөн урсгалын өөрчлөлтийг анхны үр ашигт хүүгээр хорогдуулсан дүнд үндэслэн Банк үнэ цэнийн бууралтын алдагдал бүртгээгүй бол өөрчлөлтийг нь ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ.

Санхүүгийн өр төлбөрийг өөрчлөх

Одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн нөхцлийн өөрчлөлт нь ихээхэн ач холбогдолтой гэж дүгнэгдээгүй, улмаар данснаас хасахад хүргэхгүй бол санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг гэрээнд заасан ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг тооцоолохдоо санхүүгийн өр төлбөрийн анхны үр ашигт хүүгийн хямдруулалтын аргаар дахин тооцоолно. Үүний үр дүнд гарсан аливаа зөрүүг шууд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Банк санхүүгийн өр төлбөрийн хувьд, чанарын хүчин зүйлээс хамаарч, засварласан хямдруулсан өнөөгийн үнэ цэнэ болон санхүүгийн өр төлбөрийн анхны дансны үнийн хооронд арав буюу түүнээс дээш хувьтай зөрүү гарахад хүргэсэн өөрчлөлтийг мэдэгдэхүйц гэж үзнэ.

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт*Хугацаа болон нөхцөлд их хэмжээгээр өөрчлөлт орсонтой холбоотой үл хүлээн зөвшөөрөх*

Харилцагчдад олгосон зээл гэх мэт санхүүгийн хөрөнгийг гэрээний нөхцөл нь шинэ зээл шиг болж өөрчлөгдөхөд үл хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралт хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд эдгээр хөрөнгийн хувьд зөрүүг нь үл хүлээн зөвшөөрөлтийн олз, гарзаар бүртгэнэ. Шинээр хүлээн зөвшөөрсөн зээл нь үнэ цэнэ буурсан зээлийг худалдаж авсан нөхцөлд биш бол уг зээл нь зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал тооцоолох үүднээс 1-р шатлалд ангилагдана.

Их хэмжээний өөрчлөлтөөс бусад үед үл хүлээн зөвшөөрөх

Санхүүгийн хөрөнгө. Банк санхүүгийн хөрөнгийг (санхүүгийн хөрөнгийн хэсэг эсвэл хоорондоо төстэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн хэсэг) тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан үед үл хүлээн зөвшөөрнө. Мөн Банк нь хөрөнгийг шилжүүлсэн бөгөөд шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шаардлагыг хангаж байгаа нөхцөлд хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (санхүүгийн хөрөнгийн хэсэг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгийн хэсэг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Банк тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн, эсвэл
- “Дамжуулан өнгөрөөх” хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн

Дамжуулан өнгөрөөх хэлцэл нь Банк тухайн санхүүгийн хөрөнгөөс хүлээх гэрээний эрхээ хадгалж үлдэх бөгөөд (анхны хөрөнгө) доорх гурван нөхцөл биелж байх нөхцөлд гэрээний үүргийн дагуу тэдгээр хүлээн авсан мөнгөн урсгалыг нэг болон түүнээс дээш байгууллагад (эцсийн хүлээн авагчид) шилжүүлнэ:

- Хэрэв тухайн нэг байгууллагын зээлдүүлсэн дүн дээр зах зээлийн хүүгээр хуримтлагдсан хүүтэй хамт бүрэн авах эрхтэй богино хугацаат урьдчилгааг оруулалгүйгээр Банк нь эцсийн хүлээн авагчид анхны хөрөнгө нь дүйцэх хэмжээний мөнгөн урсгалыг цуглуулаагүй цагт ямар нэгэн төлбөр төлөх үүрэггүй болно,
- Банк нь эцсийн хүлээн авагчдаас үнэт цааснаас бусад нөхцөлөөр анхны хөрөнгийг зарах эсвэл барьцаалж болохгүй,
- Банк нь эцсийн хүлээн авагчдын өмнөөс цуглуулсан мөнгөн урсгалыг удаан хугацаагаар саатуулалгүйгээр шилжүүлэх үүрэгтэй

Шилжүүлэлтийг зөвхөн доорх нөхцөлүүдийг хангасан тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө:

- Банк хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл
- Банк тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй болон хадгалж үлдээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Хэрвээ шилжүүлэгч холбогдолгүй гуравдагч этгээдэд хөрөнгийг бүхэлд нь зарах болон шилжүүлэхэд нэмэлт хязгаарлалтгүйгээр тухайн чадварыг эзэмшдэг гэж үзсэн үед Банк хяналтыг шилжүүлсэн гэж үзнэ.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)**Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)***Их хэмжээний өөрчлөлтөөс бусад үед үл хүлээн зөвшөөрөх (үргэлжлэл)*

Банк хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Банкны уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Банк холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Банкны хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ.

Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Банкны төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ. Хэрэв шилжүүлсэн хөрөнгөд үргэлжилсэн оролцоо бичгээр эсвэл худалдан авах опцион (эсвэл аль аль нь) хэлбэрээр байвал, Банкны үргэлжилсэн оролцоо нь эргүүлэн худалдан авахад төлөх шаардлагатай дүнгээр хэмжигдэнэ. Хөрөнгөд бичгээр худалдан авах опцион заасан байгууллагын үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ болон нөхцөлийн хэрэгжих үнийн аль багаар хязгаарлагдана.

Санхүүгийн өр төлбөр. Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ. Анхны санхүүгийн өр төлбөрийн бүртгэлийн дүн ба төлсөн дүн хоёрын зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Гэрээний нөхцөлд өөрчлөлт орсон зээлүүд

Банк заримдаа барьцаа хөрөнгийг хураах гэхээсээ илүү зээлдэгчийн санхүүгийн хүндрэлийн улмаас зээлийн анхны нөхцөлд хөнгөлөлт, өөрчлөлт оруулдаг. Зээлдэгчийн одоогийн эсвэл хүлээгдэж буй санхүүгийн хүндрэлээс үүдэн хөнгөлөлт, өөрчлөлтийг хийсэн ба зээлдэгч санхүүгийн хувьд хэвийн байсан бол Банк энэхүү хөнгөлөлт, өөрчлөлтийг зөвшөөрөхгүй байх байсан тохиолдолд уг зээлийг Банк өөрчлөлттэй зээл гэж үзнэ. Санхүүгийн хүндрэлийг харуулсан үзүүлэлтүүд нь гэрээний шалгуур үзүүлэлтүүдийг хангахгүй байх эсвэл Зээлийн Эрсдэлийн хэлтсээс гаргасан үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно.

Энэхүү өөрчлөлтүүдэд төлбөрийн хугацааг сунгах, зээлийн шинэ нөхцөл тохирох зэрэг орно. Банк нь нөхцөл өөрчилсөн зээлийг тогтмол хянах бодлого баримталж ирээдүйн зээлийн төлөлт тасалдахгүй төлөгдөх боломжийг хянадаг.

Хэрэв ихээхэн өөрчлөлттэй бол дээр тайлбарласны дагуу зээлийг үл хүлээн зөвшөөрнө. Зээлийг үл хүлээн зөвшөөрөхгүйгээр, зээлийн нөхцөлийг дахин авч хэлэлцсэний дараа нөхцөл өөрчлөхөөс өмнө тооцсон анхны үр ашигт хүүгээр үнэ цэнийн бууралтыг тооцдог.

Зээлийн нөхцөл дахин тохирч, өөрчилсөн хэдий ч үл хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд зээлийн эрсдэл ихээхэн хэмжээгээр нэмэгдсэн гэж үздэг тул зээлийг 2-р шатанд ангилдаг. Нөхцөл өөрчилсөн актив гэж ангилагдсан харилцагч уг ангиллаас гарахын тулд дараах бүх шалгуурыг хангасан байх шаардлагатай:

- Бүх зээлүүд нь хэвийн байх ёстой
- Хамгийн багадаа туршилтын хугацааны талд нь шинэчилсэн эргэн төлөлтийн хуваарийн дагуу тогтмол төлбөрийг хийсэн байх
- Үйлчлүүлэгч 30 хоногоос дээш хугацаа хэтрэлтэй гэрээгүй байх

Шинэчлэгдсэн буюу Өөрчлөлт орсон хөрөнгийн талаарх мэдээллийг 34-р тодруулгад тусгасан болно.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

“Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал (ЗҮЦХА)” аргын ерөнхий ойлголт

Банк “санхүүгийн хэрэглүүр” ангилалд хамаарах зээлийн үүрэг болон санхүүгийн баталгаа, бодит үнэ цэнийн өөрчлөлт ашиг, алдагдлын тайланд бүртгэгдээгүй бусад өрийн хэрэглүүр болон бүх зээлд зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын сан байгуулсан. СТОУС-9-н дагуу өмчийн хэрэглүүр нь үнэ цэнийн бууралтанд орохгүй.

Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал нь хөрөнгийн ашиглалтын нийт хугацаанд үүсэх зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлаас хамаарна. Хэрвээ анх бүртгэснээс алдагдал нь мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн бол алдагдал нь 12 сарын хүлээгдэж буй алдагдлаас хамаарна. Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өөрчлөгдсөнийг хэмжих Банкны бодлого журмыг тодруулга 34-д тусгасан.

Ирээдүйн 12 сарын ЗҮЦХА нь нийт хугацааны ЗҮЦХА аргын нэг хэсэг байх бөгөөд тайлагналын өдрийн дараах 12 сард санхүүгийн хэрэглүүрийн чанаргүйдлийн магадлалын үр дүнгээр ЗҮЦХА-г илэрхийлнэ.

Санхүүгийн хэрэглүүрийн үндсэн багцаас шалтгаалан нийт хугацааны ЗҮЦХА болон ирээдүйн 12 сарын ЗҮЦХА-г тусгай болон бүлгийн үнэлгээгээр тооцоолно. Банк нь бүлэг санхүүгийн хөрөнгийг бүлгийн үнэлгээний аргаар хэмжинэ.

Банк нь үнэлгээ хийх журмыг тодорхойлсон бөгөөд тайлант үеийн эцэс бүрт санхүүгийн хэрэглүүрийн үлдэх хугацаанд үүсч болох эрсдэлийн өөрчлөлтийг харгалзан санхүүгийн хэрэглүүрийг анх бүртгэснээс хойш ЗҮЦХА-д мэдэгдэхүйц өссөн эсэхийг харгалзан авч үзнэ.

Дээр дурьдсан процесс дээр тулгуурлан, доор дурьдсанаар Банк зээлийг шатлал 1, шатлал 2, шатлал 3 гэж ангилсан:

Шатлал 1: Зээлийг анх хүлээн зөвшөөрөх үед Банк нь 12 сарын ЗҮЦХА-г бүртгэнэ. Мөн шатлал 1-рүү үүсч болох эрсдэл нь буурсан шатлал 2-ын зээлүүд дахин ангилагдана.

Шатлал 2: Анх хүлээн зөвшөөрсөн үеэс зээлийн үүсч болох эрсдэл ихэссэн үед Банк нь нийт хугацааны ЗҮЦХА-г бүртгэнэ. Мөн шатлал 2-руу үүсч болох эрсдэл нь буурсан шатлал 3-ын зээлүүд дахин ангилагдана.

Шатлал 3: Үнэ цэнийн бууралтанд орсон зээлүүд багтана. Банк нь нийт хугацааны турш ЗҮЦХА-г бүртгэнэ.

ХАҮҮЦБ: ХАҮҮЦБ хөрөнгө нь анх хүлээн зөвшөөрөх үед үнэ цэнэ буурсан байсан санхүүгийн хөрөнгө юм. ХАҮҮЦБ хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр бүртгэх бөгөөд дараа үеийн хүүгийн орлогыг үнэ цэнийн бууралтаар тохируулсан ҮАХ-р тооцно. Тус хөрөнгийн хүлээгдэж буй зээлийн алдагдалд өөрчлөлт орсон тохиолдолд зөвхөн холбогдох ЗҮЦХА-г тэр хэмжээгээр нэмэгдүүлж эсвэл багасгана.

Банк нь санхүүгийн хөрөнгийг төлөгдөх нийт дүн эсвэл зарим хэсгийг төлөгдөх боломжгүй гэж үзвэл санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулна. Үүнийг санхүүгийн хөрөнгийн (хэсэгчилсэн) үл хүлээн зөвшөөрөлт гэнэ.

ЗҮЦХА тооцоолол

Банк нь ЗҮЦХА-г үр ашигт хүүгээр хямдруулсан хүлээгдэж буй мөнгөний дутагдлыг гурван өөр магадлалаар жигнэсэн хувилбараар тооцоолдог. Мөнгөний дутагдал нь гэрээний дагуух мөнгөн гүйлгээ болон эргэн төлөгдөхөөр хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний зөрүү юм.

ЗҮЦХА тооцооллын механизм болон гол элементийн хамт доор үзүүлэв:

ЧМ: Чанаргүйдлийн магадлал (ЧМ) нь өгөгдсөн цаг хугацаанд төлбөрийн чадваргүй болох магадлалаар тооцоолно. Хэрвээ хэрэглүүр нь өмнө нь үл хүлээн зөвшөөрч байгаагүй мөн харгалзах багцад үргэлжлүүлэн байгаа бол үнэлсэн хугацааны тодорхой хугацаанд нэг удаа алдагдал үүсэх боломжтой.

ЧӨД: Чанаргүйдэлд өртөх дүн (ЧӨД) нь тайлагналын дараах зээлийн хүлээгдэж буй өөрчлөлт, гэрээний дагуух үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөлт, зээлийн үүргийн хүрээнд нэмж олгосон дүн болон төлбөр хоцорсноор үүссэн хуримтлагдсан хүүг харгалзсан, ирээдүйн ЧӨД-ийн тооцоолдог.

АХЧ: Алдагдал хүргэх чанаргүйдэл (АХЧ) гэдэг нь өгөгдсөн цаг хугацаанды туршид чанаргүйдлийн үеийн алдагдлын тооцоолол юм. Энэ нь гэрээний дагуу мөнгөн урсгал болон зээлдэгч хүлээн авахаар тооцоолсон дүн, барьцаа хөрөнгө борлуулсан дүнгийн нийлбэрийн зөрүүнээс тооцно.

ЗҮЦХА-г тооцохдоо Банк гурван хувилбарыг авч үздэг (суурь, эерэг болон сөрөг) ба хувилбар тус бүрийн ЧМ, ЧӨД болон АХЧ нь ялгаатай байна.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

ЗҮЦХА тооцоолол (үргэлжлэл)

ЗҮЦХА-г ЧМ, ЧӨД, АХЧ-г ирээдүйн сар бүр болон тусгайлсан эсвэл бүлгийн сегмент бүрээр төсөвлөн тодорхойлдог. Эдгээр гурван үндсэн бүрэлдэхүүнийг хооронд нь үржүүлэн, цаашид эдгээр нь хэвээр үйлчлэх магадлалаар мөн тохируулна (тухайлбал, чанаргүйдэлд өртөх дүн нь ойрын саруудад урьдчилан төлөгдөхгүй эсвэл чанаргүйдэхгүй). Үүгээр ирээдүйн сар бүрээрхи ЗҮЦХА-г тооцох ба тайлагналын өдрөөр үүнийг буцаан дискаунтлан нийлбэрийг нь авдаг. ЗҮЦХА-ийн тооцоололд ашиглагдах дискаунтын хувь нь зээлийн анхны үр ашигт хүүний хувь байх эсвэл түүний ойролцоо хувь байна.

Үнэ цэнийн бууралтын зардал болон буцаалт нь санхүүгийн хөрөнгийн дансны үнийн өөрчлөлтийн ашиг, алдагдлын тохируулгаас тусдаа бүртгэгдэх болон толилуулагдана.

ЗҮЦХА-ын тооцооллын аргыг доор хураангуйлав:

Шатлал 1: Ирээдүйн 12 сарын ЗҮЦХА нь нийт хугацааны ЗҮЦХА загварын нэг хэсэг байх бөгөөд тайлагналын өдрийн дараах 12 сард санхүүгийн хэрэглүүрийн чанаргүйдлийн үр дүнгээр ЗҮЦХА-ыг илэрхийлнэ. Банк нь ирээдүйн 12 сарын ЗҮЦХА тайлагналын өдрөөс хойш 12 сарын дотор ЧМ-д үндэслэн тооцдог. ЧӨД-ийн урьдчилсан төсөөлөлд 12 сарын дотор хүлээгдэж буй ЧМ-ыг хэрэглэх бөгөөд хүлээгдэж буй АХЧ-аар үржүүлэгдэж анхны үр ашигт хүүтэй ойролцоо дүнгээр хорогдуулна.

Шатлал 2: Зээлийг анх олгосноос хойш тухайн зээлд зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлттэй байгаа нь тогтоогдсон зээлүүдэд Банк нь нийт хугацааны ЗҮЦХА-ын сан байгуулан бүртгэнэ. Санг байгуулахдаа хэд хэдэн хувилбарууд дээр үндэслэн тооцоолох боловч ЧМ болон АХЧ-ыг нь нийт хугацаанд тооцолж гаргана. Хүлээгдэж буй мөнгөний дутагдалыг үр ашигт хүүтэй ойролцоо хувиар хорогдуулна.

Шатлал 3: Үнэ цэнэ буурсан гэж үзсэн зээлийн хувьд, Банк нь нийт хугацааны ЗҮЦХА-ыг бүртгэнэ. Энэ аргачлал нь Шатлал 2-т ашигласантай ижил аргачлалаар тооцогдох бөгөөд ЧМ-ыг 100% гэж үзнэ.

ХАҮҮЦБЙ: ХАҮҮЦБ хөрөнгө анх хүлээн зөвшөөрөх үед үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгө юм. Банк нь зөвхөн анх хүлээн зөвшөөрсөн үеэс хойшхи магадлалаар жигнэсэн гурван хувилбарыг зээлээр тохируулсан үр ашигт хүүгээр хорогдуулсан хуримтлагдсан нийт хугацааны ЗҮЦХА-г хүлээн зөвшөөрнө.

Зээлийн үүрэг болон аккредитив: Зээлийн үүрэгт нийт хугацааны ЗҮЦХА тооцохдоо, Банк нь ирээдүйн олгогдох зээлийн үүргийн дүнг тооцоолно. Зээл олгогдох тохиолдолд ЗҮЦХА нь магадлалаар жигнэсэн гурван хувилбараар хүлээгдэж буй мөнгөний дутагдлын өнөөгийн үнэ цэнээр тооцогдоно. Хүлээгдэж буй мөнгөний дутагдал нь хүлээгдэж буй үр ашигт хүүгээр хорогдуулсан байна. Зээлийн карт болон зээлийн үүргийг агуулсан бүтээгдэхүүний хувьд, ЗҮЦХА-г зээлтэй нь хамт тооцон, толилуулна. Зээлийн үүрэг болон аккредитивийн хувьд, ЗҮЦХА нь бусад өглөгт хүлээн зөвшөөрөгдөнө.

Санхүүгийн баталгааны гэрээнүүд: Банкны санхүүгийн баталгаа тус бүрийн үүрэг нь анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрөгдсөн хуримтлагдсан хорогдол хассан дүн болон ЗҮЦХА сангийн аль ихээр нь хэмжигдэнэ. Банк нь ЗҮЦХА-г эзэмшигчид нөхөн олгох дүнгийн өнөөгийн үнэ цэнэ дээр үндэслэн тооцно. Эрсдлээр тохируулсан хүүгээр дутагдлыг хорогдуулна. Тооцоолол нь магадлалын-жигнэсэн гурван хувилбар дээр хийгдэнэ. Санхүүгийн баталгааны ЗҮЦХА нь бусад өглөгт хүлээн зөвшөөрөгдөнө.

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэх өрийн хэрэглүүр

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн ЗҮЦХА нь санхүүгийн байдлын тайланд санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй бөгөөд бодит үнэ цэнэ нь хэвээр үлдэнэ. Үүний оронд, хэрвээ хөрөнгө нь хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн байсан бол үүсэх үнэ цэнийн бууралтыг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хуримтлагдсан үнэ цэнийн бууралт гэж бүртгэх ба үр дүнг ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ. Бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдсэн хуримтлагдсан алдагдлыг хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед ашиг, алдагдлын тайланд шилжүүлэн бүртгэнэ.

--	--	--	--	--	--

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

ЗҮЦХА тооцоолол (үргэлжлэл)

Кредит карт ба бусад зээлийн шугамууд

Банк харилцагчиддаа төрөл бүрийн байгууллагын болон иргэдийн овердрафт, зээлийн картны бүтээгдэхүүн санал болгодог ба Банк нэг өдрийн өмнө мэдэгдэл өгч уг хэрэгслийг цуцлах, эсвэл зээлийн эрхийн хэмжээг бууруулах эрхтэй. Банк зээлийн алдагдлын эрсдэлийг гэрээний мэдэгдлийн хугацаагаар хязгаарладаггүй бөгөөд харин үйлчлүүлэгчдийн зан төлөв, чанаргүй болох магадлал болон цаашдын эрсдэлийг бууруулах арга аргачлалууд болох зээлийг цуцлах, зээлийн хэмжээг бууруулах гэх мэт зүйлсүүдийг тусгасан байдаг.

Эдгээр бүтээгдэхүүнүүдийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц ихэссэн эсэх талаархи үнэлгээ нь зээлийн бусад бүтээгдэхүүнүүдийн үнэлгээтэй адил юм. Үнэлгээ нь харилцагчдийн дотоод зээлжих зэрэглэлийн өөрчлөлтөд суурилсан боловч тухайн хэрэгслийн хэрэглээний өөрчлөлт гэх мэт чанарын хүчин зүйлсд мөн гол ач холбогдлыг өгдөг.

Зээлийн карт болон овердрафтын ЗҮЦХА-г дискаунтлахад ашиглах хүүний хувь нь тухайн бүтээгдэхүүнүүдийн нийт ашиглагдах хугацаанд тооцогдох жилийн дундаж үр ашигт хүү байна. Энэхүү тооцоо нь олон зээл сар бүр бүрэн төлөгдөж, дараа сараасаа хүү тооцохгүй байхаар хийгдсэн.

Ирээдүйн мэдээлэл

ЗҮЦХА-ын загвартаа Банк нь доорхи эдийн засгийн өгөгдлүүдийг ирээдүйн мэдээлэл болгон ашигладаг. Үүнд:

- Инфляцийн түвшин
- Дотоодын нийт бүтээгдэхүүний (“ДНБ”) өсөлт
- Ам.доллар ханш
- Бодлогын хүү
- Зээлийн өсөлт
- Мөнгөний нийлүүлэлт
- Ажилгүйдлийн түвшин
- Арилжааны банкуудын зээлийн үлдэгдэл

ЗҮЦХА-ын тооцоололд ашиглаж буй энэхүү мэдээлэл нь санхүүгийн тайлангийн өдрөөрх зах зээлийн бүх шинж чанаруудыг агуулаагүй байх магадлалтай. Үүний нөлөөг тооцоололд тусгахын тулд зарим тохиолдолд, чанарын тохируулгууд болон давхацалуудыг зөрүү материаллаг үед түр тохируулга хийдэг.

Зээлийн сайжруулалт: Барьцаа хөрөнгийн үнэлгээ болон санхүүгийн баталгаа

Санхүүгийн хөрөнгийн эрсдэлийг бууруулах үүднээс, Банк барьцаа хөрөнгө авдаг. Барьцаа хөрөнгө нь төрөл бүрийн хэлбэрээр байдаг, жишээ нь: мөнгөн хөрөнгө, үнэт цаас, аккредитив болон баталгаа, үл хөдлөх хөрөнгө, авлага, бараа материал, бусад санхүүгийн бус хөрөнгө болон үр дүнгийн тооцооны гэрээ байна. Барьцаа хөрөнгийг эзэмшээгүй тохиолдолд Банкны санхүүгийн байдлын тайланд бүртгэхгүй.

Зээлийн сайжруулалтаас хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг, СТОУС-ын дагуу тусад нь хүлээн зөвшөөрөх шаардлагагүй бөгөөд өр төлбөрийн хэрэгслийн гэрээний нөхцлүүдийн салшгүй хэсэг гэж тооцогддог ба зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын хэмжилтэд оруулдаг. Үүний үндсэн дээр барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ нь үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцоонд нөлөөлдөг. Барьцаа хөрөнгийг ерөнхийд нь хамгийн багадаа анх хүлээн зөвшөөрөхдөө болон хагас жилийн хугацаанд дахин үнэлдэг.

Боломжийг нэмэгдүүлэх зорилгоор, Банк нь барьцаа хөрөнгийн зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгийг үнэлэхдээ идэвхтэй зах зээлийн мэдээллийг ашигладаг. Идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаггүй бусад санхүүгийн хөрөнгийг үнэлгээний арга ашиглан үнэлдэг. Санхүүгийн бус барьцаа хөрөнгийг (жишээ нь: үл хөдлөх хөрөнгө) ипотекийн зуучлагч буюу гуравдагч этгээдээс ирсэн мэдээлэлд эсвэл орон сууцны үнийн индексүүдэд үндэслэн үнэлнэ.

Барьцаалагдсан зээл нь зээлийн гэрээний нөхцөлд тусгагдсан эсвэл зээлийн салшгүй хэсэг болох ба зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцоонд хамрагдсан болно.

Зээлийн гэрээний нөхцөлтэй холбоогүй баталгааг балансын гадуурх зүйл ангид салангид үзүүлэх бөгөөд үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцооллыг хийдэг.

--	--	--	--	--	--

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө

Банк нь дотоод бодлогынхоо дагуу өмчлөх бусад хөрөнгийг банкны үйл ажиллагаанд ашиглах эсвэл борлуулах зорилгоор эзэмшихээ тодорхойлдог. Дотоодын үйл ажиллагаанд ашигтай байх нь тогтоогдсон хөрөнгийг харгалзах хөрөнгийн ангилалд шилжүүлэхдээ барьцаалсан хөрөнгийн доод өртөгөөр эсвэл анхны баталгаажсан хөрөнгийн дансны үнээр шилжинэ. Хөрөнгийг борлуулах нь илүү ашигтай байхаар тодорхойлсон хөрөнгийг бодит үнэ цэнээр (хэрэв санхүүгийн хөрөнгө бол) эсвэл санхүүгийн бус хөрөнгө бол өмчилсөн өдрөөрх борлуулах зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр "Борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгө" рүү шилжүүлдэг. 12 сараас дээш хугацаанд борлуулагдах хөрөнгийг “Бусад хөрөнгө”-д бодит үнэ цэнээс борлуулагдах өртгийг хассан дүнгийн аль багаар тайлагнана.

Үнэт метал

Үнэт металд бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх алт болон мөнгө багтдаг.

Данснаас хасах

Банк нь хөрөнгийн эргэн төлөлтийг зогсоосон үед санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн данснаас хасна. Хэрвээ данснаас хасах үнэ хуримтлагдсан алдагдлаас их тохиолдолд, зөрүүгээр нь алдагдлыг нэмэгдүүлж дараа нь дансны нийт үнийн дүнг бууруулна. Дараах үеийн эргэн төлөлтүүд нь зээлийн алдагдлын зардлыг бууруулна.

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг нягтлан бодох бүртгэлийн өмчийн аргыг ашиглан бүртгэнэ. Хараат компани гэж Банкны мэдэгдэхүйц нөлөөлөлтэй компанийг хэлнэ. Мэдэгдэхүйц нөлөө гэдэг нь хараат компанийн санхүү болон үйл ажиллагааны бодлогын шийдвэрт шууд оролцох эрхийг хэлнэ.

Өмчийн аргыг ашиглах үед хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт нь санхүүгийн байдлын тайлан дахь өртөг дээр худалдан авалтын дараах хараат компанийн цэвэр хөрөнгийн Банкны хувь оролцооны өөрчлөлтийг нэмсэнтэй тэнцүү байна. Хараат компанитай холбоотой бүртгэгдсэн гүүдвилл нь хөрөнгө оруулалтын дүнд багтах бөгөөд дангаар нь үнэ цэнийн бууралт хэмжихгүй мөн хорогдуулахгүй.

Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хараат компанийн үйл ажиллагааны үр дүнгийн Банкны эзэмшлийн хувь хэмжээгээрх хэсгийг тусгана. Хараат компанийн өмчид шууд өөрчлөлт орсон үед Банк энэхүү өөрчлөлтийг өөрийн хувь эзэмших хэмжээгээр хүлээн зөвшөөрөн, шаардлагатай тодруулгыг өмчийн өөрчлөлтийн тайландаа тусгана. Банк болон хараат компани хооронд хийгдсэн ажил гүйлгээнээс үүссэн аливаа бодит бус ашиг, алдагдлыг хараат компанийн эзэмшлийн хувь хэмжээ хүртэлх хэсгээр устгах бичилт хийнэ.

Хараат компанийн ашгийн хувийг ашиг, алдагдал ба дэлгэрэнгүй орлогын тайланд толилуулна. Энэ ашиг нь хараат компанийн хувьцаа эзэмшигчдэд хамааралтай бөгөөд татварын дараах ашиг болно. Мөн хараат компани охин компанитай бөгөөд түүнд цөөнхийн сонирхолын хэсэг бүртгэгддэг бол түүнийг ч мөн авч үзсэн ашиг байна.

Хараат компанийн санхүүгийн тайланг Банкны тайлангийн хугацаатай нэг хугацаанд бэлтгэнэ. Шаардлагатай бол, хараат компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчилж Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлнэ.

Өмчийн аргыг хэрэглэсний дараа, хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтад нэмэлт үнэ цэнийн бууралтын сан байгуулах шаардлагатай эсэхийг Банк тодорхойлно. Банкны хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтад үнэ цэнийн бууралт үүссэн гэх бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн тайлан бэлтгэх бүрдээ тодорхойлно. Хэрэв тийм нотолгоо байгаа бол уг хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх дүн, бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр алдагдлын дүнг тооцож, уг дүнг ашиг, алдагдлын тайланд ‘хараат компанийн ашгийн хувь’ хэсэгт хүлээн зөвшөөрнө.

Хараат компани дахь мэдэгдэхүйц нөлөөллөө алдсаны дараа Банк үлдсэн хөрөнгө оруулалтаа бодит үнээр тооцож хүлээн зөвшөөрнө. Уг нөлөөллөө алдсаны дараах дансны үнэ, үлдсэн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ хоёрын зөрүү болон хөрөнгө борлуулсны ашиг, алдагдлуудыг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Санхүүгийн байдлын тайланд тусгасан бэлэн мөнгө, түүнтэй адилтгэх хөрөнгүүд нь 3 сар ба түүнээс бага хугацаатай бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж болон касс дахь бэлэн мөнгө зэрэг үнэ цэнийн буралтын эрсдэл маш бага хөрөнгүүд хамаарна.

Мөнгөн гүйлгээний тайлан дахь бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь Монголбанкин дахь хязгаарлалтгүй харилцах данс, 3 сар ба түүнээс богино хугацаатай засгын газрын үнэт цаас, бусад банкин дахь харилцах, хадгаламжуудаас бүрдэнэ.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Буцаан худалдан авах ба урвуу буцаан худалдан авах хэлцлүүд

Ирээдүйд тодорхой заасан хугацаанд буцаан худалдан авах нөхцөлтэй хэлцэл (“репо”)–ийн дор худалдсан үнэт цаасыг санхүүгийн байдлын тайлангаас үл хүлээн зөвшөөрөхгүй. Учир нь Банк эзэмшилтэй холбоотой ихэнхи эрсдэлийг хүлээж, өгөөжийг хүртэж байна. Санхүүгийн байдлын тайланд хүлээн авсан бэлэн мөнгийг хөрөнгөөр, репо хэлцлийн хуримтлагдсан хүүг өр төлбөрөөр тусгах ба энэ нь банканд олгосон зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлнэ. Борлуулсан ба ирээдүйд буцаан худалдан авах үнийн зөрүүг хүүний зардал гэж үзэж үр ашигт хүүний аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна. Нөгөө тал нь үнэт цаасыг худалдах эсвэл дахин барьцаалах эрхтэй бол, Банк нь тухайн үнэт цаасуудыг санхүүгийн байдлын тайландаа борлуулахад бэлэн барьцаанд тавьсан санхүүгийн хөрөнгө эсвэл борлуулахад бэлэн барьцаанд тавьсан санхүүгийн хөрөнгө оруулалтын аль тохиромжтой ангилалд үлдээнэ.

Эсрэгээрээ, буцаан худалдах хэлцэл (“урвуу репо”)–ийн дагуу худалдан авсан үнэт цааснуудыг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөггүй. Банкны төлсөн мөнгө ба хуримтлагдсан хүүний дүнг санхүүгийн тайланд “Зээлсэн үнэт цаас ба урвуу буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа” гэж тусгах ба энэ нь Банкнаас авсан зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлнэ. Худалдан авсан ба буцаан худалдах үнийн зөрүүг “Хүү болон түүнтэй адилтгах орлого” гэж бүртгэх ба ҮАХ–ийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна.

Түрээс

Банк нь гэрээ байгуулагдах үед түрээсийн шинж чанар агуулсан эсэхийг үнэлдэг. Өөрөөр хэлбэл гэрээнд тодорхойлогдож байгаа хөрөнгийг хэсэг хугацааны турш ашиглан хянах эрхийг шилжүүлсэн болно.

Банк - түрээслэгч

Банк нь богино хугацаатай түрээс эсвэл бага өртөгтэй хөрөнгийг түрээслэхээс бусад тохиолдолд бүх түрээсийг хүлээн зөвшөөрөх, хэмжих нэг аргыг ашигладаг. Банк нь түрээсийг төлөх түрээсийн өр төлбөрийг болон хөрөнгийг ашиглах эрхийг хүлээн зөвшөөрдөг.

Ашиглах эрхтэй хөрөнгө

Банк нь ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн өдрөөс эхлэн хүлээн зөвшөөрдөг (жишээлбэл, үндсэн хөрөнгийг ашиглах боломжтой болсон өдөр). Ашиглах эрхтэй хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын алдагдлыг хасч өртгөөр нь хэмжиж, түрээсийн өр төлбөрийг дахин үнэлэхэд тохируулна. Ашиглах эрхтэй хөрөнгийн өртөгт түрээсийн өр төлбөр, хүлээн авсан түрээсийн эхний өртөг, түрээсийн урамшууллыг авалгүйгээр эхлэхээс өмнө хийсэн түрээсийн төлбөрүүд орно. Ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар элэгдүүлнэ. Ашиглах эрхтэй хөрөнгөд үнэ цэнийн бууралт тооцно.

Түрээсийн өглөг

Түрээсийн эхлэх өдөр Банк нь түрээсийн нийт хугацааны туршид хийгдэх түрээсийн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнээр хэмжсэн түрээсийн өглөгийн хүлээн зөвшөөрнө. Түрээсийн төлбөрт тогтмол төлбөр (түрээсийн урамшууллыг аваагүй), индекс эсвэл хувь хэмжээнээс хамааран хувьсах түрээсийн төлбөрүүд, үлдэгдэл үнийн баталгааны дагуу төлөх хүлээгдэж буй төлбөрүүд орно. Индекс эсвэл хувь хэмжээнээс хамааралгүй хувьсах түрээсийн төлбөрийн тайлант үеийн зардал гэж хүлээн зөвшөөрнө.

Түрээсийн хүүгийн хэмжээг тодорхойлох боломжгүй тохиолдолд Банк нь түрээс эхлэх үеийн зээлийн өсөн нэмэгдэх хүүг ашиглан түрээсийн өр төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцоолно. Түрээс эхэлсэн өдрөөс хойш түрээсийн өр төлбөрийг хуримтлагдсан хүүгээр нэмэгдүүлж, төлсөн түрээсийн төлбөрөөр бууруулдаг. Мөн түүнчлэн түрээсийн хугацаанд өөрчлөлт оруулаг, тогтмол төлбөрийн шинж чанарт өөрчлөлт орруулах эсвэл уг хөрөнгийг худалдаж авах үнэлгээнд өөрчлөлт оруулах зэрэг өөрчлөлтүүд гарсан тохиолдолд түрээсийн өр төлбөрийн дүнг дахин тооцоолно.

Богино хугацаат түрээсүүд

Банк нь зарим богино хугацааны оффисын түрээсийн (12 сар болон түүнээс бага хугацаатай түрээс эсвэл эсвэл АТМ–ийн талбайн түрээсгэх мэт) хувьд хүлээн зөвшөөрөлтийн чөлөөлтийг ашигласан. Богино хугацаат түрээсийн төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар зардалд хүлээн зөвшөөрнө.

Түрээсийн гэрээг шинэчлэх, цуцлах сонгол бүхийн түрээсийн гэрээний хугацааг тодорхойлох

Банк нь түрээсийн үл цуцлагдах хугацааг тодорхойлохдоо тухайн түрээсийг үргэлжлүүлэн түрээслэх нь тодорхой үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд сунгагдах хугацаа эсвэл тухайн үргэлжлүүлэн түрээслэх нь үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд цуцлах хугацааг оруулна тооцно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Түрээс (үргэлжлэл)

Банк нь тухайн түрээсийн гэрээг дахин сунгагдах үндэслэлийг тодорхойлход тодорхой үнэлэмжийг ашигласан. Өөрөөр хэлбэл тухайн түрээсийг сунгах эсвэл цуцлах сонголтыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх эдийн засгийн хөшүүргийг бий болгох бүхий л хүчин зүйлийг авч үзсэн. Түрээс эхэлсэн өдрөөс хойш Банкны өөрийн хянаж чадах үйл явдал, нөхцөл байдалд болон сунгах (эсвэл цуцлах) сонголтыг хэрэгжүүлэх чадварт өөрчлөлт орсон тохиолдолд түрээсийн хугацааг дахин үнэлнэ.

Банк нь салбарын үйл ажиллагаанд нь өндөр ач холбогдолтой түрээсийн талбайн сунгах хугацааг түрээслэх хугацааны нэг хэсэг болгон шинэчилсэн хугацааг оруулсан.

Үндсэн хөрөнгө

Барилга байгууламж ба газраас бусад үндсэн хөрөнгийг анхлан өртгөөр бүртгэнэ. Анхны өртөгт тухайн үндсэн хөрөнгийн зайлшгүй хэсгийг шинээр солих зэрэг шууд хамааралтай зардлууд орох ба хүлээн зөвшөөрөлтийн шаардлагыг хангаж байгаа тохиолдолд өртөгт шингээнэ. Хэрэв тухайн үндсэн хөрөнгө зарим зайлшгүй хэсгийг тогтмол хугацаагаар сольж байршуулах шаардлага үүсдэг бол Банк нь тухайн хэсгийг үндсэн хөрөнгөөс тусад нь болон харгалзах ашиглалтын хугацаа ба элэгдүүлэх аргыг тодорхойлж хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн анх бүртгэхэд шууд холбогдон гарсан хяналт шалгалтын зардал нь үндсэн хөрөнгөөр бүртгэх шаардлагыг хангаж байгаа тохиолдолд өртөгт шингээж бүртгэнэ. Бүх төрлийн засвар үйлчилгээний зардлыг ашиг алдагдлаар бүртгэнэ.

Анхны хэмжилтээс хойших тайлант үед барилга болон газраас бусад үндсэн хөрөнгийн ангиллууд нь хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр илэрхийлдэг.

Барилга байгууламж ба газар нь бодит үнэ цэнээр хэмжигдэнэ. Үнэлгээг 3-5 жилийн давтамжтайгаар хийнэ. Дахин үнэлэгдэх өдрүүдийн хооронд, барилгуудад үнийн бууралтийг илэрхийлэхүйц хэмжээнд элэгдэл тооцно. Дахин үнэлгээний нэмэгдлийг (өмнө нь ашиг, алдагдлын тайланд тусгасан дахин үнэлгээний алдагдлыг буцааж буй тохиолдолд, уг хэсгийг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө) бусад дэлгэрэнгүй орлогын тайлангаар дамжуулан "Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц" нэртэйгээр өөрийн хөрөнгийн хэсэгт хуримтлуулна.

Хөрөнгийн дахин үнэлгээний дүн болон хөрөнгийн анхны өртөг дээр суурилсан элэгдлүүдээс үүссэн зөрүүг жил бүр хөрөнгийн дахин үнэлгээний нөөцөөс хуримтлагдсан ашиг руу шилжүүлнэ. Мөн дахин үнэлгээний өдрийн байдлаарх хуримтлагдсан элэгдлийг хөрөнгийн бүртгэлийн нийт дүнтэй цэвэршүүлж, бүртгэлийн дүнг дахин үнэлгээний дүнгээр дахин илэрхийлнэ. Борлуулах эсвэл данснаас хасах тохиолдолд тухайн хөрөнгөтэй холбоотой дахин үнэлгээний нөөцийг хуримтлагдсан ашиг руу шилжүүлнэ.

Дуусаагүй барилгыг барилгын тоног төхөөрөмжийн өртөг болон бусад зардлаас үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр илэрхийлнэ. Дуусаагүй барилгыг тухайн хөрөнгө баригдаж дууссан эсвэл үйл ажиллагаанд ашиглаж эхэлтэл элэгдүүлдэггүй.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тухайн хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцож үлдэх өртөг хүртэл дараах хугацаагаар элэгдүүлнэ:

<u>Хөрөнгийн төрөл</u>	<u>Ашиглалтын хугацаа (жилээр)</u>
Барилга байгууламж ба газар	25 – 60
Оффисын тавилга ба тоног төхөөрөмж	3 – 15
Компьютер ба бусад	2 – 13

Үндсэн хөрөнгө ба түүний томоохон хэсгүүдийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхгүй болсон үед данснаас хасна. Үүнтэй холбоотойгоор үүссэн аливаа нэг олз, гарзыг (хөрөнгө борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр тооцно) тухайн тайлант жилийн ашиг, алдагдлын тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр ашгийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг тайлант жилийн эцэс бүрт хянаж үздэг.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

Биет бус хөрөнгө

Банкны биет бус хөрөнгөд компьютерийн програм хангамж, лиценз болон газар ашиглах эрх орно.

Зөвхөн биет бус хөрөнгийн өртгийг зохистойгоор хэмжиж болох ба хүлээгдэж буй эдийн засгийн ирээдүйн өгөөж нь банканд орж ирэх нь магадлалтай болсон үед л биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Тусад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрснөөс хойших тайлант үед, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан бүртгэнэ.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэхийг үнэлнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай хугацааны туршид нь хорогдуулна. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа тайлант жил бүрийн эцэст хянаж үздэг. Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ.

Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг ашиг, алдагдлын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө. Биет бус хөрөнгийн өртгийг 3-10 жилийн ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргыг ашиглан, үлдэх өртөг хүртэл нь хорогдуулна.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үндсэн хөрөнгө

Хөрөнгө оруулалтын зориулалттай үндсэн хөрөнгийг анх шууд холбогдон гарсан аливаа зардлыг шингээсэн өртгөөр хүлээн зөвшөөрнө. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа бодит үнэ цэнийн аргаар тайлант өдрөөрх зах зээлийн үнэлгээгээр толилуулна. Бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн аливаа олз ба гарзыг холбогдох татварын нөлөөг тооцсон дүнгээр тайланд үед ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийг тодорхойлохдоо Олон улсын үнэлгээний стандартын хорооноос зөвлөсөн үнэлгээний загварыг мөрдсөн хараат бус мэргэшсэн үнэлгээчний жилийн үнэлгээний тайланг үндэслэнэ.

Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийг борлуулсан үед(жишээ нь худалдан авагч тал тухайн хөрөнгийг бүрэн ашиглах эрхийг авсан өдрөөр) эсвэл ашиглалтаас бүрэн гарсан болон тухайн хөрөнгийг борлуулснаар хүртэх эдийн засгийн өгөөж байхгүй болсон үед данснаас хасна. Тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийг данснаас хасахдаа бусад хувьсах хүчин зүйлүүд болох гол санхүүгийн бүрэлдэхүүн оршиж байгаах эсэх, мөнгөн бус шинжтэй давуу талууд болон худалдан авагч талд өгөх өглөг(зарим тохиолдод) зэргийн нөлөөг авч үзнэ.

Хэрэв хөрөнгийн зориулалтад өөрчлөлт орсон бол хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөөс/-д шилжүүлдэг. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг банкны ашиглалтад буй үндсэн хөрөнгө руу шилжүүлэх тохиолдлолд ашиглалтад өөрчлөлт орсон өдрөөрх бодит үнэ цэнээр хөрөнгийн өртгийг тооцож дараагийн хэмжилтүүдийг хийнэ. Үндсэн хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөд шилжвэл, Банк нь тухайн өдрөөр дагаж мөрдөж буй Үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу хүлээн зөвшөөрнө.

Борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Банк нь эргэлийн бус хөрөнгийн дансны үнэ нь тухайн хөрөнгийг ашигласнаар бус борлуулснаар орж ирэх мөнгөн урсгалаас нөхөгдөхөөр байгаа тохиолдолд борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгө руу шилжүүлдэг. Борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгийг түүний дансны үнэ ба бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүнгийн аль багаар хэмжинэ. Борлуулалтын зардал нь тухайн хөрөнгийг борлуулахтай шууд холбогдон гарсан зардлаас холбогдох санхүүгийн болон орлогын албан татварын зардлыг хассан дүнтэй тэнцүү байна.

Хөрөнгийг зөвхөн тухайн нөхцөлд богино хугацаанд борлуулах боломжтой буюу өндөр магадлалтай байгаа тохиолдолд борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгөөр ангилна. Шаардагдах борлуулалтын үйл ажиллагаа нь борлуулалтад мэдэгдэхүйц өөрчлөлт бий болгох эсвэл борлуулалтыг зогсоох нөлөөгүй байх шаардлагатай. Удирдлагаас тухайн хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө руу ангилах шийдвэр гаргаснаас хойш нэг жилийн хугацаанд борлуулалтыг бүрэн хийж дуусгахаар төлөвлөнө.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон байж болох шинж тэмдэг байгаа эсэхийг Банк тайлант хугацаа тутамд шалгаж үздэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрсэн эсвэл жилд нэг удаа хийдэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тестийг хийх шаардлагатай үед Банк нь хөрөнгөөс цуглуулан авах боломжтой дүнг тооцоолно. Цуглуулан авах дүн нь хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнэ (борлуулалтын зардлыг хасаж тооцсон) ба ашиглалтын үнэ цэнэ хоёрын аль өндөр нь байна. Хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүн хүртэл нь бууруулж бүртгэнэ. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөд харгалзах эрсдэлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно. Борлуулалтын зардлыг хассаны дараах бодит үнэ цэнийг тодорхойлохдоо тохиромжтой үнэлгээний загварыг ашиглан тооцоолно. Үнэлгээний үржүүлэгч, нийтэд хувьцаагаа зардаг охин компанийн хөрөнгийн бирж дээрх хувьцааны үнэ эсвэл бодит үнэ цэнийн бусад үзүүлэлтүүдээр эдгээр тооцооллыг хэмжиж болно.

Гүүдвиллээс бусад хөрөнгүүд дээр, тайлагналын өдөр бүр өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал арилсан эсвэл буурсан эсэх талаар ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэх талаар үнэлгээг хийдэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл Банк нь тухайн хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн нөхөн төлөгдөх дүнг ойролцоогоор тооцож үзнэ. Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн цуглуулан авах дүнг тодорхойлоход ашигласан тооцооллуудад өөрчлөлт гарсан тохиолдолд л өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана. Буцаалт нь хязгаартай байх ба ингэснээр хөрөнгийн бүртгэлийн дүн нь цуглуулан авах дүн ба өмнөх жилүүдэд хөрөнгийн үнэ цэнийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөгүй байсан бол байх ёстой байсан бүртгэлийн цэвэр дүнгээс (элэгдлийг хассан цэвэр дүнгээс) хэтрэхгүй байна. Ийм буцаалтуудыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Ажилтнуудын тэтгэмж

Богино хугацаат тэтгэмж

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Банкны ажилтнуудаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана.

Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

Заавал төлөгдөх даатгалын шимтгэлүүд

Монгол улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь ашиг, алдагдлын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Нооц

Банканд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн) байгаа энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед нөөцийг хүлээн зөвшөөрнө. Аливаа нэг нөөцтэй холбоотой зардлыг ашиг, алдагдлаар аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь толилуулна.

Сегментийн тайлан

Банкыг бүрэлдүүлэгч аль нэг үйл ажиллагааны сегмент нь бизнесийн үйл ажиллагааны хүрээнд бусад бүрэлдэхүүн хэсгүүдээс орлого олох, зардал хүлээх зэрэг орлого зарлагын гүйлгээг тогтмол хийдэг. Банкны үйл ажиллагаа хариуцсан шийдвэр гаргагч албан тушаалтан нь бүх үйл ажиллагааны сегментийн үр дүнг тогтмол хянаж, сегментүүдэд шаардлагатай нөөцүүдийг хуваарилах, боломжит санхүүгийн үзүүлэлтүүдийг ашиглан гүйцэтгэлийг нь үнэлэх үүрэгтэй ажилладаг.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

Татвар

Тайлант хугацааны орлогын албан татвар

Одоогийн болон өмнөх тайлант хугацааны өнөөгийн албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан.

Хойшлуулсан татвар

Хойшлуулсан орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн хоёрын хооронд түр зөрүүний дүнгээс тайлан тэнцлийн аргыг хэрэглэн тооцдог. Дараахаас бусад бүх түр зөрүүнүүд дээр хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хэрэв хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө нь бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийгдэх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол;
- Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт, хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотой татвар ногдох түр зөрүүнүүдийн хувьд, үүссэн түр зөрүү нь ойрын ирээдүйд арилах ба түр зөрүүг ашиглаж болох татвар ногдох ашиг олох магадлал байгаа бол.

Хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг бүртгэлийн дүнг бууруулна. Үл хүлээн зөвшөөрсөн хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр дахин үнэлж үздэг ба хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг ашиглахыг зөвшөөрсөн татвар ногдох орлого ирээдүйд орж ирэх магадлалтай болсон үед хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийг олж авах эсвэл өр төлбөрийг барагдуулах тэр тайлант хугацаанд хэрэглэгдэнэ гэж хүлээж байгаа (тайлант жилийн эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын хувь хэмжээ, татварын хуулиуд дээр үндэслэн) татварын хувь хэмжээгээр хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө, өр төлбөрийг хэмжинэ.

Өөрийн хөрөнгөнд шууд хүлээн зөвшөөрсөн зүйлүүдтэй холбоотой тайлант жилийн болон хойшлуулсан татваруудыг мөн өөрийн хөрөнгөнд хүлээн зөвшөөрөх ба ашиг, алдагдалын тайланд хүлээн зөвшөөрөхгүй.

Нэг татвар төлөгч, нэг татварын байгууллагад хамаарах хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнах хуулиар олгогдсон эрхтэй бол хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнаж болно.

Эздийн өмч

Энгийн хувьцаа

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөөр ангилсан. Шинэ хувьцаа гаргахтай шууд холбоотой нэмэгдэл зардлыг хувьцаа гаргасан орлогоос татварыг хассаны дараах байдлаар өөрийн хөрөнгийг хорогдуулах байдлаар толилуулна.

Нэмж төлөгдсөн капитал

Нэмж төлөгдсөн капитал нь хувьцааны нэрлэсэн үнээс илүү гарсан дүнгээрх нийлүүлсэн хувь юм. Нэмж төлөгдсөн капитал нь мөн хувьцаа эзэмшигчдийн нэмэлтээр оруулсан хөрөнгөнөөс үүсч болно.

Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг нь зарласан ногдол ашгаар буурдаг хуримтлагдсан ашиг, алдагдлыг илэрхийлнэ. Үүнд мөн нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтийн нөлөө, өмнөх тайлант үеийн залруулга багтана.

Дахин үнэлгээний нөөц

Банкны барилга болон газар дахин үнэлсэнээс үүссэн нэмэгдлийг хөрөнгийн дахин үнэлгээний нөөц дансанд бүртгэдэг.

Тусгай зориулалттай нөөц

Тусгай зориулалттай нөөц нь зээлийн болон хураан авсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын санг Монголбанкны журам болон СТОУС-ын дагуу тооцоолоход үүссэн зөрүүг илэрхийлдэг. Энэхүү нөөц нь өмчийн бусад хэсэгт бүртгэгдсэн бөгөөд Монголбанкны зөвшөөрлөөр Банкны хувьцаа эзэмшигчид хуваарилагдана.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

Эздийн өмч (үргэлжлэл)

Бодит үнэ цэнийн нөөц

Бодит үнэ цэнийн нөөц нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд-д ангилагдсан өрийн хэрэглүүрийн бодит үнийн хуримтлагдсан цэвэр өөрчлөлт, хүлээгдэж буй алдагдалыг хассан дүнгээр, өмчийн хэрэглүүрийн бодит үнийн хуримтлагдсан цэвэр өөрчлөлтөөс бүрдэнэ.

Нэгж хувьцаанд ногдох ашиг

Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашгийг энгийн хувьцаа эзэмшигчдэд олгохоор тооцсон жилийн цэвэр ашгийг тайлант хугацааны туршид гаргасан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд харьцуулж тооцоолно.

Хорогдуулсан нэгж хувьцаанд ногдох ашгийг энгийн хувьцаа эзэмшигчдэд олгохоор тооцсон жилийн цэвэр ашиг дээр аливаа татварын нөлөөллийг оруулсан хөрвөгч давуу эрхтэй хувьцаа болон хөрвөгч бонд (хорогдуулагч үнэт цаас)-ын хүүг нэмж, уг дүнгээ хэрвээ хорогдуулагч үнэт цааснуудыг бүгдийг нь хөрвүүлсэн тохиолдолд нэмж гаргах байсан энгийн хувьцааны тоог оруулсан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд харьцуулж тооцоолно.

Холбоотой талын ажил гүйлгээ

Холбоотой талууд гэдэгт Банктай дараах байдлаар холбогдсон аж ахуй нэгж болон хувь хүн орно. Үүнд:

Банктай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:

- Банканд дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
- Банканд томоохон нөлөөлөлтэй эсвэл
- Банкны эсвэл Банкны толгой компанийн гол удирдах албан тушаалтнуудын нэг.

Дараах нөхцлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуй нэгж нь Банканд хамааралтай болно. Үүнд:

- Аж ахуйн нэгж болон Банк нь нэг ижил группийн гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой).
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани (эсвэл нөгөө аж ахуйн нэгж нь гишүүн болох Банкны хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани).
- Аль аль аж ахуйн нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд.
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуй нэгжийн хараат компани.
- Аж ахуйн нэгж нь Банкны эсвэл Банктай холбоотой аж ахуйн нэгжийн ажиллагсдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог. Хэрвээ Банк нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Банктай холбоотой тал болно.
- Аж ахуйн нэгжийг Банканд дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог.
- Банканд дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон хувь хүн нь аж ахуйн нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуйн нэгжийн (эсвэл аж ахуйн нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.
- Аж ахуйн нэгж нь эсвэл Банкны аль нэг гишүүн нь Банк эсвэл Банкны толгой компанид гол удирдах албан тушаалтай.

Холбоотой талуудтай хийсэн материаллаг бүх гүйлгээ болон дансдын үлдэгдлийн мэдээллүүдийг санхүүгийн тайланд хавсаргасан бөгөөд Тодруулга 36-д задаргааг толилуулсан.

2.5 СТОУС-ын анхлан хэрэгжүүлэлт

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн энэхүү санхүүгийн тайлан нь Банкны СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн анхны тайлан юм. Банк нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилийн санхүүгийн тайлангуудыг СТОУС 9 "*Санхүүгийн хэрэглүүр*"-ийн хэрэгжилтээс бусдаар НББОУСЗ-өөс баталж гаргасан СТОУС-ын дагуу боловсруулсан банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу бэлтгэж толилуулсан ба санхүүгийн хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтын бүртгэлдээ Монголбанкаас баталсан заавар, журмыг мөрдөж байсан.

Иймд Банк СТОУС 1-ийг хэрэгжүүлж 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлан болон 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх харьцуулсан үзүүлэлтүүдийг нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудад тодорхойлсноор СТОУС-ын дагуу бэлтгэв. Санхүүгийн тайланг бэлтгэхдээ СТОУС-д анх шилжсэн өдөр болох 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр Банкны санхүүгийн байдлын тайлангийн эхлэлтийн балансыг бэлтгэв. Энэхүү тодруулгад тайлан бэлтгэх үндэслэлийн дагуу өмнөх жилүүдэд бэлтгэсэн Банкны 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлангуудыг дахин толилуулахад хийсэн гол залруулгуудыг тайлбарлав.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

2.5 СТОУС-ын анхлан хэрэгжүүлэлт (үргэлжлэл)

Санхүүгийн байдлын тайлангийн тохируулга - 2020 оны 1 дүгээр сарын 1-нээр (СТОУС-т шилжсэн өдөр):

	Тод.	СТОУС-д тулгуурлан Монголбанк-наас баталсан заавар, журмын дагуу мян.төг	Дахин ангилал мян.төг	Дахин хэмжилт мян.төг	СТОУС-ын дагуу мян.төг
ХӨРӨНГӨ					
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	(а)	1,096,100,972		(287,248)	1,095,813,724
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	(б)	301,381,272		(447,563)	300,933,709
Санхүүгийн хөрөнгө оруулалт – борлуулахад бэлэн		782,475,730	(782,475,730)	–	–
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх санхүүгийн хөрөнгөрүү</i>	(в)		(97,023,096)		
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өрийн хэрэглүүр рүү</i>	(г)		(628,163,257)		
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өмчийн хэрэглүүр рүү</i>	(д)		(26,254,377)		
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх өмчийн хэрэглүүр рүү</i>	(е)		(31,035,000)		
Санхүүгийн хөрөнгө оруулалт - дуусгавар хугацаа хүртэл эзэмших		1,050,141,040	(1,050,141,040)	–	–
<i>Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүр рүү</i>	(ё)		(1,050,141,040)		
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх санхүүгийн хөрөнгө		–	97,023,096	–	97,023,096
<i>Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтаас</i>	(в)		97,023,096		
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өрийн хэрэглүүр		–	628,163,257	–	628,163,257
<i>Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтаас</i>	(г)		628,163,257		
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өмчийн хэрэглүүр		–	26,254,377	–	26,254,377
<i>Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтаас</i>	(д)		26,254,377		
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх өмчийн хэрэглүүр		–	31,035,000	–	31,035,000
<i>Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтаас</i>	(е)		31,035,000		
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүр		–	1,050,141,040	(1,152,420)	1,048,988,620
<i>Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтаас</i>	(ё)		1,050,141,040	(1,152,420)	
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр		494,861,756			494,861,756
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	(ж)	3,503,151,646		(34,541,745)	3,468,609,901
Бусад хөрөнгө	(з)	103,788,084		27,404,986	131,193,070
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		80,897,528			80,897,528
Үндсэн хөрөнгө		392,311,221			392,311,221
Ашиглах эрхтэй хөрөнгө		12,717,699			12,717,699
Биет бус хөрөнгө		5,870,617			5,870,617
НИЙТ ХӨРӨНГӨ		7,823,697,565	–	(9,023,990)	7,814,673,575
ӨР ТӨЛБӨР					
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж		189,383,778			189,383,778
Репо хэлцэл		65,013,356			65,013,356
Харилцагчдын харилцах, хадгаламж		3,821,434,134			3,821,434,134
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр		76,226,529			76,226,529
Зээлээр авсан санхүүжилт		759,290,707			759,290,707
Хоёрдогч өглөг		150,046,057			150,046,057
Гаргасан өрийн бичиг		1,536,488,710			1,536,488,710
Бусад өр төлбөр		508,520,501		3,791,297	512,311,798
Түрээсийн өр төлбөр		13,591,398			13,591,398
НИЙТ ӨР ТӨЛБӨР		7,119,995,170	–	3,791,297	7,123,786,467
БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД НОГДОХ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ					
Энгийн хувьцаа		50,000,707			50,000,707
Нэмж төлөгдсөн капитал		19,298,006			19,298,006
Бусад нөөц	(и)	151,476,785		27,083,011	178,559,796
Хуримтлагдсан ашиг	(и)	482,926,897		(39,898,298)	443,028,599
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		703,702,395	–	(12,815,287)	690,887,108
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		7,823,697,565	–	(9,023,990)	7,814,673,575

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

2.5 СТОУС-ын анхлан хэрэгжүүлэлт (үргэлжлэл)

Санхүүгийн байдлын тайлангийн тохируулга - 2020 оны 12 дугаар сарын 31-нээр (СТОУС-т шилжсэн өдөр):

	Тод.	СТОУС-д тулгуурлан Монголбанк-наас баталсан заавар, журмын дагуу мян.төг	Дахин ангилал мян.төг	Дахин хэмжилт мян.төг	СТОУС-ын дагуу мян.төг
ХӨРӨНГӨ					
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	(а)	856,968,353		(170,578)	856,797,775
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	(б)	570,008,607		(6,953)	570,001,654
Санхүүгийн хөрөнгө оруулалт – борлуулахад бэлэн		876,122,705	(876,122,705)		–
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх санхүүгийн хөрөнгөрүү</i>	(в)		(127,666,125)		
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өрийн хэрэглүүр рүү</i>	(г)		(714,034,384)		
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өмчийн хэрэглүүр рүү</i>	(д)		(34,422,196)		
Санхүүгийн хөрөнгө оруулалт - дуусгавар хугацаа хүртэл эзэмших		835,875,836	(835,875,836)	–	–
<i>Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүр рүү</i>	(ё)		(835,875,836)		
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх санхүүгийн хөрөнгө		–	127,666,125	–	127,666,125
<i>Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтаас</i>	(в)		127,666,125		
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өрийн хэрэглүүр		–	714,034,384	–	714,034,384
<i>Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтаас</i>	(г)		714,034,384		
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өмчийн хэрэглүүр		–	34,422,196	–	34,422,196
<i>Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтаас</i>	(д)		34,422,196		
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүр		–	835,875,836	(842,806)	835,033,030
<i>Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтаас</i>	(ё)		835,875,836	(842,806)	
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт		40,813,475			40,813,475
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр		89,371,192			89,371,192
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	(ж)	4,108,718,370		(83,591,122)	4,025,127,248
Бусад хөрөнгө	(з)	112,659,306		13,315,490	125,974,796
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		148,990,218			148,990,218
Борлуулах зориулалттай хөрөнгө		4,138,693			4,138,693
Үндсэн хөрөнгө		458,644,011			458,644,011
Ашиглах эрхтэй хөрөнгө		10,132,850			10,132,850
Биет бус хөрөнгө		4,374,414			4,374,414
НИЙТ ХӨРӨНГӨ		8,116,818,030	–	(71,295,969)	8,045,522,061
ӨР ТӨЛБӨР					
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж		102,946,144			102,946,144
Репо хэлцэл		224,287,616			224,287,616
Харилцагчдын харилцах, хадгаламж		5,311,418,183			5,311,418,183
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр		99,723,102			99,723,102
Зээлээр авсан санхүүжилт		558,736,354			558,736,354
Гаргасан өрийн бичиг		160,140,274			160,140,274
Бусад өр төлбөр		628,403,246		15,861,460	644,264,706
Түрээсийн өр төлбөр		11,384,522			11,384,522
Орлогын татварын өглөг		111,957			111,957
Хойшлогдсон татварын өр төлбөр		2,155,509			2,155,509
НИЙТ ӨР ТӨЛБӨР		7,099,306,907	–	15,861,460	7,115,168,367
БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД НОГДОХ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ					
Энгийн хувьцаа		72,723,171			72,723,171
Нэмж төлөгдсөн капитал		251,086,754			251,086,754
Бусад нөөц	(и)	193,056,881		27,324,754	220,381,635
Хуримтлагдсан ашиг	(и)	500,644,317		(114,482,183)	386,162,134
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		1,017,511,123	–	(87,157,429)	930,353,694
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		8,116,818,030	–	(71,295,969)	8,045,522,061

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

2.5 СТОУС-ын анхлан хэрэгжүүлэлт (үргэлжлэл)

Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн тохируулга - 2020 оны 12 дугаар сарын 31-нээр (СТОУС-т шилжсэн өдөр):

Тод.	СТОУС-д тулгуурлан Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу мян.төг	Дахин ангилал мян.төг	Дахин хэмжилт мян.төг	СТОУС-ын дагуу мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	707,870,414		4,709,031	712,579,445
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(506,145,302)			(506,145,302)
Хүүний цэвэр орлого	201,725,112	–	4,709,031	206,434,143
Шимтгэл, хураамжийн орлого	54,072,967			54,072,967
Шимтгэл, хураамжийн зардал	(14,708,811)			(14,708,811)
Шимтгэл, хураамжийн цэвэр орлого	39,364,156	–	–	39,364,156
Арилжааны цэвэр орлого/(зардал)	–			–
Үйл ажиллагааны бусад орлого	(5,672,447)		(15,403,295)	(21,075,742)
Үйл ажиллагааны орлого	235,416,821	–	(10,694,264)	224,722,557
Хүлээгдэж буй үнэ цэнийн бууралтын алдагдалын буцаалт/(зардал)	(64,675,317)		(71,439,966)	(136,115,283)
Үйл ажиллагааны цэвэр орлого	170,741,504	–	(82,134,230)	88,607,274
Үйл ажиллагааны зардал	(131,602,195)			(131,602,195)
Хараат компанийн алдагдлын хувь	(14,501,873)			(14,501,873)
Татварын өмнөх ашиг/(алдагдал)	24,637,436	–	(82,134,230)	(57,496,794)
Орлогын албан татварын зардал	(3,660,409)		364,144	(3,296,265)
Тайлант жилийн ашиг/(алдагдал)	20,977,027	–	(81,770,086)	(60,793,059)
Бусад дэлгэрэнгүй орлого/(зардал) (татварын дараах):				
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдах бусад дэлгэрэнгүй орлого – (татварын дараах)</i>				
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн цэвэр өөрчлөлт	(1,424,125)	1,424,125	–	–
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдах бусад дэлгэрэнгүй орлого – (татварын дараах)</i>				
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өрийн хэрэглүүрийн дахин үнэлгээний өөрчлөлт	(н)	295,801	(36,016)	259,785
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого – (татварын дараах):</i>				
Бодит үнэ цэнийн өөрчлөлийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өмчийн хэрэглүүрийн дахин үнэлгээний өөрчлөлт	(н)	(1,719,926)	3,794,546	2,074,620
Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал)	(1,424,125)	–	3,758,530	2,334,405
Тайлант жилийн татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого/(алдагдал)	19,552,902	–	(78,011,556)	(58,458,654)

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

2.5 СТОУС-ын анхлан хэрэгжүүлэлт (үргэлжлэл)

2020 оны 1 дүгээр сарын 1 болон 2020 оны 12 дугаар сарын 31-нээр Санхүүгийн байдлын тайлан, 2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн тохируулгуудын тайлбар:

(а) Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгөнд Монголбанкны шаардлагын дагуу байршуулсан зайлшгүй байлгах нөөцийн дүн багтдаг. Тус харилцах дансны дундаж үлдэгдлийг Монголбанк тодорхойлдог бөгөөд Банк өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах боломжгүй байдаг. Зайлшгүй байлгах нөөцийн ЗҮЦХА-ын хэмжээг дансны үлдэгдлээс тооцсон.

(б) Бусад банканд байршуулсан хөрөнгөд бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан төгрөгийн болон бусад валютын харилцах дансууд багтдаг. Эдгээр хөрөнгийн ЗҮЦХА-г дансны үлдэгдлээс тооцсон.

(в) Банк нь энгийн ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)-ын төлбөр нь ҮТХТ шалгуурыг хангаагүй тул бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилсан. Банк нь давуу эрхтэй ипотекийн зээлээр баталгаажсан баталгаажсан үнэт цаасыг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг ба алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилсан.

(г) СТОУС 9-ын дагуу бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэдэг өрийн хэрэглүүрд өмнө нь Монголбанкнаас тохируулсан СТОУС-ын дагуу борлуулахад бэлэн ангилалд байсан хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй Монголбанкны үнэт цаасууд, засгийн газрын бонд, үнэт цаасууд болон хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй засгийн газрын бонд болон МИК бонд багтана. Банкны 2020 оны 1-р сарын 1-ний өдрөөр үнэлгээн дээр үндэслэн, эдгээр санхүүгийн хэрэглүүр нь гэрээний төлбөрүүдийг цуглуулах болон санхүүгийн хөрөнгийг борлуулах бизнесийн загварт хамаардаг гэж үзсэн тул СТОУС 9-ийн дагуу бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр гэж ангилсан.

(д) Банк нь хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй болон бүртгэлгүй борлуулахад бэлэн өмчийн хэрэглүүрийг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх хөрөнгө оруулалт болгон өөрчлөхөөр сонгосон.

(е) Банк нь МИК Холдинг ХК-д оруулсан хөрөнгө оруулалтыг өмнө нь борлуулахад бэлэн гэж ангилсан. 2020 оны 1 сарын 1-нээр, СТОУС 9-н дагуу бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэглүүр болгон ангилсан. Нэгдлийн үр дүнд Банк нь МИК-д томоохон нөлөө үзүүлэх болсны дагуу уг хөрөнгө оруулалтыг хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтаар бүртгэсэн бөгөөд холбогдох хуримтлагдсан бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрсөн.

(ё) Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэглүүр өмнө нь дуусгавар хугацаа хүртэл эзэмших ангилалд байсан хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй Хөгжлийн Банкны бонд орсон. Энэхүү бондыг Банк нь гэрээнд заасан мөнгөн төлбөрийг цуглуулан авах зорилгоор эзэмшдэг бөгөөд гэрээний нөхцөл нь тодорхой заасан өдрүүдэд үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрөөс бүрдсэн мөнгөн гүйлгээг бий болгодог.

(ж) Харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа-д МИК-д зарахаар төлөвлөж буй төслийн ипотекийн зээлийн багц багтдаг. Банкны зорилго нь тогтсон схемийн дагуу МИК-т эдгээр зээлийн багцыг шилжүүлж, оронд нь ИЗББ авах юм. Тиймээс СТОУС 9-ыг анх хэрэгжүүлсэн өдрөөр бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх хөрөнгөрүү ангилсан.

(з) Бусад хөрөнгөд Банкны өмнөх нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу байгуулсан өмчлөх бусад хөрөнгийн сан багтсан. СТОУС 9-н дагуу тус санг дахин үнэлж буцаах бичилт хийсэн. Түүнээс гадна, бусад хөрөнгөд гуравдагч талаас авах авлагууд багтсан ба СТОУС 9-н дагуу зээлийн үнэ цэнийн бууралтыг үнэлж тохируулсан.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

2.5 СТОУС-ын анхлан хэрэгжүүлэлт (үргэлжлэл)

(и) СТОУС -н шилжилтээс хуримтлагдсан ашиг болон нөөцүүдэд нөлөөлсөн нөлөөг доорх хүснэгтээс харна уу:

	Үлдэгдэл мян.төг
2020 оны 1 сарын 1-нээр	
Бусад нөөц	
СТОУС-д тулгуурлан Монголбанк-наас баталсан заавар, журмын дагуу	151,476,785
Борлуулахад бэлэн үнэт цааснаас бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдлын тайланд бүртгэх өмчийн үнэт цаасруу дахин ангилал	(517,250)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн СТОУС 9-н дагуу ЗҮЦХА хүлээн зөвшөөрөлт	195,276
Тусгай зориулалттай нөөцийн бүртгэл	27,404,985
Бусад нөөцөд үзүүлэх цэвэр нөлөө	27,083,011
СТОУС-н дагуу	178,559,796

Хуримтлагдсан ашиг

СТОУС-д тулгуурлан Монголбанк-наас баталсан заавар, журмын дагуу	482,926,897
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүрээс бусад санхүүгийн хэрэглүүрийн СТОУС 9-н дагуу ЗҮЦХА хүлээн зөвшөөрөлт	(1,887,231)
Тэнцлийн гадуур бүртгэгдсэн хүүгийн орлогын хүлээн зөвшөөрөлт	4,001,766
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн СТОУС 9-н дагуу ЗҮЦХА хүлээн зөвшөөрөлт	(195,276)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны СТОУС 9-н дагуу үнэ цэнийн бууралтын хүлээн зөвшөөрөлт	(38,543,510)
Тэнцлийн гадуурх зээлийн үүргийн СТОУС 9-н дагуу ЗҮЦХА хүлээн зөвшөөрөлт	(3,791,297)
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт, СТОУС 9-н дагуу	27,404,985
Тусгай зориулалттай нөөцийн бүртгэл	(27,404,985)
Борлуулахад бэлэн үнэт цааснаас бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдлын тайланд бүртгэх өмчийн үнэт цаасруу дахин ангилал	517,250
Хуримтлагдсан ашигт үзүүлэх цэвэр нөлөө	(39,898,298)
СТОУС-н дагуу	443,028,599

	Үлдэгдэл мян.төг
--	---------------------

2020 оны 12 сарын 31-нээр

Бусад нөөц

СТОУС-д тулгуурлан Монголбанк-наас баталсан заавар, журмын дагуу	193,056,881
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгийн СТОУС 9-н дагуу ЗҮЦХА хүлээн зөвшөөрөлт	159,260
Тусгай зориулалттай нөөцийн бүртгэл	27,165,494
Бусад нөөцөд үзүүлэх цэвэр нөлөө	27,324,754
СТОУС-н дагуу	220,381,635

Хуримтлагдсан ашиг

СТОУС-д тулгуурлан Монголбанк-наас баталсан заавар, журмын дагуу	500,644,317
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүрээс бусад санхүүгийн хэрэглүүрийн СТОУС 9-н дагуу ЗҮЦХА хүлээн зөвшөөрөлт	(1,020,337)
Тэнцлийн гадуур бүртгэгдсэн хүүгийн орлогын хүлээн зөвшөөрөлт	8,710,797
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн СТОУС 9-н дагуу ЗҮЦХА хүлээн зөвшөөрөлт	(159,260)
Бусад хөрөнгийн СТОУС 9-н дагуу ЗҮЦХА хүлээн зөвшөөрөлт	(13,850,005)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны СТОУС 9-н дагуу үнэ цэнийн бууралтын хүлээн зөвшөөрөлт	(92,301,918)
Тэнцлийн гадуурх зээлийн үүргийн СТОУС 9-н дагуу ЗҮЦХА хүлээн зөвшөөрөлт	(15,861,460)
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт, СТОУС 9-н дагуу	7,337,693
Тусгай зориулалттай нөөцийн бүртгэл	(7,337,693)
Хуримтлагдсан ашигт үзүүлэх цэвэр нөлөө	(114,482,183)
СТОУС-н дагуу	386,162,134

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

3. Улаанбаатар Хотын Банк ХХК-тай нэгдэл

2020 оны 6 сарын 8-ны өдрийн УБХБ-ны хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр тус банкны үйл ажиллагааг бүрэн зогсоож, УБХБ-ыг татан буулгаж ХХБ-тай нэгтгэх шийдвэр гаргасан. УБХБ нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг, хязгаарлагдмал хариуцлагатай компани байсан ба 2020 оны 6 сарын 26-ны байдлаар нийт 15 салбар, 400 гаруй ажилтантай арилжааны банкны үйл ажиллагаа эрхэлж байсан.

Банкууд нь нэг эцсийн өмчлөгчтэй байсан тул удирдлагын зүгээс 2020 оны 6 сарын 26-ны өдрөөр уг нэгдлийг нийтлэг хяналт доорх бизнесийн нэгдэл гэж тодорхойлсон. Тиймээс энэхүү нэгдэл нь СТОУС 3 *Бизнесийн нэгдэл* стандартын хүрэнээс гарсан ба нэгдсэн компаниудын тайланг нэгтгэх аргыг ирээдүйд мөрдөх журмыг ашиглан бүртгэлийг хийсэн. Банкуудын санхүүгийн тайлангууд нь ижил нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу бэлтгэгддэг байсан.

Нэгдлийн өдрөөрх УБХБ-ны хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнийг дор толилуулав:

	2020 оны 6 сарын 26 мян.төг
ХӨРӨНГӨ	
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө*	7,705,567
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	106,323,028
Санхүүгийн хөрөнгө оруулалт	30,443,201
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	27,670,448
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	862,934,618
Бусад хөрөнгө	52,438,318
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	5,631,893
Үндсэн хөрөнгө	78,026,336
Ашиглах эрхтэй хөрөнгө	1,085,892
Биет бус хөрөнгө	889,144
НИЙТ ХӨРӨНГӨ	1,173,148,445

ӨР ТӨЛБӨР

Харилцагчдын харилцах, хадгаламж	808,568,971
Репө хэлцэл	8,426,638
Бусад банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	17,897,612
Зээлээр авсан санхүүжилт	37,733,505
Бусад өр төлбөр	149,862,479
Түрээсийн өглөг	970,544
Хойшлогдсон татварын өр төлбөр	1,763,700
НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,025,223,449

ЦЭВЭР ХӨРӨНГӨ

*Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнд толилуулсан нэгдлийн үр дүнд шилжиж ирсэн мөнгө ба түүнтэй адилгах хөрөнгийг илэрхийлнэ.

2020 оны 6 сарын 26-ны өдрөөр УБХБ-ны бүх хөрөнгө, өр төлбөр, нөөц болон салбарууд нь Банктай нэгтгэгдсэн ба нэг бүр нь 15,128 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 659,282 ширхэг энгийн хувьцааг гаргасан. УБХБ-ны барилга ба газрын дахин үнэлгээний нөөц болох 39,744,614 мян.төг болон Тусгай зориулалтын нөөц болох 3,669,414 мян.төг-ийг Банкны хөрөнгийн дахин үнэлгээний болон Тусгай зориулалтын нөөцүүдрүү шилжүүлэн бүртгэсэн ба цэвэр хөрөнгөөс үлдэж буй 94,537,126 мян.төг-ийг нэмж төлөгдсөн капитал дансанд хүлээн зөвшөөрсөн (Тодруулга 31-г харна уу).

Хэрэв нэгдэл 2020 оны эхэнд хийгдсэн бол банкны хүү ба түүнтэй адилтгах орлого 773,490,083 мян.төг харин татварын өмнөх ашиг 63,883,801 мян.төг байх байсан.

4. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол болон төсөөллүүд

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх ажил нь санхүүгийн тайлангийн өдрийн байдлаар орлого, зардал, хөрөнгө ба өр төлбөр дээр үнэлэмж, ойролцоолсон тооцоолол, төсөөлөл хийх ба тэдгээрийн дагалдах тодруулгууд болон болзошгүй өр төлбөр тодруулга зэргийг хамардаг ба эдгээр нь зарим тохиолдолд удирдлагаас гаргасан үнэлэмж, тооцоолол болон төсөөлөл дээр үндэслэдэг. Эдгээр төсөөлөл болон тооцооллын үр дүн нь ирээдүйн тайлант жилүүдэд хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнэд материаллаг залруулгууд хийх шаардлага буюу тодорхойгүй байдал үүсгэж болдог. Банк нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх явцдаа дараагийн тайлант жилүүд дэх хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнэд материаллаг залруулга үүсгэж болзошгүй тодорхой эрсдэл бүхий дараах гол тооцооллууд болон ирээдүйн төсөөлөл, үнэлэмжүүдийг ашигласан.

Банк хянах боломжгүй бусад хүчин зүйлүүд ирээдүйд үүссэнээс шалтгаалан банкны одоогийн тодорхойлсон байгаа ирээдүйн төсөөлөл болон нөхцөл байдлыг өөрчлөхөд хүргэж болзошгүй. Санхүүгийн байдлын тайланд орсон мэдэгдэхүйц нөлөөтэй зүйлсийг тэдгээрт ашигласан удирдлагын үнэлэмж ба/эсвэл тооцооллууд нь хоорондоо хэрхэн нийцэж байгааг доор тусгав.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Бүх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцоход Банкны удирдлагын үнэлэмж шаардагддаг. Ялангуяа ирээдүйн мөнгөн урсгалын дүн болон хугацаа, барьцаа хөрөнгийн үнэлгээг тодорхойлох шаардлагатай байдаг. Эдгээр тооцоолол нь хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалан өөрчлөгдөх бөгөөд эдгээрийн өөрчлөлт нь өөр өөр түвшний үнэ цэнийн бууралтын сан байгуулахад хүргэдэг.

Банкны зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын (ЗҮЦХА) тооцоолол нь хувьсах өгөгдөл болон тэдгээрийн харилцан хамаарлыг сонгоход ашигласан олон төсөөллүүдээс бүрдсэн цогц загварын үр дүн юм. ЗҮЦХА загварын элементүүд нь доорх нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж болон тооцооллыг шингээсэн байна:

- Тус тусын үнэлгээ бүрт ашиглах чанаргүйдлийн магадлалыг (ЧМ) тодорхойлдог Банкны зээлийн дотоод үнэлгээний загвар
- Банкны санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр ихэссэн байна гэж үнэлэх шалгуур үзүүлэлтүүд болон санхүүгийн хөрөнгүүдийн нөөц санг нийт хугацааны ЗҮЦХА болон чанарын үнэлгээ ашиглан тооцно
- ЗҮЦХА нь бүлгийн үнэлгээгээр тооцоологддог бол санхүүгийн хөрөнгийн сегментчилэл
- Өгөгдлүүдийн сонголт болон томъёонуудыг ашиглан ЗҮЦХА загварын хөгжүүлэлт
- Макро эдийн засгийн өгөгдлүүдийн харилцан холбоо хамаарлыг тодорхойлох болон эдгээрийн чанаргүйдлийн магадлал (ЧМ), чанаргүйдэлд өртөх дүн (ЧӨД), алдагдалд хүргэх чанаргүйдэлд (АХЧ) үзүүлэх нөлөө зэрэг
- ЗҮЦХА загварт ирээдүйг чиглэсэн макро эдийн засгийн хувилбаруудаас сонгох, тэдгээрийн жигнэсэн дундаж магадлалыг тодорхойлох, эдийн засгийн өгөгдлүүдийг гаргах

Банк нь бодит алдагдал хүлээсэн дүн дээрээ үндэслэн өөрийн загварыг жил бүр үнэлэж, шаардлагатай бол залруулж байх журамтай.

Ковид-19-ийн үнэ цэнийн бууралтын санд үзүүлэх нөлөө. Ковид-19 ба Банкны цаашдын эдийн засгийн хүлээлтийн хувьд Банк ЗҮЦХА-ын тооцоонд ашигласан эдийн засгийн нөлөөллүүд болон таамаглалуудыг шинэчлэн боловсруулсан болно. Бүлгийн үнэлгээн дээр нөөцийн тооцоог хийхдээ эдийн засгийн хувилбар, макро эдийн засгийн таамаглалыг үнэлсэн. Ковид-19 цар тахлын эсрэг зээлийн загвар, таамаглал, түүний дотор макро эдийн засгийн таамаглалуудыг шинэчлэн боловсруулсан бөгөөд үүнээс харахад Банкны ЗҮЦХА-н тооцоог үндэслэсэн зээлийн үндсэн загвар, арга зүй нь өмнөх онтой нийцсэн хэвээр байна.

Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн байдлын тайланд бүртгэгдсэн санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хэмжилтийн өдрөөрх идэвхтэй зах зээл дээрх үнээр хэмжиж чадахгүй бол бодит үнэ цэнийг дискаунтлагдсан мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн үнэлгээний аргыг ашиглан хэмжиж болно. Энэхүү үнэлгээний загварт ашигласан орцуудыг ажиглаж болохуйц идэвхтэй зах зээлийн мэдээллээс олж авсан ба тэдгээр нь нийцтэй биш тохиолдолд бодит үнэ цэнийг тодорхойлоходоо тодорхой түвшний үнэлэмжийг авч ашигласан. Ашигласан төсөөллүүдийн өөрчлөлтүүд нь тайлагнасан санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнэд нөлөөлж болно. Дэлгэрэнгүй толилуулгыг Тодруулга 35-аас харна уу.

4. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол болон төсөөллүүд (үргэлжлэл)**Хөрөнгийн дахин үнэлгээ**

Банк хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг (ХОЗҮХХ) бодит үнэ цэнээр бүртгэж бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг. Түүнээс гадна, Банк газар болон барилга байгууламжийг дахин үнэлэгдсэн дүнгээр хэмждэг бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрдөг. ХОЗҮХХ, газар болон барилга байгууламжийн бодит үнэ цэнэ нь итгэмжлэгдсэн хараат бус үнэлгээчний хийсэн үнэлгээнд үндэслэдэг. Хөрөнгүүдийг шаардлагатай тохируулга (хөрөнгийн шинж чанар, байршил, барилгын элэгдэл гэх зэрэг хүчин зүйлсийг харгалзан) хийсэн ижил төстэй барилгын үнэ болон орлогын хандлагын аргыг ашиглан зах зээлд суурилан үнэлсэн. 2021 оны 12 сарын 31-ний байдлаар ХОЗҮХХ болон газар, барилга байгууламжийн бодит үнэ цэнэ нь хараат бус мэргэшсэн үнэлгээчдийн үнэлгээн дээр үндэслэсэн байна.

Энэхүү үнэлгээ нь Тодруулга 35-д дурдсаны дагуу удирдлага болон үнэлгээчний хөрөнгийн үнэлэмжийг шаарддаг.

20%-с доош саналын эрх эзэмшдэг аж ахуйн нэгжид Банкны мэдэгдэхүйц нөлөөллийн тодорхойлолт

Хэдийгээр саналын эрхийн 20%-с доош хувийг эзэмшдэг ч Банк нь МИК-д мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг гэж үзэж байна. Учир нь МИК-ийн дийлэнх хувьцаа эзэмшигчид 10%-с доош хувийг эзэмшдэг бол Банк нь 10%-г эзэмшдэг (бодитоор 13.58%) ба МИК-ийн томоохон хувьцаа эзэмшигчдийн нэг юм. Мөн, Банкны холбоотой этгээдүүдийн хувьцаа эзэмшил нь ойролцоогоор 21.82% (бодитоор 29.63%) ба МИК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн нийт 5-н гишүүний 2 нь Банкны хувьцаа эзэмшигчдээс томилогдож, Банк болон түүний холбоотой этгээдүүдийг төлөөлж байна. Иймд Банкны саналын нөлөө нь холбоотой этгээдүүдийн хамтаар МИК-ийн бусад хувьцаа эзэмшигчдээс хамгийн их байна. Түүнчлэн, Банк нь жил бүр тогтмол МИК-тэй томоохон гүйлгээнүүдийг хийдэг. Хэдийгээр эдгээр гүйлгээнүүд нь бизнесийн ердийн үйл ажиллагааны хүрээнд хийгддэг боловч хэмжээ болон үнийн дүнгийн хувьд материаллаг юм.

5. Хүү болон түүнтэй адилтгах орлого

	2021	2020
	мян.төг	мян.төг
<i>Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого</i>		
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	379,891,417	503,112,704
Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэглүүр	105,874,414	138,280,327
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өрийн хэрэглүүр	76,877,070	34,872,783
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	5,018,183	10,054,972
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	2,346,939	7,366,110
Урвуу репо хэлцэл	778,428	244,414
	570,786,451	693,931,310

Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө	14,754,616	12,171,094
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	11,566,398	6,477,041
	26,321,014	18,648,135

2021 онд бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өрийн хэрэглүүрээс хүүгийн орлогод 105,874,414 мян.төг, хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн хэрэглүүрээс хүүгийн орлогод 1,097,905 мян.төг (2020 онд: тус тус 138,280,327 мян.төг ба 391,969 мян.төг)-ийн татвараас чөлөөлөгдөх Засгийн газрын үнэт цаасны хүүгийн орлого багтсан.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

6. Хүү болон түүнтэй адилтгах зардал

	2021 мян.төг	2020 мян.төг
Харилцагчдын харилцах, хадгаламж	257,645,983	263,072,945
Зээлээр авсан санхүүжилт	116,374,067	119,439,476
Репоз хэлцэл	15,057,398	7,010,255
Гаргасан өрийн бичиг	12,800,000	70,089,966
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	2,539,483	24,044,755
Түрээсийн өглөг (Тодруулга 23)	1,219,631	1,821,379
Хоёрдогч өглөг	–	20,666,526
	405,636,562	506,145,302

7. Шимтгэл, хураамжийн цэвэр орлого

	2021 мян.төг	2020 мян.төг
<i>Санхүүгийн үйлчилгээ үзүүлсэн даруй хүлээн зөвшөөрсөн хураамж, шимтгэлийн орлого:</i>		
Картын үйлчилгээ	26,654,212	20,479,309
Гуйвуулгын үйлчилгээ	13,229,064	10,248,276
Санхүүгийн баталгаа	9,222,144	9,257,769
Зээлийн үйлчилгээ	7,455,936	6,776,996
Гар утас болон цахим банкны үйлчилгээ	4,596,024	3,435,793
Бусад	2,345,760	2,206,656
	63,503,140	52,404,799

Үйлчилгээ үзүүлсэн хугацааны туршид хүлээн зөвшөөрсөн хураамж, шимтгэлийн орлого

Картын үйлчилгээ	1,733,855	1,668,168
	1,733,855	1,668,168

Шимтгэл, хураамжийн зардал

Картын үйлчилгээний шимтгэл	16,719,066	11,667,136
Бусад	4,081,789	3,041,675
	20,800,855	14,708,811

Шимтгэл, хураамжийн цэвэр орлого

	44,436,140	39,364,156
--	-------------------	-------------------

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

8. Арилжааны болон үйл ажиллагааны бусад орлого/(зардал)

	2021 мян.төг	2020 мян.төг
Ханшийн тэгшитгэлийн цэвэр олз/(гарз)	19,776,375	(17,510,013)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэрэгжээгүй олз/(гарз)	21,067,389	(6,983,603)
Үндсэн хөрөнгө борлуулсны цэвэр олз	10,997,768	169,780
ХОЗҮХХ борлуулсны цэвэр олз	6,063,066	–
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт хэсэгчлэн борлуулсны цэвэр олз (Тодруулга 16)	5,434,794	–
Үнэт металлын арилжааны цэвэр олз (цэвэр)	1,253,189	1,657,337
ХОЗҮХХ-ийн үнэлгээний олз (Тодруулга 20)	433,617	20,122,404
Өмчлөх бусад хөрөнгө борлуулсны цэвэр олз/(гарз)	204,152	(365,423)
Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралт (Тодруулга 19)	(27,650,688)	–
Бусад авлагын бүтцийн өөрчлөлтөөс үүссэн гарз (Тодруулга 19)	(17,805,897)	–
Своп хэлцлийн хүүгийн цэвэр зардал	(15,381,806)	(5,072,115)
Өмчийн хөрөнгө оруулалтын анхны хүлээн зөвшөөрөлтийн гарз (Тодруулга 15)	(14,508,803)	–
Орон сууцны зээлийн бүтцийн өөрчлөлтөөс үүссэн цэвэр гарз (Тодруулга 18)	(6,754,302)	(5,592,847)
Өмчлөх бусад хөрөнгийн данснаас хасалт	(2,123,116)	(11,246,598)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний гарз (Тодруулга 22)	(1,745,195)	–
Борлуулах зорилготой хөрөнгө борлуулсны цэвэр ашиг/(алдагдал)	3,391,791	3,022,069
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх санхүүгийн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн ашиг/(алдагдал)	(509,109)	3,585,857
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтаас хүлээн зөвшөөрсөн олз (Тодруулга 16)	–	768,590
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдлын тайланд бүртгэх өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	–	(4,158,690)
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдлын тайланд бүртгэх санхүүгийн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн ашиг/(алдагдал)	–	(41,282)
Бусад	4,451,177	568,792
	(13,405,598)	(21,075,742)

9. Хүлээгдэж буй үнэ цэнийн бууралтын алдагдлын (буцаалт)/зардал

	2021 мян.төг	2020 мян.төг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (Тодруулга 18)	(65,509,851)	97,675,718
Бусад хөрөнгө (Тодруулга 19)	17,082,876	28,362,498
Тэнцлийн гадуурх зээлийн үүрэг (Тодруулга 33)	(9,248,189)	11,417,985
Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэглүүр (Тодруулга 15)	(385,577)	(309,614)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өрийн хэрэглүүр (Тодруулга 15)	331,301	(36,016)
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (Тодруулга 14)	(1,805)	(878,618)
Монголбанкинд байршуулсан мөнгө (Тодруулга 13)	25,696	(116,670)
	(57,705,549)	136,115,283

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

10. Үйл ажиллагааны зардал

	2021 мян.төг	2020 мян.төг
Ажилтнуудын цалин, хөлс ба урамшуулал	56,426,251	53,374,168
Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тодруулга 22)	13,653,950	12,977,972
Зар сурталчилгаа, олон нийтийн харилцаа	8,914,953	6,558,443
Бусад	9,503,140	6,018,642
Даатгал	7,806,738	6,841,023
Мэргэжлийн үйлчилгээ	5,885,907	21,910,928
Мэдээллийн технологийн ашиглалт	5,498,594	5,048,774
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл (Тодруулга 23)	5,128,494	4,865,339
Техникийн туслалцаа ба гадаадын банкны гуйвуулгын хураамж	4,774,133	3,181,143
Засвар, үйлчилгээ	2,845,457	915,499
Харилцаа холбооны үйлчилгээ	2,637,928	2,316,802
Биет бус хөрөнгийн хорогдуулалт (Тодруулга 24)	2,373,456	2,421,188
Бичиг хэрэг, хангамжийн хэрэгсэл	2,008,763	1,533,807
Ашиглалтын зардал	1,041,039	1,039,742
Тээвэр	568,269	356,782
Бэлэн мөнгөний зохицуулалт	567,943	392,553
Түрээс	347,218	408,258
Хүлээн авалт, үзвэр үйлчилгээ	258,830	478,578
Харуул хамгаалалт	236,587	145,750
Сургалт	182,003	139,846
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз (Тодруулга 22)	154,371	34,119
Томилолт	124,539	296,763
Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз (Тодруулга 24)	–	346,076
	130,938,563	131,602,195

11. Орлогын албан татвар

11.1 Орлогын албан татварын зардал

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх орлогын албан татварын зардал:

	2021 мян.төг	2020 мян.төг
Орлогын албан татвар:		
Тайлант үеийн орлогын албан татварын зардал	14,601,281	1,101,888
Өмнөх тайлант үеийн дутуу бүртгэсэн орлогын албан татварын зардал	–	4,480,130
Хойшлуулсан татвар:		
Татварын түр зөрүү (Тодруулга 11.3)	1,127,785	(2,285,753)
	15,729,066	3,296,265

Банк нь санхүүгийн тайланд орлогын дүнг орлогын албан татварын хуульд заасан чөлөөлөгдөх эсвэл үл чөлөөлөгдөх зүйлүүдээр залруулсан дүнг үндэслэн орлогын албан татварын зардлыг тооцдог. Банк нь Монгол Улсын татварын хууль тогтоомжын дагуу 6 тэрбум (2020 онд: 6 тэрбум) төгрөг хүртэлх татвар ногдох орлогоос 10% (2020 онд: 10%), 6 тэрбум (2020 онд: 6 тэрбум)-аас илүү гарсан дүнгээс 25% (2020 онд: 25%) орлогын албан татвар төлдөг. Засгийн Газрын бондын хүүгийн орлого нь хуулийн дагуу татвар ногдохгүй орлого болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

11. Орлогын албан татвар (үргэлжлэл)

11.1 Орлогын албан татварын зардал (үргэлжлэл)

Банк нь татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг Банкинд хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардалд 2021 оны 12 дугаар сарын 31-нээр хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв. Үүнд:

	2021 мян.төг	2020 мян.төг
Татварын өмнөх ашиг/(алдагдал)	120,539,499	(57,496,794)
Татварын хувь хэмжээ болох 25%-иар тооцсон орлогын татварын зардал (2020 онд: 25%)	30,134,875	(14,374,199)
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын нөлөө	19,567,730	32,995,909
Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгө	–	5,045,710
Тусгай хувь хэмжээгээр татвар ногдох орлогын нөлөө	2,166,083	1,067,568
Татварын хувь хэмжээний зөрүү	(1,578,177)	10,351,153
Татвар ногдохгүй орлогын нөлөө	(7,728,804)	(1,601,932)
Татвараас чөлөөлөгдөх орлогын нөлөө	(26,743,079)	(34,668,073)
Татварын хөнгөлөлтийн нөлөө	(89,562)	–
Өмнөх тайлант үеийн дутуу бүртгэсэн орлогын албан татварын зардал	–	4,480,129
Тайлант жилийн татварын зардал	15,729,066	3,296,265

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Банк нь ирэх 4 жилийн хугацаанд татвар ногдох орлогоос хасч тооцох татварын алдагдал байхгүй (2020 онд: 56,554,692 мян.төг) байна. Албан татвар ногдуулах орлогоос жил бүр хасагдах алдагдлын хэмжээ нь 50%-аас хэтрэхгүй байна.

Банк нь татварын алдагдлаас үүссэн хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд учир нь дараагийн 4 жилд татварын алдагдлыг шилжүүлэн ашиглаж болох хангалттай татвар ногдох ашиг олох нь тодорхойгүй байна.

2021 оны орлогын албан татварын хувь хэмжээ нь 13.05% (2020 онд: 0%).

11.2 Орлогын албан татварын өглөг

	2021 мян.төг	2020 мян.төг
1 сарын 1-ээр	111,957	–
Тайлант жилийн орлогын албан татварын зардал	14,601,281	5,582,018
Бусад суутгуулсан	(2,213,239)	–
Төлсөн татвар	–	(5,470,061)
12 сарын 31-ээр	12,499,999	111,957

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

11. Орлогын албан татвар (үргэлжлэл)

11.3 Хойшлуулсан татварын өр төлбөр

2021 оны 12 сарын 31-нээр	2021 оны 1 сарын 1-нээр мян.төг	Бусад	Ашиг,	Нийт
		дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн мян.төг	алдагдлын тайланд хүлээн зөвшөөрсөн мян.төг	
Хойшлуулсан татварын (хөрөнгө)/өр төлбөр				
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх санхүүгийн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээ	2,677,562	(2,247,950)	–	429,612
Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн дахин үнэлгээ	(548,280)	–	2,106,738	1,558,458
Хараат компанийн ашгийн хувь	(20,645)	–	(978,953)	(999,598)
Түрээсийн өглөг ба Ашиглах эрхтэй хөрөнгө	46,872	–	–	46,872
	2,155,509	(2,247,950)	1,127,785	1,035,344

2020 оны 12 сарын 31-нээр	2020 оны 1 сарын 1-нээр мян.төг	Бусад	Ашиг,	УБХБ-аас	Нийт
		дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн мян.төг	алдагдлын тайланд хүлээн зөвшөөрсөн мян.төг	шилжиж ирсэн мян.төг	
Хойшлуулсан татварын (хөрөнгө)/өр төлбөр					
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх санхүүгийн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээ	–	2,677,562	–	–	2,677,562
Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн дахин үнэлгээ	–	–	(548,280)	–	(548,280)
Хараат компанийн ашгийн хувь	–	–	(1,737,473)	1,716,828	(20,645)
Түрээсийн өглөг ба Ашиглах эрхтэй хөрөнгө	–	–	–	46,872	46,872
	–	2,677,562	(2,285,753)	1,763,700	2,155,509

12. Нэгж хувьцаанд ногдох ашиг

Доорх хүснэгтээр нэгж хувьцааны үндсэн болон хорогдуулсан ашгийн тооцоололд ашигласан орлого болон хувьцааны мэдээллийг үзүүлэв:

	2021 мян.төг	2020 мян.төг
Энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдох ашиг/(алдагдал) – үндсэн болон хорогдуулсан	104,810,433	(60,793,059)
Нэгж хувьцааны үндсэн болон хорогдуулсан ашгийн тооцоололд хэрэглэгдэх энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо	4,807,082	3,674,250

Нэгж хувьцаанд ногдох ашиг

Тухайн тайлангийн хугацаанд Банкны хувьцаа эзэмшигчдийн:

	2021 мян.төг	2020 мян.төг
Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг	21,803	(16,546)
Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг	21,803	(16,546)

Нэгж хувьцаанд ногдох ашгийг тухайн жилийн цэвэр ашгийг тухайн жилд хувьцааг хувааж жижгэрүүлсэн болон хувьцаагаарх ногдол ашгийг тохируулснаар (Тодруулга 31) тодорхойлсон эргэлтэнд байгаа энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд хуваан тооцоолсон.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

13. Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө

	2021 мян.төг	2020 мян.төг
Бэлэн мөнгө	86,908,373	67,040,947
Монголбанк дахь харилцах	889,640,138	789,927,406
Дансны үнэ	976,548,511	856,968,353
Хасах: Монголбанкинд байршуулсан мөнгөний үнэ цэнийн бууралтын сан	(196,274)	(170,578)
Цэвэр дансны үнэ	976,352,237	856,797,775

Монголбанкнаас тавигддаг шаардлагын дагуу Монголбанкинд харилцан данс байршуулдаг. Монголбанкинд байршуулах бэлэн мөнгөний заавал байлгах нөөцийн үлдэгдэл нь хоёр долоо хоногийн туршид харилцагчдын харилцах, хадгаламжын дундаж үлдэгдлийн төгрөгийн 6.0% ба гадаад валютын 18.0% (2020 онд: 6.0% ба 15.0%)-иас тус тус багагүй байдаг. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны заавал байлгах шаардлагатай 14 хоногийн дундаж нөөцийн хэмжээ төгрөгөөр 204,051,735 мян.төг (2020 онд: 168,376,157 мян.төг) ба гадаад валютаар 513,533,692 мян.төг (2020 онд: 425,158,583 мян.төг) байсан.

Монголбанкинд байршуулсан мөнгөний үнэ цэнийн бууралтын сан

Доорх хүснэгтэд жилийн эцсийн ангилал болон Банкны дотоод зээлийн үнэлгээний систем дээр үндэслэсэн бэлэн мөнгө ороогүйгээр зээлийн чанар, зээлийн эрсдэлийн хамгийн их хэмжээг харуулав. Доор харуулсан дүнгүүд үнэ цэнийн бууралтын дүнг оруулаагүй дүнгээр илэрхийлэгдсэн. Банк уг хөрөнгийг В- үнэлгээгээр Шатлал 1-д ангилсан. Банкны дотоод үнэлгээний систем болон ЗҮЦХА-ын тооцооллыг тусгай эсвэл бүлгийн үнэлгээгээр тооцох зэрэг бодлого журмыг тодруулга 34-д дэлгэрэнгүй тусгасан болно:

	12 сар ЧМ шатлал	Чанаргүйдэлд өртөх дүн Шатлал 1 мян.төг	ЗҮЦХА Шатлал 1 мян.төг
2021 оны 12 сарын 31	2.409%	889,640,138	(196,274)
2020 оны 12 сарын 31	2.358%	789,927,406	(170,578)

2021 болон 2020 оны 12 сарын 31-ний ЗҮЦХА-ын сангийн өөрчлөлтийн дүнг дараах байдлаар харуулав:

	2021 мян.төг	2020 мян.төг
1 сарын 1-нээр	170,578	287,248
Тайлант жилд байгуулсан/(буцаалт) (тодруулга 9)	25,696	(116,670)
12 сарын 31-нээр	196,274	170,578

Нэмэлт мөнгөн урсгалын мэдээлэл

	2021 мян.төг	2020 мян.төг
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө (Тодруулга 13)	976,548,511	856,968,353
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (Тодруулга 14)	504,422,698	570,008,607
Монголбанкны үнэт цаас - 3 сараас доош хугацаатай (Тодруулга 15)	1,661,230,725	688,492,320
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,142,201,934	2,115,469,280
Хасах нь: Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд ашигладаггүй Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц	(717,585,428)	(593,534,740)
Хасах нь: Гадаадын банканд байршуулсан барьцаа	(159,292,237)	(143,779,003)
Хасах нь: Барьцаанд байршуулсан Монголбанкны үнэт цаас - 3 сараас доош хугацаатай	(538,216,577)	(1,782,246)
Цэвэр мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,727,107,692	1,376,373,291

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

14. Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө

	2021 мян.төг	2020 мян.төг
Гадаадын банк, санхүүгийн байгууллага дахь харилцах	244,856,076	422,344,623
Гадаадын банканд байшуулсан барьцааны данс	159,292,237	143,779,003
Дотоодын банк, санхүүгийн байгууллага дахь харилцах	889,908	2,383,173
Дотоодын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж	99,384,477	1,501,808
Дансны дүн	504,422,698	570,008,607
Хасах нь: үнэ цэнийн бууралтын сан	(5,148)	(6,953)
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн цэвэр үлдэгдэл	504,417,550	570,001,654

Бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан

Доорх хүснэгтэд Банкны дотоод зээлийн үнэлгээний систем болон жилийн эцсийн үеийн шатлалын ангилал дээр үндэслэн зээлийн чанарын болон зээлийн эрсдэлийн дээд хэмжээг харуулав. Доор харуулсан дүнгүүд үнэ цэнийн бууралтын дүнг оруулаагүй дүнгээр илэрхийлэгдсэн. Банкны дотоод үнэлгээний систем болон ЗҮЦХА-ын тооцооллыг тусгай эсвэл бүлгийн үнэлгээгээр тооцох зэрэг бодлого журмыг тодруулга 34-д дэлгэрэнгүй тусгасан болно:

	12 сар ЧМ шатлал	Чанаргүйдэлд өртөх дүн Шатлал 1 мян.төг	ЗҮЦХА Шатлал 1 мян.төг
2021 оны 12 сарын 31-нээр			
Дотоодын үнэлгээ			
A- to AA+ үнэлгээ	0.022% - 0.076%	447,407,252	2,440
BBB- to BBB+	0.257%	27,913,686	111
B- to BB+	0.875% - 2.974%	16,513,689	542
Үнэлэгдээгүй	10.11%	12,588,071	2,055
		504,422,698	5,148

2020 оны 12 сарын 31-нээр

Дотоодын үнэлгээ			
A- to AA+ үнэлгээ	0.024% - 0.081%	520,118,322	460
BBB- to BBB+	0.269%	17,974,022	74
B- to BB+	0.897% - 3.79%	8,634,376	2,662
Үнэлэгдээгүй	10.001%	23,281,887	3,757
		570,008,607	6,953

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

14. Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (үргэлжлэл)

Дараах байдлаар 2020 болон 2021 оны 12 сарын 31-ний ЗҮЦХА-н сангийн өөрчлөлтийн шинжилгээ болон холбогдох дүнг харуулав:

	2021 Шатлал 1 мян.төг	2020 Шатлал 1 мян.төг
1 сарын 1-ний байдлаар дансны дүн	570,008,607	301,381,272
Шинээр худалдаж авсан хөрөнгө	106,773,411	477,620,494
Төлөгдсөн	(174,317,103)	(210,778,477)
Гадаад валютын тохируулга	1,957,783	1,785,318
12 сарын 31-ний байдлаар дансны дүн	504,422,698	570,008,607
1 сарын 1-ний байдлаар ЗҮЦХА	6,953	885,571
Шинээр худалдаж авсан хөрөнгө	2,664	610
Төлсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн хөрөнгө (данснаас хассаныг оруулахгүй)	(4,324)	(877,235)
ЗҮЦХА-ын тооцоонд ашигласан дүнд оруулсан өөрчлөлтүүд	(145)	(1,993)
Тайлант жилд цэвэр байгуулсан/(буцаалт) (тодруулга 9)	(1,805)	(878,618)
12 сарын 31-ний байдлаар ЗҮЦХА	5,148	6,953

15. Санхүүгийн хөрөнгө оруулалт

	2021 мян.төг	2020 мян.төг
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр		
Биржид бүртгэлтэй Засгийн газрын бонд (а)	58,774,436	25,542,064
Биржид бүртгэлгүй Монголбанкны үнэт цаас (б)	1,661,230,725	688,492,320
Биржид бүртгэлтэй бонд-МИК (в)	34,429,486	–
	1,754,434,647	714,034,384

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэглүүр

Биржид бүртгэлгүй өмчийн хэрэглүүр (г)	3,395,537	7,313,358
Биржид бүртгэлтэй өмчийн хэрэглүүр (д)	54,267,410	27,108,838
	57,662,947	34,422,196

Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн хэрэглүүр

Биржид бүртгэлгүй Засгийн газрын бонд (е)	544,984,309	769,134,032
Биржид бүртгэлгүй бонд-Хөгжлийн банк (ё)	45,694,979	65,898,997
	590,679,288	835,033,030

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө

Орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас (ж)	199,870,221	127,666,125
	199,870,221	127,666,125
	2,602,647,103	1,711,155,735

- (а) Бирж дээр бүртгэлтэй Засгийн газрын бондод гадаадын хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагддаг Засгийн газрын бондууд багтана.
- (б) Биржид бүртгэлгүй Монголбанкны үнэт цаасыг нэрлэсэн үнээр эсвэл урамшуулал, хорогдуулалттай үнээр худалдаж авч болно.
- (в) Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй бонд нь гадаадын хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагддаг МИК-н бонд юм.

15. Санхүүгийн хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

- (г) Бирж дээр бүртгэлгүй өмчийн үнэт цаасны ангилалд хаалттай хувьцаат компанид оруулсан өмчийн хөрөнгө оруулалтууд багтана. Банк нь эдгээр компаниудад хяналтын бус ашиг сонирхолтой байдаг. Эдгээр хөрөнгө оруулалтуудыг Банк стратегийн шинж чанартай гэж үзэн эргэлт буцалтгүйгээр бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэхээр ангилсан. Тайлант жилийн туршид Банк нь ногдол ашиг хүлээж аваагүй.
- (д) Бирж дээр бүртгэлтэй өмчийн үнэт цааснуудад Виза болон Монголиан Майнинг Корпорэйшн ХХК-д оруулсан хөрөнгө оруулалтууд багтана. Тайлант жилд, Банк нь Монголиан Майнинг Корпорэйшн ХХК-н 4.215%-н хувьцааг зээлийн эргэн төлөлтөд тооцон авч анхны өдрийн алдагдал хүлээсэн (Тодруулга 8-г харна уу). Банк нь эдгээр компаниудад хяналтын бус ашиг сонирхолтой. Мөн эдгээр хөрөнгө оруулалтуудыг стратегийн шинж чанартай гэж үзэн эргэлт буцалтгүйгээр бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэхээр ангилсан. Тайлант жилийн туршид Банк нь Виза компаниас 293 сая.төгрөгийн ногдол ашиг хүлээн авч орлогын тайланд бусад орлогоор хүлээн зөвшөөрсөн.
- (е) Засгийн газрын бонд нь хөрөнгийн биржид бүртгэлгүй, хүүтэй Монгол улсын Засгийн газрын бонд юм.
- (ё) Монгол улсын хөгжлийн банк (“ХБ”)–ны бонд нь АСЕМ төслийн хүрээнд ХБ-аас гаргасан хүүтэй, урт хугацаатай хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй бондоос бүрдсэн.
- (ж) Орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас (“ИЗББ”) нь Монголын Ипотекийн Корпораци (“МИК”)–аас гаргасан хүүтэй, урт хугацаат энгийн болон давуу эрхтэй бондноос бүрдэнэ (Тодруулга 18-г харна уу).

Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын сан

Доорх хүснэгтэд Банкны дотоод зээлийн үнэлгээний систем болон жилийн эцсийн шатлалын ангилал дээр үндэслэсэн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх болон хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг зээлийн эрсдэл ба ЗҮЦХА-ын хамт харуулав. Өрийн хэрэглүүрийн дотоод зээлийн үнэлгээ нь В- ээс В+ зэрэглэлтэй бөгөөд шатлал 1 -д ангилагдана. Банкны дотоод үнэлгээний систем, үнэ цэнийн бууралтын хэмжилтийн талаархи мэдээллийг Тодруулга 34-д тайлбарласан

	Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр		Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн хэрэглүүр	
	Бодит үнэ цэнэ мян.төг	ЗҮЦХА мян.төг	Дансны дүн мян.төг	ЗҮЦХА мян.төг
2021 оны 12 дугаар сарын 31				
2021 оны 1 сарын 1-нээр	714,034,384	159,260	835,875,835	842,805
Шинээр худалдаж авсан хөрөнгө	17,439,418,686	5,543,849	–	–
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(16,397,237,146)	(5,212,548)	(244,739,319)	(385,577)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт	(1,775,408)	–	–	–
Валютын ханшийн тохируулга	(5,869)	–	–	–
Тайлант жилд байгуулсан/(буцаалт) (Тодруулга 9)	–	331,301	–	(385,577)
2021 оны 12 сарын 31-нээр	1,754,434,647	490,561	591,136,516	457,228
2020 оны 12 дугаар сарын 31				
2020 оны 1 сарын 1-нээр	628,163,257	195,276	1,050,141,039	1,152,419
Шинээр худалдаж авсан хөрөнгө	7,233,040,340	(3,067,950)	–	–
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(7,148,128,538)	3,031,934	(214,265,204)	(309,614)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт	251,530	–	–	–
Валютын ханшийн тохируулга	707,795	–	–	–
Тайлант жилд байгуулсан/(буцаалт) (Тодруулга 9)	–	(36,016)	–	(309,614)
2020 оны 12 сарын 31-нээр	714,034,384	159,260	835,875,835	842,805

16. Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк нь МИК-ийн 10.00% (2020 онд: 19.99%) (МИК-ийн халаасны хувьцааг авч үзвэл 13.58% (2020 онд: 27.15%))-г эзэмшиж байв. Нэгдлийн үр дүнд Банк нь уг хөрөнгө оруулалтыг хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтаар бүртгэж эхэлсэн.

2021 онд Банк нь Банкны тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэх зорилгоор МИК-д оруулсан хөрөнгө оруулалтаас холбоотой тал болох Си Эн Би Консалтинг ХХК-д нийт 17,013,040 мянган төгрөгөөр хэсэгчлэн борлуулсан. Гэсэн хэдий ч, Банк нь санал өгөх эрхийн 20%-с багыг эзэмшиж байгаа ч МИК-д мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн хэвээр байна (Тодруулга 4-г харна уу).

МИК-ийн үндсэн үйл ажиллагаа нь Монгол улсад ИЗББ гарган, түүгээр барьцаалан эсвэл олон улсын зах зээл дээр гаргасан бондын санхүүжилтээр орон сууцны зээлийн багц худалдан авах юм. МИК нь Монгол улсын хөрөнгийн биржид (“МХБ”) бүртгэлтэй хувьцаат компани юм. Банк нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар МИК-ийн 2,070,932 ширхэг (2020 онд: 4,139,912 ширхэг) хувьцааг эзэмшиж байгаа ба МХБ дээрхи МИК-ийн нэгж хувьцааны хаалтын ханш 14,990 төг (2020 онд: 14,950 төг) байв.

Энэхүү Банкны санхүүгийн тайлан гарах өдрийн байдлаар, МИК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан гараагүй байсан. Банк нь МИК-д оруулсан хөрөнгө оруулалтаа өмчийн аргаар бүртгэдэг ба ингэхдээ МИК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх гол үйл явдлуудыг зохистойгоор тохируулсан хамгийн боломжит сүүлийн санхүүгийн мэдээллийг ашигласан. МИК-ийн аудитлагдсан санхүүгийн тайлан нь Банкны ашигласан санхүүгийн мэдээллээс өөр байж болох ба аливаа зөрүү нь 2022 онд залруулагдана. Дараах хүснэгтэд Банкны МИК-д оруулсан хөрөнгө оруулалтын мэдээллийг хураангуйлан үзүүлэв:

	мян.төг	
2020 оны 1 сарын 1-нээр		–
Санхүүгийн хөрөнгө оруулалтаас дахин ангилал		26,876,310
УБХБ-аас шилжиж ирсэн (Тодруулга 3)		27,670,448
Нэгдлийн үр дүнд үүссэн олз (Тодруулга 8)		768,590
Нэгдлийн өдрөөрх хараат компанийн цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнэ		55,315,348
Хараат компанийн тайлант жилийн алдагдлын Банканд ногдох хувь		(14,501,873)
2020 оны 12 сарын 31-нээр болон 2021 оны 1 сарын 1-нээр		40,813,475
Хараат компани дахь хөрөнгө оруулалт хэсэгчлэн борлуулах хүртэлх хараат компаний алдагдлын Банканд ногдох хувь		(17,646,059)
Хэсэгчлэн борлуулах өдрөөрх хараат компанийн цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнэ		23,167,416
Хувьцаа хэсэгчлэн борлуулалтаас орж ирсэн төлбөр		(17,013,040)
Хувьцаа хэсэгчлэн борлуулснаас үүссэн олз (Тодруулга 8)		5,434,794
Хараат компани дахь хөрөнгө оруулалт хэсэгчлэн борлуулсны дараах хараат компаний алдагдлын Банканд ногдох хувь		(11,082,873)
2021 оны 12 сарын 31-нээр		506,297
	2021	2020
	мян.төг	мян.төг
Хараат компани: МИК		
Нийт хөрөнгө	4,225,506,608	4,069,222,998
Нийт өр төлбөр	(4,221,778,353)	(3,918,897,123)
Эздийн өмч	3,728,255	150,325,875
Эздийн өмч дэхь Банкны эзэмшлийн хувь 13.58% (2020: 27.15%)	506,297	40,813,475
Тухалн жилийн цэвэр хүүгийн орлого	88,685,106	83,676,178
Тухайн жилийн нийт бусад дэлгэрэнгүй алдагдал	(146,584,510)	(112,336,707)

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

17. Санхүүгийн үүсмэл хэрэглүүр

Доорх хүснэгтэд хөрөнгө болон өр төлбөрт бүртгэгдсэн санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийг нэрлэсэн үнийн хамтаар харууллаа. Нэрлэсэн үнэ нь санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн суурь болж буй хөрөнгө, жишиг ханш эсхүл индекс байх бөгөөд санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн үнэ цэнийн өөрчлөлтийг хэмжих суурь болно. Нэрлэсэн үнэ нь тайлант жилийн эцсийн байдлаарх гүйлгээний дүнг харуулах бөгөөд энэ нь зах зээлийн эрсдэл эсхүл зээлийн эрсдэлийг тодорхойлох үзүүлэлт болж чадахгүй юм.

	Нэрлэсэн үнэ мян.төг	Бодит үнэ цэнэ	
		Хөрөнгө мян.төг	Өр төлбөр мян.төг
2021 оны 12 сарын 31-нээр			
<i>Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн үүсмэл хэрэглүүр</i>			
МИК, МБ-тай хийсэн валют, хүүгийн своп хэлцэл (а)	777,151,290	69,916,420	75,951,189
МБ-тай хийсэн валют, хүүгийн своп хэлцэл (б)	422,800,045	1,969,251	2,084,772
Үнэт металлын своп хэлцэл (в)	14,244,000	28,522,286	–
Форвард хэлцэл	98,077,347	1,239,541	–
	1,312,272,682	101,647,498	78,035,961

2020 оны 12 сарын 31-нээр

<i>Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн үүсмэл хэрэглүүр</i>			
МИК, МБ-тай хийсэн валют, хүүгийн своп хэлцэл (а)	777,151,290	89,371,192	93,331,037
МБ-тай хийсэн валют, хүүгийн своп хэлцэл (б)	340,178,235	–	6,392,065
	1,117,329,525	89,371,192	99,723,102

Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн хувьд анхны хөрөнгө оруулалт бага байх буюу эсхүл огт шаардахгүй. Хэдий тийм боловч эдгээр санхүүгийн хэрэглүүр нь ихэвчлэн хөшүүргийн зэргийг өндөрсгөх бөгөөд нилээн тогтворгүй байна. Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн хэлцлийн хөрөнгө, түвшин, индексийн үнэлгээний жижиг хэмжээний өөрчлөлт нь банкны ашиг, алдагдалд томоохон нөлөө үзүүлж болзошгүй.

Банк нь санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн гэрээний эрсдэлд өртөх дүнг банкны зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд тодорхойлдог. Банкны эрсдэлийн удирдлагын стратеги ба түүний хэрэгжүүлэлтийн талаар Тодруулга 34-д толилуулав. Санхүүгийн байдлын тайлан дахь холбогдох хейджиин бүртгэл болон гүйцэтгэлийг Тодруулга 10-т болон дор толилуулав.

(а) Банк нь 2019 оны 3 дугаар сарын 28-нд МИК-тэй валют, хүүгийн своп хэлцэл (санхүүгийн үүсмэл өр төлбөр) хийсэн ба мөн өдөр Монголбанктай эсрэг позицийн хэлцэл (санхүүгийн үүсмэл хөрөнгө) хийсэн буюу Банк нь зуучлагчын байр суурьнаас хэлцэлд орсон. Банк нь анх МИК-ээс америк долларын санхүүжилт хүлээн авч спот ханшаар тооцон төгрөг төлсөн ба мөн Монголбанкинд америк долларын санхүүжилт шилжүүлж, спот ханшаар тооцон төгрөгийн санхүүжилт хүлээн авсан. Монголбанктай байгуулсан гэрээний хугацаанд, Банк нь америк долларын санхүүжилтэд LIBOR дээр тодорхой хэмжээний ашиг нэмсэн хүүг хүлээн авч төгрөгийн санхүүжилтэд төв банкны бодлогын хүүгээр хүү төлсөн. Нөгөөтэйгүүр МИК-тэй байгуулсан гэрээний хугацаанд, Банк нь америк долларын санхүүжилтэд Монголбанкнаас авсан хүүтэй ижил хувиар хүү төлж, төв банкны бодлогын хүү дээр 0.1%-ийг нэмсэнтэй тэнцэх хүү хүлээн авна. Банк нь энэхүү хоёр гэрээ дуусах өдрөөрх ханшийн зөрүүгээр санхүүжилтийг барагдуулж мөн төлбөрийг хүлээн авна.

(б) Банк нь Монголбанктай валют, хүүгийн своп хэлцэл хийсэн. Банк нь анх Монголбанкинд америк долларын санхүүжилт төлж, спот ханшаар тооцон төгрөгийн санхүүжилт хүлээн авсан. Монголбанктай байгуулсан гэрээний хугацаанд, Банк нь америк долларын санхүүжилтэд LIBOR дээр тодорхой хэмжээний ашиг нэмсэн хүүг хүлээн авах ба төгрөгийн санхүүжилтэд төв банкны бодлогын хүүтэй тэнцүү хувиар тооцсон хүү төлнө. Гэрээний хугацаа дуусгавар болоход талууд анхны гүйлгээний валютын ханшаар үндсэн төлбөрийг солилцоно.

(в) Банк нь 2021 оны 11 сарын 11-нд Степпе Голд ХХК-тай алт худалдах, худалдан авах санхүүжилтийн гэрээ хийсэн. Гэрээний дагуу, Банк урьдчилгаа төлбөр хийсэн бөгөөд 2022 онд урьдчилан тохиролцсон хэмжээний унц алттай тэнцэх бэлэн мөнгөний төлбөрийг хүлээн авна. Гэрээний хугацаа нь урьдчилгаа төлбөр төлсөн өдрөөс хойш 12 сар байх ба 2022 оны 11 дүгээр сарын 30 хүртэл хүчинтэй байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

18. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

	2021 мян.төг	2020 мян.төг
Байгууллагын зээл	3,672,863,022	3,531,609,201
Иргэдийн зээл	548,255,161	497,361,925
Жижиг, дунд байгууллага (“ЖДБ”)-ын зээл	535,436,302	410,377,769
Гүйцэтгэх удирдлага, захирал, ажилтнуудад олгосон зээл	23,922,698	33,543,834
Харилцагчдад олгосон нийт зээл ба урьдчилгаа	4,780,477,183	4,472,892,729
Үнэ цэнийн бууралтын сан	(530,333,951)	(595,849,223)
Харилцагчдад олгосон цэвэр зээл ба урьдчилгаа	4,250,143,232	3,877,043,506

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	338,322,173	148,083,742
Нийт харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	4,588,465,405	4,025,127,248

Нийт дүнгээр нь үл хүлээн зөвшөөрч шилжүүлсэн санхүүгийн хөрөнгүүд

Орон сууцны зээлийн багцын борлуулалт

Банк нь тайлант жилд (2021 оны 2 дугаар сарын 3 ба 11 дүгээр сарын 2, 12 дугаар сарын 27-нд) тогтмол хүүтэй орон сууцны барьцаат зээлийн багцаас орж ирэх мөнгөн урсгалыг хүлээн авах эрхийг МИК-ийн тусгай зориулалтын компаниудад худалдаж, оронд нь ИЗББ-ыг худалдан авсан. Банк нь зээлийн багцыг үл хүлээн зөвшөөрч давуу эрхтэй болон энгийн ИЗББ-ыг санхүүгийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн (Тодруулга 15-г харна уу).

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

Банк нь 338,322 сая төгрөгийн (2020 онд: 148,084 сая төгрөг) МИК-д худалдах ипотекийн зээлийн багцыг эзэмшдэг. Эдгээр харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх хөрөнгөд ангилсан.

Нийт дүнгээр нь үл хүлээн зөвшөөрөөгүй шилжүүлсэн санхүүгийн хөрөнгүүд

Түүнчлэн, Банк нь МИК-д үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан зээлийн багцаас орж ирэх ирээдүйн мөнгөн урсгалыг худалдсан ба зээлүүдийн гүйцэтгэлд үүрэг хүлээх нөхцөлтэй. Банк нь нийт 119,683 сая.төг (2020 онд: 50,890 сая.төг)-ийн дүнтэй орон сууцны зээлийг МИК руу худалдсан ба оронд нь 13.8% (2020 онд: 16%)-ийн хүүтэй санхүүжилт хүлээн авсан. Эдгээр гүйлгээний дагуу зарагдсан зээлийн бүх эрсдэл ба өгөөжийг банк бүрэн хариуцна. Тиймээс уг хөрөнгө нь данснаас үл хүлээн зөвшөөрөх шаардлагыг хангаагүй. 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үл хүлээн зөвшөөрөлтийг хангаагүй хөрөнгийн нийт дүн 215,070 сая.төг (2020 онд: 558,249 сая.төг) байсан (Тодруулга 30).

Чанаргүй активыг бууруулах хөтөлбөр

2016 оны 6 дугаар сард Банк нь Монголбанктай Чанаргүй активыг бууруулах хөтөлбөр (“ЧАБХ”)-ийн хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулсан ба уг гэрээгээр Банкны тодорхой хэдэн зээлдэгч нар Монголбанкнаас санхүүжилтийн дэмжлэг авахаар болсон. Хөтөлбөрийн хүрээнд, Банк нь 160 тэрбум төгрөгийн өрийн бичиг (Тодруулга 29) гаргаж, түүнийг нь Монголбанк худалдан авч, төлбөрийг бүрэн төлсөнөөр тус зээлдэгч нарт санхүүжилтийг олгосон.

Засгийн газраас авч хэрэгжүүлж буй Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөг бууруулах хөтөлбөр

2020 болон 2021 оны турш Монгол улсын Засгийн газар Монголбанктай хамтран Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн ба хөтөлбөрийн хүрээнд иргэдийн орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийн төлбөр болон хүүгийн төлөлтийг хойшлуулсан. Уг хөтөлбөрөөр зээлдэгчид 6-аас 8 сар хүртэлх хугацаанд зээлийн хүүгээс чөлөөлсөн ба зээлийн гэрээний төлбөр төлөх хугацааг мөн хугацаагаар хойшлуулсан. Уг хойшлуулагдсан төлбөрүүдийг зээлийн гэрээний сунгагдсан хугацаанд зээлдэгчид нөхөж төлнө. 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх харилцагчдад олгосон зээлийн үлдэгдэл нь 148 тэрбум төгрөг (2020 онд: 122.5 тэрбум төгрөг) байсан ба орон сууцны зээлийн бүтцийн өөрчлөлтөөс 6,754 сая.төг (2020 онд: 5,593 сая.төг) (Тодруулга 8)-ийн алдагдлыг хүлээн зөвшөөрсөн.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

18. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан

Орлогын албан татварын зардал	–	–	–	–	–	15,729,066	15,729,066
Тайлант жилийн цэвэр ашиг/(алдагдал)	35,157,671	53,702,164	75,558,484	8,866,968	32,261,089	(100,735,943)	104,810,433
Сегментийн хөрөнгө	3,321,669,894	479,270,138	935,808,687	23,289	4,112,722,977	699,176,830	9,548,671,815
Сегментийн өр төлбөр	2,766,670,792	992,344,518	3,544,265,433	759,100,506	424,148,842	42,033,004	8,528,563,095
Элэгдэл ба хорогдуулга	27,282	14,866	5,149,002	14,078	9,047	15,941,625	21,155,900
Хөрөнгийн нэмэгдэл*	2,424	816	–	5,128	880	25,342,353	25,351,601

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 сарын 31

32. Сегментийн тайлан (үргэлжлэл)

2020 оны 12 сарын 31-нээр	Байгууллагын банк мян.төг	Жижиг, дунд байгууллагын банк мян.төг	Иргэдийн банк мян.төг	Олон улсын байгууллагын банк мян.төг	Хөрөнгө зохицуулалтын газар мян.төг	Бусад мян.төг	Нийт мян.төг
Сегментийн үр дүн							
Гадаад орлого							
Цэвэр хүүгийн орлого/(зардал)	142,840,097	51,393,715	(94,417,152)	(37,190,622)	144,555,494	(747,389)	206,434,143
Хураамж ба шимтгэлийн орлого	7,926,417	9,769,876	14,074,907	14,946,325	409,666	6,945,776	54,072,967
Хураамж ба шимтгэлийн зардал	(3,561)	–	(11,666,633)	(463)	(131,248)	(2,906,906)	(14,708,811)
Арилжааны болон бусад үйл ажиллагааны цэвэр орлого/(зардал)	(7,799,437)	–	(5,657,950)	–	(20,762,595)	13,144,240	(21,075,742)
Сегмент хоорондын орлого/(зардал)	(116,839,576)	5,229,836	177,072,921	13,851,987	(171,312,362)	91,997,194	–
Нийт сегментийн орлого/(зардал)	26,123,940	66,393,427	79,406,093	(8,392,773)	(47,241,045)	108,432,915	224,722,557
Үйл ажиллагааны зардал	8,278,746	1,567,681	5,059,186	2,927,513	2,919,892	110,849,177	131,602,195
Хараат компанийн алдагдлын Банканд ногдох хувь	–	–	–	–	–	14,501,873	14,501,873
Санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал/(буцаалт)	28,841,631	30,327,554	52,014,250	–	1,614,477	23,317,371	136,115,283
Татварын өмнөх ашиг/(алдагдал)	(10,996,437)	34,498,192	22,332,657	(11,320,286)	(51,775,414)	(40,235,506)	(57,496,794)
Орлогын албан татварын зардал	–	–	–	–	(1,921,609)	5,217,874	3,296,265
Тайлант жилийн цэвэр ашиг/(алдагдал)	(10,996,437)	34,498,192	22,332,657	(11,320,286)	(49,853,805)	(45,453,380)	(60,793,059)
Сегментийн хөрөнгө	3,176,090,563	288,300,849	644,729,364	31,289	3,166,690,715	769,679,281	8,045,522,061
Сегментийн өр төлбөр	2,218,416,046	857,174,662	3,108,776,374	360,746,159	548,820,303	21,234,823	7,115,168,367
Элэгдэл ба хорогдуулга	187,927	1,278	4,879,336	16,288	155,581	15,024,089	20,264,499
Хөрөнгийн нэмэгдэл*	1,453,202	6,301	25	3,543	–	3,838,554	5,301,625

*Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн бэлэн мөнгөөрх нэмэгдэлийг илэрхийлнэ.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 сарын 31

33. Болзошгүй өр төлбөр ба үүрэг

Харилцагчдын санхүүгийн хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд, Банк нь янз бүрийн буцалтгүй үүрэг болон болзошгүй өр төлбөр хүлээж байдаг. Хэдийгээр эдгээр үүргийг санхүүгийн байдлын тайланд тусгаагүй байж болох ч, эдгээр нь зээлийн эрсдэл, улмаар Банкны нийт эрсдэлийг бүрдүүлж байдаг (Тодруулга 34-с үзнэ үү).

	2021 мян.төг	2020 мян.төг
Эх үүсвэргүй баталгаа болон аккредитив	352,804,653	289,565,616
Ашиглаагүй зээлийн шугам	297,095,737	275,547,390
	649,900,390	565,113,006

Банк харилцагчдын санхүүгийн хэрэгцээг хангахын тулд төрөл бүрийн болзошгүй өр төлбөр болон үүргийн харилцаанд ордог. Эдгээр болзошгүй өр төлбөр, үүргүүд нь санхүүгийн тайланд тусгаагдаагүй ч зээлийн эрсдэлийг агуулдаг тул Банкны эрсдлийн нэг хэсэг юм (Тодруулга 34-ийг үзнэ үү).

Доорхи хүснэгтээр тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүрэг дээрх үнэ цэнийн бууралтын сангийн хөдөлгөөнийг харуулав:

	Эх үүсвэргүй баталгаа болон аккредитив мян.төг	Ашиглаагүй зээлийн шугам мян.төг	Нийт мян.төг
2021 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	14,824,112	1,745,691	16,569,803
Шинээр нэмэгдсэн	2,515,836	3,316,564	5,832,400
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(14,037,775)	(1,042,814)	(15,080,589)
Тайлант жилийн эрсдэлийн сангийн зардал (Тодруулга 9)	(11,521,939)	2,273,750	(9,248,189)
Валютын ханшийн тохируулга	349	–	349
2021 оны 12 сарын 31-нээр	3,302,522	4,019,441	7,321,963
2020 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	4,316,502	835,316	5,151,818
Шинээр нэмэгдсэн	11,384,243	1,252,623	12,636,866
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(876,633)	(342,248)	(1,218,881)
Тайлант жилийн эрсдэлийн сангийн зардал (Тодруулга 9)	10,507,610	910,375	11,417,985
2020 оны 12 сарын 31-нээр	14,824,112	1,745,691	16,569,803

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

33. Болзошгүй өр төлбөр ба үүрэг (үргэлжлэл)

2021 болон 2020 оны 12 сарын 31-ний дансны үлдэгдэл болон холбогдох ЗҮЦХА сангийн өөрчлөлтийн болон зээлийн чанарын шинжилгээг доорх хүснэгтэд харуулав:

Эх үүсвэргүй баталгаа болон аккредитив

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2021 оны 1 сарын 1-ээрх дансны дүн	223,239,601	11,471,531	54,854,484	289,565,616
Шинээр нэмэгдсэн	248,684,732	–	–	248,684,732
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(169,210,170)	(11,003,209)	(5,232,316)	(185,445,695)
Шилжилт/ Шатлал 1 руу	39,131,553	–	(39,131,553)	–
Шилжилт/ Шатлал 2 руу	–	–	–	–
Шилжилт/ Шатлал 3 руу	(29,190,765)	(468,322)	29,659,087	–
2021 оны 12 сарын 31-нээр	312,654,951	–	40,149,702	352,804,653

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2021 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	785,998	2,603,661	11,434,453	14,824,112
Шинээр нэмэгдсэн	2,515,836	–	–	2,515,836
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(10,238,947)	(2,603,661)	(1,195,167)	(14,037,775)
Шилжилт/ Шатлал 1 руу	10,244,129	–	(10,244,129)	–
Шилжилт/ Шатлал 2 руу	–	–	–	–
Шилжилт/ Шатлал 3 руу	(769,010)	–	769,010	–
Валютын ханшийн тохируулга	349	–	–	349
2021 оны 12 сарын 31-нээр	2,538,355	–	764,167	3,302,522

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2020 оны 1 сарын 1-ээрх дансны дүн	188,687,884	160,104,858	1,483,172	350,275,914
Шинээр нэмэгдсэн	174,649,887	–	–	174,649,887
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(133,718,293)	(93,304,707)	(8,337,185)	(235,360,185)
Шилжилт/ Шатлал 1 руу	3,785,294	(3,785,294)	–	–
Шилжилт/ Шатлал 2 руу	(916,211)	916,211	–	–
Шилжилт/ Шатлал 3 руу	(9,248,960)	(52,459,537)	61,708,497	–
2020 оны 12 сарын 31-нээр	223,239,601	11,471,531	54,854,484	289,565,616

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2020 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	475,328	3,274,490	566,684	4,316,502
Шинээр нэмэгдсэн	11,259,405	124,838	–	11,384,243
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(281,770)	(28,179)	(566,684)	(876,633)
Шилжилт/ Шатлал 1 руу	21,918	(21,918)	–	–
Шилжилт/ Шатлал 2 руу	–	–	–	–
Шилжилт/ Шатлал 3 руу	(10,688,883)	(745,570)	11,434,453	–
2020 оны 12 сарын 31-нээр	785,998	2,603,661	11,434,453	14,824,112

2020 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх дансны үнийг зээлийн чанараар харуулвал:

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2021 оны 12 сарын 31-нээр				
Хэвийн	312,654,951	–	–	312,654,951
Анхаарал хандуулах	–	–	40,149,702	40,149,702
Хэвийн бус	–	–	–	–
Эргэлзээтэй	–	–	–	–
Алдагдал	–	–	–	–
Нийт	312,654,951	–	40,149,702	352,804,653

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2020 оны 12 сарын 31-нээр				
Хэвийн	223,239,601	–	–	223,239,601
Анхаарал хандуулах	–	11,471,531	–	11,471,531
Хэвийн бус	–	–	54,854,484	54,854,484
Эргэлзээтэй	–	–	–	–
Алдагдал	–	–	–	–
Нийт	223,239,601	11,471,531	54,854,484	289,565,616

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

33. Болзошгүй өр төлбөр ба үүрэг (үргэлжлэл)

Ашиглаагүй зээлийн шугам

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2021 оны 1 сарын 1-ээрх дансны дүн	249,364,112	21,129,401	5,053,877	275,547,390
Шинээр нэмэгдсэн	166,605,550	10,895,014	–	177,500,564
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(131,455,487)	(18,613,031)	(5,883,699)	(155,952,217)
Шилжилт/ Шатлал 1 руу	1,419,311	(1,024,747)	(394,564)	–
Шилжилт/ Шатлал 2 руу	(651,704)	718,483	(66,779)	–
Шилжилт/ Шатлал 3 руу	(986,684)	(1,492,934)	2,479,618	–
2021 оны 12 сарын 31-нээр	284,295,098	11,612,186	1,188,453	297,095,737

2021 оны 1-р сарын 1-ний өдрийн

байдлаарх ЗҮЦХА-ын сан	1,566,649	173,398	5,644	1,745,691
Шинээр нэмэгдсэн	3,284,190	32,374	–	3,316,564
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(972,924)	(67,357)	(2,533)	(1,042,814)
Шилжилт/ Шатлал 1 руу	109,380	(103,736)	(5,644)	–
Шилжилт/ Шатлал 2 руу	(2,242)	2,242	–	–
Шилжилт/ Шатлал 3 руу	(1,115)	(1,418)	2,533	–
2021 оны 12 сарын 31-нээр	3,983,938	35,503	–	4,019,441

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2020 оны 1 сарын 1-ээрх дансны дүн	170,970,383	7,942,504	100,789	179,013,676
Шинээр нэмэгдсэн	167,349,269	1,183,400	–	168,532,669
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(65,240,527)	(6,677,700)	(80,728)	(71,998,955)
Шилжилт/ Шатлал 1 руу	818,487	(768,618)	(49,869)	–
Шилжилт/ Шатлал 2 руу	(19,700,753)	19,700,753	–	–
Шилжилт/ Шатлал 3 руу	(4,832,746)	(250,939)	5,083,685	–
2020 оны 12 сарын 31-нээр	249,364,113	21,129,400	5,053,877	275,547,390

2020 оны 1-р сарын 1-ний өдрийн

байдлаарх ЗҮЦХА-ын сан	793,354	38,313	3,649	835,316
Шинээр нэмэгдсэн	1,086,704	165,919	–	1,252,623
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(312,066)	(28,171)	(2,011)	(342,248)
Шилжилт/ Шатлал 1 руу	9,837	(9,837)	–	–
Шилжилт/ Шатлал 2 руу	(7,428)	7,428	–	–
Шилжилт/ Шатлал 3 руу	(3,752)	(254)	4,006	–
2020 оны 12 сарын 31-нээр	1,566,649	173,398	5,644	1,745,691

2020 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх дансны үнийг зээлийн чанараар харуулвал:

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2021 оны 12 сарын 31-нээр				
Хэвийн	284,295,098	–	–	284,295,098
Анхаарал хандуулах	–	11,612,186	–	11,612,186
Хэвийн бус	–	–	1,188,453	1,188,453
Эргэлзээтэй	–	–	–	–
Алдагдал	–	–	–	–
Нийт	284,295,098	11,612,186	1,188,453	297,095,737
2020 оны 12 сарын 31-нээр				
Хэвийн	249,364,113	–	–	249,364,113
Анхаарал хандуулах	–	21,129,400	–	21,129,400
Хэвийн бус	–	–	5,053,877	5,053,877
Эргэлзээтэй	–	–	–	–
Алдагдал	–	–	–	–
Нийт	249,364,113	21,129,400	5,053,877	275,547,390

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

33. Болзошгүй өр төлбөр ба үүрэг (үргэлжлэл)

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк нь дуусаагүй барилгын гэрээний дагуу 98 сая америк доллар (2020 онд: 99 сая америк доллар)-ын үүрэг хүлээсэн байна (Тодруулга 19 ба 22-аас үзнэ үү).

Болзошгүй өр төлбөр

Аккредитив, баталгаа нь тусгай үйл явдал тохиолдоход харилцагчийн өмнөөс голдуу тендер, төлбөрийн баталгаатай холбоотойгоор төлбөр хийх үүргийг банканд ногдуулдаг. Баталгаа нь зээлийн эрсдэлтэй ижил эрсдэлийг агуулдаг.

Үүрэг

Үүрэг гэдэг нь Банкны зүгээс зээл олгох, зээлийн шугам нээх гэрээт үүргүүдийг хүлээснийг илэрхийлдэг. Ийм үүргүүд нь тогтсон дуусах хугацаа эсвэл цуцлах бусад төрлийн заалтуудтай байдаг. Зээл олгох үүрэг нь хэрэгжээгүй байтал тус үүргийнх нь хугацаа нь дууссан байж болох тул гэрээнд заасан дүн нь ирээдүйн мөнгөний шаардлагыг илэрхийлдэг гэсэн ойлголт биш юм.

Ашиглаагүй зээлийн шугам

Энэхүү хэрэгслийн гол зорилго нь харилцагчид шаардлагатай хэмжээний санхүүжилт бэлэн байгааг баталгаажуулах юм. Батлагдсан зээлийн шугамын эрхээс ашиглагдаагүй байгаа хэсэг нь зээлийг нэмэгдүүлэх үүргийг тодорхойлно. Зээлийг нэмэгдүүлэх үүргийн эрсдэл нь, ашиглаагүй зээлийн эрхийн хэмжээгээр Банк алдагдал хүлээх эрсдэл юм. Гэсэн хэдий ч, зээлийн эрхийг хэвийн байлгах тодорхой шалгуур үзүүлэлтүүдээс хамааран алдагдлын дүн нь нийт ашиглаагүй зээлийн эрхийн хэмжээнээс бага байх талтай байдаг.

Шүүхийн нэхэмжлэл

Бизнесийн онцлог шинж чанарын улмаас Банкны салбарт аливаа маргааныг шүүхийн үйл ажиллагааны дагуу шийдвэрлэх нь энгийн үзэгдэл байдаг. Банк нь шүүхийн нэхэмжлэлтэй хэрхэн ажиллах талаар тогтсон журамтай. Нэгэнт мэргэжлийн зөвлөгөө авсан, гарч болох хохирлын хэмжээг зохистойгоор тооцоолсон бол Банк нь тухайн нэхэмжлэлийн банкны санхүүгийн байдалд үзүүлж болох сөрөг нөлөөллөөс хамгаалан дансандаа залруулах бичилт хийдэг.

2020 болон 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар дээр дурдсанаас бусад Банктай холбоотой өөр ямар нэгэн томоохон шүүхийн хэрэг бүртгэгээгүй байна.

Татварын тухай хууль тогтоомж

Монгол Улсын татварын хууль тогтоомжид тайлбар, өөрчлөлт тодорхой хэмжээгээр орж байдаг. Банкны гүйлгээ, үйл ажиллагаанд хамааралтай ийм хууль тогтоомжийн талаарх удирдлагын тайлбарыг татварын алба үгүйсгэж болно.

Монголын татварын алба хууль тогтоомж, үнэлгээг тайлбарлахдаа илүү хатуу байр суурь баримталж байгаа бөгөөд урьд өмнө маргаан үүсгээгүй гүйлгээ, үйл ажиллагааг татварын алба няцааж болзошгүй юм. Үүний үр дүнд ихээхэн хэмжээний нэмэлт татвар, торгууль, хүүг тооцож болзошгүй. Санхүүгийн жилүүд татварын талаар хянах жилийн өмнөх таван жилийн хугацаанд эрх бүхий байгууллагуудаар хянуулахад нээлттэй хэвээр байна. Зарим тохиолдолд тойм нь илүү урт хугацааг хамарч болно.

Монгол Улсын үнэ шилжилтийн тухай хууль тогтоомж нь татварын албанд үнэ шилжилтийн тохируулга хийх, хянах боломжтой бүх гүйлгээ, түүний дотор дотоод шилжилтийн үнэтэй холбоотой нэмэлт татварын өр төлбөр ногдуулах боломжийг олгож байна. Гүйлгээний нөхцөл нь зах зээлийн нөхцлөөс гажсан тохиолдолд татварын алба татвар ногдуулах зүйлд тохируулга хийх, нэмэлт татвар, торгууль, хүүгийн торгууль ногдуулах эрхтэй. Одоогийн Монгол Улсын үнэ шилжилттэй холбоотой өөрчлөлтийн үр нөлөөг найдвартай үнэлэх боломжгүй хэдий ч байгууллагын санхүүгийн байдал, нийт үйл ажиллагаанд томоохон нөлөөтэй байх боломжтой.

Монгол Улсын татварын хууль тогтоомж нь тодорхой чиглэлээр, ялангуяа НӨАТ, суутганы албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар болон бусад чиглэлээр эцсийн шийдвэрлэх зааварчилгаа өгдөггүй. Банк нь аль болох ойрхон хугацаанд татварын ерөнхий хэмжээг бууруулж болохуйц эргэлзээтэй хэсгүүдийг тодорхой болгохыг эрмэлздэг. Дээр дурдсанчлан сүүлийн үеийн захиргааны болон шүүхийн үйл ажиллагааны зохицуулалтын өөрчлөлт, шинэчлэлтийн үр дүнд нарийн хяналтын дагуу татварын ийм байр сууриуд бий болж болох юм. Эдгээр нь байгууллагын санхүүгийн байдал болон ерөнхий үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой буюу нөлөөтэй байх боломжтой хэдий ч Татварын албанаас бий болгож болох аливаа шийдвэр, хяналт шалгалтын үр нөлөөг найдвартай үнэлэх боломжгүй билээ.

Удирдлагын зүгээс татварын эрсдэлийн талаар тогтмол үнэлгээ, шинжилгээ хийдэг боловч одоогийн байдлаар хангалттай урьдчилан таамаглах боломжгүй ирээдүйн өөрчлөлтөөс болж нөхцөл байдал өөрчлөгдөж болох юм.

34. Эрсдэлийн удирдлага**(1) Оршил**

Банкны үйл ажиллагааны салшгүй гол эрсдэлүүд бол зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, хүүний түвшний эрсдэл, валютын ханшийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэлүүд байдаг. Энэхүү тодруулгад Банкны хөрөнгө зохицуулалт, эрсдлийн удирдлага ба хяналтын үйл ажиллагаа, бодлого, зорилтууд болон дээр дурьдсан эрсдэлд өртөх байдлын талаарх мэдээллийг толилуулав.

Эрсдэлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт

Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) нь Банкны эрсдэлийн удирдлагын ерөнхий тогтолцоог хариуцах ба эрсдэлийн удирдлагын бодлого болон эрсдэл хүлээх чадвар болон хүлээн зөвшөөрөх эрсдэлийг тусгасан зээлийн бодлогыг батлах үүрэгтэй. Эрсдэлийг хянах, удирдах үүрэгтэй хараат бус бүрэлдэхүүнүүд мөн байна.

ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороо (“ТУЗЭУХ”)

ТУЗЭУХ нь банкны эрсдэлийн удирдлагын үндсэн чиг хандлагыг тодорхойлж, стратеги, бодлого, зарчмыг батлах ба гүйцэтгэх удирдлага эрсдэлийн удирдлагын бодлогыг банкны үйл ажиллагаанд мөрдүүлж, хэрэгжүүлж ажилладаг. ТУЗЭУХ нь дотоодын аудитын үйл ажиллагаанд туслах үүрэгтэй ажилладаг.

Дотоод аудит

Банкны эрсдэлийн удирдлагын үйл явцад Дотоод аудитын газар жилд нэг удаа аудит хийх ба аудитын үед Банкны журмуудын зохистой байдал хийгээд Банканд дагаж мөрдөж байгаа байдлыг шалгадаг. Дотоод аудит нь журмын зохистой байдлыг шалгахаас гадна Банкны журмын мөрдөлт, хэрэгжүүлэлтийг хянадаг.

Гүйцэтгэх удирдлагын хороо

Гүйцэтгэх удирдлагын хороо нь Банкны Гүйцэтгэх удирдлагуудаас бүрдэх бөгөөд Банкны стратегийн асуудал, бизнесийн бодлого төлөвлөлт болон банкны үйл ажиллагааны тогтвортой хөгжлийн талаар хэлэлцэж шийдвэр гаргаж, захирлуудын харилцан уялдааг ханган ажилладаг.

Актив пассивын удирдлагын хороо (“АПУХ”)

АПУХ нь санхүүжилтийн хөрөнгө болон өр төлбөрийг төвлөрсөн удирдлагаар хангах, хөрвөх чадвар, гадаад валют, эргэн төлөгдөх хугацаа болон хүүгийн эрсдэлийг тодорхой түвшинд хангаж ажиллах үүрэгтэй. АПУХ-ны зорилго нь Банкны санхүүгийн тайлангийн актив пассивын бүтцийг Банкний тогтвортой хөгжлийг хангах байдлаар тогтоох, актив пассивын ерөнхий удирдлагаар ашигт ажиллагаа болон хөрвөх чадварыг хангах мөн валютын, хүүгийн болон зах зээлийн бусад эрсдэлийг хянах болон удирдахад оршино.

Эрсдэлийн удирдлагын хороо (“ЭУХ”)

Эрсдэлийн Удирдлагын хороо нь Банкны болон Банкны бизнес нэгжийн үйл ажиллагаанд учирсан болон учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлох, мөн үйл ажиллагааны эрсдэл, зах зээлийн эрсдэл болон бусад эрсдэлийг багасгах зорилгоор тэдгээрийг үнэлэх, түүнийг хэрэгжүүлэх заавар удирдамж өгч ажилладаг.

Зээлийн хороод

Банкны Эрсдэлийн удирдлагын газар (“ЭУГ”) нь Банкны зах зээл, зээлийн эрсдэлийг удирдах үүргийг хүлээдэг. Зээлийн хорооны бүтцийг Банкны бүх төрлийн зээлийн эрсдэлийг удирдахад дөхөм байхаар зохион байгуулсан. Зээлийн хяналт болон шийдвэр гаргалтанд дараах түвшний Зээлийн хороод оролцдог:

1. Зээлийн ерөнхий хороо нь 500 сая төгрөгөөс дээш дүнтэй зээлийн өргөдлийг хэлэлцэн батлахаас гадна Банкны зээлийн үйл ажиллагааны заавар журмын өөрчлөлтийг батална. Түүнчлэн, одоогийн мөрдөгдөж буй бодлого журмын дагуу тодорхой заасан хэмжээнээс давсан зээлийн саналыг ТУЗ-д танилцуулан батлуулдаг.
2. Жижиглэн зээлийн хороо нь салбар зээлийн хорооны батлах хязгаараас дээш 500 сая төгрөг хүртэлх зээлийн эрсдэлийг баталдаг.
3. Цалин, хадгаламжаар баталгаажсан зээлийн зээлийн хороо нь 20 сая төгрөгөөс дээш цалин, тэтгэврийн зээлийг баталдаг.
4. Зээлийн дэд хороо нь салбарын зээлийн хорооны, тооцооны төв болон бизнес төвүүдийн зээлийн эрхээс давсан 60-180 сая төгрөг, цалин болон тэтгэврийн 20 сая төгрөг хүртэлх зээлийн хүсэлтийг хэлэлцэн батална.

Банкны эрсдэлийн удирдлагын бодлогыг Банканд тулгарч буй эрсдэлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, эрсдэлийн зохих хязгаарлалт, хяналтыг тогтоох, эрсдэл ба хязгаарлалтад нийцэж буй байдалд хяналт тавих зорилгоор тогтоодог. Зах зээлийн нөхцөл байдал, санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний өөрчлөлтийг тусгахын тулд эрсдэлийн удирдлагын бодлого, системийг тогтмол хянаж үздэг. Банк нь сургалт, стандарт, журмаараа дамжуулж ажилтнуудаа өөрсдийн үүрэг, хариуцлагаа ухамсарлаж байх сахилга баттай, үр дүнтэй хяналтын орчинг бий болгохыг зорьж байна.

34. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**Эрсдэлийг хэмжих болон тайлагнах систем**

Банк нь статистик загваруудын тусламжтайгаар түүхэн алдагдлаас ойролцоолон тооцсон ердийн тохиолдолд хүлээж болзошгүй алдагдал болон гэнэтийн тохиолдолд учирч болзошгүй онцгой алдагдлыг давхар хэмжиж чадах системийг ашиглан эрсдэлийг хэмждэг. Эдгээр статистик загваруудыг түүхэн өгөгдлөөр тооцсон магадлалыг эдийн засгийн өнөөгийн орчинд нийцүүлэх байдлаар хэрэглэдэг.

Эрсдэлийн удирдлага, хяналт нь гол төлөв Банкнаас тогтоосон хязгаарын биелэлтэд суурилна. Эдгээр хязгааруудад Банк өөрийн бизнесийн стратеги зорилт, тухайн зах зээлийн орчин, мөн цаашид хүлээх боломжтой эрсдэлийн түвшинг тусгаж өгсөн байна. Үүнээс гадна Банк нь өөрийн эрсдэл даах чадварыг бүх үйл ажиллагаа болон эрсдэлийн төрлүүдээр тодорхойлон хэмжиж, түүнд хяналт тавьдаг.

Эрсдэлийг цаг тухайд нь олж илрүүлэх, шинжлэх, хянах үүднээс бизнесийн бүх нэгжүүдээс цуглуулсан мэдээллүүдийг шинжилдэг. Боловсруулсан мэдээллээ ТУЗ, ЭУХ, АПУХ, зээлийн хороод болон бүх газар, хэлтсийн захирлуудад танилцуулж, тайлагнана. Тайланд зээлийн эрсдэлд өртөж болох нийт багцын хэмжээ, зээлийн метрикийн таамаглал, хөрвөх чадварын харьцаа болон эрсдэлийн төлөвүүдийн өөрчлөлтийг тусгана.

Улирал бүр Актив пассивын удирдлагын хороо болон Эрсдэлийн хороо нь Банкны эрсдэлд үнэлэлт, дүгнэлт өгөхөд бүх шаардлагатай мэдээллээр хангах зорилготой иж бүрэн эрсдэлийн тайланг хүлээн авдаг. Долоо хоног бүр Актив пассивын удирдлагын хороонд VaR, хөрвөх чадварын шинжилгээ, зах зээлийн эрсдэлийн лимитийн биелэлт болон бусад аливаа эрсдэл үүсгэх хүчин зүйлийн талаар танилцуулдаг.

Эрсдэлийг бууруулах арга зам

Хүүгийн түвшний эрсдэл, гадаад валютын ханшийн өөрчлөлт, зээлийн эрсдэл болон ирээдүйн үйл ажиллагаанаас үүдэж болох болзошгүй эрсдэлийн хэмжээг мэдрэмжийн шинжилгээгээр тооцон, хянаж ажилладаг. Банк зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор барьцаа хөрөнгө болон хувь хүний батлан даалт авдаг.

Эрсдэлийн хэт төвлөрөл

Төвлөрөл нь ижил, төстэй бизнесийн үйл ажиллагаанд оролцож байгаа, эсвэл нэгэн ижил газар зүйн бүсэд, эдийн засгийн ойролцоо шинж чанартай олон тооны оролцогч талуудад улс төр, эдийн засаг болон аливаа бусад өөрчлөлт нь тэдгээрийн гэрээний үүргээ гүйцэтгэх чадварт ижил маягаар нөлөөлж байгаа үед бий болдог. Төвлөрөл нь тухайн нэгж салбарт болон газар зүйн байрлалд нөлөөлж буй нөхцөл байдалд Банкны гүйцэтгэлээ хангах мэдрэмжийг илтгэнэ.

Эрсдэлийн хэт төвлөрлөөс зайлсхийх үүднээс Банк өөрийн бодлого, журамдаа олон төрлийн багцтай байх тодорхой удирдамжийг тусгасан байдаг. Үүнд нийцүүлэн зээлийн эрсдэлд тодорхойлсон төвлөрлийг хянаж удирдана.

Монголбанк дараах стандарт хязгаарлалтуудыг тогтоож, биелүүлэхийг шаарддаг. Үүнд:

- Нэг зээлдэгч болон түүний холбогдох этгээдэд олгох нийт зээлийн дүн болон зээлтэй адилтгах бусад хөрөнгийн нийлбэр дүн банкны өөрийн хөрөнгийн 20% -иас хэтрэхгүй.
- Банкны холбогдох этгээдэд олгосон зээлийн хэмжээ болон зээлтэй адилтгах бусад хөрөнгийн дүн нь банкны өөрийн хөрөнгийн 5% -иас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20% -иас тус тус хэтрэхгүй.

Банк журмаараа хадгаламжийн төвлөрлийн түвшинд харгалзах хангалттай хөрвөх чадварыг барихыг шаарддаг.

(2) Зээлийн эрсдэл

Банкны харилцагч гэрээний дагуух үүргээ биелүүлээгүй тохиолдолд Банканд үүсч болох алдагдлын эрсдэлийг зээлийн эрсдэл гэнэ. Банк нь зээлийн өргөдлүүдийг анхааралтай хянах, эрсдэлийн түвшинд тохируулсан хүүгийн хувь хэмжээг тогтоох, харилцагч талуудыг газарзүйн байршил, аж үйлдвэрийн салбараар ангилан зээлийн эрсдэлд өртөх түвшинд хязгаар тогтоох зэргээр зээлийн эрсдэлд хяналт тавьдаг.

Банк нь харилцагч талуудын зээлжих чадварт орж болзошгүй өөрчлөлт (барьцаа хөрөнгөө тогтмол шинэчлэх гэх мэт)-ийг эртнээс олж таних зорилгоор зээлийн чанарын хяналтын процессийг нэвтрүүлсэн. Зээлийн чанарын хяналтын процесс нь Банканд болзошгүй алдагдлыг тодорхойлох, засах арга хэмжээг эрт авах боломжийг бий болгодог.

Банк зээлийн үйл ажиллагааг сайжруулахын тулд зээлийн журам зааврыг тогтмол шалгаж, сайжруулж шинэчилдэг.

Зээлтэй холбоотой болзошгүй үүргийн эрсдэл

Банк нь харилцагчийн өмнөөс төлбөр төлөх магадлал бүхий баталгаа, аккредитивийг гаргадаг. Төлбөр төлөгдөх тохиолдолд баталгаа, аккредитивийн нөхцөлд тулгуурлан харилцагчаас эх үүсвэрийг төвлөрүүлнэ. Банканд зээлтэй нэгэн адил эрсдэл учруулах тул эдгээрийг зээлийн үйл ажиллагааны бодлого, журмаар зохицуулна.

34. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**(2) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)****Үнэ цэнийн бууралтын үнэлгээ*****Чанаргүйдэл, үнэ цэнийн бууралт ба сайжруулалтын тодорхойлолт***

Зээлдэгч гэрээгээр хүлээсэн төлбөрөө 90 болон түүнээс дээш хоногоор хугацаа хэтрүүлсэн эсвэл Банк зээлдэгчийн барьцаа хөрөнгийг борлуулах замаар эргэн төлөлтийг гүйцээх магадлалтай бүх тохиолдолд тухайн санхүүгийн хэрэглүүрийг үл төлөгдөх магадлалтай гэж үзэн хүлээгдэж буй алдагдлыг тооцдог.

Харилцагчдын санхүүгийн хэрэглүүрийг чанарын үнэлгээгээр үнэлж зээлийг “үнэ цэнийн бууралттай” гэж үзэх болон эргэн төлөгдөхгүй байх магадлалуудыг Банк авч үздэг. Энэ тохиолдолд Банк харилцагчийн санхүүгийн хэрэглүүрийг үл төлөгдөх магадлалтай эсэхийг нарийвчлан шинжилж хүлээгдэж буй алдагдлыг 2-р шатлал эсвэл 3-р шатлалын алинд нь тооцоологдохыг тодорхойлох замаар үнэлгээг хийнэ. Чанарын үнэлгээг хийхдээ дараах хүчин зүйлийг харгалзан үздэг. Үүнд:

- Зээлдэгчийн санхүүгийн хүндрэлээс болж тус зээл нөхцөл өөрчлөлтөд орсон;
- Зээлдэгч гэрээгээр хүлээсэн төлбөрөө 90 болон түүнээс дээш хоногоор хугацаа хэтрүүлсэн
- Зээлдэгч нь эрсдэлд орох нөхцөл байдал үүссэн эсвэл ойрын хугацаанд эрсдэх магадлалтайг тодорхойлсон Банкны дотоод үнэлгээ
- Зээлдэгч нас барах
- Зээлдэгчийн үйл ажиллагаа гэнэтийн хүчин зүйлээс эрсдэлд учирсан
- Зээлийн хугацаанд барьцаа хөрөнгийн үнэ цэнэ материаллаг хэмжээгээр буурах;
- Зээлдэгч (эсвэл зээлдэгчийн бүлэгт хамаарах аливаа хуулийн этгээд) нь дампуурлын талаархи өргөдөл мэдэгдэл гаргах

Үл төлөгдөх магадлалд орох эсэх шалгууруудын хүчин зүйл нь дараалсан 6 сар үргэлжлэн илрээгүй бол санхүүгийн хэрэглүүрийг "үнэ цэнэ сайжирсан" гэж үзэн 3-р шатлалаас шилжүүлэх эсэхийг Банк өөрийн бодлогоор зохицуулна. Активын үнэ цэнэ сайжирч 1-р шатлал болон 2-р шатлалд ангилах эсэх шийдвэр нь тухайн зээлийн болон зээл олгох үеийн дотоод үнэлгээтэй харьцуулахад эрсдэл хэрхэн өссөн байгаагаас хамаарна.

Банкны дотооддоо хэрэглэдэг үнэлгээний систем болон ЧМ-ын тооцоолол

Банкны зээлийн эрсдэлийн газар нь дотоод үнэлгээний загварыг гаргадаг. Энэхүү загварууд нь чанарын болон тоон мэдээллийг агуулдаг бөгөөд зээлдэгчийн онцлог мэдээллээс гадна зээлдэгчийн зан төлөвт нөлөөлж болох гадны нэмэлт мэдээллийг ашигладаг. Практик боломжтой үед Банк нь олон улсын, тухайлбал Мүүдиз, Стандарт энд Пурс, Фитч үнэлгээний байгууллагуудын мэдээллийг ашигладаг. Аль шатлалд хөрөнгийг ангилахад дээрх эх сурвалжуудыг ашигладаг.

Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа төлбөрийн чанаргүйдлийн магадлалыг тооцохдоо түүхэн мэдээллүүд дээр үндэслэн тооцох бөгөөд холбогдох макро эдийн засгийн хүчин зүйлсийг ашиглан урьдчилан таамаглалын тохируулгыг хийнэ. ЧМ нь нөхцөлт ЧМ гэж тодорхойлогддог бөгөөд энэ нь өмнөх хугацаанд тухайн дансны хувьд хийгдсэн бүрэн ба хэсэгчилсэн төлөлтийг харгалзан үзэж ЧМ муруйг бий болгодог. Мөн түүнчлэн, Банк ЧМ муруйг янз бүрийн хугацааны хувьд тооцоолохын тулд банк “кохорт” дүн шинжилгээг ашигладаг.

Зээл болон урьдчилгаанаас бусад санхүүгийн хөрөнгийн хувьд ашигладаг ЧМ загвар нь үнэлгээний матриц дээр суурилсан бөгөөд энэ нь холбоотой талуудын олон улсын зээлийн үнэлгээний мэдээллээс гардаг. Энэхүү зээлийн үнэлгээний мэдээллүүд нь ирээдүйн мэдээллүүдийг агуулсан байдаг.

Хөрөнгө зохицуулалт, арилжаа ба банк хоорондын харилцаа

Банкны хөрөнгө зохицуулалт, арилжаа ба банк хоорондын харилцаа болон хамтрагч талуудад санхүүгийн байгууллагууд, банк, брокер-дилерүүд, хөрөнгийн биржүүд болон клеринг төвүүд багтана. Эдгээр харилцагч байгууллагын хувьд, Банкны Хөрөнгө зохицуулалтын газраас олон улсын үнэлгээний агентуудын (тухайлбал, Мүүдиз) нийтэд нээлттэй гадаад мэдээлэлд дүн шинжилгээ хийж дотооддоо үнэлгээ өгдөг.

34. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**(2) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)*****Бизнесийн зээл***

Бизнесийн зээлийн эрсдэлийг үнэлэхдээ зээлдэгчдийг зээлийн эрсдлийг газрын шинжээчдийн хяналт дор зээлийн мэргэжилтнүүд үнэлдэг. Зээлийн эрсдлийн үнэлгээ нь харилцагчийн түүхэн, одоо, ирээдүйн нөхцөл байдлын мэдээллийг харгалзан үздэг. Үүнд:

- Харилцагчийн санхүүгийн төсөөлөл болон түүхэн мэдээлэл. Энэхүү санхүүгийн мэдээлэл нь харилцагчийн санхүүгийн гүйцэтгэлийн хэрэгжилт, хүлээгдэж буй үр дүн, төлбөрийн чадварын харьцаа, хөрвөх чадварын харьцаа болон бусад холбогдох санхүүгийн чадамжийг үнэлэх харьцаануудыг агуулна. Эдгээр үзүүлэлтүүдийн зарим нь үйлчлүүлэгчидтэй хийсэн гэрээнүүд дээр тулгуурласан байдаг тул илүү анхаарч авч үздэг.
- Харилцагчдын талаарх бусад эх сурвалжаас гаралтай нийтэд нээлттэй мэдээлэл.
- Макро-эдийн засгийн болон геополитикийн аливаа мэдээлэл
- Банкны гүйцэтгэлд хамаарах харилцагчийн менежментийн чанар, ур чадварын талаарх бодитой мэдээлэл

Үнэлгээний арга барилын нарийн төвөгтэй байдал нь зээлийн хэмжээ болон харилцагчийн цар хүрээндээ шалтгаалан өөр өөр байдаг. Зарим бизнесийн зээл нь жижиг бизнест зориулсан Банкны дотоод загвараар үнэлэгддэг.

Хэрэглээний зээл

Хэрэглээний зээлд иргэдийн бүх төрлийн хэрэглээний зээл, кредит карт болон орон сууцны зээлүүд багтдаг. Эдгээр зээлийн бүтээгдэхүүнүүд болон зарим жижиг бизнесийн зээлийн эрсдэлийн үнэлгээг зээлдэгчийн хугацаа хэтрэх магадлалыг тодорхойлох аргачлал бүхий программын загвараар үнэлдэг. Үүнд: хүн ам зүй, зээл хүсэгчийн зээлийн түүх, барьцаа хөрөнгө, одоогийн орлогын түвшин, дансны орлогын өөрчлөлт, өр төлбөрийн үлдэгдэл болон хүссэн зээлийн нөхцөл зэргийг харгалзан үздэг.

Банкны дотоод үнэлгээ

Дотоод үнэлгээ	Дотоод үнэлгээний тайлбар	Олон улсын үнэлгээ
Хэвийн	Маш сайн	A- to AA+ зэрэгтэй
Анхаарал хандуулах	Ахисан дунд үнэлгээ	BBB- to BBB+
Хэвийн бус	Дунд үнэлгээ	B- to BB+
Эргэлзээтэй	Доод үнэлгээ	Саа-С
Муу	Үнэ цэнэ буурсан	–
Үнэлэгдээгүй	Үнэлэгдээгүй	–
Тусгай үнэлгээгээр үнэ цэнэ буурсан	Тусгай үнэлгээгээр үнэ цэнэ буурсан	–

Чанаргүйдэлд өртөх дүн (“ЧӨД”)

Чанаргүйдэлд өртөх дүн нь харилцагчийн алдагдал хүлээх дүн болон эрт эргэн төлөлт хийх чадвар зэргийг харгалзан үзэж санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэ буурах үед тооцсон бодит хэмжээг хэлнэ. Зээлийн карт болон бусад зээлийн шугамын чанаргүйдэлд өртөх дүнг тодруулга 2.5-өөс харна уу.

1-р шатлалд буй зээлийн ЧӨД-г тооцоолохдоо Банк нь 12 сар дотор үүсэж болох чанаргүйдэх үйл явдлыг 12 сарын ЗҮЦХА-г тооцоход авч үзнэ. 2-р шатлал болон 3-р шатлалуудад ЧӨД-г тодорхойлохдоо нийт хугацааны түүхэн чанаргүйдэх үйл явдлыг авч үзнэ.

12 сарын болон зээлийн хугацааны ЧӨД нь бүтээгдэхүүний төрлөөс хамааран хүлээгдэж буй төлбөрийг үндэслэн тодорхойлогддог:

- Хорогдуулсан болон нэг удаагийн эргэн төлөлттэй зээлийн, зээлдэгчийн 12 сарын хугацаанд эсвэл зээлийн хугацаанд нь төлөх гэрээний төлбөрт үндэслэнэ. Мөн түүнчлэн зээлдэгчийн хүлээгдэж буй илүү төлөлтийг тохируулж өгнө. Энэхүү тооцоолд эрт төлөлт/дахин санхүүжүүлэлтийн таамаглалыг мөн тусгаж өгнө.
- Зээлийн шугамын бүтээгдэхүүний хувьд, нийт лимитээс ашигласан хувиар ЧӨД-г тооцдог.

34. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

(2) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Алдагдалд хүргэх чанаргүйдэл

АХЧ нь Банкны хүлээгдэж буй үл төлөгдөх зээлийн хэмжээг илэрхийлнэ. АХЧ нь харилцан тохиролцсон хэлбэр, нэхэмжлэлийн төрөл болон зэрэглэл, барьцаа хөрөнгө эсвэл бусад зээлийн дэмжлэг зэргээс шалтгаалан харилцан адилгүй байдаг. АХЧ нь зээл/авлага дефолт болох үед хүлээх алдагдлын нэгж хувиар илэрхийлэгдэнэ. АХЧ-ийг 12 сар эсвэл зээлийн хугацааны туршид тооцдог бөгөөд 12 сарын АХЧ нь дараагийн 12 сард дефолт болох тохиолдолд гарах алдагдлын хувийг тооцдог бөгөөд зээлийн хугацааны туршид АХЧ нь үлдэгдэл зээлийн хугацаанд гарах алдагдлын хувийг тооцдог.

АХЧ нь барьцааны үнэ болон төлөлтөөс хамааран цаг хугацаа өнгөрөх тусам өөрчлөгдөж байдаг. АХЧ -ийн коэффициентийн гол элементүүд нь:

- Цагийн хэмжээс (ЧӨД параметрийг баталгаатай, баталгаагүй хэсэгт хуваах) ба
- Барьцаа хөрөнгийн үнэ цэнэ өөрчлөгдөхөд (үл хөдлөх хөрөнгө гэх мэт барьцааны тохиолдолд үнэ нь өөрчлөгдөхгүй хэвээр байх болно)

Санхүүгийн хэрэглүүрд барьцаа хөрөнгө байхгүй, үл төлөлтийн түүхэн өгөгдөл хангалттай байгаа тохиолдолд Банк шинжээчдийн дүгнэлтийг гаргадаг. Тайлангийн өдрөөрх нөхцөл байдал, өгөгдлийн бүрэн гүйцэд байдлаас хамааран Банк АХЧ-ийн коэффициентийн үе шатыг тодорхойлохын тулд түүхэн мэдээллийн хандлага эсвэл гадаад эх сурвалжаас авсан түүхэн өгөгдлийг ашигладаг.

Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт

Банк нь ЗҮЦХА-д хамаарах бүх хөрөнгийг тасралтгүй хянадаг. Тухайн нэг санхүүгийн хэрэглүүр эсвэл багц хэрэглүүр нь 12 сарын ЗҮЦХА эсвэл нийт хугацааны ЗҮЦХА-г хамаарах эсэхийг тодорхойлохын тулд Банк нь уг хөрөнгүүдийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхийг үнэлдэг.

Банк нь гэрээний нөхцөлд өөрчлөлт орсон хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн тохиолдолд чанарын шинжилгээ хийдэг. Зарим тохиолдолд зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийн шалтгааныг чанаргүйдэл бус “Чанаргүйдлийн тодорхойлолт”-д дурьдагдсан үйл явдлуудтай холбож тайлбарладаг. Зээлийн ангиллын өөрчлөлтийг үл харгалзан 30 хоногоос дээш хугацаа хэтрэлттэй зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн байна гэж үздэг.

Ижил төстэй бүлэг хөрөнгүүдийн ЗҮЦХА-г тооцохдоо, анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхийг шинжлэхдээ ижил арга, аргачлалуудыг ашигладаг.

Бүлгийн үнэлгээгээр санхүүгийн хөрөнгүүдийг ангилах нь

Доорх хүчин зүйлээс хамаарч “ЗҮЦХА зарчмуудын тойм” 2.5-т тайлбарласнаар Банк нь ЗҮЦХА -ын нөөцийг бүлгийн болон тусгай үнэлгээгээр тооцдог.

Банк нь ЗҮЦХА -ийг тусгай үнэлгээгээр тооцоолох хөрөнгийн ангилалд дараах зээлүүд орсон:

- Шатлал 3-т ангилагдсан, зээлийн өрийн үлдэгдэл 5.0 тэрбум төгрөгөөс их зээлдэгчдийн хувьд тусгайлсан үнэлгээг хийх
- Холбоотой зээлдэгчдийн доторх аль нэг зээлдэгч нь шатлал 3-т ангилагдсан бөгөөд тухайн холбоотой зээлдэгч нарын нийт зээлүүдийн өрийн үлдэгдэл (бүх үе шатууд дах зээлүүд орно) нь 5.0 тэрбум төгрөгөөс дээш дүнтэй байх
- Шатлал харгалзахгүйгээр томоохон бөгөөд онцгой шинж чанартай байгууллагын зээлийн багцын зээл

Банк нь ЗҮЦХА -ийг бүлгийн үнэлгээгээр тооцоолох үед тусгай үнэлгээнд ороогүй бүх зээлийг оруулна. Банк нь эдгээр зээлүүдийг зээлдэгчийн сегмент дээр үндэслэн доорх жижиг багцуудад ангилдаг.

- Байгууллагын зээл
- Жижиг, дунд байгууллага (“ЖДБ”)-ын зээл
- Иргэдийн зээл

34. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

(2) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

ЗҮЦХА -ын загварын өгөгдөлд дүн шинжилгээ хийх нь

Банк нь ЧМ болон ЗҮЦХА-г тооцоолохдоо ирээдүйг илтгэх мэдээллийг ашиглан ирээдүйн макро эдийн засгийн өөрчлөлт ЗҮЦХА-д хэрхэн нөлөөлж болохыг харгалзаж үздэг. Энгийн шугаман хамаарлын аргыг ашиглан ажиглагдахуйц чанаргүйдлийн/дефолтын хувь болон макро эдийн засгийн хүчин зүйл хоорондын харилцан хамаарлыг тооцдог. Ашигласан мэдээллийн багцад зээлийн бүтээгдэхүүн бүрд хамаарах ЧМ болон голлох макро хүчин зүйлүүдийн улирал бүрийн мэдээллүүд ордог. Макро эдийн засгийн хүчин зүйлийн мэдээллийг Үндэсний статистикийн хороо болон Монголбанкны мэдээллийн сангаас татдаг бол ЧМ хувь нь банкны дотоод мэдээллийн сангаас гаргасан түүхэн мэдээллийг ашигладаг. Банк нь 2021 онд нэг жилийн өмнөх байдлаар дефолтийн хувьтай хамгийн их уялдаатай байсан ДНБ-ийн өсөлт болон бодлогын хүүг Байгууллагын зээл, Жижиг, дунд байгууллагын зээл болон иргэдийн зээлийн хувьд ашигласан (2020 оны хувьд ДНБ-ийн өсөлт болон инфляцийн түвшинг Жижиг, дунд байгууллагын зээл болон иргэдийн зээлд, Зээлийн өсөлт болон Мөнгөний нийлүүлтийн М2 өсөлтийг бизнесийн зээлд).

Арга зүйн хувьд, эхлээд оновчтой макро эдийн засгийн хүчин зүйлүүдийг урьдчилан сонгохдоо шугаман хамаарлын шинжилгээ хийсэн. Дараа нь коэффициентуудыг энгийн регрессийн шинжилгээ ашиглан тооцоолсон. Тооцооллын үр дүнд гарсан коэффициентууд болон таамаглалуудаас ЧМ-д хамаарах ирээдүйн талаарх мэдээлэл хүчин зүйлүүдийг тохируулан авч үзсэн тул урьдчилсан чанаргүйдлийн хувь болон түүхэн дундаж чанаргүйдлийн хувийн харьцааг ЧМ болгон авч үзсэн. Эдгээр тохируулга нөлөөлөгч хүчин зүйлс болон тохируулсан ЧМ хувиуд нь ирээдүйн эдийн засгийн өсөлтийн талаар хамгийн бодитой төсөөлөл өгч чадна гэж үзсэн тул ЗҮЦХА загварын суурь төсөөлөл болно. Сайн болон муу төсөөллүүдийг тухайн загвараар таамагласан чанаргүйдлийн хувь дахь түүхэн тохируулагч хүчин зүйлүүдийг үндэслэн тооцсон ба тохируулагч хүчин зүйлийн тархалтыг тодорхой тоонуудаар хэмжсэн. Төсөөлөл бүрийн ЗҮЦХА-г тухайн төсөөлөлд хамаарах ЧМ хувьд үндэслэн тооцсон бол бодит ЗҮЦХА-г дээрх гурван төсөөллийн дараах пропорцоор жигнэсэн дунджаар авсан байна. Үүнд: эерэг болон сөрөг төсөөллийн 10%, суурь төсөөллийн 80%.

Тооцооллын 3 төсөөлөлд хамаарах тохируулгын коэффициентыг доорх хүснэгтээс харна уу:

2021 оны 12 сарын 31-нээр

	Байгууллагын зээл	ЖДБ-ын зээл	Иргэдийн зээл
Сөрөг төсөөлөл	2.0515	2.0515	1.9102
Суурь төсөөлөл	1.5049	1.5049	1.4340
Эерэг төсөөлөл	0.4702	0.4702	0.5423

2020 оны 12 сарын 31-нээр

	Байгууллагын зээл	ЖДБ-ын зээл	Иргэдийн зээл
Муу төсөөлөл	1.6457	1.6457	1.7978
Суурь төсөөлөл	0.8268	0.8268	0.9244
Сайн төсөөлөл	0.3763	0.3763	0.5170

Бүтцийн өөрчлөлт орсон зээлийн тойм

Эрсдэлийн удирдлагын үүднээс зээлд бүтцийн өөрчлөлт орсон бол Банкны тусгай хөрөнгийн хэлтэс нь зээлийг эргэн төлөгдөх хүртэл хяналт тавьдаг.

Доорхи хүснэгтэд бүтэц өөрчлөгдсөн санхүүгийн хөрөнгийн нийт дансны дүн болон холбогдох ЗҮЦХА-г 2021 оны болон 2020 оны 12 сарын 31-ээр тус бүр харуулав:

	2021 мян.төг	2020 мян.төг
<i>Бүтэц өөрчлөгдсөн зээлүүд:</i>		
Дансны нийт үнэ	64,091,637	100,863,249
Холбогдох ЗҮЦХА	(30,898,992)	(39,142,484)

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

34. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

(2) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Эрсдэлийн төвлөрлийн шинжилгээ

Банк дотооддоо хэрэглэдэг зээлийн үнэлгээний систем, шатлалыг ашиглан гаргасан зээлийн чанар болон зээлийн эрсдэлд өртөж болох хамгийн их дүнтэй холбоотой тодруулгуудыг 13, 14, 15 ба 16-р тодруулгаас харна уу.

Дараах хүснэгтэд Банкны харилцагчдад олгосон зээл, урьдчилгааг (Тодруулга 18) аж үйлдвэрийн салбараар нь ангилан, зээлийн барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ эсвэл зээлийн чанарыг сайжруулах бусад зүйлүүдийг авч үзэхээс өмнөх нийт дүнгээр нь үзүүлэв.

	Нийт багцын хэмжээ			
	2021 мян.төг	%	2020 мян.төг	%
Худалдаа, үйлчилгээ	1,183,191,976	23%	1,081,692,227	23%
Уул уурхай, олборлолт	910,296,524	18%	803,578,265	17%
Барилга байгууламж	520,921,588	10%	524,422,331	11%
Санхүүгийн үйлчилгээ	373,142,568	7%	345,712,884	7%
Үйлдвэрлэл	515,616,099	10%	463,561,209	10%
Орон сууц	517,222,290	10%	350,247,810	8%
Төлбөрийн карт	251,922,005	5%	226,539,171	5%
Зочид буудал, ресторан, аялал жуулчлал	166,213,301	3%	166,055,406	4%
Тээвэр, харилцаа холбоо	137,752,916	3%	83,985,658	2%
Хадгаламж барьцаалсан	93,026,232	2%	58,371,395	1%
Эрүүл мэнд	43,576,125	1%	40,198,807	1%
Боловсрол	80,961,554	2%	72,568,273	2%
Цахилгаан, эрчим хүч ба дулаан	31,187,578	1%	24,967,725	1%
Хөдөө аж ахуй	22,047,101	0%	25,461,384	1%
Бусад	271,721,499	5%	353,613,926	8%
	5,118,799,356	100%	4,620,976,471	100%

*Бусад салбарын компаниудын хувьцааг л эзэмшдэг холдинг компанийг банкны салбарын кодчиллын дагуу санхүүгийн үйлчилгээ гэж ангилсан.

Зээлийн барьцаа хөрөнгө ба бусад сайжруулалтууд

Барьцаа хөрөнгийн төрөл болон үнэлгээний дүн нь зээлдэгчийн зээлийн эрсдэлийн үнэлгээ болон олгох зээлийн төрлөөс хамаарна. Барьцаанд авсан хөрөнгийн гол төрлүүдийг доор үзүүлэв. Үүнд:

- Байгууллагуудад олгосон зээл: Үл хөдлөх хөрөнгө, бараа материал, үйлдвэр ба тоног төхөөрөмж, машин механизм;
- Иргэдийн зээл: Тээврийн хэрэгсэл; орлого; үл хөдлөх хөрөнгө; орон сууцны үл хөдлөх хөрөнгө
- Жижиг, дунд үйлдвэрлэлд олгосон зээл: Үл хөдлөх хөрөнгө

Банк барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тогтмол хянадаг ба гэрээний дагуу шаардлагатай үед нэмэлт барьцаа хөрөнгө гаргуулахыг шаардаж болно.

Банк журмын дагуу өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг зохион байгуулалттайгаар борлуулдаг. Хөрөнгө борлуулсанаас олсон орлогыг зээлийн үлдэгдэл төлбөрийг багасгах болон төлж дуусгахад зориулна. Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг Банк нь өөрийн бизнесийн хэрэгцээнд ашигладаггүй.

Банк дотооддоо хэрэглэдэг зээлийн үнэлгээний систем ба жилийн эцсийн шатлалын ангиллыг ашиглан гаргасан зээлийн чанар болон зээлийн эрсдэлд өртөж болох хамгийн их дүнтэй холбоотой тодруулгуудыг 13, 14, 15 ба 16-р тодруулгаас харна уу.

Санхүүгийн хэрэглүүрүүд нь бодит үнэ цэнээрээ бүртгэгддэг санхүүгийн хэрэглүүрийн хувьд тодруулга 15-д, ирээдүйн үнэлгээний өөрчлөлтөөс үүдэн гарах зээлийн эрсдэлд өртөж болох хамгийн их дүнг бус харин одоогийн байгаа зээлийн эрсдэлийг харуулсан.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 дугаар сарын 31

34. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

(2) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Банкны харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны барьцааг доор харуулав:

	2021		2020	
	Нийт мян.төг	Барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ мян.төг	Нийт мян.төг	Барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ мян.төг
Байгууллагын зээл	3,672,863,022	2,652,553,356	3,531,609,201	1,465,921,794
ЖДБ-ын зээл	535,436,302	477,497,748	410,377,769	315,859,385
Иргэдийн зээл	572,177,859	319,753,238	530,905,759	308,809,627
	4,780,477,183	3,449,804,342	4,472,892,729	2,090,590,806

Зээлийн төвлөрлийн харьцаа

Банкнаас аливаа этгээд, түүнтэй холбогдох этгээд, харилцан хамаарал бүхий этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалт, бусад хэлцлийн нийлбэр дүн нь тухайн банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй. Хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн дарга болон гишүүн, гүйцэтгэх удирдлага, банкны ажилтан эсвэл түүнтэй холбоотой аливаа этгээдэд олгох зээл, түүнтэй адилтгах хөрөнгө, баталгааны дээд хэмжээ нь банкны өөрийн хөрөнгийн 5 хувиас нийт дүн нь Банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх ёстой.

2021 болон 2020 оны 12 сарын 31-ний байдлаар тодорхой зээлдэгчдэд, түүнтэй холбогдох этгээд, харилцан хамаарал бүхий этгээдэд олгосон зээлийн дүн нь зохистой харьцаа буюу 20%-с хэтэрсэн байна. Нийт хэтэрсэн дүн нь 4,259 сая төгрөг (2020: 14,572 сая.төгрөг) байсан ба уг дүн өөрийн хөрөнгийн зохистой харьцааг үнэлэхэд тохируулагдсан байна (Тодруулга 38-г харна уу).

(3) Төлбөрийн чадварын эрсдэл

Санхүүгийн хэвийн болон хүндрэлтэй нөхцөлд төлбөр тооцооны үүргээ гүйцэтгэх боломжгүй байх эрсдэлийг төлбөрийн чадварын эрсдэл гэнэ. Уг эрсдэлийг хязгаарлахын тулд удирдлага нь үндсэн харилцах, хадгаламжийн эх үүсвэрээс гадна олон төрлийн эх үүсвэрийг төвлөрүүлэх ба өдөр тутам ирээдүйн мөнгөн урсгал болон төлбөрийн чадвараа хянадаг. Үүний тулд нэмэлт эх үүсвэр шаардагдсан үед ашиглагдах өндөр үнэлгээтэй барьцаа хөрөнгийн бэлэн байдал болон хүлээгдэж буй мөнгөн урсгал зэргийн үнэлгээ хийхийг шаарддаг.

Харилцагч харилцахаас татан авалт хийх, хадгаламжийн хугацаа дуусаж бэлэн мөнгө авах болон Банк зээлдэгчид зээлийн олголт хийх тохиолдолд Банк нь хангалттай хэмжээний бэлэн мөнгөтэй байх шаардлагатай болдог. АПУХ нь бэлэн мөнгөний эдгээр гадагш мөнгөн урсгалыг нөхөх хамгийн бага мөнгөн урсгалын түвшин болон гэнэтийн эрэлтийн үед гарах зардлыг нөхөхөд бэлэн байх ёстой банк хоорондын болон бусад зээлийн хэрэгслийн доод түвшинд хязгаарлалт тогтоодог.

34. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

(3) Төлбөрийн чадварын эрсдэл (үргэлжлэл)

Төлбөрийн чадварын эрсдэлд өртөх байдал

Банкнаас төлбөрийн чадварын эрсдэлийг удирдахад ашигладаг гол хэмжүүр бол төлбөрийн чадвартай хөрөнгийг нийт өр төлбөртэй харьцуулах харьцаа бөгөөд энэ нь Монгол Улсын Банкны тухай хуульд заасан төлбөрийн чадварын харьцаатай нийцэж байгаа юм.

Энэ зорилгоор Банк төлбөрийн чадварын харьцааг дараах байдлаар тооцоолдог. Банкны төлбөрийн чадвартай хөрөнгийг тооцохдоо бэлэн мөнгө, бусад банк болон санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламж, Монголбанкны хөрөнгө оруулалтын үнэт цаасыг оруулна. Харин түргэн гүйцэтгэгдэх өр төлбөрийг тооцохдоо харилцагчаас төвлөрүүлсэн харилцах, хадгаламж, бусад банк болон санхүүгийн байгууллагуудаас байршуулалсан харилцах, хадгаламж, гадаадын санхүүгийн байгууллагуудын зээл, татвар, гаргасан өрийн бичиг зэрэг орно.

Тайлангийн өдрөөрх төлбөрийн чадварын харьцаа:

	2021	2020
12 дугаар сарын 31-ний байдлаар	40.6%	39.3%

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдэж буй хугацаагаар шинжилсэн шинжилгээ

Дараах хүснэгтэд 2021 болон 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн өр төлбөр болон хөрөнгийн дуусгавар хугацааг тэдгээрийн гэрээний дагуу эргэн төлөх үүрэг дээр үндэслэн харууллаа. Мөн Банк дийлэнх харилцагчид нь гэрээт хугацаанаасаа өмнө зарлагын гүйлгээ хийхгүй байх гэсэн хүлээлт дээр үндэслэсэн бөгөөд харилцах, хадгаламжийн тодорхой хувийг хадгалах хүлээгдэж буй мөнгөн урсгалыг тусгаагүй болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2021 оны 12 сарын 31

34. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

(3) Төлбөрийн чадварын эрсдэл (үргэлжлэл)

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдэж буй хугацаагаар шинжилсэн шинжилгээ (үргэлжлэл)

2021 оны 12 сарын 31-нээр	Хугацаагүй мян.төг	3 сараас ихгүй мян.төг	3 сараас 6 сар мян.төг	6 сараас 1 жил мян.төг	1-ээс 5 жил мян.төг	5-аас дээш жил мян.төг	Нийт мян.төг
Санхүүгийн хөрөнгө							
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	976,548,511	8,017,940	–	–	–	–	984,566,451
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	405,038,221	101,772,804	–	–	–	–	506,811,025
Санхүүгийн хөрөнгө оруулалт	60,692,439	1,271,633,439	93,249,457	241,384,642	939,200,934	634,783,058	3,240,943,969
Нийт хэрэгжсэн своп хэлцэл:							
- Орж ирсэн гүйлгээ	–	863,327,381	1,245,156	2,147,447	135,860,418	–	1,002,580,402
- Гарсан гүйлгээ	–	(798,718,006)	(2,623,675)	(3,897,800)	(137,754,694)	–	(942,994,175)
